ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. ЕРӨНХИЙ ЗААЛТУУД

эр томьёоны тодорхойлолт	Энэхүү Гэрээнд хэрэглэсэн дараах нэр томьёог өөрөөр тайлбарлах шаардлагатайгаас бусад тохиолдолд доор дурдсан утгаар ойлгоно.	
		“Урьдчилгаа төлбөрийн баталгаа” гэж 14.2.1 [Урьдчилгаа төлбөрийн баталгаа] дэх хэсэгт заасны дагуу гаргасан баталгааг хэлнэ.
		“Суурь огноо” гэж Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 28 хоногийн өмнөх огноог хэлнэ.
		“Шаардлага” гэж энэхүү гэрээний нөхцөлийн аль нэг заалтад заасан эрх болон үүргээс чөлөөлөгдөх эсхүл Гэрээ болон Ажлыг гүйцэтгэхтэй холбоотой, тэдгээрээс үүдэн бий болсон гэрээний нэг талаас нөгөө талдаа гаргаж буй хүсэлт, шаардлага, нэхэмжлэлийг хэлнэ.
		“Ажил эхлүүлэх огноо” гэж 8.1 [Ажил эхлүүлэх]-ийн дагуу Захиалагчийн хүргүүлсэн ажил эхлүүлэх Мэдэгдэлд заасан огноог хэлнэ.
		“**Гэрээний нийцлийн хяналтын систем**” гэж 4.9.2 [Гэрээний нийцлийн хяналтын систем]-ийн дагуу Ажил гэрээнд нийцэж байгаа эсэхийг хянах зорилгоор Гүйцэтгэгчийн боловсруулж, хэрэгжүүлэх системийг хэлнэ.
		“Гэрээний нөхцөл” гэж Гэрээний Ерөнхий Нөхцөлд заасан бүхий л зохицуулалт болон Тусгай нөхцөлөөр нэмсэн, өөрчилсөн бүхий л зохицуулалтыг хэлнэ.
		“Гэрээ” гэж Гэрээний хэлэлцээр, Гэрээний хэлэлцээрт дурдсан бүхий л хавсралтууд, Гэрээний нөхцөл, Захиалагчийн шаардлага, төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө, Тендер, Түншлэлийн гэрээ (хэрэв шаардлагатай бол) болон Гэрээний хэлэлцээрт тусгасан бусад нэмэлт баримт бичгүүдийг хэлнэ.

		“Гэрээний хэлэлцээр” гэж 1.6 [Гэрээний хэлэлцээр]-д заасны дагуу Талуудын байгуулсан хэлэлцээр, түүнд хавсаргасан аливаа санамж бичгүүдийг хэлнэ.
		“Гэрээний өгөгдөл” гэж Тусгай Нөхцөлийн А хэсгийг бүрдүүлж буй баримт бичгийг хэлнэ.
		“Гэрээний үнэ” гэж Гэрээний хэлэлцээрт Ажлыг хийж гүйцэтгэхээр тохиролцож тусгасан үнийн дүн, түүнд Гэрээний дагуу оруулсан тохируулга (хэрэв байгаа бол)-ыг хэлнэ.
		“Гүйцэтгэгч” гэж Гэрээний хэлэлцээрт заасан Гүйцэтгэгч болон түүний хууль ёсны эрх залгамжлагчийг хэлнэ.
		“Гүйцэтгэгчийн баримт бичиг” гэж 5.2 [Гүйцэтгэгчийн Баримт бичиг]-д тодорхойлсны дагуу Гүйцэтгэгчийн боловсруулсан тооцоолол, цахим файл, компьютерын программ болон бусад программ хангамж, зураг, гарын авлага, загвар, техникийн шаардлага болон техникийн шинжтэй бусад баримт бичгийг хэлнэ.
		“Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж” гэж Ажил гүйцэтгэхэд шаардагдах Гүйцэтгэгчийн бүх төрлийн багаж, тоног төхөөрөмж, машин механизм, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл болон бусад хэрэгслийг хэлнэ. Түр ажилд зориулсан Тоног төхөөрөмж, Барилгын үндсэн ажлыг бүрдүүлэх буюу барилгын бүрдэлд орж суурилагдах үндсэн техник хэрэгсэл, материал болон бусад хэрэгслүүд нь Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжид хамаарахгүй.
		“Гүйцэтгэгчийн ажилтан” Гүйцэтгэгчийн төлөөлөгч, мөн Ажлын талбай болон Ажил явагдах бусад газруудад ажиллах нийт ажилтанг ойлгоно. Үүнд Гүйцэтгэгчийн болон Туслан Гүйцэтгэгч нарын мэргэжлийн болон туслах ажилтнууд, бусад ажилтан, мөн Ажил гүйцэтгэх явцад Гүйцэтгэгчид тусламж үйлчилгээ үзүүлэх аливаа бусад ажилтнууд багтана.
		“**Гүйцэтгэгчийн төлөөлөгч**” гэж Гэрээнд Гүйцэтгэгчээс нэр заан оруулсан, эсхүл 4.3 [Гүйцэтгэгчийн төлөөлөгч]-ийн дагуу Гүйцэтгэгчийн томилсон, Гүйцэтгэгчийг төлөөлж ажиллах хувь хүнийг хэлнэ.
		“Зардал” гэж Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ажлын талбай болон талбайн гадна Гүйцэтгэгчийн

		бодитоор зарцуулсан (зарцуулахаар тооцсон) татвар, нэмэлт зардал болон бусад төлбөр хураамж, ашиг ороогүй бүх зардлыг хэлнэ. Гүйцэтгэгч нь Гэрээний нөхцлийн холбогдох хэсгийн дагуу зардлыг төлбөрт тооцуулах эрхтэй тохиололд Гэрээний үнэ дээр нэмж тооцно.
		“Ашиг шингэсэн үнэ” гэж Гэрээний өгөгдөлд заасан (хэрэв заагаагүй бол таван (5%)) тодорхой хувийг зардал дээр нэмсэн дүнг хэлнэ. Гүйцэтгэгч нь энэхүү Гэрээний нөхцлийн дагуу нэмүү шингэсэн үнэ тооцуулах эрхтэй тохиолдолд энд дурдсан ашгийн хувийг зөвхөн зардал дээр нэмэх ба Гэрээний үнэ дээр нэмж тооцно.
		“**Тухайн Улс**” гэж үндсэн ажлыг гүйцэтгэх ажлын талбай (эсхүл түүний ихэнхи хэсэг) байрлах улсыг хэлнэ.
		“Маргаанаас зайлсхийх, шийдвэрлэх зөвлөл” гэж Гэрээнд МЗШЗ гэж нэрлэгдсэн, эсхүл 21.1 [МЗШЗ байгуулах], 21.2 [МЗЗЗ-н гишүүний (гишүүдийн) томилгоо амжилтгүй болох] хэсгийн дагуу томилогдсон нэг гишүүн эсхүл гурван гишүүн (тухайн нөхцөл байдлаас хамаарч) бүхий зөвлөлийг хэлнэ.
		“**МЗШЗ-ийн гэрээ**” гэж Гэрээний ерөнхий нөхцлийн Хавсралтад заасан “Маргаанаас зайлсхийх, шийдвэрлэх зөвлөлтэй байгуулах гэрээний ерөнхий нөхцөл”–г удирдлага болгож Гэрээний талууд болон МЗШЗ-н гишүүд гарын үсэг зурсан эсхүл зурагдсан гэх үзэх хэлцэлийг хэлнэ.
		“**Ажил дуусах огноо**” гэж Захиалагчийн олгосон “Ажил хүлээн авах гэрчилгээ” –нд заасан огноог; эсхүл 10.1 [Ажлыг бүхэлд нь эсхүл бүрдэл хэсгийг хүлээн авах]-ийн сүүлийн өгүүлбэрт заасан нөхцөл хангагдаж Ажлыг бүхэлд нь эсхүл ажлын бүрдэл хэсэг нь Гэрээний дагуу дууссан гэж тооцсон огноог; эсхүл 10.2 [Ажлын бүрэлдэхүүн хэсгийг хүлээн авах]-д заасны дагуу ажлыг бүрэлдэхүүн хэсгээр нь хүлээн авахаар зөвшөөрсөн тохиолдолд Захиалагч ажлыг бүрэлдэхүүн хэсгээр нь хүлээн авсан эсхүл ашиглаж эхэлсэн огноог тус тус хэлнэ.
		“**хоног**” гэж хуанлийн 1 /нэг/ хоногийг хэлнэ.
		“**Өдрөөр тооцох төлбөрийн хуваарь**” гэж гэрээний 13.5 [Өдрөөр тооцох төлбөр]-ийн дагуу тус ажилд зарцуулсан ажиллах хүчин, материал болон тоног төхөөрөмжтэй холбоотой Гүйцэтгэгчид төлөх төлбөрийн дүн болон төлбөр тооцох аргачлалыг харуулсан баримт бичгийг хэлнэ.
		“**Доголдол мэдэгдэх хугацаа**” буюу “ДМХ” гэж Ажлыг бүхэлд нь эсхүл бүрдэл эсхүл бүрэлдэхүүн хэсгээр нь хүлээн авсан ажилд гарсан доголдол болон эвдрэл гэмтлийн талаар мэдэгдэл хүргүүлэх Гэрээний өгөгдөл хэсэгт заасан (хэрэв заагаагүй бол 1 жилээр

		тооцох) хугацааг хэлнэ. Энэхүү хугацааг 11.3 [Доголдол мэдэгдэх хугацааг сунгах]-ийн дагуу сунгаж болох бөгөөд Ажлыг бүхэлд нь эсхүл бүрдэл эсхүл бүрэлдэхүүн хэсэг байдлаар хүлээн авсан “Ажил дуусах огноо”-оос эхлэн тоолно.
		“**Алданги**” гэж Гүйцэтгэгч нь 8.2 [Ажил дуусах огноо]-д заасан хугацаанд Ажлыг гүйцэтгээгүй тохиолдолд 8.8 [Алданги]-д заасны дагуу төлөх төлбөрийг хэлнэ.
		“Маргаан” гэж дор дурдсан нөхцөл байдлыг хэлнэ. талуудын аль нэг нь нөгөө талын эсрэг шаардлага гаргасан (үүнд: энэхүү Гэрээний нөхцөлд тодорхойлсон шаардлага гаргах, эсхүл Гэрээний нөхцөлийн дагуу Захиалагчийн төлөөлөгч шийдвэрлэх шаардлагатай асуудал гэх мэт) b) нөгөө тал нь (эсхүл Захиалагч нь 3.5.2 [Захиалагчийн төлөөлөгчийн шийдвэр] дахь хэсгийн дагуу) шаардлагыг бүхэлд нь эсхүл түүний зарим хэсгийг эсэргүүцсэн, мөн шаардлага гаргасан тал нь эсэргүүцлийг хүлээн зөвшөөрөөгүй (3.5.5 [Захиалагчийн төлөөлөгчийн шийдвэрийг үл зөвшөөрөх] хэсгийн дагуу Үл зөвшөөрөх мэдэгдэл хүргүүлэх замаар). Хэрэв нөгөө тал нь шаардлагыг няцааж чадаагүй эсхүл шаардлагатай хариуг өгч чадаагүй байсан хэдий ч маргааныг шийдвэрлэж байгаа МЗШЗ эсхүл арбитр нь нөхцөл байдлаас шалтгаалж татгалзал болон хариу тайлбарыг ирүүлсэнд тооцож маргааныг шийдвэрлэж болно.
		“Захиалагч” гэж Гэрээний хэлэлцээрт Захиалагч гэж тодорхойлсон болон түүний хууль ёсны эрх залгамжлагчийг хэлнэ.
		“**Захиалагчийн тоног төхөөрөмж**” гэж 2.6 [Захиалагчийн нийлүүлэх материал болон Захиалагчийн тоног төхөөрөмж]-д заасан Захиалагчаас Гүйцэтгэгчид ашиглуулах боломжтой багаж, тоног төхөөрөмж, машин механизм, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг (хэрэв байгаа бол) хэлэх ба үүнд 10 [Захиалагч ажил хүлээн авах] дугаар зүйлд заасны дагуу хүлээлгэж өгөөгүй байгаа Үндсэн техник хэрэгсэл орохгүй.
		“**Захиалагчийн ажилтан**” гэж Захиалагчийн төлөөлөгч, 3.2 [Захиалагчийн бусад ажилтан]-д заасан туслах ажилтан, Гэрээний дагуу Захиалагч үүргээ гүйцэтгэхтэй холбоотой ажиллах Захиалагчийн бусад бүх ажилтан, Гүйцэтгэгчид хүргүүлсэн

		Мэдэгдэлд “Захиалагчийн ажилтан” гэж тодорхойлсон аливаа этгээдийг хэлнэ.
		“Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээний өгөгдөл хэсэгт Захиалагчийн томилсон этгээд, эсхүл 3.1 [Захиалагчийн төлөөлөгч]-ын дагуу шинээр томилогдсон этгээдийг хэлнэ.
		“Захиалагчийн шаардлага” гэж Гэрээнд Захиалагчийн шаардлага гэж заасан баримт бичгийг түүнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлтийн хамт ойлгоно. Энэхүү баримт бичиг нь Ажлын зорилго, хамрах хүрээ, Түлхүүр ажилтан, зураг төсөл, Ажилд хэрэглэх бусад техникийн болон үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг тусгасан баримт бичиг байна.
		“**Захиалагчийн нийлүүлэх материал**” гэж 2.6 [Захиалагчийн нийлүүлэх материал болон Захиалагчийн тоног төхөөрөмж] хэсэгт заасан Захиалагчаас Гүйцэтгэгчид нийлүүлэх (хэрэв шаардлагатай бол) материалыг хэлнэ.
		“Онцгой нөхцөл байдал” гэж 18.1 [Онцгой нөхцөл байдал]-д тодорхойлсон үйл явдал эсхүл нөхцөл байдлыг хэлнэ.
		“**Хугацаа сунгах” буюу “ХС**” гэж 8.5 [Ажил дуусах хугацааг сунгах]-д заасны дагуу хийгдсэн Ажил дуусах хугацааг сунгах утгыг агуулна.
		“ФИДИК” гэж Federation Internationale des ingenieurs-Conseils буюу Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн Холбоог хэлнэ.
		“Эцсийн төлбөр нэхэмжлэх” гэж 14.11.2 [Баталгаажсан эцсийн төлбөрийн нэхэмжлэх]-д тодорхойлсон нэхэмжлэхийг хэлнэ.
		“Гадаадын мөнгөн тэмдэгт” гэж Гэрээний нийт үнийг эсхүл хэсэгчлэн төлөх мөнгөн тэмдэгтийг хэлэх ба энэ нь тухайн улсын дотоодын мөнгөн тэмдэгт биш байна.
		“Ерөнхий нөхцөл” гэж ФИДИК-ээс гаргасан “EPC/Түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээний нөхцөл” хэмээх энэхүү баримт бичгийг хэлнэ.
		“Бараа” гэж Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж, материал, үндсэн техник хэрэгсэл болон түр ажил, эсхүл эдгээрийн аль тохирохыг хэлнэ.

		“**Түншлэл**” гэж түншлэл, ассоциаци, консорциум эсхүл хоёр болон түүнээс дээш этгээдийн хувь нийлүүлээгүй нөхөрлөлийн түншлэлийн болон бусад хэлбэрийг хэлнэ.
		“**Түншлэлийн гэрээ**” гэж Түншлэл болж Гүйцэтгэгчээр оролцож байгаа хоёр болон түүнээс дээш этгээдүүдийн хооронд байгуулсан, түншлэлийн гишүүдийн хууль зүйн үүргийг тусган Захиалагчид ирүүлсэн тендерийн баримт бичгийг хэлнэ. Энэхүү баримт бичигт Түншлэлийн гишүүн тус бүр гарын үсэг зурж, Захиалагчид хаяглан дараах зүйлсийг тусган ирүүлнэ. Үүнд: үншлэлийн гишүүн тус бүр нь Гүйцэтгэгчийн Гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлттэй холбоотойгоор Захиалагчийн өмнө хамтын болон дангаараа хүлээх үүрэг хариуцлага; үншлэлийн ахлагчийг тодорхойлж бүрэн эрхийг олгосон байдал; үншлэлийн гишүүн тус бүрийн хийж гүйцэтгэх Ажлын болон хэсэгчилсэн ажлын цар хүрээг (хэрэв шаардлагатай бол) тодорхойлсон байдал.
		“Түлхүүр ажилтан” гэж Техникийн шаардлагад заасан Гүйцэтгэгчийн Төлөөлөгчөөс бусад Гүйцэтгэгчийн ажилтныг (хэрэв шаардлагатай бол) хэлнэ.
		“**Хууль тогтоомж**” гэж тухайн улс орны (эсхүл бүс нутгийн) бүхий л хууль тогтоомж, дүрэм, журам, хууль эрхийн акт, зарлиг, тушаал, захирамж, олон улсын гэрээ хэлэлцээр, олон улсын хууль тогтоомжууд болон бусад хууль, гэрээ, аливаа төр, захиргааны байгууллага, агентлагууд болон төрийн эрх бүхий байгууллагын гаргасан дүрэм журмыг хэлнэ.
		“Дотоод мөнгөн тэмдэгт” гэж тухайн Улсын мөнгөн тэмдэгтийг хэлнэ.
		“Материал” гэж Гүйцэтгэгчээс ажлын талбай эсхүл бусад газарт хүлээлгэн өгөхөөр тохиролцсон үндсэн ажлыг бүрдүүлж буй (үндсэн техник хэрэгслээс бусад) бүхий л эд зүйлсийг хэлнэ. Үүнд Гэрээнд заасны дагуу нийлүүлэхээр тохиролцсон угсралт суурилуулалтад хамрагдахгүй бусад материал (хэрэв шаардлагатай бол) багтана.
		“Сар” гэж хуанлийн сарыг (Григорианы календарийн дагуу) хэлнэ.
		“**Зөвшөөрсөн мэдэгдэл**” гэж Гүйцэтгэгчийн баримт бичиг эсхүл энэхүү Гэрээний Нөхцөлийн дагуу

		Гүйцэтгэгчээс ирүүлсэн бусад баримт бичгүүдэд Захиалагчийн өгсөн татгалзах зүйлгүй гэсэн мэдэгдэл бөгөөд энэхүү Гүйцэтгэгчийн баримт бичиг болон ирүүлсэн баримт бичгийг Ажил гүйцэтгэхэд ашиглаж болно.
		"**Мэдэгдэл**" гэж 1.3 [Мэдэгдэл болон Бусад харилцаа]-д заасны дагуу гарсан, Мэдэгдэл гэж тодорхойлсон аливаа бичгэн харилцааг хэлнэ.
		"**Татгалзсан мэдэгдэл**" гэж гэрээний аль нэг тал 3.5 [Хэлэлцээр эсхүл Шийдвэр]-д заасан Захиалагчийн төлөөлөгчийн шийдвэр, эсхүл 21.4 [МЗШЗ-ийн шийдвэр гаргуулах]-д заасан МЗШЗ-ийн шийдвэрийг зөвшөөрөхгүй тохиолдолд нөгөө талдаа хүргүүлж болох Мэдэгдлийг хэлнэ.
		"**Тусгай нөхцөл**" гэж Гэрээний тусгай нөхцөл гэж нэрлэгдэн гэрээнд орсон баримт бичгийг хэлэх бөгөөд тус нөхцөл нь А хэсэг - Гэрээний өгөгдөл, Б хэсэг – Тусгай заалтууд гэсэн хэсгээс бүрдэнэ.
		"**Тал**" гэж тухайн нөхцөл байдлаас хамаарч Захиалагч эсхүл Гүйцэтгэгчийг хэлнэ. **Талууд** гэж Захиалагч болон Гүйцэтгэгчийг хамтад нь хэлнэ.
		"**Гүйцэтгэлийн гэрчилгээ**" гэж 11.9 [Гүйцэтгэлийн гэрчилгээ]-д заасны дагуу Захиалагчаас олгосон (эсхүл олгосон гэж тооцох) гэрчилгээг хэлнэ.
		"Чанарын үзүүлэлтэд нийцээгүйн торгууль" гэж Ажлын гүйцэтгэл, үндсэн техник хэрэгсэл болон ажлын бүрэлдэхүүн (нөхцөл байдлаас шалтгаалан) нь Чанарын үзүүлэлтийг хангаагүй тохиололд Гүйцэтгэгч нь Захиалагчид төлөх хохирлыг хэлнэ.
		"Гүйцэтгэлийн баталгаа" гэж 4.2 [Гүйцэтгэлийн баталгаа]-ын дагуу гаргасан баталгааг хэлнэ.
		"Үндсэн ажил" гэж Гэрээний дагуу Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэх үндсэн шинж чанартай ажлыг хэлнэ.
		"**Үндсэн техник хэрэгсэл**" гэж үндсэн ажлын нэг хэсэг болж ажлын талбай эсхүл Гэрээгээр тохирсон бусад газарт үлдэх багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, машин механизм болон тээврийн хэрэгсэл (бүрдүүлбэрийн хамт)-ийг хэлнэ.
		"**Ажлын календарчилсан төлөвлөгөө**" гэж 8.3 [Ажлын календарчилсан төлөвлөгөө]-д заасны дагуу Гүйцэтгэгчээс Захиалагчаар батлуулахаар ирүүлсэн бөгөөд Захиалагч зөвшөөрсөн (эсхүл өгсөнд тооцож болох) цаг хугацааны нарийвчилан төлөвлөгөөг хэлнэ.
		"**Нөөц хөрөнгө**" гэж 13.4 [Нөөц хөрөнгө]-д заасны дагуу Ажлын аль ч хэсгийг гүйцэтгэх, эсхүл Үндсэн

		техник хэрэгсэл, материал эсхүл ажил үйлчилгээг ханган нийлүүлэхэд зориулан Захиалагчаас тогтоож Гэрээнд тусгасан дүнг хэлнэ.
		“**Чанарын удирдлагын тогтолцоо**” гэж 4.9.1 [Чанарын удирдлагын тогтолцоо]-д заасны дагуу боловсруулсан Гүйцэтгэгчийн чанарын удирдлагын тогтолцоо (тухай бүр шинэчлэгдэж эсхүл нэмэлт өөрчлөлт орсон)-г хэлнэ.
		“**Суутган барих мөнгөн дүн**” гэж Захиалагч 14.3 [Явц дундын төлбөрийн хүсэлт]-д заасны явц дундын төлбөр бүрээс суутган хуримтлуулж 14.9 [Суутган барих мөнгөн дүнг чөлөөлөх]-ийн дагуу төлөх төлбөрийг хэлнэ.
		“Баримт бичгийн хяналт” гэж Гүйцэтгэгчийн зүгээс гаргаж гаргаж өгсөн баримт бичиг нь Гэрээ болон гэрээгээр хүлээсэн Гүйцэтгэгчийн үүрэгтэй нийцэж байгаа эсэхэд өгч буй Захиалагчийн үнэлэлт, дүгнэлтийг хэлнэ.
		“Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө” гэж Тендерийн баримт бичгийн хавсралт байдлаар Захиалагчаас өгсөн маягтын дагуу Гүйцэтгэгчийн боловсруулж ирүүлсэн, Гэрээний бүрдэл хэсэг болсон баримт бичгийг хэлнэ. Энэхүү баримт бичигт дата, төлбөрийн жагсаалт болон хуваарь, ханш болон үнэ, баталгаа орж болно.
		“**Төлбөрийн хуваарь**” гэж төлбөрийн хуваарь (хэрэв шаардлагатай бол) гэх нэрээр Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөний нэг хэсэг болсон Гүйцэтгэгчид төлөх төлбөрийн дүн болон төлбөр төлөх аргыг харуулсан баримт бичгийг хэлнэ.
		“Чанарын үзүүлэлт” гэж Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөний нэг хэсэг болсон Чанарын үзүүлэлт (хэрэв шаардлагатай бол) нь Ажлын гүйцэтгэл, үндсэн техник хэрэгсэл болон хэсэгчилсэн ажил (нөхцөл байдлаас шалтгаалан) нь Захиалагчийн тавьсан шаардлагыг баталгаатай хангаж байгаа болохыг харуулсан баримт бичиг болно. Ажлын гүйцэтгэл, үндсэн техник хэрэгсэл болон хэсэгчилсэн ажил нь гүйцэтгэлийн чанартаа хүрээгүй тохиололд гүйцэтгэгч хохирол төлөх үндэслэл болно.
		“Үнийн задаргаа” гэж Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөний нэг хэсэг болсон Төлбөрийн задаргаа (хэрэв шаардлагатай бол) гэж нэрлэгдсэн баримт бичгийг хэлнэ.

		“Ажлын бүрдэл хэсэг” гэж Гэрээний өгөгдөлд Ажлын бүрдэл хэсэг (хэрэв шаардлагатай бол) хэмээн онцгойлон тодорхойлсон хэсэг ажлыг хэлнэ.
		“Ажлын талбай” гэж үндсэн ажлыг хийж гүйцэтгэх үндсэн техник хэрэгсэл болон бараа материал хүргэх газрыг ойлгохоос гадна Ажлын талбайн бүрдэлдэхүүн байдлаар Гэрээнд заасан бусад газрыг хэлнэ.
		“Тусгай зохицуулалт” гэж Тусгай нөхцөлийн Б хэсгийг бүрдүүлж байгаа Тусгай зохицуулалт хэмээн нэрлэгдсэн баримт бичгийг (хэрэв шаардлагатай бол) хэлнэ.
		“**Төлбөрийн нэхэмжлэл**” гэж 14.3 [Явц дундын төлбөрийн хүсэлт], 14.10 [Ажлыг бүрэн хийж дуусмагц өгөх төлбөрийн нэхэмжлэл], эсхүл 14.11 [Эцсийн төлбөрийн нэхэмжлэл]-д тус тус заасны дагуу Төлбөрийн хүсэлтийн бүрдэл хэсэг болгон Гүйцэтгэгчээс хүргүүлсэн нэхэмжлэлийг хэлнэ.
		“**Туслан гүйцэтгэгч**” гэж Гэрээнд туслан гүйцэтгэгч гэж нэр заагдсан этгээд, эсхүл Ажлын бүрдэл хэсгийг гүйцэтгүүлэхээр Гүйцэтгэгчийн томилсон туслан гүйцэтгэгч эсхүл зураг төсөл зохиогч этгээд, мөн тэдгээрийн хууль ёсны эрх залгамжлагч нарыг хэлнэ.
		“**Ажил хүлээн авсан гэрчилгээ**” гэж 10 [Захиалагч ажил хүлээн авах] дахь заалтын дагуу Захиалагчийн олгосон (эсхүл олгосонд тооцох) гэрчилгээг хэлнэ.
		“**Түр ажил**” гэж Ажлын талбайд Ажил гүйцэтгэхэд шаардагдах (Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжөөс бусад) бүх төрлийн түр ажлыг хэлнэ.
		“Тендер” гэж Гүйцэтгэгчээс гарын үсэг зурж ирүүлсэн Түншлэлийн гэрээ (хэрэв байгаа бол), Гүйцэтгэгчийн тендерт хавсаргасан бусад баримт бичиг (Гэрээний нөхцөл, Захиалагчийн шаардлага, төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөнөөс бусад) бүхий саналыг хэлэх бөгөөд энэ нь гэрээний салшгүй нэг хэсэг болно.
		“Зүгшрүүлэлт, тохируулга” гэж 10 [Ажил хүлээн авах] дугаар зүйлийн дагуу Ажлыг бүхэлд нь эсхүл бүрдэл хэсгээр (тухайн нөхцөл байдлаас хамаарч) нь хүлээн авсны дараа Захиалагчийн шаардлагад тусгасан, Тусгай зохицуулалтын дагуу хийгдэх туршилтыг (хэрэв шаардлагатай бол) хэлнэ.
		“Хяналт, Туршилт” гэж Гэрээний 10 [Ажил хүлээн авах] дугаар зүйлд заасны дагуу Ажлыг бүхэлд нь

		эсхүл хэсэгчлэн хүлээн авахаас өмнө (нөхцөл байдлаас хамаарч) Гэрээнд заасан, Талууд шинээр тохиролцсон, эсхүл ажилд өөрчлөлт оруулах замаар тусгагдсан Гэрээний 9 [Хяналт, туршилт] дүгээр зүйлийн дагуу гүйцэтгэх туршилтыг хэлнэ.
		“Ажил дуусах хугацаа” гэж Ажил эхлэх огнооноос эхлэн 8.2 [Ажил дуусах хугацаа]-д заасан Ажлыг бүхэлд нь эсхүл хэсэгчилсэн (тухайн нөхцөл байдлаас хамаарч) байдлаар дуусгахад зарцуулах Гэрээний өгөгдөлд заасан хугацааг хэлэх бөгөөд тус хугацааг 8.5 [Ажил дуусгах хугацааг сунгах]-ийн дагуу сунгаж болно.
		“Урьдчилан мэдэх боломжгүй нөхцөл” гэж туршлагатай гүйцэтгэгч Суурь огнооны өдөр урьдчилан мэдэх боломжгүй байсан нөхцөлийг хэлнэ.
		“Ажлын өөрчлөлт” гэж 13 [Ажлын өөрчлөлт болон үнийн тохируулга]-д заасны дагуу хийх Ажилд оруулсан аливаа өөрчлөлтийг хэлнэ.
		“Ажил” гэж Үндсэн болон Түр ажил эсхүл эдгээрийн аль тохирохыг хэлнэ.
		“Жил” гэж 365 хоногийг хэлнэ.
1.2 Үг хэллэгийн тайлбар		Гэрээнд өөр утга илэрхийлснээс бусад тохиолдод дор дурьдсан утгаар ойлгоно. эг хүйсийг илэрхийлсэн биеийн төлөөний үг нь бүх хүйсийг илэрхийлнэ; анц тоо нь олон тоог, олон тоо нь ганц тоог илэрхийлнэ; зөвшөөрөх”, “зөвшөөрсөн” эсхүл “зөвшилцөл” гэсэн үгсийг агуулсан зохицуулалт нь бичгээр үйлдэгдсэн байхыг шаардана; бичмэл” эсхүл “бичгээр” гэдэг нь гараар бичсэн, бичгийн машинаар үйлдэгдсэн, хэвлэсэн эсвэл цахим хэлбэрээр боловсруулсан байнга хадгалагдах баримт бичиг; болно” гэж Гэрээний аль нэг тал болон аливаа этгээд тодорхой үйлдэл хийх эсхүл хийхгүй байх эрхтэй болохыг илэрхийлнэ; үүрэгтэй” гэж Гэрээний аль нэг тал болон

		аливаа этгээд нь гэрээгээр тодорхой үүрэг хүлээсэн болохыг илэрхийлнэ. зөвшөөрөл” гэж Захиалагч эсхүл Гүйцэтгэгч нь нөгөө талын хүсэлтийг хүлээн зөвшөөрөх эсхүл зөвшөөрөл олгохыг илэрхийлнэ; агуулсан”, “агуулах”, “багтсан” гэдэг нь дор дурьдсан зүйлсээр хязгаарлагдахгүй эсвэл тэдгээр зүйлсээр тодорхойлогдохгүй гэсэн утгыг илэрхийлнэ; тгээд эсвэл талуудыг илэрхийлсэн үг нь хувь хүн, хуулийн этгээдийг илэрхийлнэ. Ажлыг гүйцэтгэх” эсхүл “Ажлын гүйцэтгэл” нь зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх, дуусгах, аливаа доголдлыг арилгах утгыг илэрхийлнэ. Хэрэв гэрээний нөхцөлд тоочиж бичсэн бөгөөд тэдгээрийн хооронд “ба”, “эсхүл”, “мөн”, “болон/эсхүл” гэсэн үгс орсон бол тоочиж бичсэн бүх зүйлс нь түүний өмнөх зүйлтэй хамт уншигдана. Гэрээний нөхцлийг тайлбарлахад гарчиг болон зүйлийн нэрийг харгалзан үзэхгүй.
1.3 Мэдэгдэл болон бусад харилцаа		Гэрээний нөхцөлд заасны дагуу Мэдэгдэл (Татгалзсан мэдэгдэл мөн багтана) хүргүүлэх болон харилцааны бусад хэлбэр (хүлээн авсан тухай мэдэгдэл, хүлээн зөвшөөрөх, зөвлөмж, зөвшилцөл, баталгаажуулалт, гэрчилгээ, Шаардлага, зөвшөөрөл, шийдвэр, шийдэл, үүргээс чөлөөлсөн мэдэгдэл, зааварчилгаа, Зөвшөөрсөн мэдэгдэл, хурлын тэмдэглэл, зөвшөөрөл, санал, бүртгэл, хариу, тайлан, хүсэлт, Баримт бичгийн хяналт, Төлбөрийн нэхэмжлэл г.м)-ээр баримт бичгийг олгох, хангах, илгээх, хүргүүлэх, цахим хэлбэрээр явуулахдаа бичгэн хэлбэртэй байх бөгөөд (a) Дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: i. Цаасан эх хувь нь Гүйцэтгэгчийн төлөөлөгч эсхүл Захиалагчийн төлөөлөгчийн гарын үсгээр баталгаажсан байна; ii. Гэрээний өгөгдөлд заасан цахим системийг ашиглаж цахим эх хувийг дамжуулахдаа талуудын төлөөлөгчийн албан ёсны цахим хаягыг ашиглах бөгөөд Гэрээний

		нөхцөлд заасан тохиолдолд дээрх хоёр хэлбэрийг хамтад нь ашиглана. (b) Хэрэв Мэдэгдэл хүргүүлж байгаа бол “Мэдэгдэл” гэж заавал тодорхойлох бөгөөд харилцааны бусад хэлбэрт хамаарах тохиолдолд Гэрээний холбогдох заалтыг дурдаж харилцааны аль хэлбэрт хамаарах болохыг тодорхойлон заана. (c) Биечлэн хүргэж өгөх (хүлээн авсан баримтын дагуу), эсхүл шуудан, илгээмжээр илгээх (хүлээн авсан баримтын дагуу), эсхүл энэ зүйлийн (a)(ii) хэсэгт заасны дагуу цахим системийг ашиглаж илгээнэ; (d) Гэрээний өгөгдөлд заасан хүлээн авагчийн хаягаар илгээж, хүргэж, дамжуулна. Хэрэв хүлээн авагч нь хаягаа өөрчилсөн тухай мэдэгдлийг ирүүлсэн тохиолдолд тухайн мэдэгдлийг Илгээгч хүлээн авсанаас хойш мэдэгдэл болон харилцааны бусад хэлбэрийн баримт бичгийг шинэчилсэн хаягаар хүргүүлнэ. Энэхүү гэрээний нөхцөлийн дагуу Мэдэгдэл эсхүл Татгалзсан мэдэгдэл болон харилцааны бусад хэлбэрийн баримт бичгийг дээрх (d) хэсэгт заасан хүлээн авагчийн одоогийн хаягаар хүргүүлж, хүлээн авагч нь баримт бичгийг хүлээн авснаар баримт бичгийн үйлчлэл эхэлнэ. Илгээгч нь цахим хэлбэрээр хүргүүлж буй Мэдэгдэл болон харилцааны бусад хэлбэрийн баримт бичиг хүргэгдээгүй тухай мэдэгдэл хүлээн авсанаас бусад тохиолдолд тухайн баримт бичгийг хүргүүлсэний дараах өдрөөс эхлэн хүлээн авсанд тооцно. Дээр дурдсан бүх мэдэгдэл болон харилцааны бусад хэлбэрийг үндэслэлгүйгээр саатуулж, хойшлуулж болохгүй. Хэрэв гэрээний аль нэг тал эсхүл Захиалагчийн төлөөлөгчөөс Мэдэгдэл, Татгалзсан мэдэгдлийг цахим болон цаасан хэлбэрээр зориулсан хүлээн авагчид хүргүүлэхдээ хуулбар хувийг Захиалагчийн төлөөлөгч эсхүл гэрээний нөгөө талд хүргүүлнэ. Харилцааны бусад хэлбэрийн баримт бичгийг Гэрээ болон Гэрээний нөхцлийн дагуу Захиалагчийн төлөөлөгч эсхүл гэрээний талуудад хуулбарлаж хүргүүлнэ.

Хэрэглэгдэх хууль болон хэл		Энэхүү гэрээг тайлбарлаж хэрэглэхдээ Гэрээний өгөгдөл (заагаагүй бол тухайн Улсын хууль тогтоомж)-д заасан улсын хууль тогтоомжийг баримтлах бөгөөд бусад улсын хууль тогтоомжийг баримтлахгүй. Гэрээний албан ёсны хэлийг Гэрээний өгөгдөл (заагаагүй бол Гэрээний нөхцөл бичигдсэн хэл)-д заана. Хэрэв гэрээний зарим хэсэг нэгээс олон хэлээр бичигдсэн тохиолдолд гэрээний албан ёсны хэл дээрх хувилбар нь давуу хүчинтэй байна. Харилцаанд хэрэглэгдэх хэлийг Гэрээний өгөгдөлд заана. Хэрэв харилцааны хэлийг тодорхойлоогүй тохиолдолд Гэрээний албан ёсны хэлийг харилцаандаа ашиглана.
1.5 Баримт бичгийн эрэмбэ дараалал		Гэрээг бүрдүүлж буй баримт бичгүүд нь нэг нэгэнтэйгээ уялдаатай тайлбарлагдана. Хэрэв эдгээр баримт бичгүүдэд ямар нэгэн маргаантай, хоёрдмол утгатай, эсхүл зөрүүтэй зүйл байвал баримт бичгүүдийн давуу байдал нь доорх эрэмбэ дараалын дагуу байна. Үүнд: (а) Гэрээний хэлэлцээр; (б) Тусгай нөхцөлийн А хэсэг- Гэрээний өгөгдөл; (в) Тусгай нөхцөлийн Б хэсэг- Тусгай зохицуулалт; (г) энэхүү Гэрээний Ерөнхий Нөхцөл; (д) Захиалагчийн шаардлага; (е) Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө; (ё) Тендер; (ж) Түншлэлийн гэрээ (байгаа тохиолдолд); (з) Гэрээний бүрдэл хэсэг болох бусад баримт бичгүүд. Хэрэв гэрээний аль нэг тал баримт бичигт хоёрдмол утга, зөрүүтэй зүйл илрүүлсэн тохиололд тэдгээрийг тодорхой дурдсан Мэдэгдлийг нөгөө талдаа яаралтай өгнө. Захиалагч тухайн Мэдэгдлийг хүлээн авсны дараагаар шаардлагатай тодруулга эсхүл зааварчилгааг өгнө.
1.6 Гэрээний хэлэлцээр		Гэрээ нь Гэрээний хэлэлцээрт заасан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Гэрээний хэлэлцээрийг

		байгуулахтай холбогдон хууль тогтоомжид заасны дагуу төлөх тэмдэгтийн хураамж болон бусад зардлыг (хэрэв байгаа бол) Захиалагч хариуцна. Хэрэв Гүйцэтгэгч нь түншлэлийн хэлбэртэй бол түншлэлийн гишүүн тус бүрийн эрх бүхий төлөөлөгч Гэрээний хэлэлцээрт гарын үсэг зурна.
1.7 Эрх шилжүүлэх		Гэрээний аль ч тал гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ бүхэлд нь эсхүл зарим хэсгийг болон гэрээний дагуу олох аливаа давуу байдал, ашиг хүртэх эрхийг бусдад шилжүүлэхгүй. Гэхдээ, аль ч тал: эрээний нөгөө талтай урьдчилан тохиролцсон тохиолдолд зөвхөн тухайн талын шийдвэрээр Гэрээгээр хүлээсэн үүргээ бүхэлд нь эсхүл зарим хэсгийг шилжүүлж болно, эрээний дагуу авах мөнгөн төлбөрийн шаардах эрхээ нөгөө талын урьдчилсан зөвшөөрөлгүйгээр банк болон санхүүгийн байгууллагад шилжүүлж болно.
1.8 Баримт бичгийг хадгалж, хамгаалах хүлээлгэн өгөх		Гүйцэтгэгчийн аливаа баримт бичгүүд нь Захиалагчид хүлээлгэн өгөх хүртэл Гүйцэтгэгчийн хадгалалт, хамгаалалтад байна. Гүйцэтгэгч нь баримт бичиг тус бүрийг цаасан нэг хувь, цахим нэг хувь (Захиалагчийн шаардлагад заасан хэлбэрээр, хэрэв заагаагүй бол Захиалагчийн хүлээн зөвшөөрсөн хэлбэрээр)-ийг, Гэрээний өгөгдөлд заасан тохиолдолд нэмэлт цаасан хувийн хамтаар Захиалагчид хүргүүлнэ. Гүйцэтгэгч нь доор дурдсан баримт бичгүүдийн хуулбарыг ажлын Талбайд байнга хадгална. Үүнд: (а) Гэрээ; (б) 6.10 [Гүйцэтгэгчийн тэмдэглэл] болон 20.2.3 [Зэрэгцээ гаргасан бүртгэл]-д заасан тэмдэглэл; (в) Захиалагчийн шаардлагад тусгагдсан (хэрэв байгаа бол) хэвлэмэл материал; (г) Гүйцэтгэгчийн баримт бичгүүд; (д) Гэрээний дагуу хийгдсэн ажлын өөрчлөлт, Мэдэгдэл болон харилцааны бусад хэлбэрийн баримт бичиг. Захиалагчийн ажилтнууд нь Гүйцэтгэгчтэй өөрөөр тохиролцсоноос бусад тохиолдолд ердийн ажлын цагаар дээрх бичиг баримтуудтай танилцах эрхтэй байна.

		Хэрэв Захиалагч нь Гүйцэтгэгч (Гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс)-ийн боловсруулсан баримт бичгийн алдаа дутагдал, доголдол (техникийн болон бусад хэлбэр)-ын талаар мэдсэн бол нөгөө талдаа тухайн алдаа дутагдал, доголдлыг арилгах талаарх Мэдэгдлийг нэн даруй хүргүүлнэ. Гүйцэтгэгч нь өөрийн зардал, эрсдэлээр тухайн алдаа дутагдал, доголдолыг нэн даруй арилгана.
1.9 Гүйцэтгэгчийн баримт бичгийг Захиалагч ашиглах		Гүйцэтгэгч нь Гүйцэтгэгчийн баримт бичиг болон Гүйцэтгэгчийн (эсхүл түүний нэрийн өмнөөс) боловсруулсан зураг төслийн зохиогчийн болон бусад оюуны өмчийн эрхийг эзэмшинэ. Гүйцэтгэгч нь Гүйцэтгэгчийн баримт бичиг, Зураг төслийг хуулбарлах, ашиглах, тараах, өөрчлөх боломжтой зохиогчийн болон оюуны өмчийн эрхийг Захиалгачид (Гэрээний нөхцөлд гарын үсэг зурснаар) олгосонд тооцно. Уг эрх нь бусдад шилжүүлэх боломжтой байх бөгөөд ямарваа нэгэн төлбөргүй, цуцлах боломжгүй, гуравдагч этгээд ашиглахад хязгаарлалт тавиагүй байна. Энэхүү эрх нь ажлыг гүйцэтгэж дуусгах зорилгын хүрээнд хэрэгжих ба: жлын холбогдох хэсгийн ашиглалтын хугацаа үргэлжилсэнд нь)-ны туршид үйлчилнэ; жлын холбогдох хэсгийг зохих ёсоор эзэмшиж буй этгээдэд Ажлыг дуусгах, ашиглах, арчлах, өөрчлөх, тохируулах, засварлах болон буулгах зорилгоор Гүйцэтгэгчийн баримт бичиг, зураг төслийг хувилах, ашиглах, тараах эрхийг олгоно; үйцэтгэгчийн баримт бичиг болон зураг төсөл нь цахим файл, компьютерын программ болон бусад программ хангамжийн хэлбэрээр байгаа тохиолдолд тэдгээрийг ажлын талбай, Захиалагч, Захиалагчийн төлөөлөгчийн байршил болон гэрээнд заагдсан бусад байршилд байх аливаа компьютерт ашиглах эрхийг олгоно эрээ цуцлах тохиолдолд: 5.2 [Гүйцэтгэгч буруугаас үүдэн гэрээг цуцлах]-ын дагуу Гүйцэтгэгчийн баримт бичиг болон Гүйцэтгэгчийн боловсруулсан зураг төслийг хувилах, ашиглах, тараах эрхийг Захиалагчид олгоно. эрээний 15.5 [Захиалагчийн санаачилгаар гэрээг цуцлах], 16.2

		[Гүйцэтгэгч гэрээг цуцлах], эсхүл 18.5 [Гэрээг сайн дураар цуцлах]-д зааснаар гэрээ цуцлагдсан бол Гүйцэтгэгч нь холбогдох төлбөрийг авсан тохиолдолд Гүйцэтгэгчийн баримт бичгийг Захиалагч хувилах, ашиглах, тараах эрхтэй байна. Захиалагч (түүний нэрийн өмнөөс) Гүйцэтгэгчээс урьдчилж авсан зөвшөөрөлгүйгээр Гүйцэтгэгчийн баримт бичиг болон зураг төслийг дээрхээс бусад зорилгоор гуравдагч этгээдэд ашиглуулах, хувилах, эсхүл дамжуулахыг хориглоно.
1.10 Захиалагчийн баримт бичгийг Гүйцэтгэгч ашиглах		Талуудын хооронд, Захиалагч өөрөө (эсхүл түүний нэрийн өмнөөс) боловсруулсан Захиалагчийн шаардлага болон бусад баримт бичгүүдийн зохиогчийн эрх, мөн түүнчлэн бусад оюуны өмчийн эрхийг Захиалагч өөртөө хадгална. Гүйцэтгэгч нь Гэрээг хэрэгжүүлэх зорилгоор, эдгээр баримт бичгийг өөрийн зардлаар хувилж, ашиглаж мөн дамжуулж болно. Гэрээг хэрэгжүүлэх зорилгод шаардлагатайгаас бусад тохиолдолд, Гүйцэтгэгч нь Захиалагчаас урьдчилан авсан зөвшөөрөлгүйгээр, эдгээр баримт бичгийг (бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн) гуравдагч этгээдэд ашиглуулах, хувилуулах, эсхүл дамжуулах ёсгүй.
Нууцлал		Гүйцэтгэгч нь Гэрээний дагуу үүргээ гүйцэтгэж байгаа эсэхийг шалгах зорилгоор Захиалагч нь үндэслэл бүхий шаардлага тавьж болох бөгөөд энэ тохиолдолд Гүйцэтгэгч нь уг шаардсан нууцлалын зэрэглэлтэй болон бусад мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй. Гүйцэтгэгч нь Гэрээний дагуу хүлээсэн өөрийн үүргээ биелүүлэхэд шаардлагатайгаас бусад тохиолдолд, Гэрээг бүрдүүлж байгаа бүх баримт бичгийг нууц гэж үзэж ёстой. Гүйцэтгэгч нь Захиалагчаас авсан урьдчилан зөвшөөрөлгүйгээр Гэрээний аливаа мэдээллийг техникийн болон арилжааны шинжтэй болон бусад баримт бичигт нийтлэх, нийтлэхийг зөвшөөрөх, задруулахыг хориглоно. Гүйцэтгэгчээс “нууц” гэсэн тэмдэг дарж ирүүлсэн бүхий л мэдээллийг Захиалагч, түүний ажилтан

		нууцална. Захиалагч, түүний ажилтан нь гэрээний 15.2 [Гүйцэтгэгчийн буруугаас үүдэн гэрээг цуцлах]-ын дагуух өөрийн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатайгаас бусад тохиолдолд нууцын тэмдэгтэй ирсэн мэдээллийг гуравдагч этгээдэд задруулах, задруулахыг зөвшөөрөхгүй. Талуудын нууц хадгалах үүрэг дараах тохиолдолд үйлчлэхгүй: (а) нэг талаас хүлээн авахаас өмнө нууц хадгалах үүрэггүйгээр нөгөө тал мэдээллийг эзэмшиж байсан: (б) Гэрээний нөхцлийн зөрчилгүйгээр олон нийтэд ил болсон (в) нууц хадгалалтын үүрэг хариуцлага хүлээхгүй гуравдагч этгээдээс тухайн Тал хуулийн дагуу олж авсан.
1.12 Хууль тогтоомжид нийцүүлэх		Гүйцэтгэгч болон Захиалагч нь Гэрээг биелүүлэхдээ мөрдөж буй бүх хууль, тогтоомжуудыг даган биелүүлэх үүрэгтэй. Захиалагчийн шаардлагад өөрөөр заагаагүй тохиолдолд. (а) Захиалагч нь Үндсэн ажилд шаардлагатай төлөвлөлт, бүсчлэл, эсхүл барилгын болон ижил төстэй зөвшөөрөл, эрх, гэрчилгээ ба/эсхүл баталгааг, түүнчлэн Захиалагчийн зүгээс олж авсан буюу олж авбал зохих талаар Захиалагчийн шаардлагад заасан аливаа бусад зөвшөөрлийг авсан байх (эсхүл авах) ёстой. Алдаа, дутагдал нь доор дурдсан (в) заалтыг даган биелүүлээгүй Гүйцэтгэгчийн буруугаас шалтгаалснаас бусад тохиолдолд, Захиалагч нь тэдгээрийг аваагүйгээс үүдэлтэй аливаа алдаа, эсхүл саатлын үр дагавраас Гүйцэтгэгчийг чөлөөлөх ба хамгаална; (б) Гүйцэтгэгч нь Ажлыг гүйцэтгэхэд холбогдолтой хууль, тогтоомжийн шаардлагын дагуу бүх мэдэгдлийг өгсөн байхын дээр, бүх татвар, төлөөс, хураамжийг төлөх ба бусад бүх зөвшөөрөл, гэрчилгээ, баталгаажуулалтыг авсан байх ёстой. Алдаа, дутагдал нь 2.2 [Дэмжлэг, туслалцаа]-ыг даган биелүүлээгүй тохиолдолд, Гүйцэтгэгч нь үүнийг хийгээгүйтэй холбоотой аливаа алдаа, дутагдлын үр дагавраас Захиалагчийг чөлөөлөх ба хамгаална; (в) Дээр дурдсан (а) заалтын дагуу аливаа нэвтрэх эрх, зөвшөөрөл, гэрчилгээ, эсхүл баталгааг Захиалагчаас авхуулахын тулд Гүйцэтгэгч нь, Захиалагчийн шаардлагад тодорхойлсон, эсхүл Захиалагчид өөр байдлаар үндэслэлтэйгээр шаардагдаж болох тийм туслалцаа, дэмжлэгийг

		болон бүх баримт бичгийг Захиалагчийн шаардлагад заасан хугацааны дотор ханган: түүнчлэн (г) Дээр дурдсан (а) заалтын дагуу Захиалагчийн авсан аливаа нэвтрэх эрх, зөвшөөрөл, гэрчилгээ, эсхүл баталгааг Гүйцэтгэгч мөрдөднө. Хэрэв Гүйцэтгэгч нь дээрх (в) заалтыг даган биелүүлэхдээ, дээр дурдсан (а) заалтын дагуу аливаа нэвтрэх эрх, зөвшөөрөл, гэрчилгээ, эсхүл баталгааг авахдаа Захиалагчийн гаргасан алдаа, эсхүл саатлаас шалтгаалан ямар нэгэн сааталтай тулгарах ба/эсхүл Зардал гаргахад хүрвэл, Гүйцэтгэгч нь 20.2 [Нэмэлт хугацаа ба/эсхүл Төлбөрийн нэхэмжлэл]-ын дагуу хугацаа сунгахын ба/эсхүл Ашиг шингэсэн үнийг төлүүлэх эрхтэй. Хэрэв Захиалагч нь, доор дурдсан заалтуудыг даган биелүүлээгүй Гүйцэтгэгчийн алдаанаас шалтгаалан нэмэлт зардал гаргахад хүрвэл, эдгээр зардлыг 20.2 [Төлбөрийн ба/эсхүл хугацаа сунгах нэхэмжлэл]-ын дагуу Гүйцэтгэгчээр төлүүлэх эрхийг эдэлнэ: ээр дурдсан (в): эсхүл ахиалагч нь 2.2 [Дэмжлэг, туслалцаа]-ыг даган биелүүлэх нөхцөлд дээр дурдсан (б), эсхүл (г).
1.13 Дангаар болон хамтран хүлээх хариуцлага		Хэрэв Гүйцэтгэгч нь түншлэлээр байгуулагдсан бол: эрээгээр хүлээсэн Гүйцэтгэгчийн үүргийг биелүүлэхдээ түншлэлийн гишүүд нь Захиалагчийн өмнө хамтдаа ба тус тусдаа хариуцлага хүлээнэ; үншлэлийн удирдагч нь Гүйцэтгэгч ба Түншлэлийн гишүүн тус бүрийг холбох эрх мэдэлтэй байна; түүнчлэн ишүүдийг, мөн гишүүн тус бүрийн гүйцэтгэх Ажлын бүрдэл хэсэг ба цар хүрээг болон Түншлэлийн хуулийн статусыг Захиалагчийн урьдчилсан зөвшөөрөлгүйгээр (гэхдээ энэхүү зөвшөөрөл нь өөрчлөгдсөн түншлэлийг дээр дурдсан (а) заалтын дагуух аливаа хариуцлагаас чөлөөлөхгүй) өөрчлөхгүй.
1.14 Хариуцлагын хязгаарлалт		Аль ч Тал дор дурдсан зүйл, заалтын дагуу хүлээхээс бусад, ямар нэгэн Ажлыг ашиглах боломжийг алдсаны хохирол, ашгийн алдагдал, аливаа гэрээний хохирол, эсхүл Гэрээг биелүүлэхтэй холбоотойгоор нөгөө Талаас хүлээж болох аливаа шууд бус, эсхүл

		гарцаагүй үүссэн эвдрэл ба хохирлын хариуцлагыг нөгөө Талын өмнө хүлээхгүй: .8 [Хугацаа хэтэрсний/хойшилсны хохирол/Саатлаас үүдэлтэй хохирол]; 3.3.1 [Зааварчилгаагаар ажилд өөрчлөлт оруулах]-ийн (в) заалт; [Захиалагчийн санаачилгаар гэрээг цуцалсны дараах төлбөр]; 6.4 [Гүйцэтгэгч гэрээг цуцалсны дараах төлбөр]; 7.3 [Оюуны болон аж үйлдвэрийн өмчийн эрх]; 7.4 [Гүйцэтгэгчийн нөхөн төлбөр]-ийн нэгдүгээр догол мөрт; ба 7.5 [Захиалагчийн нөхөн төлбөр]. Доор дурдсан зүйл, заалтын дагуу хүлээхээс бусад, Гэрээний дагуу, эсхүл түүнийг биелүүлэхтэй холбоотойгоор Захиалагчийн өмнө хүлээх Гүйцэтгэгчийн нийт хариуцлага нь Гэрээний өгөгдөлд заасан дүнгээс, эсхүл (хэрэв дүнг заагаагүй бол) Гэрээний үнээс хэтрэх ёсгүй: .6 [Захиалагчийн нийлүүлэх материал болон Захиалагчийн тоног төхөөрөмж]; .19 [Түр үйлчилгээ] ; 7.3 [Оюуны болон Аж үйлдвэрийн өмчийн эрх]; 7.4 [Гүйцэтгэгчийн нөхөн төлбөр]-ийн нэгдүгээр догол мөрт. Энэхүү зүйл нь үүргээ зөрчсөн Талын залилан, илт цалгар назгай байдал, хайхрамжгүй хандлага, үүргээ санаатайгаар биелүүлэхгүй байх, эсхүл хөнгөн хуумгай, зүй бус үйлдлийн аливаа тохиолдолд хүлээх хариуцлагыг хязгаарлахгүй.
1.15 Гэрээг цуцлах		Гэрээг зохицуулах Хуульд заасан аливаа заавал биелүүлэх шаардлагыг хангаж, энэхүү Гэрээний нөхцөлийн ямар нэгэн Зүйл, заалтын дагуу Гэрээг цуцлах нь Зүйл, заалтад зааснаас өөр ямар ч төрлийн арга хэмжээ авахыг, аль ч Талаас шаардахгүй.

2. ЗАХИАЛАГЧ		
2.1 **Ажлын талбайд нэвтрэх эрх**		Захиалагч нь Гэрээний өгөгдөлд заасан хугацаанд Гүйцэтгэгчид Ажлын талбайг бүхэлд нь хүлээлгэж өгөх ба нэвтрэх эрхийг олгоно. Энэхүү Гүйцэтгэгчид хүлээлгэж өгсөн Ажлын талбай болон нэвтрэх эрх нь зөвхөн Гүйцэтгэгчид олгогдоогүй болно.

		Гэрээний дагуу Захиалагч Гүйцэтгэгчид барилгын суурь, бүтээц, үндсэн техник хэрэгсэл, нэвтрэх эрхийг олгох тохиолдолд Захиалагчийн шаардлагад заасан хугацаа болон аргачлалын дагуу олгоно. Захиалагч нь Гүйцэтгэлийн баталгааг хүлээн авах хүртэл дээрх эрхийг олгохгүй байж болно. Хэрэв Гэрээний өгөгдөлд хугацаа заагаагүй тохиолдолд Захиалагч нь Ажлын талбайд нэвтрэх эрх болон Ажлын талбайг Ажил эхлэх огноонд Гүйцэтгэгчид олгоно. Хэрэв Захиалагч нь заасан хугацаанд дээрх эрхийг олгоогүйн улмаас Гүйцэтгэгчид хугацааны хоцролт, нэмэлт зардал гарсан бол Гүйцэтгэгч нь 20.2 [*Нэмэлт хугацаа болон төлбөрийн талаарх шаардлага*]-д заасны дагуу хугацаа сунгах, Ашиг шингэсэн үнийг шаардах эрхтэй. Хэрэв Захиалагчийн үүргийн зөрчил нь Гүйцэтгэгчийн баримт бичгийг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл түүнд гарсан алдаа дутагдал зэрэг Гүйцэтгэгчийн буруугаас шалтгаалсан тохиолдолд Гүйцэтгэгч нь шаардах эрхээ алдана. Гэрээгээр Захиалагч нь Гүйцэтгэгчийн баримт бичгийн дагуу барилгын суурь, бүтээц, үндсэн техник хэрэгсэл, нэвтрэх эрхийг олгох тохиолдолд Гүйцэтгэгч нь Захиалагчийн шаардлагад заасан хугацаа болон аргачлалын дагуу Гүйцэтгэгчийн баримт бичгийг гаргаж өгнө.
2.2. **Дэмжлэг, туслалцаа**		Гүйцэтгэгч хүсэлт гаргасан тохиолдолд Захиалагч нь Гүйцэтгэгчийн хүсэлтийн дагуу дараах дэмжлэг туслалцааг нэн даруй үзүүлнэ. a) Нийтэд нээлтэй биш байгаа холбогдох хууль тогтоомж; b) Холбогдох хууль тогтоомжид заасан зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, лиценз (эдгээрийг авахад шаардлагатай мэдээлэл): Үүнд: (i) 1.12 *[Хууль тогтоомжид нийцүүлэх]*-д заасны дагуу Гүйцэтгэгч авах шаардлагатай, (ii) Бараа материалын тээвэрлэлтэд шаардлагатай гаалийн бүрдүүлэлт г.м; (iii) Ажлын талбайг чөлөөлж Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг улсын хилээр гарагдах шаардлагатай.

2.3 **Захиалагчийн ажилтан болон бусад Гүйцэтгэгчид**		Ажлын талбайд болон түүний ойр орчимд байгаа Захиалагчийн ажилтнууд болон бусад Гүйцэтгэгч нар нь доор дурдсан үүргийг биелүүлж байгаа эсэхэд Захиалагч хяналт тавина. Үүнд: a) Гэрээний 4.6 *[Хамтын ажиллагаа]*-д заасны дагуу Гүйцэтгэгчтэй хамтран ажиллаж буй эсэх; b) 4.8 *[Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар хүлээх үүрэг]*-ийн (a)-аас (e) хүртэлх заалт болон 4.18 *[Байгаль орчныг хамгаалах]*-д заасны дагуу Гүйцэтгэгчтэй адил үүргийг хүлээн биелүүлж байгаа эсэхэд Захиалагчийн ажилтан эсхүл Захиалагчийн бусад Гүйцэтгэгч (хэрэв байгаа бол) нь авилга, хээл хахууль, залилан мэхлэх, хуйвалдах, дарамт шахалт үзүүлсэн нь баримтаар нотлогдсон тохиолдолд тэдгээр этгээдийг ажлыг талбайгаас гаргахыг Гүйцэтгэгч шаардах эрхтэй.
2.4 Захиалагчийн санхүүжилт		Төслийн санхүүжилтийн талаар Захиалагчийн хүлээх үүргийг Гэрээний өгөгдөлд дэлгэрэнгүй тусгана. Хэрэв Захиалагч нь Санхүүжилтдээ томоохон хэмжээний өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн эсхүл түүний санхүүгийн нөхцөл байдалд өөрчлөлт орсоны улмаас Санхүүжилтээ өөрчлөх (Захиалагчаас тогтоосон хугацаанд төлөх ёстой үлдэгдэл төлбөрийг төлөх Захиалагчийн чадавхид нөлөөлөхөөр) болсон бол дэлгэрэнгүй мэдээлэл бүхий мэдэгдлийг Гүйцэтгэгчид нэн даруй хүргүүлнэ. Хэрэв Гүйцэтгэгч нь: (a) Гэрээний хэлэлцээрт заасан Гэрээний үнийн дүнгийн арван хувиас (10%) илүү үнийн дүн бүхий ажилд өөрчлөлт хийх зааварчилгаа авсан эсхүл нийт ажлын өөрчлөлтүүд нь Гэрээний үнийн дүнгийн 30 хувиас хэтэрсэн тохиолдолд; (b) 14.7 [*Төлбөр*]-д заасны дагуу төлбөрийг хүлээн аваагүй бол; (c) Захиалагчаас санхүүжилтдээ томоохон хэмжээний өөрчлөлт хийсэн тухай Мэдэгдлийг Гүйцэтгэгч энэхүү хэсэгт заасны дагуу хүлээн аваагүй бол; Гүйцэтгэгч нь тодруулга хүсэлт хүргүүлэх эрхтэй ба Захиалагч нь уг хүсэлтийг хүлээн авсанаас хойш 28 хоногийн дотор үлдэгдэл төлбөрийг хугацаанд нь

		төлөх боломжтой болохоо нотлосон баримтыг Гүйцэтгэгчид хүргүүлнэ.
2.5. **Ажлын талбайн өгөгдөл, мэдээлэл**		Захиалагч нь ажлын талбайн байр зүй, гидрогеологи, цаг уурын болон байгаль орчны нөхцөлийн талаарх өөрт байгаа бүхий л холбогдох мэдээллийг суурь огнооноос өмнө Гүйцэтгэгчид гаргаж өгөх үүрэгтэй бөгөөд суурь огнооноос хойш олж авсан дээрх мэдээллүүдийг мөн адил Гүйцэтгэгчид нэн даруй олгоно. Эргэлтийн цэгийн солбилцол, түвшин, хил заагийн тэмдэглэгээ (гэрээний нөхцөлд “ажлын талбайн өгөгдөл”)-г Захиалагчийн шаардлагад тодорхой тусгасан байна. Захиалагч нь 5.1 [*Зураг төслийн талаарх ерөнхий үүрэг*]-д зааснаас бусад тохиолдолд Ажлын талбайн өгөгдөл, мэдээллийн үнэн зөв, хангалттай, бүрэн бүтэн байдалд хариуцлага хүлээхгүй.
2.6. **Захиалагчаас хангах материал болон Захиалагчийн тоног төхөөрөмж**		Захиалагчийн шаардлагад тусгасан тохиолдолд материал болон Захиалагчийн тоног төхөөрөмжийг Захиалагчийн шаардлагад заасан хугацаа, үнэ, аргачлалыг баримтлан Захиалагч нь Гүйцэтгэгчид ажил гүйцэтгэхэд нь зориулж гаргаж өгнө. Гүйцэтгэгчийн ажилтан Захиалагчийн тоног төхөөрөмжийг ашиглах, хэрэглэх, жолоодох, удирдах эсхүл хяналтандаа байлгах хугацаанд тухайн тоног төхөөрөмжийн ашиглалт болон бүрэн бүтэн байдалд Гүйцэтгэгч хариуцлага хүлээнэ.
	3. ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ	
3.1 **Захиалагчийн төлөөлөгч**		Захиалагч нь Захиалагчийн төлөөлөгчийг томилох бөгөөд гэрээний нөхцөлд өөрөөр заагаагүй тохиолдолд тухайн этгээд нь Захиалагчийг төлөөлөх эрхтэй байна. Захиалагчийн төлөөлөгч нь гэрээний 15 [*Захиалагч гэрээг цуцлах*]-д зааснаас бусад тохиолдолд Захиалагчийн бүрэн эрх (Захиалагч нь Гүйцэтгэгчид төлөөлөх эрхгүй тухай мэдэгдэх хүртэл)-ийг эдэлнэ. Захиалагчийн төлөөлөгч нь (хэрэв хуулийн этгээд бол түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд байна): (a) өөрт олгогдсон эрх, үүргийг хэрэгжүүлнэ; (b) эрх, үүрэг хэрэгжүүлэх чадавхитай байна;

		(c) мэргэжлийн ур чадвартай байна; (d) гэрээний 1.4 [*Хэрэглэгдэх хууль ба хэл*]-д заасан хэлийг бүрэн эзэмшсэн байна. Захиалагчийн төлөөлөгч нь хуулийн этгээд тохиолдолд түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдийг томилсон (эсхүл өөрчилж томилсон) мэдэгдлийг талуудад хүргүүлнэ. Энэхүү мэдэгдлийг талууд хүлээн авснаар хүчин төгөлдөр болно. Захиалагчийн төлөөлөгч нь өөрийгөө төлөөлж байгаа этгээдийн бүрэн эрхийг дуусгавар болсон тохиолдолд мэдэгдэл хүргүүлнэ. Захиалагчийн төлөөлөгчийг төлөөлөх эрхий бүхий этгээдийг Захиалагч нь солих тохиолдолд 14-өөс доошгүй хоногийн өмнө шинээр томилогдох этгээдийн нэр, хаяг, эрх үүрэг болон томилох өдрийн талаарх мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ. Энэхүү нөхцөлд зааснаар Захиалагчийн шинээр томилох этгээд (хуулийн этгээд эсвэл хувь хүн)-ийг Гүйцэтгэгч үндэслэл бүхий байдлаар татгалзсан тохиолдолд Захиалагч томилохгүй.
3.2 **Захиалагчийн бусад ажилтан**		Захиалагч эсхүл Захиалагчийн төлөөлөгч нь өөрийн эрх, үүргийг Гүйцэтгэгчид мэдэгдэл хүргүүлэх замаар туслах ажилтнуудад шилжүүлж, цуцлаж болох бөгөөд уг мэдэгдэлд тухайн ажилтны нэр, даалгасан үүрэг, даалгавар, олгосон эрхийг заана. Тухайн мэдэгдлийг Гүйцэтгэгч хүлээн авсанаар хүчин төгөлдөр болно. Захиалагчийн төлөөлөгч нь дараах эрх, үүргээ шилжүүлэхийг хориглоно. Үүнд: a) гэрээний 3.5 [*Хэлэлцээр ба шийдвэр*]-д заасан эрх, үүрэг b) гэрээний 15.1 [*Үүргийн зөрчил арилгах тухай мэдэгдэл*]-д заасны дагуу мэдэгдэл хүргүүлэх. Эрх, үүрэг шилжүүлэх туслах ажилтнууд нь 1.4 *[Хэрэглэгдэх хууль ба хэл]*-д заасан хэлийг бүрэн эзэмшсэн байх бөгөөд тухайн эрх, үүргийг хэрэгжүүлэх чадавхитай байна.
3.3 **Итгэмжлэгдсэн этгээдүүд**		Гэрээний 3.1 [*Захиалагчийн төлөөлөгч*], 3.2 [*Захиалагчийн бусад ажилтнууд*]-д заасан Мэдэгдлээр эрх, үүрэг шилжүүлэн авсан Захиалагчийн төлөөлөгч, туслах ажилтнууд нь зөвхөн Итгэмжлэлд заасан хүрээнд Гүйцэтгэгчид зааварчилгаа өгөх, Мэдэгдэл хүргүүлэх, харилцах

		эрхтэй. Итгэмжлэгдсэн этгээдийн зөвшөөрөл, хяналт, шалгалт, бүртгэл, тайлан, зааварчилгаа, хүсэлт, мэдэгдэл, туршилт зэрэг итгэмжлэлийн хүрээнд гаргаж буй бүхий л шийдвэр, үйлдэл нь Захиалагчийн гаргасан шийдвэрийн нэгэн адил хүчин чадалтай байна. Гэвч: (а) Итгэмжлэгдсэн этгээдийн албан бичигт өөрөөр заагаагүй бол Гүйцэтгэгчийг Гэрээгээр хүлээсэн аливаа үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй; (б) Хэрэв Гүйцэтгэгч нь итгэмжлэгдсэн этгээдийн өгсөн заавар, албан бичиг, мэдэгдэлтэй холбоотой асуудлын талаар тодруулах тохиолдолд Захиалагчид мэдэгдэл хүргүүлнэ. Хэрэв Гүйцэтгэгчийн мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор Захиалагчаас хариу ирүүлээгүй эсхүл итгэмжлэгдсэн этгээдийн зааварчилгаа, албан бичиг, мэдэгдэлд аливаа өөрчлөлт оруулсан эсхүл хүчингүй болгосон тухай шийдвэр гаргаагүй бол Захиалагч зөвшөөрсөн гэж үзнэ.
3.4 **Зааварчилгаа**		Захиалагч нь гэрээнд заасны дагуу ажил, үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай зааварчилгааг доор дурдсаны дагуу Захиалагчийн төлөөлөгч эсвэл туслах ажилтанаар дамжуулан Гүйцэтгэгчид хэдийд ч хүргүүлж болно. Зааварчилгаа нь холбогдох үүргийг тодорхойлж, тухайн үүрэгт холбогдох Гэрээний заалтыг дурдсан байна. Гүйцэтгэгч нь зөвхөн Захиалагчийн төлөөлөгч, эсхүл гэрээний 3.2 [*Захиалагчийн бусад ажилтнууд*]-д заасны дагуу зааварчилгаа өгөх зохих эрх олгогдсон туслах ажилтанаас зааварчилгааг авна. Гүйцэтгэгч нь Захиалагчийн төлөөлөгч эсхүл итгэмжлэгдсэн туслах ажилтны өгсөн зааварчилгааг дагаж мөрдөнө. Хэрэв ажилд өөрчлөлт оруулах талаар зааварчилгаанд дурдсан бол гэрээний 13.3.1 [*Зааварчилгаагаар ажилд өөрчлөлт оруулах*]-ийг дагаж мөрдөнө. Ажлын өөрчлөлтийн талаар зааварчилгаанд дурдаагүй хэдий ч Гүйцэтгэгч дараах тохиолдолд

		тухайн зааварчилгаатай холбоотой ажлыг гүйцэтгэж эхлэхээс өмнө Захиалагчид нэн даруй мэдэгдэл хүргүүлнэ. Үүнд: a) Зааварчилгаа нь ажилд өөрчлөлт оруулах агуулга бүхий байх b) холбогдох хууль тогтоомжид нийцээгүй, Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаагүй, технологийн хувьд боломжгүй. Хэрэв мэдэгдлийг Захиалагч хүлээн авснаас хойш зааварчилгааг баталгаажуулсан, буцаасан эсхүл аливаа өөрчлөлт хийсэн тухай хариу Мэдэгдэлийг 7 хоногийн дотор хүргүүлээгүй тохиолдолд Захиалагчийн зүгээс уг зааварчилгааг хүчингүй болгосонд тооцно. Захиалагч хариу өгсөн тохиолдолд Гүйцэтгэгч нь Захиалагчийн хариуг дагаж мөрдөнө.
3.5 **Эвлэрэл ба шийдвэр**		Захиалагчийн төлөөлөгч энэ зүйлд заасан үүргийг гүйцэтгэхдээ Захиалагчаас үл хамааралтайгаар бие дааж хэрэгжүүлнэ. Гэрээний нөхцөлд заасан аливаа асуудал, шаардлагыг хэлэлцэх болон шийдвэрлэхдээ Захиалагчийн төлөөлөгч нь дараах журмыг мөрдөнө:
3.5.1		<u>Эвлэрүүлэл</u> Захиалагчийн төлөөлөгч нь талуудтай хамтад нь болон тусад нь зөвлөлдөж талуудыг эвлэрүүлэх талаар хүчин чармайлт гаргаж ажиллана. Захиалагчийн төлөөлөгч нь гэрээний 3.5.3 [Сүүлийн хугацаа]-д заасан хугацаанд багтааж боломжит хугацаанд эвлэрүүлэх ажиллагааг нэн даруй эхлүүлнэ. Захиалагчийн төлөөлөгчийн санал болгосон болон талуудын тохиролцосноос өөрөөр заагаагүй бол Захиалагчийн төлөөлөгч нь талуудад эвлэрсэн тухай мэдэгдлийг олгоно. Хэрэв гэрээний 3.5.3 [*Сүүлийн хугацаа*]-д заасан хугацаанд багтааж талууд эвлэрсэн бол Захиалагчийн төлөөлөгчөөс талуудын гарын үсэг зурж эвлэрсэн тухай мэдэгдлийг талуудад хүргүүлнэ. Уг мэдэгдлийг “Талууд эвлэрсэн тухай мэдэгдэл” гэх бөгөөд эвлэрлийг баталгаажуулсан баримтын хуулбарыг хавсаргана. Хэрэв:

		a) гэрээний 3.5.3 [*Сүүлийн хугацаа*]-д заасан хугацаанд эвлэрээгүй бол; b) талууд заасан хугацаанд багтааж эвлэрэлд боломжгүй тухай Захиалагчийн төлөөлөгчид мэдэгдсэн бол. Захиалагчийн төлөөлөгч нь талуудад зохих мэдэгдлийг хүргүүлж 3.5.2 [*Захиалагчийн төлөөлөгчийн шийдвэр*]-т заасан арга хэмжээг нэн даруй авна.
3.5.2		<u>Захиалагчийн төлөөлөгчийн шийдвэр</u> Захиалагчийн төлөөлөгч нь холбогдох бүх нөхцөл байдлыг харгалзан үзэж үүссэн аливаа асуудал, шаардлагыг гэрээний дагуу шударгаар шийдвэрлэнэ. Захиалагчийн төлөөлөгч нь 3.5.3 [*Сүүлийн хугацаа*]-д заасан хугацааны дотор шийдвэр гаргаж талуудад мэдэгдэл хүргүүлнэ. Энэхүү мэдэгдлийг "Захиалагчийн төлөөлөгчийн шийдвэрийн тухай мэдэгдэл" гэх бөгөөд тухайн шийдвэрийн үндэслэл холбогдох баримтыг нарийвчлан тусгана.
3.5.3		<u>Сүүлийн хугацаа</u> Талууд эвлэрэлд хүрсэн тохиолдолд Захиалагчийн төлөөлөгч нь талуудад энэ талаарх мэдэгдлийг доор дурдсан өдрөөс хойш 42 хоногийн дотор эсхүл Захиалагчийн төлөөлөгчийн санал болгож талууд хүлээн зөвшөөрсөн хугацааны дотор хүргүүлнэ. Үүнд: a) талууд эвлэрэх эсхүл шийдвэрлэх шаардлагатай асуудал (шаардлагаас бусад) байгаа тохиолдолд гэрээний нөхцөлийн холбогдох хэсэгт заасан хугацааны эхэнд b) гэрээний 20.1 [Ш*аардлага*]-ийн (c)-д заасан Шаардлага гаргах тохиолдолд Захиалагчийн төлөөлөгч гэрээний 20.1-т заасны дагуу шаардлага гаргаж буй талаас мэдэгдэл хүлээн авсан өдөр; c) гэрээний 20.1 [*Шаардлага*]-ийн (a) эсхүл (b) заалтад заасны дагуу шаардлага гаргаж байгаа тохиолдолд Захиалагчийн төлөөлөгч нь: (i) гэрээний 20.2.4 [*Нарийвчилсан шаардлага*]-д заасны дагуу тухайн шаардлагыг хүлээн авсан өдөр; (ii) гэрээний 20.2.6 [*Үргэлжилсэн нөлөөллөөс үүдэлтэй шаардлага*]-д заасан нарийвчилсан шаардлагыг

		явц дунд болон сүүлийн хүлээн авсан өдөр. Захиалагчийн төлөөлөгч нь аливаа асуудлыг шийдвэрлэсэн тохиолдолд энэ талаарх мэдэгдлийг Гэрээний 3.5.1-д заасан өдрөөс хойш 42 хоногийн дотор эсхүл Захиалагчийн төлөөлөгчийн санал болгож талууд хүлээн зөвшөөрсөн хугацааны дотор хүргүүлнэ. Хэрэв Захиалагчийн төлөөлөгч нь зохих хугацаанд эвлэрлийн болон шийдвэрийн тухай мэдэгдлийг хүргүүлээгүй бол: (i) Гэрээний аль нэг талын гаргасан Шаардлагыг Захиалагчийн төлөөлөгч хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн гэж үзнэ (ii) Хэлэлцэх эсхүл шийдвэрлэх шаардлагатай асуудлын хувьд Татгалзсан мэдэгдлийн шаардлагагүйгээр гэрээний талууд тухайн асуудлыг 21.4-д заасны дагуу МЗШЗ-д хандаж шийдвэрлүүлж болно. Энэ тохиолдолд гэрээний 3.5.5 болон 21.4.1 дэх хэсэг үйлчилэхгүй.
3.5.4		<u>Эвлэрэл эсхүл шийдвэрийн үр дагавар</u> Аливаа эвлэрэл эсхүл шийдвэрийг энэхүү хэсэгт заасны дагуу засвар оруулсан эсхүл шийдвэрийн хувьд түүнийг гэрээний 21-д заасны дагуу өөрчлөлт оруулах хүртэл талууд дагаж мөрдөж, биелүүлэх үүрэгтэй. Хэрэв эвлэрэл эсхүл шийдвэр нь гэрээний талууд нэгэндээ төлөх төлбөртэй холбоотой бол Гүйцэтгэгч нь дараагийн төлбөрийн нэхэмжлэлдээ төлбөрийн дүнг тусгах бөгөөд Захиалагч нь 14.7 [Явц дундын т*өлбөр*] болон 14.13 [*Эцсийн төлбөр*]-д заасны дагуу дараагийн төлбөр дээр нэгтгэн тооцож төлнө. Хэрэв Захиалагчийн төлөөлөгчийн эвлэрүүлэл болон шийдвэрийн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор уг мэдэгдэлд бичилтийн, хэвлэлтийн эсхүл арифметик/тооцооллын алдаа илэрсэн бол: а) Захиалагчийн төлөөлөгч дээрх алдааг илрүүлсэн бол энэ талаар талуудад нэн даруй мэдэгдэнэ;

		b) Гэрээний аль нэг тал уг алдааг илрүүлсэн бол энэ талаарх мэдэгдлийг Захиалагчийн төлөөлөөгчид хүргүүлнэ. Хэрэв Захиалагчийн төлөөлөгч нь тухайн мэдэгдэлд алдаа байхгүй гэж үзвэл энэ талаар Талуудад нэн даруй мэдэгдэнэ. Захиалагчийн төлөөлөгч алдааг олж мэдсэнээс хойш эсхүл дээрх (b)-д заасны дагуу мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор эвлэрэл болон шийдвэрийн талаарх мэдэгдлийг засаж залруулан талуудад хүргүүлнэ. Залруулсан хэлцэл болон шийдвэрийг Гэрээний нөхцөлд заасан эвлэрэл болон шийдвэрийн нэгэн адил авч үзнэ.
3.5.5		<u>Захиалагчийн төлөөлөгчийн шийдвэрийг эс зөвшөөрөх</u> Хэрэв гэрээний аль нэг тал нь Захиалагчийн төлөөлөгчийн шийдвэрийг эс зөвшөөрвөл: (a) нөгөө талдаа Татгалзсан мэдэгдэл хүргүүлэх бөгөөд хувийг Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ; (b) Уг татгалзсан мэдэгдэл нь “Захиалагчийн төлөөлөгчийн шийдвэрийг эс зөвшөөрсөн тухай мэдэгдэл” тэргүүтэй байх бөгөөд эс зөвшөөрч буй үндэслэлийг дурдсан байна. (c) Уг татгалзсан мэдэгдэлийг гэрээний 3.5.2 [*Захиалагчийн төлөөлөгчийн шийдвэр*]-т заасан мэдэгдэл эсхүл гэрээний 3.5.4 [*тохиролцоо эсхүл шийдвэрийн үр нөлөө*]-д заасны дагуу засч залруулсан шийдвэрийн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш (эсхүл 3.5.3-т заасан шийдвэр гаргах хугацаа дуусгавар болж Шаардлагыг хэрэгсэхгүй болгосонд тооцсоноос хойш) 28 хоногийн дотор хүргүүлнэ. (d) Үүний дараа гэрээний талууд 21.4 [*МЗШЗ шийдвэр гаргах*]-д заасны дагуу МЗШЗ-д хандаж болно. Дээрх (c) дэд хэсэгт заасны дагуу 28 хоногийн дотор гэрээний аль нэг тал Татгалзсан мэдэгдэлийг өгөөгүй бол Захиалагчийн төлөөлөгчийн шийдвэрийг хоёр тал хүлээн зөвшөөрсөнд тооцож, тус шийдвэр эцсийн бөгөөд заавал биелэгдэх шинжтэй байна.

		Хэрэв гэрээний аль нэг тал нь захиалагчийн төлөөлөгчийн шийдвэрийн зөвхөн зарим хэсгийг эс зөвшөөрвөл: (a) Татгалзсан мэдэгдэлд тухайн хэсгийг (хэсгүүдийг) тодорхой заана; (b) Тухайн эс зөвшөөрсөн болон түүний салшгүй хэсэг нь шийдвэрийн бусад хэсэгт нөлөөлөхгүй (c) Шийдвэрийн бусад хэсэгт Татгалзсан мэдэгдэл өгөөгүй гэж үзэх бөгөөд эцсийн, заавал биелэгдэх шинжтэй байна. Хэрэв гэрээний аль нэг тал нь 3.5-д заасан эвлэрэл болон Захиалагчийн төлөөлөгчийн эцсийн бөгөөд заавал биелэгдэх шинжтэй шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал нь бусад эрхийг хөндөхгүйгээр 21.6-д заасны дагуу арбитрт шууд хандах эрхтэй. Энэ тохиолдолд 21.7-ийн эхний болон гурав дахь цогцолборт заасан зохицуулалт үйлчилнэ.
3.6 **Уулзалт**		Гэрээний аль нэг тал нь нөгөө талаа Ажлын гүйцэтгэл, цаашид гүйцэтгэх ажилтай холбоотой асуудлыг хэлэлцэх зорилгоор менежментийн уулзалтад оролцохыг шаардаж болно. Гэрээний аль нэг талын хүсэлтээр захиалагчийн бусад гүйцэтгэгч, төрийн байгууллага, албан тушаалтан, нийтлэг үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээд болон туслан гүйцэтгэгч нар дээрх хуралд оролцож болно. Захиалагч нь менежментийн хурал бүрийн тэмдэглэлийг хөтлөх бөгөөд хуралдаанд оролцсон оролцогчдод хурлын тэмдэглэлийн хуулбарыг хүргүүлнэ. Дээрх хурал болон хурлын тэмдэглэлд заасан авах аливаа арга хэмжээ нь Гэрээнд нийцсэн байна.
	4. ГҮЙЦЭТГЭГЧ	
4.1 **Гүйцэтгэгчийн ерөнхий үүрэг**		Гүйцэтгэгч нь гэрээний дагуу ажлыг гүйцэтгэнэ. Ажил дуусаны дараа тухайн гүйцэтгэсэн ажил нь Захиалагчийн шаардлагад зааж, тодорхойлсон зориулалтад тохирсон байх ёстой. Хэрвээ зорилго, зориулалтыг нь тодорхойлоогүй, тайлбарлаагүй бол уг ажил нь ердийн зорилтод нийцсэн байх ёстой. Гүйцэтгэгч нь Захиалагчийн шаардлагад заасан өөрийн үүргээ биелүүлэхэд шаардлагатай, тоног

		төхөөрөмж (сэлбэг хэрэгсэл байвал тэдгээрийн хамт) болон Гүйцэтгэгчийн баримт бичгүүд, Гүйцэтгэгчийн ажилтнууд болон бараа, бүтээгдэхүүн, мөн Гүйцэтгэгчийн үүргээ биелүүлэхэд шаардагдах түр болон үндсэн бусад зүйлс, ажил үйлчилгээгээр хангах үүрэгтэй. Гэрээнд заасан ажилд Захиалагчийн шаардлага болон Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө заасан эсхүл Гэрээнд заасан ажлыг биелүүлэхэд шаардлагатай аливаа ажлыг багтаах ба үүнд тогтвортой, тасралтгүй байдлаар бүрэн гүйцэд аюулгүй, зохистой үйл ажиллагааг явуулахад шаардагдах ажлууд мөн хамаарах юм. Гүйцэтгэгч нь өөрийн бүх ажил ба үйл ажиллагааг зохих шаардлагад нийцүүлэх, тэдгээрийг тасралтгүй бөгөөд аюулгүй байдлаар гүйцэтгэх, улмаар барилгын бүх ажлын болон барилгын аргачлалын хариуцлагыг хүлээнэ. Гүйцэтгэгч нь Захиалагч талаас шаардсан тухай бүр Ажлын гүйцэтгэлд хэрэгжүүлэх зорилгоор Гүйцэтгэгч талаас санал болгож буй тохируулга болон аргачлалын дэлгэрэнгүйг Захиалагчид гаргаж өгөх үүрэгтэй. Захиалагчид урьдчилан мэдэгдэлгүйгээр эдгээр тохируулга болон аргачлалд ач холбогдол бүхий өөрчлөлтийг хийхгүй болно.
4.2 **Гүйцэтгэлийн баталгаа**		Гүйцэтгэгч нь Гэрээний төгс гүйцэтгэлийг найдвартай хангахын тулд Гүйцэтгэлийн баталгааг (өөрийн зардлаар), Гэрээний өгөгдөлд заасан дүн ба мөнгөн тэмдэгтээр гаргуулна. Хэрэв Гэрээний өгөгдөлд мөнгөний дүнг заагаагүй бол энэ хэсэг үйлчлэхгүй.
4.2.1		<u>Гүйцэтгэгчийн үүрэг</u> Талуудын хооронд байгуулагдсан Гэрээний хэлэлцээрт гарын үсэг зурснаас хойш 28 хоногийн дотор Гүйцэтгэгч нь Гүйцэтгэлийн баталгааг Захиалагчид хүргүүлнэ. Гүйцэтгэлийн баталгааг Захиалагчийн зөвшөөрсөн (гэхдээ, ийм зөвшөөрөл ба/эсхүл хэлэлцээр нь энэхүү дэд зүйлийн дагуу хүлээх аливаа үүргээс Гүйцэтгэгчийг чөлөөлөхгүй) хуулийн этгээдээр ба тухайн улсын дотор (эсхүл хууль зүйн өөр зохицуулалтаар), Тусгай Нөхцөлд хавсаргасан, эсхүл Захиалагчийн зөвшөөрсөн өөр маягтын дагуу гаргуулсан байна.

		Гүйцэтгэлийн гэрчилгээг олгох болон гэрээний 11.11 дүгээр зүйл [*Ажлын талбайг чөлөөлөх*] дэх хэсгийн заалтуудыг Гүйцэтгэгч биелүүлж дуусах хүртэл хугацаанд Гүйцэтгэлийн баталгааг хүчин төгөлдөр мөрдөх, хангах үүргийг Гүйцэтгэгч хүлээнэ. Хэрвээ Гүйцэтгэлийн баталгаанд дуусгавар болох огноог тусгасан бөгөөд дуусгавар болох огнооноос 28 хоногийн өмнө Гүйцэтгэгч нь Гүйцэтгэлийн баталгааг авах эрхийг хангаагүй бол Гүйцэтгэгч нь Гүйцэтгэлийн баталгааны дуусгавар болох хугацааг Гүйцэтгэлийн баталгааг олгох хүртэл болон 11.11 дүгээр зүйл [*Ажлын талбайг чөлөөлөх*] хэсгийн заалтуудыг Гүйцэтгэгч бүрэн гүйцэтгэж дуусах хүртэл хугацаагаар сунгах ёстой. Хэрвээ гэрээний 13 дугаар зүйл [Нэмэлт *өөрчлөлт болон үнийн тохируулга*]-т заасны дагуу аливаа Гэрээний нэмэлт өөрчлөлт болон/эсхүл үнийн тохируулга хийгдсэний улмаас Гэрээний хэлэлцээрт заасан Гэрэний үнийн хорин хувиас (20%) илүү Гэрээний үнийн хуримтлагдсан өсөлт эсхүл бууралт гарсан тохиолдолд: (a) Өсөлт бий болсон тохиолдолд Захиалагчийн хүсэлтээр Гүйцэтгэгч нь тухайн мөнгөн тэмдэгтээр Гүйцэтгэлийн баталгааны хэмжээг хуримтлагдсан өсөлттэй тэнцүү хувиар нэн даруй ихэсгэнэ. Хэрэв захиалагчийн энэхүү хүсэлтээс шалгаалан Гүйцэтгэгч зардал гаргасан бол уг өсөлтийг Захиалагч зааварчилсаны адилаар үзэж, гэрээний 13.3.1 [*Зааварчилгаагаар нэмэлт өөрчлөлт оруулах*]-ийг хэрэглэнэ; (b) Бууралт бий болсон тохиолдолд Захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авсаны үндсэн дээр Гүйцэтгэгч тухайн мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэлийн баталгааны хэмжээг хуримтлагдсан бууралттай тэнцүү хувиар бууруулж болно.
4.2.2		<u>Гүйцэтгэлийн баталгааны дагуу шаардлага гаргах</u> Захиалагч нь гагцхүү дараах тохиолдлуудад Гэрээнд заагдсан дүнгээр Гүйцэтгэлийн баталгааны шаардлага гаргах ба бусад тохиолдолд Гүйцэтгэлийн баталгааны дагуу шаардлага гаргах эрхгүй: (a) Энэ хэсэгт заасны дагуу Гүйцэтгэлийн баталгааны хүчинтэй байх хугацааг Гүйцэтгэгч сунгаагүй бол Захиалагч гэрээний бүх дүнг

		(эсхүл өмнө бууруулсан бол үлдсэн дүнгээр) бүрэн хэмжээгээр нэхэмжилж болно. (b) Гүйцэтгэгч нь гэрээний 3.5-д зааснаар харилцан зөвшөөрсөн эсхүл тогтоосон эсхүл гэрээний 21 дүгээр зүйлд заасны дагуу харилцан зөвшөөрсөн эсхүл тогтоосон дүнг гэрээ хийгдсэн эсхүл тогтоосон эсхүл шийдвэрлэсэн эсхүл арбитрын шийдвэр гарсан (тухайн нөхцөл байдлаас хамаарч) өдрөөс хойш 42 хоногийн дотор Захиалагчид төлж барагдуулаагүй бол; (c) Гүйцэтгэгч нь гэрээний 15.1 дүгээр зүйлд заасны дагуу ирүүлсэн мэдэгдэлд дурдсан үүрэг даалгаврыг 42 хоногт багтаан эсхүл бусад хугацаанд мэдэгдэлд тусган (хэрвээ байвал) биелүүлээгүй бол; (d) Гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлсэн эсэхээс үл хамааран гэрээний 15.2 дугаар зүйл [*Гүйцэтгэгчийн буруугаас гэрээ цуцлах*]-т заасны дагуу Захиалагчийн зүгээс Гэрээг цуцлах нөхцөл байдал үүссэн бол; эсхүл (e) Хэрэв гэрээний 11.5 дугаар зүйлд заасны дагуу Гүйцэтгэгч нь аливаа доголдол эсхүл гэмтэж эвдэрсэн аж үйлдвэрийн нэгжийг Ажлын талбайгаас гаргах ёстой бөгөөд Гүйцэтгэгчийн Мэдэгдэлд тусгасан холбогдох хугацааг (эсхүл Захиалагчтай зөвшилцсөн бусад хугацаанд) дуусахаас өмнө уг үндсэн тоног төхөөрөмжийг засварлаагүй, Ажлын талбайд буцаан авчраагүй, дахин суурилуулаагүй, дахин шалгаж тестлээгүй бол. Захиалагч нь Гүйцэтгэлийн баталгааны шаардлагаас үүсэх бүхий л хохирол, алдагдал, төлбөрөөс (шүүхийн хураамж болон зардлыг багтаана) Гүйцэтгэгчийг хамгаалах, хохиролгүй болгох үүрэгтэй ба энэхүү үүргийг Захиалагч нь шаардлага гаргах эрхгүй байсан ч биелүүлнэ. Гүйцэтгэлийн баталгааны хүрээнд Захиалагч хүлээн авсан аливаа мөнгөн дүнг: (i) Гэрээний 14.13 дугаар зүйлд заасан Сүүлийн төлбөрт тусгана (төлбөрийн дүнд багтаана); эсхүл (ii) Хэрвээ Гэрээ цуцлагдсан тохиолдолд гэрээний 15.4 дүгээр зүйл, 15.7 дугаар зүйл, 16.4 дүгээр зүйл, 18.5 дугаар зүйл, эсхүл 18.6 дугаар зүйлд (нөхцөл байдлаас хамаарна) тус тус заасны дагуу Гүйцэтгэгчид төлөх төлбөрт оруулан тооцно.

4.2.3		<u>Гүйцэтгэлийн баталгааг буцаан олгох</u> Захиалагч нь дараах тохиолдолд Гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэгчид буцаана: a) Гүйцэтгэлийн гэрчилгээг хүргүүлснээс хойш 21 өдөрт багтаан буцаан олгох ба Гүйцэтгэгч нь гэрээний 11.11 дүгээр зүйлд заасныг биелүүлсэн бол; эсхүл b) Хэрвээ гэрээний 15.5 дугаар зүйл, 16.2 дугаар зүйл, 18.5 дугаар зүйл эсхүл 18.6 дугаар зүйл хэсгүүдэд тус тус заасны дагуу Гэрээ цуцлагдсан бол Гэрээ цуцлагдсаны дараа нэн даруй Гүйцэтгэлийн баталгааг буцаан олгоно.
4.3 **Гүйцэтгэгчийн төлөөлөгч**		Гүйцэтгэгч нь Гүйцэтгэгчийн төлөөлөгчийг томилох бөгөөд тухайн төлөөлөгчид Гүйцэтгэгчийн төлөөлөгчийг сольж томилохоос бусад Гэрээний дагуу Гүйцэтгэгчийг төлөөлж ажил гүйцэтгэхэд шаардагдах бүхий л эрхийг олгоно. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь уг ажилд хамаарах инженерийн үндсэн чиглэлээр мэргэшсэн, туршлагатай, чадвартай байх ба гэрээний 1.4 дугаар зүйлд заасан харилцааны хэлийг бүрэн эзэмшсэн байна. Гүйцэтгэгчийн төлөөлөгчийг нэр заан гэрээнд дурдаагүй бол Гүйцэтгэгч нь Ажил эхлүүлэх огноогоос өмнө Гүйцэтгэгчийн төлөөлөгчөөр томилохоор санал болгож буй хүний нэр болон дэлгэрэнгүй мэдээллийг зөвшилцөхөөр Захиалагчид хүргүүлнэ. Хэрвээ зөвшилцөлд хүрээгүй бөгөөд улмаар эгүүлэн татсан бол, эсхүл томилогдсон этгээд нь Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн ажил үүргээ биелүүлээгүй бол Гүйцэтгэгч нь тухайн томилгоон дээр өөр тохирох хүний нэр, холбогдох мэдээллийг санал болгон мөн адил хүргүүлнэ. Хэрвээ энэхүү саналыг хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор Захиалагч нь тухайн санал болгож буй хүнээс татгалзсан эсхүл солих тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлэх байдлаар хариу мэдэгдээгүй бол Захиалагчийг тухайн төлөөлөгчийг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ. Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр Гүйцэтгэгч нь томилогдсон Гүйцэтгэгчийн төлөөлөгчийг эгүүлэн татах эсхүл түүнийг өөр этгээдээр солих (Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь нас барах, өвчин эмгэг, тахир дутуу болох шалтгаанаар эсхүл ажлаас халагдсанаар ажил үүргээ биелүүлэх чадамжгүй

		болохоос бусад тохиолдлыг оруулна. Эдгээр тохиолдолд тухайн төлөөлөгчийг эгүүлэн татсан шийдвэрийг шууд хүчин төгөлдөр үйлчилнэ хэмээн үзэн үүрэг гүйцэтгэгч төлөөлөгчийн томилгоог хийх бөгөөд энэхүү төлөөлөгчийг Захиалагчийн зүгээс хүлээн зөвшөөрөл өгөх хүртэл эсхүл энэхүү хэсэгт заасны дагуу орны өөр этгээдийг томилох хүртэл түр томилгоо гэж үзнэ) эрхгүй. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь гэрээний дагуу Гүйцэтгэгчийн гүйцэтгэлийг удирдан чиглүүлэх үүрэг хариуцлагыг үргэлжид хүлээнэ. Гэрээний дагуу ажил гүйцэтгэх бүхий л хугацаанд Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь Гүйцэтгэгчийн төлөө болон түүнийг төлөөлөн ажиллах ба үүнд гэрээний 1.3 дугаар зүйлд заасны дагуу бүхий л мэдэгдэл болон бусад харилцааг хүлээн авах, илгээх; гэрээний 3.4 дүгээр зүйлд заасны дагуу аливаа даалгаврыг хүлээн авах зэрэг үүрэгт ажлуудыг багтаана. Захиалагч өөрөөр тохиролцоогүй бол Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь Ажлын талбайд Ажил гүйцэтгэж байх явцад бүхий л хугацаанд Ажлын талбайд суурин байрлаж ажиллана. Хэрвээ Гүйцэтгэгчийн төлөөлөгч Ажил гүйцэтгэх явцад Ажлын талбайг түр хугацаагаар орхих бол тохирох хүнийг түүний оронд Захиалагчийн урьдчилсан зөвшөөрөлтэйгөөр түр томилно. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь доор дурдсанаас бусад ямар нэгэн үүрэг ба эрх мэдлийг чадвар, туршлагатай аливаа этгээдэд шилжүүлж болох ба түүнийг ямар ч үед цуцлаж болно: a) гэрээний 1.3 дугаар зүйлд заасны дагуу Мэдэгдэл болон бусад бичиг захидлыг хүлээн авах, илгээх эрх; b) гэрээний 3.4 дүгээр зүйлд заасны дагуу зааварчилгааг хүлээн авах эрх үүрэг. Ажиллах этгээдийн нэр заасан, түүнчлэн шилжүүлэн өгсөн ба цуцалсан үүрэг, эрх, цаг хугацааг дурдсан Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдэгдлийг Захиалагч хүлээн авах хүртэл аливаа эрх, үүргийн шилжүүлэлт ба цуцлалт хүчин төгөлдөр бус байна. Эдгээрт хамаарал бүхий этгээдүүд нь гэрээний 1.4 дүгээр зүйлд заасан харилцааны хэлийг бүрэн эзэмшсэн байх шаардлагатай.

4.4 **Туслан гүйцэтгэгч**		Гүйцэтгэгч нь дараах зүйлсийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй: (a) Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж байгаа ажлын нийт нийлбэр үнэ нь Гэрээний ерөнхий хэлэлцээрт дэх гэрээний үнэ дэх Гэрээний өгөгдөлд заасан (хэрэв заагаагүй бол бүх ажлын хувьд) хувиас их байгаа бол; (b) Гэрээний өгөгдөлд заасны дагуу туслах гэрээ зөвшөөрөгдөхгүй Ажлын аливаа хэсгийг. Гүйцэтгэгч нь бүх Туслан гүйцэтгэгчдийн ажлыг хариуцаж, туслан гүйцэтгэгчдийн нийт ажлыг удирдан зохицуулах бөгөөд туслан гүйцэтгэгч, мөн түүнчлэн түүний төлөөлөгч болон ажилчдын хийсэн үйлдэл, зөрчлийг Гүйцэтгэгчийн хийсэн үйлдэл, алдаа мэт хариуцлага хүлээнэ. Гэрээний өгөгдөлд заасны дагуу Гүйцэтгэгч нь доорх үйл ажиллагаанаас өмнө Захиалагчид 28-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэл хүргүүлнэ. Үүнд: (i) Туслан гүйцэтгэгчийн холбогдох туршлагыг багтаасан дэлгэрэнгүй мэдээллийн хамт түүний төлөвлөсөн томилгоо; (ii) Туслан гүйцэтгэгчийн ажил эхлэхээр товолсон өдөр; (iii) Туслан гүйцэтгэгчийн Ажлын талбай дээрх ажил эхлэхээр товолсон өдөр.
4.5 **Санал болгосон туслан гүйцэтгэгч**		Энэхүү хэсэгт “Санал болгосон туслан гүйцэтгэгч” гэж Захиалагчийн шаардлагад нэрлэгдсэн Туслан гүйцэтгэгч эсхүл гэрээний 13.4 дүгээр зүйлд заасны дагуу Захиалагч туслан гүйцэтгэгчээр ажиллуулахыг Гүйцэтгэгчид даалгасан туслан гүйцэтгэгчийг хэлнэ.
4.5.1		<u>Томилгоог эсэргүүцэх</u> Гүйцэтгэгч нь Захиалагчийн зааварчилгааны дагуу томилогдсон Туслан гүйцэтгэгчийг ажилд авах үүрэг хүлээхгүй бөгөөд Гүйцэтгэгч нь зааварчилгааг хүлээн авснаас хойш 14-өөс доошгүй хоногийн дотор томилогдсон туслан гүйцэтгэгчийг эсэргүүцэж байгаа тухайгаа Захиалагчид дэлгэрэнгүй мэдэгдэл өгөх замаар үндэслэл бүхий эсэргүүцэл гаргаж болно. Тухайн эсэргүүцэл нь доорх зүйлсийн аль нэгээс (бусад зүйлээс) үүдэлтэй бол мөн Захиалагч нь уг асуудлаас үүсэх үр дагавараас Гүйцэтгэгчийг

		хамгаалах үүрэг хүлээснээс бусад тохиолдолд, эсэргүүцлийг үндэслэлтэй гэж үзнэ: (a) Туслан гүйцэтгэгчийн мэргэжлийн ур чадвар, хөрөнгийн эх үүсвэр болон санхүүгийн чадавх хангалтгүй гэж үзэх шалтгаан байсан (b) томилогдсон туслан гүйцэтгэгч, мөн түүний төлөөлөгч болон ажилтнууд нар нь бараа материалыг зориулалтын бусаар ашиглах буюу тэдгээрт хайнга, тоомжиргүй хандах явдлаас Гүйцэтгэгчийг хамгаалах талаар туслах гэрээнд тусгагдаагүй байсан, эсхүл (c) энэхүү гэрээний дагуу ажил (хэрэв зураг төслийн ажил байгаа бол түүнийг багтаан) гүйцэтгэх зорилгоор томилогдсон Туслан гүйцэтгэгч нь туслах гүйцэтгэх ажилдаа дараах нөхцөлийг тусгаагүй тохиолдолд: (1) Гүйцэтгэгчийг, түүний Гэрээний дагуу хүлээхтэй ижил үүрэг, хариуцлагаас чөлөөлөх хэмжээний үүрэг, хариуцлагыг Гүйцэтгэгчийн өмнө хүлээнэ, ба (2) Гэрээтэй холбоотой, эсхүл Гэрээг хэрэгжүүлэх явцад үүсэх бүх үүрэг, хариуцлагаас, мөн түүнчлэн Туслан гүйцэтгэгч хүлээсэн үүргээ биелүүлээгүй алдаанаас, эсхүл түүний хариуцлагагүй үйлдлээс үүдсэн үр дагавараас Гүйцэтгэгчийг хамгаална.
4.5.2		<u>Томилогдсон туслан гүйцэтгэгчид төлөх төлбөр</u> Гүйцэтгэгч нь туслан гүйцэтгэх гэрээний дагуу төлөгдвөл зохих мөнгөн дүнг томилогдсон Туслан гүйцэтгэгчид төлнө. Гэрээний 4.5.3-т зааснаас бусад тохиолдолд эдгээр дүн болоод үүн дээр нэмэгдсэн бусад хураамжийг Гэрээний 13.4 дүгээр зүйлийн (b)-д заалтын дагуу Гэрээний үнэд нэмж оруулна.
4.5.3		<u>Төлбөр хийгдсэн талаарх нотлох баримт</u> Захиалагч нь Томилогдсон Туслан гүйцэтгэчид төлбөл зохих дүнг тусгасан гэрээний 14.7 дугаар зүйл [*Төлбөр*]-д заасан завсрын төлбөрийг хийхээс өмнө түрүүчийн Захиалагчийн хийсэн завсрын төлбөрийн дагуу авбал зохих, суутган барих мөнгөний дүнгээр, эсхүл өөр байдлаар хийгдсэн суутгалыг хассан бүх дүнг томилогдсон Туслан гүйцэтгэгч хүлээн авсан тухай зохих нотлох баримтыг ирүүлэхийг Гүйцэтгэгчээс шаардаж болно. Хэрэв Гүйцэтгэгч нь:

		(a) Энэхүү зохих ёсны нотлох баримтыг Захиалагчид ирүүлээгүй, эсхүл (b) (i) Эдгээр дүнг төлөхгүй байх, эсхүл төлөхөөс татгалзах зохих ёсны эрхтэй гэж Захиалагчид бичгээр мэдэгдээгүй, ба (ii) Гүйцэтгэгчийн энэхүү эрхийн талаар томилогдсон Туслан гүйцэтгэгчид мэдэгдсэн тухай зохих нотлох баримтыг Захиалагчид өгөөгүй бол, Захиалагч (дан ганц өөрийн үзэмжээрээ) нь дээрх (a) эсвэл (b) дэд хэсэгт заасан нотлох баримтыг Гүйцэтгэгч гаргаж өгөөгүй болон томилогдсон Туслан гүйцэтгэгчид төлөх ёстой өмнөх төлбөрийн тодорхой хэсгийг эсхүл бүхэлд нь (зохих суутгалыг хассан) шууд томилогдсон Туслан гүйцэтгэгчид төлж болно. Үүний дараа Захиалагч нь томилогдсон Туслан гүйцэтгэгчид шууд төлсөн дүнг тусгасан мэдэгдлийг Гүйцэтгэгчид өгөх бөгөөд энэхүү дүнг тухайн Мэдэгдлийн дараах дараагийн завсрын төлбөрт гэрээний 14.6.1-ийн (б) заалтын дагуу суутгал хэлбэрээр оруулна.
4.6 **Хамтын ажиллагаа**		Гүйцэтгэгч нь Захиалагчийн шаардлагад заасны дагуу эсхүл Захиалагчийн зааварчилгааны дагуу дараахь этгээдүүдтэй хамтран ажиллаж, зохих боломжуудаар хангах үүрэгтэй: Үүнд: (a) Захиалагчийн ажилтнууд; (b) Захиалагчийн ажилд татан оролцуулсан аливаа бусад гүйцэтгэгч нарт, ба (c) Хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан төрийн өмчийн байгууллагууд болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн ажилтнууд. Гэрээнд тусгаагүй аливаа ажлыг тухайн талбай дээр эсхүл түүний ойролцоо гүйцэтгэх ажилд хүн томилон ажиллуулж болно. Ийм нөхцөл бололцоонд Гүйцэтгэгчийн хариуцлага хүлээх үүрэгтэй түүний тоног төхөөрөмж, Түр барилгыг ашиглах болон нэвтрэх арга хэмжээг, эсхүл Талбай дээр байгаа Гүйцэтгэгчийн бусад хэрэгслүүд, эсхүл үйлчилгээг оруулж болно. Гүйцэтгэгч нь ажлын талбай дээрх Гүйцэтгэгчийн барилга угсралтын ажлыг хариуцах ба Захиалагчийн шаардлагад заагдсан эсхүл Захиалагчийн

		зааварчилгааны дагуу өөрийн үйл ажиллагааг бусад гүйцэтгэгчдийн (хэрвээ байгаа бол) үйл ажиллагаатай уялдан зохицож хамтран ажиллах тал дээр бүхий л бололцоотой арга хэмжээг авч ажиллана. Хэрэв энэхүү Дэд зүйлийн дагуу өгсөн зааварчилгаанаас шалтгаалан Гүйцэтгэгчид саатал тулгарах болон/эсхүл Зардал гаргахад хүргэсэн бол Захиалагчийн шаардлагад заасан хамтын ажиллагаа, тохиромжтой нөхцөл бололцоог олгох болон үйл ажиллагааг зохицуулах нь Урьдаас таах боломжгүй байсан хэмээн үзэж Гүйцэтгэгч нь гэрээний 20.2 дугаар зүйлд заасны дагуу Хугацаа сунгах эсхүл ашиг шингэсэн үнийг төлүүлэх эрхтэй.
4.7 **Төслийн байрлалыг ажлын талбайд буулгах**		Гүйцэтгэгч нь ажлыг гэрээний 2.5 дугаар зүйлд заасан ажлын талбайн өгөгдөлтэй уялдуулан хийнэ. Гүйцэтгэгч нь: (a) Ажлын талбайн өгөгдлийг ажилд ашиглахаас өмнө тэдгээрийн үнэн зөв байдлыг шалгана; (b) Ажлын талбайн өгөгдөл, байр зүй, эргэлтийн цэгийн солбилцол, хил заагийн тэмдэглэгээ дэх аливаа алдааг засаж залруулна; (c) Ажлын бүх хэсгийн байршлыг зөв тогтоох хариуцлагыг хүлээнэ.
4.8 **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар хүлээх үүрэг**		Гүйцэтгэгч нь: (a) ХАБЭА-н (Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн) холбогдох бүхий л хууль, дүрэм журам, стандартыг дагаж мөрдөнө; (b) Гэрээнд заасан ХАБЭА-н бүхий л шаардлага, үүргийг биелүүлнэ; (c) Гүйцэтгэгчийн ХАБЭА-н ажилтнаас (гэрээний 6.7 дугаар зүйлд заасны дагуу томилогдсон) өгөгдсөн бүх шийдвэрийг дагаж мөрдөнө; (d) Ажлын талбайд болон ажил явагдаж байгаа бусад газруудад (хэрэв байгаа бол) орох эрх бүхий бүх хүмүүсийн эрүүл мэнд ба аюулгүй байдлыг хангахад анхаарал тавьж ажиллана; (e) Дээрх хүмүүсийг аюул, осолд өртүүлэхгүйн тулд саад болох хэрэгцээгүй зүйлсийг зайлуулан, Талбай болон Обьектыг (хэрэв байгаа бол бусад газруудыг) цэвэр байлгана (f) Хаалт, хашаа барьж, гэрэлтүүлэг тавьж, харуул хамгаалалт ажиллуулж, хяналтаар ханган: (i) гэрээний 10 дугаар зүйлд заасны дагуу Ажлыг бүрэн хүлээн авах хүртэл хугацаанд Ажилд зориулан;

		(ii) ДМХ-ийн явцад Гүйцэгтгэж дуусаагүй ажлыг гүйцэтгэх эсхүл доголдлыг засч залруулах Ажлын аливаа бүрдэл хэсэгт зориулан дээрхийг хангах үүргийг хүлээнэ. Мөн (g) Зэргэлдээх газар ба өмчийн эзэд, эзэмшигчид ба оршин суугчид, түүнчлэн олон нийт ашиглахад болон тэднийг хамгаалахад зориулан, ажлыг гүйцэтгэлтэй холбоотойгоор шаардагдаж болох (автозам, явган хүний зам, хамгаалалтын хэрэгслүүд болон хашаа зэргийг багтаасан) аливаа Түр барилгаар хангаж ажиллах ёстой. Ажил эхлэх огнооноос эхлэн 21 хоногт болон Ажлын талбайд барилга угсралтын ажил эхлэхийн өмнө Гүйцэтгэгч нь Ажлыг гүйцэтгэхээр төлөвлөж байгаа Ажлын талбай болон бусад газруудад тусгайлан зориулж боловсруулсан ХАБЭА-н гарын авлагыг Захиалагчид мэдээллийн журмаар танилцуулна. Энэхүү гарын авлагыг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу шаардагдах ХАБЭА-н бусад баримт бичгүүд дээр нэмэлтээр хэрэглэгдэнэ. ХАБЭА-н гарын авлага нь дараах ХАБЭА-н багц шаардлагуудыг хангасан байна. Үүнд: (i) Захиалагчийн шаардлагад тусгасан шаардлагууд; (ii) Гэрээгээр хүлээсэн Гүйцэтгэгчийн ХАБЭА-н үүрэгтэй нийцсэн байх; (iii) Ажил гүйцэтгэлийн Ажлын талбай болон бусад гадна талбайд (хэрвээ байвал) байх эрх бүхий хүмүүст зориулагдсан ХАБЭА-н зүй зохистой орчинг бүрдүүлэх, улмаар түүнийгээ хадгалахад чиглэгдсэн шаардлагууд. Энэхүү гарын авлагыг шаардлагатай бол Гүйцэтгэгч эсхүл Гүйцэтгэгчийн ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн эсхүл Захиалагчийн зохих хүсэлтээр хянан шинэчилж байна. Хянаж сайжруулсан зааврыг Захиалагчид тухай бүрд нь шуурхай танилцуулна. Гэрээний 4.20 дугаар зүйл [Ажлын *явцын тайлан*]-ийн (g) заалтад заасан тайланд тавигдах шаардлагууд дээр нэмэлтээр Гүйцэтгэгч нь аливаа осол гарсан тохиолдолд уг ослын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Захиалагчид аль болохоор богино хугацаанд хүргүүлэх үүрэгтэй бөгөөд ноцтой гэмтэл,

		амь нас алдсан ослын үед Захиалагчид шуурхай мэдээлнэ. Гүйцэтгэгч нь Захиалагчийн шаардлагад заасны дагуу болон Захиалагчийн шаардсаны дагуу хүний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай ба эд хөрөнгөд учирсан аливаа хохиролтой холбоотой бүртгэл, тайланг (ХАБЭА-н холбогдох хууль тогтоомж, журмын дагуу) хөтлөх үүрэгтэй.
4.9 **Чанарын удирдлага ба Төслийн удирдлагын систем** 4.9.1		<u>Чанарын удирдлагын тогтолцоо (Quality Management System)</u> Гүйцэтгэгч үйл ажиллагаагаа Гэрээний шаардлагад нийцэж буйг нотлох зорилгоор Гүйцэтгэгчийн Чанарын удирдлагын тогтолцоо (ЧУТ) боловсруулж хэрэгжүүлнэ. Энэхүү ЧУТ нь Ажилд тусгайлан зориулагдан боловсруулагдах ба Ажил эхлэх огнооноос хойш 28 хоногийн дотор Захиалагчид хүргүүлсэн байна. Үүний дараа, ЧУТ нь шинэчлэгдэх эсхүл нэмэлт, өөрчлөлт орох бүрт хуулбарыг нь Захиалагчид нэн даруй хүргүүлэх үүрэгтэй. ЧУТ нь Захиалагчийн шаардлагад заасны (хэрвээ байгаа бол) боловсруулагдсан байх ба мөн Гүйцэтгэгчийн журмуудыг багтаана. Үүнд: (a) Ажил, Бараа материал, ажлын ур чадвар туршилт зэрэгтэй холбогдолтой, үнэн зөв бөгөөд бүрэн баталгаатай, гэрээний 1.3 дугаар зүйлд заасан бүхий л мэдэгдлүүд болон бусад бичиг захидлууд, Гүйцэтгэгчийн баримт бичиг, Барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл, ашиглалтын болон засвар үйлчилгээний гарын авлага ба зэрэгцээ гаргасан бүртгэл мэдээллээр хангах; (b) Ажил гүйцэтгэх үе шатуудын болон Туслан гүйцэтгэгчдийн хоорондох харилцан үйлчлэлийн зохистой зохицуулалт ба зохион байгуулалтыг хангах; ба (c) Гүйцэтгэгчийн баримт бичгийг Хянуулж, дүгнүүлэхээр Захиалагчид хүргүүлэх. Гүйцэтгэгч нь ЧУТ-ний дотоод аудитыг тогтмол хийх бөгөөд хамгийн багадаа 6 сар тутам 1 удаа хийх үүрэгтэй. Гүйцэтгэгч нь дотоод аудит дуусанаас хойш 7 хоногийн дотор тайланг үр дүнгийн хамтаар Захиалагчид танилцуулах ёстой. Тайлан бүрт шаардлагатай тохиолдолд нь сайжруулахаар санал болгож буй арга хэмжээ болон/эсхүл ЧУТ болон/эсхүл түүний хэрэгжүүлэлтийг боловсронгуй болгох саналуудыг тусгана.

		Хэрвээ Гүйцэтгэгч нь өөрийн чанарын баталгаажуулалтын гэрчилгээнд хөндлөнгийн аудит хийлгэх шаардлагатай бол Гүйцэтгэгч нь хөндлөнгийн ямар нэгэн аудитын шалгалтаар тогтоосон аливаа алдаа дутагдлыг тодорхой дурдсан Мэдэгдлийг Захиалагчид нэн даруй хүргүүлнэ. Хэрэв Гүйцэтгэгч нь Түншлэл бол энэхүү үүрэг нь Түншлэлийн гишүүн бүрт хамаарна.
4.9.2		<u>Төслийн удирдлагын систем</u> (Compliance Verification System) Гүйцэтгэгч нь зураг төсөл, материал, Захиалагчийн ханган нийлүүлсэн материалууд (хэрвээ байвал), үндсэн тоног төхөөрөмж, ажил болон ажиллах ур чадвар зэрэг нь Гэрээний дагуу байгааг нотлон харуулах Төслийн удирдлагын системийг боловсруулж, хэрэгжүүлнэ. Төслийн удирдлагын систем нь Захиалагчийн шаардлагад нарийвчлан заасан нөхцөл шаардлагуудыг бүрэн хангасан байх ёстой бөгөөд Гүйцэтгэгчийн хийсэн бүхий л хяналт, туршилтын үр дүнг хэрхэн тайлагнах арга хэлбэрийг багтаасан байна. Хэрвээ хяналт эсхүл туршилт нь Гэрээний шаардлагад нийцэхгүй байгаа нь тогтоогдсон нөхцөлд 7.5 дугаар зүйл [*Доголдол болон татгалзал*]-ийг дагаж мөрдөнө.
4.9.3		<u>Ерөнхий заалт</u> Чанарын удирдлагын систем болон/эсхүл Төслийн удирдлагын системийг дагаж мөрдөх нь Гүйцэтгэгчийг, Гэрээний дагуу, эсхүл түүнтэй холбоотойгоор хүлээх аливаа үүрэг, хариуцлагаас үл чөлөөлнө.
4.10 **Ажлын талбайн мэдээллийг ашиглах**		Гүйцэтгэгч нь 2.5 дугаар зүйлийн дагуу Захиалагчийн олгосон бүх мэдээллийг баталгаажуулах хариуцлалгыг хүлээнэ.
4.11 **Гэрээний үнийн дүнгийн хүрэлцэхүйц байдал**		Гүйцэтгэгч нь Гэрээний ерөнхий хэлэлцээлт заасан Гэрээний үнийн үнэн зөв, хүрэлцээтэй байдлыг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ. Гэрээнд өөрөөр заагаагүй бол Гэрээний хэлэлцээрт заасан Гэрээний үнэ нь Гэрээний дагуу Гүйцэтгэгчийн

		хүлээсэн бүхий л үүргийг мөн Ажлыг Гэрээний шаардлагад нийцүүлэн зохих ёсоор гүйцэтгэхэд шаардлагатай бүх зүйлсийг багтаасан байна.
4.12 **Урьдчилан тооцоолох боломжгүй хүндрэлүүд**		Тусгай нөхцөлд өөрөөр заагаагүй бол: (a) Гүйцэтгэгч нь Ажилд нөлөөлж болохуйц эрсдэл, урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдал, болон бусад нөхцөл байдлын талаар бүхий л шаардлагатай мэдээллийг олж авсан хэмээн үзнэ. (b) Гэрээний хэлэлцээрт гарын үсэг зурснаар Гүйцэтгэгч нь Ажлыг амжилттай гүйцэтгэж дуусгах зардал болон хүндрэлүүдийг урьдчилан тооцоолох талаар бүрэн хариуцлагыг хүлээнэ. (c) Гэрээний үнэд урьдчилан тооцоолох боломжгүй хүндрэл болон зардлын үнийг тооцон өөрчлөлт оруулахгүй.
4.13 **Зорчих эрх болон Зөөврийн болон туслах байгууламж**		Гүйцэтгэгч нь Ажлын зориулалтаар шаардагдаж болох, Ажлын талбайд нэвтрэх эрхийг оролцуулан тусгай болон/эсхүл түр хугацааны зорчих эрхийн бүх төлбөр ба хураамжийг өөрөө хариуцна. Гүйцэтгэгч нь Ажлын зориулалтаар шаардагдаж болох, ажлын талбайн гаднах аливаа нэмэлт зөөврийн болон туслах байгууламжийг өөрийн зардлаар олж авах ба эрсдэлийг өөрөө хүлээнэ.
4.14 **Нийтийн болон бусдын эрх ашгийг хөндөхөөс зайлсхийх**		Гүйцэтгэгч нь дараах зүйлсийн эрх ашгийг хөндөхөөс зайлсхийнэ: (a) Олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах, үймүүлэхэд, эсхүл (b) Захиалагчийн болон бусдын эзэмшлийнх, эсхүл олон нийтийн хэрэгцээнийх эсэхээс үл хамааран, бүх авто зам, явган хүний ззамыг хаах, гарц, гарамыг бөглөх, ашиглалтыг хязгаарлахад хөндлөнгөөс оролцохгүй. Гүйцэтгэгч нь ийм хөндлөнгийн шаардлагагүй болон зүй зохисгүй оролцооноос үүдэлтэй бүх гарз хохирол, алдагдал, зардал (шүүхийн шимтгэл болон төлбөрийг хамруулсан)-ыг нөхөн төлөх хариуцлагаас Захиалагчийг чөлөөлөх ба хамгаалах үүрэгтэй.
4.15 **Замын зөвшөөрөл, Нэвтрэх орц, гарц**		Суурь огнооны өдөрт Гүйцэтгэгчийг ажлын талбайн Замын зөвшөөрөл, Нэвтрэх орц, гарцын хүрэлцээ ба тохиромжтой байдлыг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ. Гүйцэтгэгч нь аливаа зам эсхүл гүүрийг Гүйцэтгэгчийн зам ашиглалт эсхүл ажиллагсдын нөлөөгөөр

		эвдрэхээс урьдчилан сэргийлэх шаардлагатай бүх арга хэмжээг авна. Эдгээр арга хэмжээнд тээврийн хэрэгсэл (хууль дүрэмд заасны дагуу хүлээн зөвшөөрөгдсөн даац болон өргөн (хэрвээ байвал), бусад хязгаарлалтуудад нийцсэн) болон замын урсгалын зүй зохистой ашиглалт багтана. Эдгээр нөхцөлүүдэд өөрөөр заагаагүй бол: (a) Гүйцэтгэгч нь (Талууд хоорондоо) Гүйцэтгэгчийн нөлөөтэй үүссэн аливаа замын эвдрэлийг засах болон Гүйцэтгэгчийн ашиглалтын үеийн замын засвар үйлчилгээг хариуцна; (b) Гүйцэтгэгч нь Замын зөвшөөрөл, Нэвтрэх орц, гарц, ашиглагдах маршрутын дагуух шаардлагатай бүх тэмдэг, тэмдэглэгээг хариуцах бөгөөд Гүйцэтгэгчийн ашиглах зам, тэмдэг, тэмдэглэгээ, чиглэлийн талаарх холбогдох байгууллагаас шаардаж болох аливаа аман болон бичгэн зөвшөөрлүүдийг авах үүрэгтэй; (c) Гүйцэтгэгчийн ашиглалт болон бусад Замын зөвшөөрөл, Нэвтрэх орц, гарцтай холбоотойгоор гаргасан гуравдагч этгээдийн аливаа шаардлагыг Захиалагч хариуцахгүй; (d) Захиалагч нь Замын зөвшөөрөл, Нэвтрэх орц, гарц, маршрутын нөхцөл байдлын талаар баталгааг гаргахгүй; (e) Гүйцэтгэгчийн ашиглах Замын зөвшөөрөл, Нэвтрэх орц, гарц, маршрутын нөхцөл байдал хангалтгүй байх эсхүл хангагдаагүйтэй холбоотой бүхий л Зардлыг Гүйцэтгэгч хариуцна. Нэвтрэх зам, маршрутын хүртээмжгүй байдал эсхүл байхгүйгээс шалтгаалан Захиалагчийн зүгээс эсхүл гуравдагч этгээдээс зам маршрутад Суурь огнооноос хойш өөрчлөлт оруулсны улмаас Гүйцэтгэгч нь хугацаа хоцролт үүсэх эсхүл Зардал гарсан бол Гүйцэтгэгч нь гэрээний 20.2 дугаар зүйлд заасны дагуу Хугацааг сунгах шаардлага гаргах болон/эсхүл тухайн Зардлыг төлүүлэх эрхтэй.
4.16 **Бараа, материалын тээвэрлэлт**		Гүйцэтгэгч нь: (a) Аливаа үндсэн тоног төхөөрөмж эсхүл бусад барааны үндсэн зүйлсийг (Захиалагчийн шаардлагад заасны дагуу) Ажлын талбайд хүргэгдэх өдрөөс 21-нээс багагүй хоногийн өмнө Захиалагчид мэдэгдэл хүргүүлнэ;

		(b) Ажилд шаардагдах бүх бараа болон бусад зүйлсийг савлаж баглах, ачих, зөөж тээвэрлэх, хүлээн авах, буулгах, хадгалах, арчилж хамгаалах үүрэг хариуцлагыг хүлээнэ; (c) Бүх барааг импортлох, тээвэрлэхтэй холбоотой бүхий л гаалийн бүрдүүлэлт, зөвшөөрлүүд, татвар хураамж, төлбөр зэргийг хариуцах бөгөөд тэдгээрийг Ажлын талбайд хүргүүлэхтэй холбоотой бүхий л үүрэг хариуцлагыг хүлээнэ; (d) Бүх барааны импорт, тээвэрлэлт, тээвэрлэлттэй холбоотойгоор үүсч болох аливаа хохирол, алдагдал, зардал төлбөр (хууль ёсны төлбөр, зардлыг багтаана) зэрэг эрсдлүүдээс Захиалагчийг хамгаалах бөгөөд тэдгээрийн импорт, тээвэрлэлт, тээвэрлэлттэй холбоотойгоор гуравдагч этгээдээс үүсэх бүхий л шаардлага болон төлбөрийг асуудлаар хэлэлцээр хийх, төлбөрийг барагдуулах үүргийг хүлээнэ.
4.17 Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж		Гүйцэтгэгч нь Гүйцэтгэгчийн бүх тоног төхөөрөмжийг бүрэн хариуцна. Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжүүд Ажлын талбайд орж ирснээс хойш эдгээр тоног төхөөрөмжийг гагцхүү Ажил гүйцэтгэх зорилгоор ашиглана. Гүйцэтгэгч нь Гүйцэтгэгчийн үндсэн тоног төхөөрөмжүүдийг Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр Ажлын талбайгаас гаргахыг хориглоно. Гэхдээ энэхүү зөвшөөрөл нь Ажлын талбайгаас бараа болон Гүйцэтгэгчийн ажилтнуудыг /ажиллах хүчнийг/ тээвэрлэж буй тээврийн хэрэгсэлд үл хамаарна. Гэрээний 4.16 дугаар зүйлд заасны дагуу хүргүүлсэн аливаа мэдэгдлээс гадна Гүйцэтгэгч нь аливаа Гүйцэтгэгчийн үндсэн тоног төхөөрөмжийг ажлын талбайд оруулсан өдрийг мэдээлсэн мэдэгдлийг Захиалагчид хүргүүлэх үүрэгтэй. Энэхүү мэдэгдлийг Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг ажлын талбайд оруулах хугацаанаас 7 хоногийн дотор хүргүүлэх бөгөөд тоног төхөөрөмжийн өмчлөгч нь Гүйцэтгэгч эсхүл Туслан гүйцэтгэгч эсэх, эсхүл бусад этгээдийн өмчлөлд буй эсэх, түрээслэсэн эсхүл зээлдсэн эсэх, хэрвээ зээлдсэн эсхүл түрээслэсэн бол тухайн түрээслэгч эсхүл зээлдүүлэгч этгээдийн албан ёсны мэдээллийг тусгасан байна.
4.18 **Байгаль орчныг хамгаалах**		Гүйцэтгэгч нь дараах нөхцөлүүдийг хангахад чиглэгдсэн шаардлагатай бүх арга хэмжээнүүдийг авах үүрэгтэй. Үүнд:

		a) хүрээлэн буй орчныг хамгаалах (Ажлын талбайд болон талбайн гадна орчинд); b) Ажил гүйцэтгэхтэй холбоотой аливаа байгаль орчны үнэлгээ болон нөлөөлөх байдлын тайланд тусгасан шаардлагуудыг (хэрвээ байвал) хангах; c) Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа болон/эсхүл ажлаас хамаарал бүхий бохирдол, дуу чимээ болон бусад байдлаар иргэдэд болон эд хөрөнгөд учруулах хохирол, тав тухыг алдуулах үр дагавар, хохирлыг хязгаарлах. Гүйцэтгэгч нь Гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас үүсч болох хаягдал бохирдол, гадаргууд хаягдах хаягдлууд, бохир ус, бусад хорт бодис нь Захиалагчийн шаардлагад болон холбогдох хууль тогтоомжид заасан хэмжээ, утгаас хэтрэхгүй байх байх үүрэг хариуцлагыг хүлээнэ.
4.19 **Түр хэрэглээ (ус, цахилгаан, хий болон бусад)**		Гүйцэтгэгч нь дор дурдсанаас бусад тохиолдолд Гүйцэтгэгчид ажлыг гүйцэтгэхэд шаардагдах цахилгаан, хий, харилцаа холбоо, усан хангамж зэрэг түр хэрэглээгээр хангах болон бусад холбогдох ажил үйлчилгээгээр хангах үүрэг хүлээнэ. Энэ хэсгийн бусад заалтууд нь хэрвээ Захиалагчийн шаардлагад “Захиалагч нь Гүйцэтгэгчийн ашиглах хэрэглэгдэхүүн хариуцна” гэж заасан тохиолдолд гагцхүү хүчин төгөлдөр үйлчилнэ. Гүйцэтгэгч нь техникийн тодорхойлтод дэлгэрэнгүй мэдээлэл ба тусгагдсан үнэ нь Ажлын талбайн Түр хэрэглэгдэхүүнүүд Ажил гүйцэтгэх зорилгоор ашиглах эрхтэй. тэдгээр ажил үйлчилгээг явуулахад Гүйцэтгэгчид шаардагдах аливаа аппарат, багаж хэрэгслээр хангах болон ашиглалтын тоо хэмжээг гаргах ажлын эрсдэл болон зардлыг Гүйцэтгэгч хариуцна. Гүйцэтгэгч нь ашиглалтын тоо хэмжээг гаргах/тооцоолох аппарат/багаж хэрэгсэлд Захиалагчийн зөвшөөрлийг авна. Гэрээний өгөгдөлд тусгагдсан (хэрвээ тусгаагүй бол сар бүр) төлбөрийн хуваарь тус бүр дэх ашиглалтын тоо хэмжээг (хэрвээ байвал) Гүйцэтгэгч тооцоолох бөгөөд уг тоо хэмжээ (Захиалагчийн шаардлагад заасан үнэ)-нд хамаарах Гүйцэтгэгчийн төлөх үнийн дүнг холбогдох Тайланд тусгасан байх ёстой.
4.20		Гүйцэтгэгч нь Сар тутмын явцын тайланг Захиалагчийн шаардлагад заасан маягтын (хэрвээ маягт байхгүй бол Захиалагчаас хүлээн зөвшөөрсөн маягтын) дагуу гүйцэтгэж Захиалагчид хүргүүлнэ. Сар

Ажлын явцын тайлан		тутмын явцын тайлан бүрийг цаасан хэвлэмэл 1 эх хувь, цахимаар 1 хувь болон Гэрээний өгөгдөлд заасны дагуу нэмэлт хэвлэмэл хувийг (хэрвээ байвал) хүргүүлнэ. Анхны тайлангийн хугацаа нь Ажил эхлэх огнооноос хойш нэг сарын хугацааг бүтэн хамрана. Үүний дараа сар бүрийн явцын тайланг сар бүрийн сүүлийн өдрөөс хойш 7 хоногийн дотор хүргүүлж тайлагнах үүрэгтэй. Явцын тайланг Ажил дуусах огноог хүртэл эсхүл хэрвээ ажил хүлээн авсан гэрчилгээнд дутуу ажил бүртгэгдсэн байвал тэдгээр ажлыг бүрэн гүйцэтгэж дуусах хүртэлх хугацаанд үргэлжлүүлэх ёстой. Захиалагчийн шаардлагад өөрөөр дурдаагүй бол Явцын тайлан бүрт дараах зүйлсийг багтаасан байх ёстой. Үүнд: (a) зураг төслийн үе шат бүр, Гүйцэтгэгчийн баримт бичиг, худалдан авалт, материал, хийцийн үйлдвэрлэл, Талбайд хүргэх тээвэрлэлт, барилгын ажил, угсралт, туршилт, ашиглалтад оруулах болон туршилтын ажиллагаа зэргийг хамруулсан ажлын явцын график, бүдүүвч ба дэлгэрэнгүй тайлбарыг; (b) Ажлын талбайд болон талбайн бус байршилд гүйцэтгэсэн үйлдвэрлэл болон ажлын явц, төлөв байдлыг харуулсан гэрэл зурагнууд болон/эсхүл видео бичлэгүүд (c) Үндсэн тоног төхөөрөмж болон материалын үндсэн зүйл тус бүрийн үйлдвэрлэлийн мэдээлэл буюу үйлдвэрийн байршил, явцын хувь болон дараах хугацаануудын бодит болон төлөвлөсөн хугацаанууд: (i) Үйлдвэрлэж эхлэх хугацаа (ii) Гүйцэтгэгчийн хяналт шалгалтын хугацаа (iii) Тест/туршилтын хугацаа (iv) Тээвэрлэлтийн болон Ажлын талбайд ирүүлэх хугацаа (d) 6.1-т заасан дэлгэрэнгүй мэдээллүүд (e) Чанартай холбоотой баримт бичгүүдийн хуулбар, хяналт, шалгалтын тайлангууд, туршилтын үр дүнгүүд, тохирлын гэрчилгээ болон бусад баталгаажилтын баримт бичгүүд (материалын гэрчилгээнүүд багтана); (f) Гэрээний өөрчлөлтүүдийн жагсаалт болон 20.2.1-т заасны дагуу хүргүүлсэн аливаа мэдэгдлүүд (Талуудын аль аль нь); (g) Эрүүл ахуй болон аюулгүй ажиллагаатай холбоотой тоон мэдээллүүд, үүнд хүрээлэн буй байгаль орчин болон олон нийтийн

		харилцаатай холбоотой гарсан аливаа аюултай осол ба авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл багтана. (h) Явцын бодит гүйцэтгэл болон төлөвлөлтийн харьцуулалт, үүнд Ажлын график болон Ажил дуусах хугацааны дагуу Ажлыг гүйцэтгэж дуусахад сөргөөр нөлөөлж болохуйц аливаа үйл явдал эсхүл нөхцөл байдлыг дэлгэрэнгүйгээр тусгах ба хугацаа хоцролтыг шийдвэрлэхээр авч хэрэгжүүлсэн (эсхүл авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн) арга хэмжээнүүдийг мөн адил тусгана. Гэхдээ, ажлын явцын аливаа тайланд тусгагдсан ямар ч зүйл нь эдгээр Нөхцөлийн дэд зүйлийн дагуух Мэдэгдлийг бүрдүүлэхгүй.
4.21 **Ажлын талбайн аюулгүй байдал**		Гүйцэтгэгч нь ажлын талбайн харуул хамгаалалтыг хариуцах ба: (a) Эрх олгогдоогүй этгээдүүдийг Ажлын талбайд нэвтрүүлэхгүй байх; (b) Эрх бүхий этгээдүүд нь Гүйцэтгэгчийн ажилтнууд, Захиалагчийн ажилтнууд болон Захиалагчаас Гүйцэтгэгч рүү мэдэгдэл илгээсний үндсэн дээр эрх бүхий этгээд гэж тогтоогдсон бусад ажилтнуудаар хязгаарлагдана.
4.22 **Ажлын талбайн зохион байгуулалт**		Гүйцэтгэгч нь зохион байгуулалтыг, үйл ажиллагаагаа гагцхүү Ажлын талбайн дотор явуулах үүрэгтэй бөгөөд хэрвээ Гүйцэтгэгчийн зүгээс нэмэлт талбай шаардагдахаар бол Захиалагчийн зүгээс тухайн нэмэлт талбайг ажлын талбай гэж зөвшөөрч батласан байх шаардлагатай. Гүйцэтгэгч нь Ажлын талбайн дотор болон нэмэлт талбайд Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж байршуулах болон Гүйцэтгэгчийн ажилтнууд үйл ажиллагааг явуулах, тэдгээрийг талбайн хязгаарыг давахгүй байх зэрэг тал дээр шаардлагатай арга хэмжээнүүдийг авч ажиллана. Гүйцэтгэгч нь бүхий л хугацаанд Ажлын талбайг аливаа шаардлагагүй эд зүйлс, материалаас ангид байлгах ба аливаа Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж (гэрээний 4.17 дугаар зүйлд хамаарах)-ийг болон илүүдэл материалыг Ажлын талбайд зүй ёсоор хадгалах эсхүл талбайгаас чөлөөлөх үүргийг хүлээнэ. Мөн Гүйцэтгэгч нь цаашид шаардлагагүй Түр ажил болон аливаа эвдэрч хаягдсан эд зүйлс, аюултай

		бодис, хог хаягдлуудыг талбайгаас чөлөөлж цэвэрлэх үүрэгтэй. Ажил хүлээн авсан гэрчилгээ олгогдсоны дараа Гүйцэтгэгч нь нэн даруй Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжүүд, илүүдэл материал, эвдэрч хаягдсан эд зүйлс, аюултай бодис, хог хаягдлууд, Түр ажил болон Ажил хүлээн авсан гэрчилгээнд дурдагдсан Ажил болон Ажлын талбайн хэсгийг чөлөөлж цэвэрлэнэ. Гүйцэтгэгч нь Ажлын талбайн болон Ажлын бүрдэл хэсгийг чөлөөлж цэвэр, аюулгүй байдалд үлдээнэ. Гэхдээ, Гүйцэтгэгч нь Захиалагчтай харилцан зөвшилцсөний дагуу гэрээний дагуу үүргээ биелүүлэхэд нь Гүйцэтгэгчид шаардагдах тийм Бараа материалыг, ДМХ-ны туршид, Гүйцэтгэгч Ажлын талбай дээр үлдээж болно.
4.23 **Археологийн ба геологийн олдвор**		Ажлын талбайд олдсон аливаа олдворууд, зоос, үнэт болон эртний эд зүйлс, археологийн болон геологийн байгууламж, бүтээц, бусад эд зүйлсийг Захиалагчийн эрх мэдэл болон хадгалалт, хамгаалалтад шилжүүлж байршуулна. Эдгээр олдворуудаас аливаа эд зүйлсийг Гүйцэтгэгчийн ажилтнууд болон бусад хүн гэмтээх эсхүл авч явахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зохимжтой бүхий л арга хэмжээг Гүйцэтгэгч авна. Аливаа олдвор, эд зүйлс олдсон даруй Гүйцэтгэгч нь аль болох богино хугацаанд тэдгээр олдвор эд зүйлсийг хурдан хугацаанд шалгах болон/эсхүл судлах боломжийг олгосон мэдэгдлийг Захиалагчид хүргүүлнэ. Энэхүү Гүйцэтгэгчийн мэдэгдэл нь олдворын тухай тодорхойлолт мэдээллийг агуулах бөгөөд Захиалагчийн зүгээс тэрхүү олдвортой хэрхэн харьцаж хандах талаар даалгавар, зааварчилгааг хүргүүлэх ёстой. Хэрвээ Гүйцэтгэгч нь Захиалагчийн зааварчилгааг дагаж биелүүлсний улмаас Зардал гарсан эсхүл хугацааны хоцролт үүссэн бол гэрээний 20.2 дугаар зүйлд заасны дагуу Гүйцэтгэгч нь тухайн зардлыг барагдуулах эсхүл хугацаа сунгах шаардлага гаргах эрхтэй.
	5. ЗУРАГ ТӨСӨЛ	

5.1 **Зураг төслийн талаарх ерөнхий үүрэг**		Гүйцэтгэгч нь Суурь огнооноос өмнө Захиалагчийн шаардлага (хэрэв байгаа бол зураг төслийн норм, тооцоолол зэргийг хамаарна)-ыг нягталж үзнэ. Гүйцэтгэгч нь доор дурдсанаас бусад тохиолдолд Ажлын зураг төслийг гүйцэтгэж, хариуцах ба Захиалагчийн шаардлага (зураг төслийн норм, тооцоолол зэргийг хамруулан)-ын үнэн зөв байдлыг хариуцна. Зураг төслийг дараах мэргэжилтэнгүүд бэлтгэнэ. Үүнд: (a) инженер эсвэл бусад мэргэжлийн хүмүүс, мэргэшсэн, туршлагатай, хариуцаж буй зураг төслийн чиглэлээр мэргэшсэн байна; (b) Захиалагчийн шаардлагад заасан шалгуурыг (хэрэв байгаа бол) нийцсэн; болон (c) холбогдох хууль тогтоомжийн дагуу зураг төсөл боловсруулах чадвартай бөгөөд эрхтэй. Захиалагч нь гэрээнд анх тусгагдсан Захиалагчийн шаардлага дахь аливаа алдаа, зохимжгүй байдал, дутагдал зэргийг хариуцахгүй бөгөөд дор дурдсанаас бусад тохиолдолд мэдээллийн бүрэн гүйцэд, үнэн зөв байдлын талаар ямар нэгэн тайлбар өгсөн гэж үзэхгүй. Гүйцэтгэгчийн Захиалагчаас эсхүл бусад байдлаар хүлээн авсан аливаа мэдээ, мэдээлэл нь Гүйцэтгэгчийг Ажлын зураг төсөл эсхүл гүйцэтгэлийн хариуцлагаас чөлөөлөхгүй. Гэхдээ Захиалагч нь Захиалагчийн шаардлагын дараах хэсгүүд болон Захиалагчийн зүгээс өгсөн дараах мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцна: (a) Тогтмол эсхүл Захиалагчийн хариуцлага байхаар Гэрээнд заасан хувь хэмжээ, мэдээлэл; (b) Ажил болон түүний аливаа хэсгийн төлөвлөсөн зорилтын тайлбарууд; (c) Гүйцэтгэсэн ажлын туршилт болон биелэлтийн шалгуур; (d) Гэрээнд өөрөөр заагаагүй бол Гүйцэтгэгчийн шалгах боломжгүй хувь хэмжээ болон мэдээлэл.
5.2 **Гүйцэтгэгчийн баримт бичиг**		Гүйцэтгэгчийн баримт бичиг нь дараах баримт бичгүүдээс бүрдэнэ. Үүнд: (a) Захиалагчийн шаардлагад заасан баримт бичгүүд(хэрэв байгаа бол);

		(б) гэрээний 1.12 [*Хууль тогтоомжид нийцүүлэх*]-д заасны дагуу Гүйцэтгэгчийн хариуцах бүх зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, лиценз болон хууль дүрэм, норм норматив заасан бусад зөвшөөрлүүд; болон (в) шаардлагатай тохиолдолд гэрээний 5.6 болон 5.7-д заасан баримт бичгүүд.
5.2.1		<u>Гүйцэтгэгчийн бэлтгэл</u> Захиалагчийн шаардлагад өөрөөр заагаагүй бол Гүйцэтгэгч нь Гүйцэтгэгчийн баримт бичгийг гэрээний 1.4 дүгээр зүйл [*Хэрэглэгдэх Хууль болон Хэл*]-д дурьдсан харилцааны хэлээр үйлдэнэ. Гүйцэтгэгч нь ажлын гүйцэтгэлийн явцад зураг төслийг дуусгах, хэрэгжүүлэх болон өөрийн ажилтандаа зааварчилгаа өгөхөд шаардлагатай Гүйцэтгэгчийн бүх баримт бичиг болон бусад баримт бичгийг бэлтгэнэ.
5.2.2		<u>Захиалагчийн хяналт</u> Энэхүү гэрээний 5.2.2-т: - “Хяналтын хугацаа” гэж 21 хоногоос хэтрэхгүй хугацааг эсхүл Захиалагчийн шаардлагад өөрөөр заасан бол Захиалагч Гүйцэтгэгчийн баримт бичиг болон мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс эхлэн тооцсон хугацааг хэлнэ. - "Гүйцэтгэгчийн баримт бичиг"-т хянуулахаар ирүүлэх шаардлагатай гэж Захиалагчийн шаардлага, эсхүл эдгээр нөхцөлд заагаагүй Гүйцэтгэгчийн баримт бичгийг оруулахгүй харин Гүйцэтгэгчийн баримт бичиг бүрэн бүтэн байхад шаардлагатай бүх баримт бичгийг орно. - “Гүйцэтгэгчийн мэдэгдэл” гэдэгт Гүйцэтгэгчийн холбогдох баримт бичгийг Гүйцэтгэгч өөрөө энэхүү гэрээний 5.2.2-т заасны дагуу хянахад бэлэн гэж үзсэн бөгөөд Захиалагчийн шаардлага болон эдгээр нөхцөлд нийцэж байгаа Мэдэгдлийг ойлгоно. Хэрэв Захиалагчийн шаардлага эсвэл эдгээр нөхцөлд Гүйцэтгэгчийн баримт бичгийг хянуулахаар Захиалагчид хүргүүлэхийг заасан бол уг баримт бичгийг Гүйцэтгэгчийн мэдэгдлийн хамт ирүүлнэ. Захиалагч нь Хяналтын хугацаанд багтаан дараах мэдэгдлийг Гүйцэтгэгчид өгнө:

		(a) Зөвшөөрсөн тухай мэдэгдэл (Ажилд төдийлөн нөлөөлөхгүй жижиг асуудлын талаархи сэтгэгдэлийг багтааж болно); эсвэл (b) Гүйцэтгэгчийн баримт бичиг нь Захиалагчийн шаардлага эсхүл Гэрээтэй нийцэхгүй (заасан хэмжээгээр) байгаа тухай мэдэгдлийг тус тус өгнө. Хэрэв Захиалагч нь Хяналтын хугацааны дотор Мэдэгдэл өгөөгүй бол Захиалагчийг Гүйцэтгэгчийн баримт бичигт Зөвшөөрсөн тухай мэдэгдэл өгсөн гэж үзнэ (Гүйцэтгэгчийн баримт бичигт тулгуурласан бусад бүх Гүйцэтгэгчийн баримт бичгийг (хэрэв байгаа бол) өгсөн, эсхүл өгсөн гэж үзсэн тохиолдолд эсэргүүцэл үзүүлэхгүй байх тухай мэдэгдэлийг олгоно). Гүйцэтгэгчийн зураг төсөл нь гэрээнд нийцэж байгааг нотлохын тулд Гүйцэтгэгчийн нэмэлт баримт бичгүүд шаардлагатай гэж Захиалагч зааварласан бол Гүйцэтгэгч үүнийг өөрийн зардлаар нэн даруй бэлтгэж, захиалагчид хүлээлгэн өгнө. Хэрэв Захиалагч дээрх (b) дэд хэсгийн дагуу мэдэгдэл өгсөн бол Гүйцэтгэгч нь: (a) Гүйцэтгэгчийн баримт бичгийг хянаж засварлана; (b) энэхүү гэрээний 5.2.2-т заасны дагуу хянуулахаар Гүйцэтгэгчийн баримт бичгийг Захиалагчид дахин өгөх бөгөөд Хяналтын хугацааг Захиалагч уг баримт бичгийг хүлээн авсан өдрөөс эхлэн тооцно; мөн (c) Хянаж засварлах, дахин илгээх болон/эсвэл Захиалагч нэмж хянан шалгаснаас үүдэн аливаа саатал бий болсон тохиолдолд Гүйцэтгэгч нь хугацаа сунгах эрх эдлэхгүй. Хэрэв дахин илгээж, нэмж хянан шалгасны үр дүнд Захиалагчид нэмэлт зардал гарвал Захиалагч нь гэрээний 20.2-д заасны дагуу гарсан зардлыг Гүйцэтгэгчээр төлүүлэх эрхтэй.
5.2.3		<u>Барилгын ажил</u> Гэрээний 5.6 болон 5.7-д заасан Гүйцэтгэгчийн баримт бичгээс бусад тохиолдолд Гүйцэтгэгчийн баримт бичгийг хянуулахаар ирүүлэх шаардлагатай ажлын хэсэг тус бүрийг: (a) зураг төсөл, гүйцэтгэлтэй холбоотой Гүйцэтгэгчийн бүх баримт бичгийг Зөвшөөрсөн тухай мэдэгдэл (эсвэл өгсөн гэж үзэх)

		Захиалагчаас ирүүлэх хүртэл уг зураг төсөлтэй холбоотой хэсгийн барилга угсралтын ажлыг эхлүүлэхгүй; (b) Гүйцэтгэгчийн баримт бичигт туссаны дагуу тухайн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх шаардлагатай; мөн (c) Гүйцэтгэгч нь Захиалагчид шалтгаанаа тайлбарласан Мэдэгдэл өгөн, урьд нь Хянуулж, дүгнүүлэхээр танилцуулсан зураг төсөл болон Гүйцэтгэгчийн баримт бичгүүдийг өөрчилж болно. Хэрэв Гүйцэтгэгч эь Ажлын, энэхүү зураг төсөл болон Гүйцэтгэгчийн баримт бичгүүд хамааралтай хэсгийн барилгын ажлыг эхэлсэн бол: (i) тухайн барилга угсралтын ажлыг түр зогсоох (ii) гэрээний 5.2.2-ын (b) хэсгийн дагуу Захиалагч Гүйцэтгэгчийн баримт бичигтэй холбоотой мэдэгдэл хүргүүлсний адилаар 5.2.2 заалтыг хэрэглэнэ (iii) баримт бичигтэй холбоотой Зөвшөөрсөн тухай Мэдэгдлийг Захиалагчаас ирүүлэх (эсхүл ирүүлсэн гэж үзэх) хүртэл уг ажлыг дахин эхлүүлэхгүй.
5.3 **Гүйцэтгэгчийн хүлээх үүрэг**		Гүйцэтгэгч нь зураг төсөл, Гүйцэтгэгчийн баримт бичиг, ажлын гүйцэтгэл болон гүйцэтгэсэн Ажлууд нь дор заасанд нийцсэн байх үүргийг хүлээнэ: (a) Тухайн Улсын хууль тогтоомж; (b) Өөрчлөлтөөр орсон Гэрээний хавсралт дахь баримт бичгүүд
5.4 **Техникийн стандарт болон Норм, дүрэм**		Гүйцэтгэгчийн баримт бичгүүд, ажлын гүйцэтгэл болон гүйцэтгэсэн Ажил нь тухайн Улсын техникийн стандартууд, барилга, байгууламж, байгаль орчны тухай хууль тогтоомжууд, Ажлын үр дүнд бий болсон бүтээгдэхүүнд хэрэглэгдэх хуулиуд болон Захиалагчийн шаардлагад заасан бусад стандартуудад нийцсэн байх ёстой. Эдгээр бүх техникийн болон бусад стандартууд, хуулиуд нь гэрээний 10-д заасны дагуу Захиалагчийн хүлээн авсан үндсэн Ажил болон ажлын хэсэгт давуу эрхтэйгээр үйлчилнэ. Гэрээн дэх стандартын мэдээлэлд өөрөөр заагаагүй бол суурь огноонд нийцүүлэн хийсэн мэдээлэл гэж ойлгоно. Хэрэв тухайн улсад хэрэглэгдэх шинэ эсхүл өөрчлөгдсөн стандартууд нь Суурь огнооны дараа

		хүчин төгөлдөр болсон бол Гүйцэтгэгч нь Захиалагчид нэн даруй мэдэгдэл хүргүүлэн (шаардлагатай бол эсхүл Захиалагч хүсэлт гаргасан тохиолдолд) түүнийг дагаж мөрдөх саналыг илгээнэ. Дараах тохиолдолд: (a) Захиалагч дагаж мөрдөх шаардлагатай гэж үзэж байгаа бөгөөд ингэж дагаж мөрдөх нь ажлын гүйцэтгэлд өөрчлөлт оруулахыг шаарддаг бол; мөн (b) Гүйцэтгэгчийн дагаж мөрдөх санал нь өөрчлөлтийг бүрдүүлж байгаа бол Захиалагч нь 13-д заасны дагуу Өөрчлөлтийг хийнэ.
5.5 **Сургалт**		Хэрвээ Захиалагчийн шаардлагад Гүйцэтгэгч нь Захиалагчийн (болон бусад ажилтан) ажилчдын сургалтыг хариуцахгүй гэж тусгайлан заасан бол энэхүү хэсгийн заалтууд үйлчлэхгүй. Гүйцэтгэгч нь Захиалагчийн ажилчдад (болон Захиалагчийн шаардлагад заагдсан бусад ажилчдын) Ажлын ашиглалт, засвар үйлчилгээ болон бусад чиглэлээр Захиалагчийн шаардлагад заасан хэмжээгээр сургалт явуулна. Хэрэв Захиалагчийн шаардлагад ажлыг хүлээн авахаас өмнө явуулах сургалтын талаар тусгасан бол, сургалт нь Захиалагчийн шаардлагын дагуу явагдаж дуусах хүртэл гэрээний 10.1-ийн дагуу хүлээн авах зорилгоор Ажлыг дууссан гэж үзэхгүй. Сургалтын хугацааг Захиалагчийн шаардлагад тусгасан (тусгаагүй бол Захиалагчийн зөвшөөрөлтэйгээр хийгдэнэ) байх ёстой. Гүйцэтгэгч нь Захиалагчийн шаардлагад тусгасан болон шаардлагатай эрх бүхий туршлагатай сургалтын багш ажилтнууд, сургалтын байр болон сургалтын материалуудаар хангах үүрэгтэй.
5.6 **Барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийн бүртгэл**		Хэрэв Захиалагчийн шаардлагад Гүйцэтгэгч боловсруулж бэлтгэх ёстой гүйцэтгэлийн бүртгэлийг тусгаагүй бол энэ хэсэг хамаарахгүй. Гүйцэтгэгч нь гүйцэтгэсэн ажлынхаа нарийн байршил, хэмжээ ба нарийвчилсан мэдээллийг харуулсан Барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийн талаарх иж бүрэн тэмдэглэлийг боловсруулж бэлтгэх ба байнга шинэчилж байна. Гүйцэтгэлийн тэмдэглэлийн хэлбэр, хэмжээ, харьцуулалтыг систем, цахим хадгалалтын арга хэлбэр болон бусад холбогдох мэдээллүүд нь

		Захиалагчийн шаардлагад заасны дагуу (хэрэв тусгагдаагүй бол Захиалагчийн зөвшөөрснөөр) байх ёстой. Эдгээр гүйцэтгэлийн тайланг ажлын талбайд хадгалах бөгөөд энэхүү хэсэгт заасан зорилгоор гагцхүү ашиглана. Гүйцэтгэгч нь гэрээний 5.2.2-д заасны дагуу Захиалагчид дараахыг илгээнэ: (a) Ажлын төгсгөлд хийх туршилт эхлэхээс өмнө Ажил болог ажлын хэсэгт (нөхцөл байдлаас хамааруулан) хийгдсэн гүйцэтгэлийн бүртгэл; мөн (b) Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн аливаа ажлын хүрээнд шинэчилсэн гүйцэтгэлийн тайлан. Үүнд: (i) 10.1-д заасны дагуу Ажил хүлээн авсан гэрчилгээ олгохоос өмнө Ажлын төгсгөлд хийх туршилтын үер болон дараах; мөн (ii) 10.1-д заасны дагуу Гүйцэтгэлийн гэрчилгээ олгохоос өмнө хүлээн авсны дараах. Энэхүү хэсгийн дагуу гүйцэтгэгчээс ирүүлэх гүйцэтгэлийн бүртгэлийн хувь буюу тоо ширхэг нь гэрээний 1.8-д заасан шаардлагын дагуу байна.
5.7 **Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлага**		Хэрэв Захиалагчийн шаардлагад Гүйцэтгэгч нь ашиглалтын, засвар үйлчилгээний гарын авлагыг бэлтгэхээр заагаагүй бол энэ хэсэг хамаарахгүй. Гүйцэтгэгч нь уг ажилд зориулсан ашиглалт, засвар үйлчилгээний иж бүрэн гарын авлагыг (эдгээр нөхцөл дэх "ашиглалтын болон засвар үйлчилгээний гарын авлага") бэлтгэж, шинэчилж байна. Ашиглалтын болон засвар үйлчилгээний гарын авлагын хэлбэр болон бусад холбогдох дэлгэрэнгүй мэдээлэл нь Захиалагчийн шаардлагад заасны дагуу байх ёстой бөгөөд ямар ч тохиолдолд эдгээр гарын авлагад доорх зүйлсийг зааж өгнө: (a) Захиалагч дараах зүйлийг хийхэд хангалттай дэлгэрэнгүй мэдээлэлтэй байх ёстой. Үүнд: (i) Ажил болон түүний хэсэг, үндсэн техник хэрэгсэлийн үзүүлэлт (хэрэв байгаа бол) нь

		Захиалагчийн шаардлага болон Чанарын үзүүлэлтэд заасан гүйцэтгэлийн шалгуурт нийцэж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд тухайн Ажлыг ашиглах, засвар үйлчилгээ хийх, тохируулах; (ii) Үндсэн техник хэрэгсэлийг ашиглах, засвар үйлчилгээ хийх, задлах, угсрах, тохируулах, засварлах; мөн (b) Захиалагч нь ирээдүйд үндсэн техник хэрэгсэлийг ашиглах, засвар үйлчилгээ хийхэд шаардагдах нөөц сэлбэг хэрэгсэлийн материалыг багтаана. Гүйцэтгэгч нь Хяналт, Туршилт эхлүүлэхийн өмнө гэрээний 5.2.2-т заасны дагуу Ажил болон түүний Хэсэгт зориулсан Ашиглалтын болон засвар үйлчилгээний түр гарын авлагыг Захиалагчид хүргүүлнэ. Хяналт, Туршилтын үеэр Ашиглалтын болон засвар үйлчилгээний түр гарын авлагад ямар нэгэн алдаа, доголдол илэрсэн тохиолдолд Гүйцэтгэгч нь өөрийн зардлаар учирсан алдаа, доголдлыг яаралтай засч залруулна. Гэрээний 10.1-д заасан аливаа Хүлээн авах гэрчилгээг олгохоос өмнө Ашиглалтын болон засвар үйлчилгээний эцсийн гарын авлагыг гэрээний 5.2.2-д заасны дагуу Захиалагчид ирүүлнэ.
5.8 **Зураг төслийн алдаа**		Гүйцэтгэгчийн зураг төсөл болон Гүйцэтгэгчийн баримт бичигт алдаа, орхигдуулсан зүйл, тодорхой бус байдал, зөрчил, дутагдал болон бусад доголдол илэрсэн бол дээрхийг гэрээний 7.5-д заасны дагуу засч залруулна. Гүйцэтгэгчийн уг баримт бичиг нь өмнө нь гэрээний 5.2.2-д заасны дагуу Захиалагчийн өгсөн (эсвэл өгсөн гэж үзсэн) Татгалзах зүйлгүй тухай мэдэгдлийн талаар байсан бол 5.2.2-ын (b) дэд хэсгийн дагуу Гүйцэтгэгчийн баримт бичгийн талаар Захиалагч мэдэгдэл өгсөнтэй адил 5.2.2-т заасан заалтыг хэрэглэнэ. Энэхүү хэсэгт заасан бүх засвар, дахин илгээсэн материалуудын эрсдэл, зардлыг Гүйцэтгэгч хариуцна.

6. АЖИЛТАН БА ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА		
6.1 Ажилтан ба хөдөлмөрийн харилцааг зохион байгуулах		Захиалагчийн шаардлагад өөрөөр заагаагүй бол Гүйцэтгэгч өөрийн бүх ажилтнууд, тэдгээрийн цалин хөлс, хоол хүнс, унаа тээвэр болон байрлах байр, нийгмийн халамжийн асуудлуудыг хариуцан, зохион байгуулж ажиллана.
6.2 Цалингийн хувь хэмжээ болон Хөдөлмөрийн нөхцөл		Гүйцэтгэгч нь ажил явагдаж буй газарт, мөрдөж буй бүх Хуульд нийцсэн бөгөөд тухайн төрлийн ажилд буюу салбарт тогтоосноос доошгүй цалин хөлсийг төлөх ба хөдөлмөрийн орчин нөхцөлийг хангаж мөрдөнө. Хэрэв хүрэлцэхүйч цалингийн хэмжээ болон орчин нөхцөл тогтоогдоогүй бол, Гүйцэтгэгч нь ижил төстэй үйл ажиллагаатай ажил олгогчдын тогтоон мөрдөж буй цалингийн хэмжээ болон хөдөлмөрийн нөхцөлийн тухайн орон нутгийн дундаж түвшингээс доошгүй ажлын хөлсийг төлөх ба хөдөлмөрийн нөхцөлийг хангана.
6.3 Ажилтан ажилд авах		Гүйцэтгэгч нь Захиалагчийн ажилчдаас шинээр ажилтан авах эсхүл авахаар оролдохгүй. Захиалагч нь Гүйцэтгэгчийн ажилчдаас шинээр ажилтан авах эсхүл авахаар оролдохгүй.
6.4 Хөдөлмөрийн тухай хууль тогтоомж		Гүйцэтгэгч нь түүний ажилчдын ажил эрхлэлтийн (цалин хөлс ба ажлын цагийг оролцуулсан), эрүүл мэндийн, аюулгүй байдлын, нийгмийн хамгааллын, цагаачлалын ба гадаад руу цагаачлах тухай хууль зэргийг хамруулсан, Гүйцэтгэгчийн ажилчдад хамааралтай, хөдөлмөрийн холбогдох бүх Хуулийг дагаж мөрдөх ба тэднийг хууль ёсны бүх эрхээ эдлэх боломжоор хангана. Гүйцэтгэгч нь ажлын байран дахь аюулгүй байдалтай холбоотой хуулийг багтаан холбогдох Хууль, тогтоомжийг дагаж мөрдөхийг өөрийн нийт ажилчдаас шаардах ёстой.
6.5 Ажлын цаг		Дор дурдсанаас бусад тохиолдолд, Гэрээний өгөгдөлд заасан, орон нутгийн хэмжээнд зөвшөөрөгдсөн амралтын өдрүүдэд, эсхүл ажлын өдрийн хэвийн цагаас гадуур ажлын Талбай дээр ажил гүйцэтгэхийг хориглоно: (а) Гэрээнд өөрөөр заасан;

		(b) Инженер зөвшөөрөл өгсөн; эсхүл (c) амь нас, эд хөрөнгийг хамгаалахад, эсхүл Ажлын аюулгүй, бүрэн бүтэн байдлыг хангахын тулд ажлыг хийхээс өөргүй болсон, эсхүл хийх шаардлагатай болсон тохиолдолд Гүйцэтгэгч нь хийх шаардлагатай ажлыг болон түүний шалтгааныг тодорхой дурдсан Мэдэгдлийг Инженерт яаралтай өгнө.
6.6 Ажилчдын байр, сууц		Захиалагчийн шаардлагад өөрөөр заагаагүй бол, Гүйцэтгэгч нь өөрийн ажилчдад зориулан шаардлагатай бүх байр, сууц, ахуйн хангамжийн барилга байгууламжаар хангах ба тэдгээрийг засварлаж арчилна. Хэрэв эдгээр байр, сууц ба барилга байгууламж нь Захиалагчаас Гүйцэтгэгчид урьдчилан өгсөн зөвшөөрөлтэйгөөс бусад тохиолдолд Ажлын талбай дээр байрлах бол, тэдгээр нь Захиалагчийн шаардлагад заасан талбайн дотор байрших ёстой. Хэрэв эдгээр байр, сууц ба барилга байгууламж нь Ажлын талбайн бусад хэсэгт баригдсан байвал Гүйцэтгэгч тэдгээрийг өөрийн зардлаар нэн даруй зайлуулах ба эрсдэлийг өөрөө хариуцна. Гүйцэтгэгч нь Захиалагчийн ажилчдыг Захиалагчийн шаардлагад заасны дагуу байр, суулцаар мөн хангана.
6.7 Хөдөлмөрийн аюулгүй байдал		Гүйцэтгэгч нь 4.8-ийн шаардлагууд дээр нэмээд, өөрийн ажилчдын эрүүл мэндийг хамгаалах ба аюулгүй байдлыг хангах урьдчилан сэргийлэх бүх шаардлагатай арга хэмжээг цаг ямагт авна. Гүйцэтгэгч нь орон нутгийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран: (a) Бүхий л хугацаанд Гүйцэтгэгчийн болон Захиалагчийн ажилчдад зориулсан байранд, Захиалагчийн шаардлагад заасны дагуу эмнэлгийн ажилтныг ажиллуулах, анхны тусламжийн хэрэгслүүдийг бэлэн байлгах, эмнэлгийн булан байгуулах, түргэн тусламжийн болон эмнэлгийн аливаа бусад үйлчилгээг үзүүлэх боломжийг бүрүүлэх; (b) шаардлагатай ахуйн нөхцөлийг бүрдүүлэх, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг мөрдүүлэх болон тахал, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зохион байгуулалтын тохиромжтой бүх арга хэмжээг авсан байна.

		Гүйцэтгэгч нь осол аваараас урьдчилан сэргийлэх, мөн эрүүл мэнд аюулгүй ажиллагааны дүрмийг сахиулах ажлыг хариуцан ажиллах эрүүл мэнд ба аюулгүй ажиллагааны албан тушаалтныг Ажлын талбай дээр томилсон байна. Тухайн ажилтан нь: (i) энэ чиглэлээр мэргэшсэн, туршлагатай бөгөөд энэхүү үүргийг биелүүлэх чадвартай байх; ба (ii) Ажлын талбайд нэвтрэх эрх бүхий ба/эсхүл тэнд ажиллаж байгаа бүх хүний эрүүл мэнд ба аюулгүй байдлыг хангах болон осол аваараас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах талаар удирдамж, зааварчилгаа өгөх эрхтэй байна. Гүйцэтгэгч нь Ажлыг гүйцэтгэх нийт хугацааны туршид энэхүү ажилтанд, хариуцсан үүргээ биелүүлэхэд нь шаардлагатай бүх зүйл болон эрх мэдлээр хангах үүрэгтэй.
6.8 Гүйцэтгэгчийн удирдлага хяналт		Ажил эхлэх өдрөөс Гүйцэтгэлийн гэрчилгээг олгох хүртэл Гүйцэтгэгч нь Ажлыг төлөвлөх, гүйцэтгэлийг зохион байгуулах, удирдах, чиглүүлэх, үзэж шалгах, турших ба хянах шаардлагатай бүх удирдлагаар хангана. Удирдлага хяналт нь хангалттай тооны хүнээс бүрдсэн байна: a) харилцаж буй хэлээр чөлөөтэй ярьж, бичдэг, эсхүл тухайн хэлний зохих мэдлэгтэй (1.4-д заасан); b) Ажлыг аюулгүй бөгөөд чанартай гүйцэтгэхэд хийгдэх бүх төрлийн ажлын (тулгарч болзошгүй эрсдэлийн шаардлагатай арга техник, түүнчлэн осол аваараас урьдчилан сэргийлэх аргыг хамруулсан)
6.9 Гүйцэтгэгчийн ажилтан		Гүйцэтгэгчийн ажилтан нь (хэрэв байгаа бол Түлхүүр ажилтнуудыг оролцуулан) тус тусын эрхэлсэн ажил, эсхүл мэргэжлээрээ зохих хэмжээнд мэргэшсэн, ур чадвартай ба туршлагажсан хүмүүс байна. Захиалагч нь, Ажилд буюу Ажлын талбай дээр ажиллуулж буй, (хэрэв байгаа бол), Гүйцэтгэгчийн Төлөөлөгч болон Түлхүүр ажилтнуудыг оролцуулан, доорх дутагдал гаргасан аливаа хүнийг халахыг

		(эсхүл халах нөхцөлийг хангахыг) Гүйцэтгэгчээс шаардаж болно: (a) сахилга батыг байнга зөрчдөг, анхаарал хянамж муутай; (b) албан үүргээ гүйцэтгэхдээ чадвар муутай, хайхрамжгүй ханддаг; (c) Гэрээний аливаа заалтыг мөрддөггүй; (d) аюулгүй байдал, эрүүл мэнд, эсхүл байгаль орчныг хамгаалахад сөргөөр нөлөөлөх аливаа үйлдлийг байнга хийдэг; (e) зохих нотлох баримтын үндсэн дээр авлига, залилан, үгсэн хуйвалдсан, эсхүл хүч хэрэглэсэн үйл явдалд оролцсон нь илэрхий болсон; эсхүл (f) 6.3-ийг зөрчин Захиалагчийн ажилтнуудаас ажилд авсан. Шаардлагатай тохиолдолд Гүйцэтгэгч нь солиход тохиромжтой орны хүнийг томилно (эсхүл томилох нөхцөлийг хангана). Гүйцэтгэгчийн Төлөөлөгчийг солих тохиолдолд, 4.3-ийг хэрэглэнэ. Түлхүүр ажилтнуудыг (хэрэв байгаа бол) солих тохиолдолд, 6.12-ийг хэрэглэнэ.
6.10 Гүйцэтгэгчийн бүртгэл		Гүйцэтгэгч санал болгож, Захиалагч зөвшөөрснөөс бусад тохиолдолд, Гүйцэтгэгч нь 4.20-ийн дагуу гаргах сар тутмын явцын тайландаа доор дурдсан зүйлсийн бүртгэлийг, Ажлын нарийвчилсан төлөвлөгөөнд үзүүлсэн ажил тус бүр дээр, ажил явагдаж байгаа байршил тус бүр дээр, мөн ажлын өдөр тус бүрээр гаргаж тусгана: (a) Гүйцэтгэгчийн ажилчдын албан тушаалын ба тэдгээрийн ажилласан бодит цаг (b) Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийн нэр төрөл тус бүрийн ба тэдгээрийн ажилласан бодит цаг (c) ашиглаж буй Түр ажлын нэр төрөл (d) Байнгын ажилд зориулан суурилуулсан Үндсэн техник хэрэгсэлийн нэр төрөл; ба (e) Хэрэглэсэн Материалын нэр төрлийн ба тэдгээрийн тоо хэмжээ
6.11 Сахилгын зөрчил		Гүйцэтгэгчийн ажилчдын зүгээс болон тэдний дунд хууль бус, үймж танхайрсан үйлдэл гаргах буюу нийгмийн хэв журам зөрчих явдлаас урьдчилан сэргийлэх бүхий л шаардлагатай арга хэмжээг Гүйцэтгэгч бүх хугацааны туршид авч хэрэгжүүлэх ба Ажлын талбай дээр болон түүний ойролцоо байгаа

		хүмүүсийн амар тайван байдал болон өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаална.
6.12 Түлхүүр ажилтнууд		Хэрэв Захиалагчийн шаардлагад Түлхүүр ажилтнуудын талаар тусгаагүй бол энэхүү хэсгийг хэрэглэхгүй. Гүйцэтгэгч нь Тендерт Түлхүүр ажилтнуудын албан тушаалд нэр заагдсан хүмүүсийг томилох ёстой. Хэрэв тэгж нэр заагдаагүй, эсхүл томилогдсон хүн нь холбогдох Түлхүүр ажилтны албан тушаалд ажиллаж чадахгүй байгаа бол Гүйцэтгэгч нь түүний оронд энэхүү албан тушаалд томилохоор төлөвлөж буй өөр хүний нэр ба дэлгэрэнгүй мэдээллийг зөвшөөрөл авахаар Захиалагчид хүргүүлнэ. Хэрэв зөвшөөрөл өгөхөөс татгалзсан, эсхүл зөвшөөрлөө дараа нь хүчингүй болгосон бол, Гүйцэтгэгч нь энэхүү албан тушаалд оронд нь ажиллах тохиромжтой хүний нэр ба дэлгэрэнгүй мэдээллийг мөн адилаар хүргүүлнэ. Хэрэв Захиалагч нь аливаа ийм мэдээллийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор, энэхүү албан тушаалд тухайн хүнийг томилохоос (эсхүл оронд нь сольж ажиллуулахаас) татгалзсан тухайгаа дурдсан мэдэгдэл илгээн хариу өгөөгүй бол, Захиалагчийг зөвшөөрлөө өгсөн гэж үзнэ. Гүйцэтгэгч нь Захиалагчийн урьдчилсан зөвшөөрөлгүйгээр аливаа Түлхүүр ажилтнуудын томилгоог хүчингүй болгохгүй, мөн түүнийг өөр хүнээр солихгүй (хэрэв тухайн хүн нас барах, өвчлөх, хөдөлмөрийн чадвараа алдах, эсхүл огцрох зэргээс шалтгаалан үүргээ биелүүлэх чадамжгүй болсон бол, энэ тохиолдолд түүний томилгоог шууд хүчингүй болсонд тооцох ба оронд нь хийх томилгоог Захиалагчаас зөвшөөрөл өгөх хүртэл, эсхүл энэхүү хэсгийн дагуу орны өөр хүнийг томилох хүртэл түр томилгоо гэж үзнэ). Ажил хийгдэх нийт хугацааны туршид бүх Түлхүүр ажилтнууд нь Талбайд (эсхүл, ажлууд Талбайн гадна хийгдэж байвал тухайн ажлын байршилд) суурин байрлаж ажиллана. Хэрэв Ажлыг гүйцэтгэх явцад аль нэг Түлхүүр ажилтан түр хугацаагаар явах бол, тохирох хүнийг түүний оронд Захиалагчийн урьдчилсан зөвшөөрөлтэйгөөр түр томилно.

		Бүх Түлхүүр ажилтнууд нь 1.4-д заасан харилцааны хэлээр чөлөөтэй ярьж, бичдэг байна.
7. ҮНДСЭН ТЕХНИК ХЭРЭГСЭЛ, БАРАА МАТЕРИАЛ БОЛОН АЖЛЫН УР ЧАДВАР		
7.1 **Ажил гүйцэтгэх арга барил**		Гүйцэтгэгч нь үндсэн техник хэрэгсэлийн хангалт, угсралт болон зүгшрүүлж ашиглалтад оруулах болон засвар үйлчилгээг түүнчлэн материалын олборлолт, үйлдвэрлэлт, хангалт болон туршилт шинжилгээг, мөн Ажлыг гүйцэтгэх үед явцад хийгдэх бусад бүх үйл ажиллагааг дараах байдлаар гүйцэтгэнэ: (a) Гэрээнд заасан (хэрэв байгаа бол)- арга хэлбэрээр; (b) Нийтэд танигдсан оновчтой арга туршилтын дагуу мэргэжлийн өндөр түвшинд, анхаарал, хянамгай байдлаар; мөн (c) Гэрээнд өөрөөр зааснаас бусад тохиолдолд зүй ёсоор тоноглогдсон тоног төхөөрөмж, хэрэгсэл болон аюулгүй Бараа материалаар хийнэ.
7.2 **Материалын дээж**		Гүйцэтгэгч нь бараа материалыг Ажилд ашиглахын өмнө дараах материалын дээж, холбогдох мэдээллийг захиалагчид ирүүлж зөвшөөрөл авна: (a) Гүйцэтгэгчийн зардлаар гэрээнд заасан материалын дээжүүд; мөн (b) Өөрчлөлтийн журмаар Захиалагчаас зааварчилсан нэмэлт дээжүүд. Дээж тус бүр нь гарал үүслээр нь болон Ажилд хэрэглэгдэх зориулалтаар нь тэмдэглэсэн шошготой байна.
7.3 **Үзлэг, шалгалт**		Захиалагчийн ажилтнууд нь Гэрээний өгөгдөлд заасан ердийн ажлын цагаар болон бусад тохиромжтой ямар ч үед: (a) Ажлын талбайн бүх хэсэгт болон байгалийн гаралтай Материалыг олборлож буй бүх газруудад бүрэн нэвтрэх эрхтэй байна; (b) Үйлдвэрлэл, боловсруулалт, болон барилгын ажлын явцад (талбай дээр болон өөр бусад хэсэгт): (i) Материал, үндсэн техник хэрэгсэл болон ажлын ур чадварын түвшинд (захиалагчийн шаардлагад заасан хэмжээгээр) үзлэг хийх, шалгах, судлах, хэмжих, турших, шинжлэх,

		(ii) Үндсэн техник хэрэгсэл болон бараа, материалын боловсруулалт, үйлдвэрлэлийн явцыг шалгах, мөн (iii) Бүртгэл, тайланг бэлтгэх, боловсруулах (гэрэл зураг болон видео бичлэгийг оролцуулан); мөн (c) Эдгээр нөхцөлд болон Захиалагчийн шаардлагад заасан бусад үүрэг, хяналтыг хэрэгжүүлэх. Гүйцэтгэгч нь Захиалагчийн ажилтнуудад талбайд нэвтрэх, байр сууцыг ашиглах, зөвшөөрөл олгох ба аюулгүй ажиллагааны хэрэгслээр хангах зэргийг хамруулсан эдгээр үйл ажиллагаануудыг явуулах бүх боломж бололцоог олгоно. Шалгах, хянах, хэмжих болон турших эрх олгогдсон Захиалагчийн ажилтнуудын ажлын тухайд Гүйцэтгэгч нь аливаа Материал, үндсэн техник хэрэгсэл, эсхүл ажил үзлэг шалгалтад бэлэн болмогц, түүнийг хучих, булж далдлах, эсхүл хадгалах зориулалтаар баглаж савлах болон тээвэрлэхээс өмнө Захиалагчид мэдэгдэл өгнө.Үүний дараа Захиалагчийн ажилтнууд шалгалт, хяналт, хэмжилт, туршилтыг шалтгаангүй хоцроохгүйгээр хийж гүйцэтгэнэ эсхүл Захиалагчийн ажилтнууд тэдгээрийг хийх шаардлагагүй гэсэн мэдэгдлийг Захиалагч Гүйцэтгэгчид нэн даруй хүргүүлнэ. Хэрвээ Захиалагч нь дээрх мэдэгдэлийг өгөөгүй эсхүл Захиалагчийн ажилтан нь Гүйцэтгэгчийн мэдэгдэл (эсвэл Гүйцэтгэгчтэй тохиролцсон хугацаанд)-д заасан хугацаанд ирж оролцоогүй бол Гүйцэтгэгч нь хучих, булж далдлах, эсхүл хадгалах зориулалтаар баглаж савлах болон тээвэрлэх зэрэг үйл ажиллагаагаа үргэлжлүүлж болно. Гүйцэтгэгч нь энэхүү зүйлийн дагуу мэдэгдэл өгөөгүй тохиолдолд Захиалагч шаардсан үед уг ажлыг ил гаргах, дараа нь засаж янзлан анхна байдалд нь оруулах бүх ажлыг Гүйцэтгэгч өөрийн зардлаар гүйцэтгэх ба эрсдэлийг өөрөө хариуцна.
7.4 **Гүйцэтгэгчийн хийх туршилт**		Гэрээний 12-д өөрөөр заагаагүй бол энэхүү хэсэг нь Гэрээнд заасан бүх туршилтын ажиллагаанд хэрэглэгдэнэ. Гүйцэтгэгч нь дурдсан туршилтыг зохих ёсоор нь бөгөөд үр дүнтэй явуулахад шаардлагатай бүх аппарат, тусламж дэмжлэг, баримт бичгүүд болон

		бусад холбогдох бусад мэдээлэл, цахилгаан эрчим хүч, ус, тоног төхөөрөмж, шатахуун, хэрэглээний зүйлс, багаж хэрэгсэл, ажилллах хүч, бараа материал болон тохирох мэргэжлийн, ур чадвар, туршлагатай ажилтнаар туршилтын хугацаанд хангана. Бүх аппарат, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг Захиалагчийн шаардлагад заасан, эсхүл мөрдөж буй Хуулиудад тодорхойлсон стандартуудын дагуу шалгаж тохируулсан байх ба хэрэв Захиалагчаас хүсвэл, Гүйцэтгэгч нь шалгалт, тохируулалтын гэрчилгээг туршилт явуулахаас өмнө танилцуулна. Гүйцэтгэгч нь аливаа үндсэн техник хэрэгсэл, материал болон ажлын бусад хэсгүүдэд хийхээр заасан туршилт, шинжилгээг хийхдээ Захиалагчид албан бичгээр хугацаа болон байршлыг нь заасан мэдэгдэлийг хүргүүлнэ. Захиалагчийн ажилчдыг оролцуулах үүднээс туршилтын байршлыг харгалзан боломжит хугацаанд энэүү Мэдэгдлийг хүргүүлнэ. Захиалагч нь гэрээний 13-д заасны дагуу туршилтыг явуулах байршил, хугацаа болон нарийн мэдээллийг өөрчлөх эсхүл нэмэлт туршилт явуулах талаар Гүйцэтгэгчид зааварчилгаа өгч болно. Хэрэв тэдгээр өөрчлөгдсөн эсхүл нэмэлт туршилтын үр дүнд туршигдсан үндсэн техник хэрэгсэл, Бараа материал болон ажлын ур чадвар нь Гэрээнд заасантай нийцэхгүй байгаа нь тогтоогдвол уг Өөрчлөлтийг гүйцэтгэснээс үүдэн гарах зардал, саатлыг Гүйцэтгэгч хариуцна. Захиалагч нь туршилтад биечлэн оролцох хүсэлтэй байгаа тухайгаа Гүйцэтгэгчид 72-оос доошгүй цагийн өмнө мэдэгдэнэ. Захиалагч нь энэхүү Дэд зүйлийн дагуу Гүйцэтгэгчийн мэдэгдэлд заасан цаг болон газарт хүрэлцэн ирээгүй тохиолдолд мөн Захиалагч талаас өөр зааварчилгаа өгөөгүй бол Гүйцэтгэгч нь туршилтыг үргэлжлүүлэн хийнэ. Энэхүү тохиолдолд эдгээр туршилтыг Захиалагчийг биечлэн оролцуулан хийсэн хэмээн үзнэ. Хэрэв Гүйцэтгэгч нь эдгээр зааварчилгааг дагаж мөрдсөнөөр эсхүл Захиалагчийн хариуцлагаас болж хугацаа хожимдсон эсхүл илүү Зардал гарсан тохиолдолд Гүйцэтгэгч нь гэрээний 20.2-т заасан нэмэлт хугацаа тогтоолгох эсхүл ашиг шингэсэн үнийг төлүүлэх эрхийг эдэлнэ. Гүйцэтгэгч нь заасан туршилтуудын (төрөл бүрийн болон нэмэлт туршилтуудыг оруулаад) хугацааг

		хожимдуулсан бөгөөд үүний улмаас Захиалагчийг илүү зардал гаргахад хүргэсэн бол Захиалагч гэрээний 20.2-ийн дагуу эдгээр зардлыг Гүйцэтгэгчээр төлүүлэх эрхтэй. Гүйцэтгэгч нь зохих ёсоор баталгаажсан туршилтын тайланг Захиалагчид нэн даруй хүргүүлнэ. Заасан туршилтууд шаардлага хангасан тохиолдолд Захиалагч нь Гүйцэтгэгчийн туршилтын гэрчилгээг баталгаажуулах эсхүл Гүйцэтгэгчид туршилтын гэрчилгээг олгоно. Захиалагч нь туршилтын ажилд оролцоогүй бол түүнийг туршилтын үзүүлэлт, үр дүнг үнэн зөв хэмээн хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ. Ажлын үндсэн техник хэрэгсэл, бараа материал болон бусад бүрдэл хэсгүүд нь заасан туршилтанд тэнцээгүй тохиолдолд гэрээний 7.5-ийг хэрэглэнэ.
7.5 **Доголдол ба Татгалзал**		Хэрэв үзлэг, хяналт шалгалт, хэмжилт болон туршилтын үр дүнгээр үндсэн техник хэрэгсэл, бараа материал, зураг төсөл нь доголдолтой болон ажлын ур чадвар нь хангалтгүй эсхүл Гэрээнд заасантай нийцэхгүй байгаа тохиолдолд Захиалагч нь доголдолтой гэж үзсэн үндсэн техник хэрэгсэл, бараа материал, зураг төсөл нь доголдолтой болон ажлын ур чадвар нь хангалтгүй байгаа талаар тайлбарласан мэдэгдлийг Гүйцэтгэгчид өгнө. Ийнхүү Гүйцэтгэгч нь нэн даруй тухайн доголдлыг засварлах санал боловсруулан хүргүүлнэ. Захиалагч уг саналыг хянаж үзээд хэрэв энэхүү шийдлээр хийж гүйцэтгэвэл гэрээнд заасан тухайн үндсэн техник хэрэгсэл, бараа материал, Гүйцэтгэгчийн зураг төсөл болон ажлын ур чадвартай нийцэхгүй гэж үзвэл албан бичгээр үүнийгээ тодорхойлж Гүйцэтгэгчид мэдэгдэл илгээж болно. Энэхүү мэдэгдлийг авсны дараа Гүйцэтгэгч нэн даруй саналаа шинэчилж Захиалагчид илгээх ёстой. Хэрэв Захиалагч Гүйцэтгэгчийн санал болгосон шийдэлд (эсхүл шинэчилж өгсөн шийдэл) 14 хоногийн дотор албан бичгээр хариу өгөхгүй бол Захиалагч Зөвшөөрсөн тухай мэдэгдэл илгээсэн гэж үзнэ. Гүйцэтгэгч засварын ажлын санал (эсвэл шинэчилсэн санал)-ыг нэн даруй ирүүлээгүй, эсхүл Захиалагч зөвшөөрсөн тухай мэдэгдэл өгөн (эсвэл өгсөн гэж

		үзсэн) санал болгосон засварын ажлыг гүйцэтгээгүй бол Захиалагч нь: (a) Гэрээний 7.6-ийн (a) эсвэл (b) хэсгийн дагуу Гүйцэтгэгчид зааварчилгаа өгөх; эсвэл (b) Гэрээний 11.4-ийн (a) дахь хэсгийг хэрэглэх тохиолдолд Гүйцэтгэгчид үндэслэл бүхий мэдэгдэл өгөх замаар зураг төсөл, үндсэн техник хэрэгсэл, бараа материал, ажлын ур чадвараас татгалзана. Аливаа үндсэн техник хэрэгсэл, бараа материал, зураг төсөл, ажлын ур чадвар дахь доголдлыг засварласны дараа хэрэв Захиалагч зарим ажлуудад дахин туршилт хийхийг шаардвал гэрээний 7.4-ийн дагуу туршилтыг Гүйцэтгэгчийн эрсдэл, зардлаар давтан хийнэ. Татгалзсан болон дахин туршилт хийснээр Захиалагчийг нэмэлт зардал гаргахад хүргэсэн бол гэрээний 20.2-д заасны дагуу Захиалагч эдгээр зардлыг Гүйцэтгэгчээр төлүүлэх эрхтэй.
7.6 **Засварлан сайжруулах ажил**		Ажил хүлээн авах гэрчилгээг олгохоос өмнө Захиалагч хэдийд ч хамаагүй өмнө нь хийгдсэн хяналт, шалгалт, хэмжилт, туршилт, туршилтын гэрчилгээ болон Захиалагчийн зөвшөөрсөн тухай мэдэгдэл зэрэг албан бичигт нэмэлтээр дараах зааварчилгааг өгч болно. Үүнд: (a) Гэрээний шаардлагад нийцээгүй аливаа үндсэн техник хэрэгсэл эсхүл бараа материалын доголдлыг арилгах эсхүл Ажлын талбайгаас гаргах, солих/орлуулах, засч залруулах (шаардлагатай бол Ажлын талбайгаас гадуур); (b) Гэрээнд нийцээгүй аливаа бусад ажлыг засах, зайлуулах, дахин гүйцэтгэх; (c) Осол, урьдчилан таамаглашгүй нөхцөл байдал болон бусад зүйлээс шалтгаалж аливаа ажлын аюулгүй байдалд нөлөөлсөн бөгөөд нэн яаралтай засч сайжруулах ажлыг хийж гүйцэтгэх Гүйцэтгэгч шаардлагыг аль болох боломжит хугацаанд биелүүлэх бөгөөд шаардлагад заасан хугацаанаас (хэрэв байвал) хэтрүүлэхгүй байх эсхүл дээрх (c) хэсгийн дагуу хойшлуулж болзошгүй нөхцөлд нэн даруй арга хэмжээ авна. Дээрх (c) хэсэгт заасан аливаа ажил нь дараах зүйлтэй хамааралтай биш бол энэ хэсэгт заасан бүх

		засварын ажлын зардлыг Гүйцэтгэгч хариуцна. Дараах зүйлсэд: (i) Захиалагч эсхүл Захиалагчийн төлөөлөгчийн үйлдлээс шалтгаалж Гүйцэтгэгчид энэхүү ажлыг хийж гүйцэтгэхэд хугацааны хоцрогдол эсхүл зардал бий болсон бол Гүйцэтгэгч 20.2-т заасны дагуу нэмэлт хугацаа тогтоолгох эсхүл ашиг шингэсэн үнийг нэхэмжлэх эрхтэй. (ii) Давагдашгүй хүчин зүйл бий болсон тохиолдолд гэрээний 18.4-ийг хэрэглэнэ. Хэрэв Гүйцэтгэгч Захиалагчийн өгсөн шаардлагыг биелүүлж чадаагүй бол, Захиалагч өөр хуулийн этгээдийг хөлслөн авч тухайн ажлыг гүйцэтгүүлж болно. Энэхүү хэсэгт заасан Гүйцэтгэгч тухайн ажлын төлбөрийг төлөхөөс бусад тохиолдолд гэрээний 20.2-ийн дагуу Захиалагч нь Гүйцэтгэгчийн алдаанаас шалтгаалж үүссэн бүх зардлыг төлүүлэх эрхтэй. Энэхүү эрхийн хүрээнд Захиалагч гэрээний дагуу бусад эрхэд халдахгүй байх ёстой
7.7 **Үндсэн техник хэрэгсэл болон бараа материалын өмчлөл**		Үндсэн техник хэрэгсэл болон бараа материалын аливаа зүйл тус бүр нь тухайн Улсын Хууль тогтоомжид заасан үндсэн шаардлагуудыг бүрэн хангах ёстой бөгөөд доорх дэд хэсгүүдийн заалтуудыг хангасан тохиолдолд ямар нэг барьцаа, саадгүйгээр Захиалагчийн өмч болно. Үүнд: (a) Ажлын талбайд хүргэгдсэн бол; (b) Гүйцэтгэгч нь гэрээний 8.11-д заасны дагуу үндсэн техник хэрэгсэл болон бараа материалын үнийг төлсөн бол; Гүйцэтгэгч нь гэрээний 14.5-д заасны дагуу тогтоосон үндсэн техник хэрэгсэл болон бараа материалын үнийг төлсөн бол.
7.8 **Роялти [Нөөц/баялаг ашигласны төлбөр]**		Захиалагчийн шаардлагад өөрөөр заагаагүй бол Гүйцэтгэгч бүх нөөц ашигласны төлбөр, түрээс мөн дараах зүйлтэй хамаарал бүхий бусад төлбөрүүдийг төлөх үүргийг хүлээнэ. Үүнд: (a) Ажлын талбайн гаднаас байгалийн эх үүсвэр бүхий Материал авч ашигласны төлбөр; (b) Захиалагчийн шаардлагад заасан Ажлын талбай доторх хог хаях цэгээс бусад, газар шороо, ухмал, нураалтын ажлаас гарсан материалын хог хаягдал болон бусад хаягдал

		материалыг (байгалийн эсхүл хүний бүтээсэн) зайлуулах/хаях төлбөр.
8.1 **Ажил эхлүүлэх**		Ажил эхлэх огноог Гэрээний хэлэлцээрт заагаагүй бол Захиалагч нь ажил эхлэхээс өмнө 14-өөс доошгүй хоногийн дотор Ажил эхлэх огноог заасан мэдэгдлийг Гүйцэтгэгчид өгнө. Тусгай нөхцөлд өөрөөр заагаагүй бол Ажил эхлэх огноо нь гэрээний 1.6 дахь хэсэгт заасны дагуу Гэрээ бүрэн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 42 хоногийн дотор байна. Гүйцэтгэгч ажил эхэлсэн өдрөөс хойш Ажлыг аль болох хурдан эхлүүлж, түргэн шуурхай, сааталгүй үргэлжлүүлнэ.
8.2 **Ажил дуусгах хугацаа**		Гүйцэтгэгч нь ажлыг бүхэлд нь эсхүл ажлыг хэсэгчлэн (хэрвээ байвал) ажил дуусах хугацаанд заагдсан (тухайн нөхцөл байдлаас хамаарч) хугацаанд дуусгах бөгөөд үүнд гэрээний 10.1 дэх хэсэгт нийцүүлсэн байдлаар Гэрээнд заасан бүхий л ажлыг хийж дуусгана.
8.3 **Ажлын календарчилсан төлөвлөгөө**		Гүйцэтгэгч нь гэрээний 8.1 дэх хэсэгт заасны дагуу мэдэгдэл хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор ажил гүйцэтгэх анхны Ажлын календарчилсан төлөвлөгөөг Захиалагчид хүргүүлнэ. Энэхүү Ажлын календарчилсан төлөвлөгөөг Захиалагчийн шаардлагад заасан программ хангамжийг (хэрэв заагаагүй бол Захиалагчийн зөвшөөрсөн программ хангамж) ашиглан бэлтгэнэ. Тусгай нөхцөлд өөрөөр заагаагүй бол аливаа Ажлын календарчилсан төлөвлөгөө нь бодит гүйцэтгэлийг илтгээгүй эсвэл Гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэгт нийцэхгүй байгаа тохиолдолд Гүйцэтгэгч нь ажлын бодит гүйцэтгэлийг үнэн зөв тусгасан шинэчилсэн Ажлын календарчилсан төлөвлөгөөг хүргүүлнэ. Анхны болон хянаж шинэчилсэн Ажлын календарчилсан төлөвлөгөөг гэрээний өгөгдөлд заасны дагуу нэг цаасан хувь, нэг цахим хувь, нэмэлт цаасан хуулбар (хэрэв байгаа бол)-аар Захиалагчид ирүүлэх бөгөөд үүнд: (a) Ажил болон ажлын бүрдэл хэсгийн ажлуудын (хэрвээ байвал) ажил эхлэх огноо болон ажил дуусах хугацаа;

		(b) 2.1 дэх хэсэгт заасан Гүйцэтгэгчийг ажлын талбайд нэвтрэх, бүхэлд нь болон хэсэгчилэн эзэмших (хэсэг тус бүрээр) эрхийг олгосон өдөр. (c) Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэх төлөвлөлтийн дараалал ба үүнд зураг төслийг ажлын (хэрвээ байвал) үе шат бүрийн төлөвлөлт, Гүйцэтгэгчийн баримт бичгийг бэлтгэн боловсруулах болон хүргүүлэх, ханган нийлүүлэлт, үйлдвэрлэл, хяналт, Ажлын талбай руу тээвэрлэх, хүргэх, барилга угсралт, угсралт, суурилуулалт болон аливаа нэр дэвшүүлсэн Туслан гүйцэтгэгчийн (4.5 дэх хэсэгт заасны дагуу нэрлэсэн) гүйцэтгэх ажил болон туршилт, туршилтын ажиллагааг хийхэд шаардагдах, хүлээгдэж буй хугацааг хамруулсан, Ажлыг гүйцэтгэхдээ Гүйцэтгэгчээс баримтлахаар төлөвлөсөн дэс дараалал; (d) 5.2.2 дахь хэсэгт заасан Хяналтын хугацаа болон Захиалагчийн шаардлагад заасан эсхүл Гэрээний нөхцөлөөр шаардсан аливаа хүргүүлсэн/ирүүлсэн мэдээлэл, баримт бичгийг хянаж, шалгах хугацаа; (e) Гэрээнд заасан эсхүл гэрээний дагуу шаардсан шалгалт, туршилт, шинжилгээ хийх дараалал болон хугацаа; (f) Ажлын хянаж шинэчилсэн Ажлын календарчилсан төлөвлөгөөнд: Захиалагчаас 7.5 дэх хэсэгт заасны дагуу Зөвшөөрсөн тухай мэдэгдэл өгсөн эсхүл 7.6 дахь хэсэгт заасны дагуу засварлах ажил (хэрвээ байвал) өгсний дагуу уг засварлах (хэрвээ байвал) ажлуудын дараалал болон хугацаа; (g) Учир зүйн хувьд хоорондоо уялдсан бөгөөд үйл ажиллагаа тус бүрийн хамгийн эрт эхлэх ба хамгийн оройтож дуусах хугацааг харуулсан бүх үйл ажиллагааг (Захиалагчийн шаардлагад нарийвчлан заасан түвшинд), цонхтой цагийг (хэрэв байгаа бол) ба эгзэгтэй зам; (h) Тухайн бүс, нутгийн албан ёсны амралтын болон баяр ёслолын өдрүүд (хэрвээ байвал); (i) Үндсэн техник хэрэгсэл болон бараа материалын нийлүүлэлт/хүргэлтийн бүх үндсэн хугацаа; (j) Ажлын хянаж шинэчилсэн Ажлын календарчилсан төлөвлөгөө болон үйл ажиллагаа бүрт: өнөөгийн бодит явцыг, ажлын явцад гарсан аливаа хоцролт ба түүний бусад үйл ажиллагаанд үзүүлж буй нөлөөг (хэрэв байгаа бол); ба (k) Дараах зүйлсийг багтаасан дагалдах тайлан:

		(i) Ажлын гүйцэтгэлийн голлох/томоохон үе шатуудын тодорхойлолт; (ii) Гүйцэтгэгч Ажлын гүйцэтгэлд хэрэглэхээр төлөвлөж буй аргачлалын ерөнхий тодорхойлолт; (iii) Ажлын талбайд дээр шаардагдах Гүйцэтгэгчийн ажилчдын албан тушаал тус бүрээр мөн тоног төхөөрөмжийг тоог төрөл тус бүрээр нь гаргасан Гүйцэтгэгчийн бодит тооцоог харуулсан нарийвчилсан мэдээллүүд; (iv) Ажлын хянаж шинэчилсэн Ажлын календарчилсан төлөвлөгөөнд Гүйцэтгэгчээс урьд нь танилцуулсан төлөвлөгөөнд оруулсан аливаа чухал, томоохон өөрчлөлтүүдийн талаарх тайлбар, тодорхойлолт; болон (v) Аливаа хоцролтоос Ажлын явцад үзүүлсэн үр нөлөөг арилгах Гүйцэтгэгчийн санал. Захиалагч нь Гүйцэтгэгчээс ирүүлсэн анхны Ажлын календарчилсан төлөвлөгөө болон ажлын хянаж шинэчилсэн Ажлын календарчилсан төлөвлөгөө бүрийг хянаж дүгнэх ба эдгээр төлөвлөгөө нь ямар хэмжээнд Гэрээтэй нийцэхгүй байгааг, эсхүл ажлын бодит явцыг тусгаагүй, эсхүл Гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг, хариуцлагатай өөр байдлаар нийцээгүйг дурдсан мэдэгдлийг Гүйцэтгэгчид өгч болно. Хэрэв Захиалагч ийм мэдэгдлийг: - анхны Ажлын календарчилсан төлөвлөгөөг хүлээн авснаас хойш 21 хоногт багтаан; эсхүл - хянаж шинэчилсэн Ажлын календарчилсан төлөвлөгөөг хүлээн авснаас хойш 14 хоногт багтаан хүргүүлээгүй бол Захиалагчийг Зөвшөөрсөн тухай мэдэгдэл хүргүүлсэн гэж үзэх бөгөөд Гүйцэтгэгчээс хүргүүлсэн анхны эсхүл хянаж шинэчилсэн төлөвлөгөө (тухайн нөхцөл байдлаас хамаарч) нь Ажлын календарчилсан төлөвлөгөө болно. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хүлээсэн бусад үүрэгтээ нийцүүлэн ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу үргэлжлүүлэн ажиллана. Захиалагчийн ажилтнууд нь ажлаа төлөвлөхдөө Ажлын календарчилсан төлөвлөгөөнд тулгуурлан цаашдын үйл ажиллагааг төлөвлөх эрхтэй. Аливаа Ажлын календарчилсан төлөвлөгөө эсхүл аливаа дагалдах тайланд байгаа юуг ч Гэрээний дагуух Мэдэгдэл гэж авч үзэхгүй, эсхүл тэдгээрт

		байгаа юуг нь ч Гэрээний дагуу Мэдэгдэл өгөх аливаа үүргээс Гүйцэтгэгчийг чөлөөлөхгүй. Хэрэв Захиалагч нь ямар ч үед Гүйцэтгэгчид, Ажлын календарчилсан төлөвлөгөө нь гэрээтэй нийцэхгүй (тодорхой хэмжээгээр) эсхүл бодит ахиц дэвшлийг тусгаагүй эсвэл Гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагатай зөрчилдөж байгаа тухай мэдэгдэл өгсөн бол, Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор энэ хэсэгт заасны дагуу хянаж шинэчилсэн хөтөлбөрийг Захиалагчид танилцуулна.
8.4 **Сануулга**		Талууд нөгөө талдаа одоо мэдэгдэж байгаа эсхүл ирээдүйд болж магадгүй үйл явдал эсхүл нөхцөл байдлын талаар урьдчилан мэдэгдэнэ. Үүнд: (a) Гүйцэтгэгчийн ажилчдын ажилд сөргөөр нөлөөлж; (b) Обьектын ажил дуусаны дараа түүний гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж; (c) Гэрээний үнийг өсгөж; ба/эсхүл (d) Ажил, эсхүл түүний бүрдэл хэсгийн (хэрэв байгаа бол) ажлын биелэлтийг удаашруулан саатуулж болох зэрэг багтана. Захиалагч нь эдгээр үйл явдал, эсхүл нөхцөл байдлын нөлөөллөөс зайлсхийх, эсхүл түүнийг бууруулах саналаа 13.3.2-т заасан хэсгийн дагуу танилцуулахаар Гүйцэтгэгчид хүсэлт гаргаж болно.
8.5 **Ажил дуусгах хугацааг сунгах**		Гүйцэтгэгч нь дор дурдсан аль нэг шалтгааны улмаас гэрээний 10.1 -д заасан хэсгийг биелүүлэхэд хамаарал бүхий Ажил дуусах хугацаа хойшлогдсон эсхүл хойшлогдохоор байгаа бол 20.2-д хэсэгт заасны дагуу Ажил дуусах хугацааг сунгах эрхтэй. Үүнд: (a) Өөрчлөлт; (20.2 хэсгийг дагаж мөрдөх шаардлагагүйгээс бусад тохиолдолд) (b) Эдгээр нөхцөлийн хэсгийн дагуу Хугацаа сунгах эрх олгож буй хоцролтын шалтгаан (c) Захиалагч, Захиалагчийн ажилтан, эсхүл Ажлын талбайд ажиллаж буй Захиалагчийн бусад гүйцэтгэгч нараас шалтгаалсан эсхүл тэдэнд хамраалтай аливаа хоцролт, түр зогсолт эсхүл урьдчилан сэргийлэх арга хэмжээ (эсхүл гоц халдварт өвчин, тахал эсхүл Төр засгийн шийдвэрээс шалтгаалан Захиалагчийн нийлүүлэх бараа материалын хангалт дутагдах,

		хомсдох зэрэг урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдал үүссэн бол). Гэрээний 20.2-д заасан хэсгийн дагуу Хугацаа сунгалт тус бүрийг тогтоохдоо Захиалагчийн төлөөлөгч нь өмнөх шийдвэрээ 3.5 -д заасан хэсгийн дагуу хянах бөгөөд ХС-ыг нийтэд нь нэмэгдүүлж болох боловч багасгах ёсгүй. Хэрвээ Захиалагчийн хариуцлага хүлээх асуудлаас шалтгаалсан хоцролт нь Гүйцэтгэгчийн хариуцлага хүлээх асуудлаас шалтгаалсан хоцролттой давхцаж байвал Гүйцэтгэгчийн ХС-ыг хийхдээ Тусгай заалтуудад тусгагдсан журам болон аргачлалд нийцүүлэн тооцно (хэрвээ тусгагдаагүй бол холбогдох бүхий л нөхцөл байдлыг харгалзан үзсэн зохих байдлаар шийдвэрлэнэ).
8.6 **Эрх бүхий этгээдээс шалтгаалсан ажлын саатал**		Хэрэв: (a) Гүйцэтгэгч нь тухайн Улсын хууль ёсны байгуулагдсан холбогдох төрийн байгууллагууд, эсхүл хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн гаргасан шийдвэрийг дагаж мөрдсөн; (b) Эдгээр төрийн болон аж ахуйн нэгжүүд нь Гүйцэтгэгчийн ажлыг саатал учруулсан эсхүл тасалдуулсан; ба (c) Хоцролт эсхүл саатлыг Урьдчилан таамаглах боломжгүй байсан; бол эдгээр шалтгаанаас үүссэн аливаа хоцролт болон саатлыг 8.5-ийн (b) хэсэгт заасан хугацаа хоцролтын шалтгаан гэж үзнэ.
8.7 **Ажлын явцын үнэлгээ**		Хэрэв ямар ч үед: (a) Бодит ажлын явц нь холбогдох Дуусгах хугацаанд багтаан Ажил болон түүний хэсэг ажлыг дуусгахад хэтэрхий удаан; (b) 8.3-т заасны дагуу ажлын явц нь Ажлын календарчилсан төлөвлөгөө (эсхүл ажлын төлөвлөгөө болж амжаагүй бол анхны төлөвлөгөө)-нөөс хоцорсон эсхүл хоцрох төлөвтэй, бөгөөд энэхүү удаашрал ба хоцролт нь гэрээний 8.5-д заасан шалтгааны үр дагавар биш бол, Захиалагч нь ажлын явцыг эрчимжүүлэн, Ажлыг эсхүл түүний хэсэг ажлыг холбогдох Дуусгах хугацаанд нь багтаан дуусгахын тулд Гүйцэтгэгчээс хэрэглэхээр төлөвлөж буй ажлын аргачлалуудыг тодорхойлж тусгасан,

		хянаж шинэчилсэн Ажлын календарчилсан төлөвлөгөөг гэрээний 8.3-ийн дагуу ирүүлэхийг Гүйцэтгэгчээс шаардана. Хэрвээ Захиалагчаас өөрөөр заасан мэдэгдлийг ирүүлээгүй бол эдгээр шинэчилсэн аргачилал, төлөвлөгөөг Гүйцэтгэгч дагаж мөрдөн ажиллах үүрэгтэй бөгөөд үүнтэй холбоотойгоор ажлын цагийг нэмэгдүүлэх болон Гүйцэтгэгчийн ажиллагсдын тоог нэмэх эсхүл Бараа материалыг нэмэгдүүлэх шаардлага гарч болзошгүй ба эдгээрийн зардал болон эрсдэлийг Гүйцэтгэгч хариуцна. Энэхүү шинэчилсэн аргачлалууд нь Захиалагчыг илүү зардал гаргахад хүргэхээр бол гэрээний 20.2-д заасны дагуу эдгээр төлбөрийг болон мөн хугацаа хойшилсны хохирлыг (хэрвээ байвал) Гүйцэтгэгчээр төлүүлэх эрхтэй. Гэрээний 8.5-д дурдсан шалтгаануудаас үүдэлтэй ажлын хоцролтыг багасгахын тулд Захиалагчаас зааварчилсан ажлыг эрчимжүүлэх арга хэмжээг хамруулан шинэчилсэн аргачлалд гэрээний 13.3.1 дэх хэсгийг хэрэглэнэ.
8.8 **Хугацаа хэтэрүүлснээс үүсэх хохирол**		Гүйцэтгэгч гэрээний 8.2-д заасныг биелүүлээгүй тохиолдолд Захиалагч нь 20.2-ийн дагуу Хугацаа хойшилсны хохирлын төлбөрийг Гүйцэтгэгчээс нэхэмжлэх эрхтэй. Хугацаа хойшилсны хохирол нь Гэрээний өгөгдөлд тусгагдсан дүн бөгөөд Ажлын эсхүл түүний хэсгийн холбогдох Дуусгах хугацаанаас Дууссан огнооны хоорондох хугацаанд, өдөр тутам төлөгдөнө. Энэхүү хэсгийн дагуу төлөгдөх Хугацаа хойшилсны хохирлын нийт мөнгөн дүн нь Гэрээний өгөгдөлд заасан Хугацаа хойшилсны хохирлын дээд хэмжээнээс (хэрвээ байвал) хэтрэх ёсгүй. Эдгээр Хугацаа хойшилсны хохирол нь гагцхүү Гүйцэтгэгч гэрээний 8.2 дахь хэсгийг биелүүлээгүйтэй холбоотой үүссэн хохирол байх бөгөөд үүнд Ажил дуусахаас өмнө гэрээний 15.2-ийн дагуу гэрээг цуцлах тохиолдол хамаарахгүй. Эдгээр Хугацаа хойшилсны хохирол нь Гүйцэтгэгчийг Ажил бүрэн дуусгах эсхүл Гэрээгээр болон түүнтэй холбоотойгоор хүлээсэн аливаа бусад үүрэг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй. Энэхүү хэсэг нь Гүйцэтгэгчийн Хугацаа хойшилсны хохирол төлөх болон Гүйцэтгэгчийн үйлдсэн аливаа

		хууран мэхлэлт, залилан, хариуцлагагүй байдал, санаатай болон санамсаргүйгээр гаргасан алдаа, зөрчлөөс үүдэн бий болох хариуцлагаас чөлөөлөхгүй.
8.9 **Захиалагч Ажлыг түр зогсоох**		Захиалагч нь Гүйцэтгэгчийн ажлын явцыг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн зогсоох даалгаврыг хэзээ ч өгөх эрхтэй бөгөөд уг даалгаварт түр зогсоох болсон шалтгаан болон хугацааг тодорхой дурдсан байна. Түр зогсолтын хугацаанд Гүйцэтгэгч нь тухайн ажлыг бүхэлд нь (тухайн нөхцөл байдлаас хамааран) эсхүл тухайн хэсгийн эвдрэл гэмтэл, элэгдэл хорогдол зэргээс хамгаалах, хадгалах, найдвартай байдлыг хангах үүргийг хүлээнэ. Тухайн түр зогсолтын шалтгааны хариуцлагыг Гүйцэтгэгч хүлээх тохиолдолд гэрээний 8.10, 8.11 болон 8.12-ыг хэрэглэхгүй.
8.10 **Захиалагч Ажлыг түр зогсоосноос үүсэх үр дагавар**		Гэрээний 8.9 -д дагуу Захиалагчийн өгсөн даалгаврыг гүйцэтгэхэд болон гэрээний 8.13 -д заасны дагуу Ажлыг дахин эхлүүлснээс болж Гүйцэтгэгчид хоцролт үүссэн эсхүл зардал гарсан бол Гүйцэтгэгч 20.2 -д заасны дагуу нэмэлт хугацаа тогтоолгох эсхүл ашиг шингэсэн үнийн төлбөрийг гаргуулах эрхтэй байна. Доорх зүйлсийг засварлаж, сайжруулахад Гүйцэтгэгч нь хугацаа сунгах шаардлага гаргах эсхүл зардлын төлбөрийг нэхэмжлэх эрхгүй: (a) Гүйцэтгэгчийн алдаатай зураг төсөл, ажлын хангалтгүй ур чадвар болон чанаргүй үндсэн техник хэрэгсэл болон бараа материалаас үүдэлтэй үр дагаврыг; (b) гэрээний 8.9-д заасны дагуу хамгаалах, хадгалах эсхүл найдвартай байдлыг хангах үүргийг Гүйцэтгэгч биелүүлээгүйн улмаас үүссэн аливаа элэгдэл хорогдол, хохирол гэмтэл эсхүл эвдрэлийг залруулах үйл ажиллагааны зардал.
8.11 **Захиалагч Ажлыг түр зогсоосны дараах үндсэн техник хэрэгсэл болон бараа материалын төлбөр**		Ажлын талбайд хүргэгдээгүй үндсэн техник хэрэгсэл болон бараа материалын үнийг (гэрээний 8.9-ийн дагуу ажлыг түр зогсоосон өдрөөс) доорх тохиолдолд төлүүлэх эрхтэй: (a) Үндсэн техник хэрэгсэл дээр хийгдэх ажил, эсхүл үндсэн техник хэрэгсэл болон бараа материалын нийлүүлэлт 28 хоногоос дээш хугацаагаар түр зогссон, ба (i) Ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу төлөвлөсөн үндсэн техник

		хэрэгсэл болон бараа материалыг түр зогсолтын үеэр дуусгасан ба Ажлын талбай руу хүргэхэд бэлэн болгосон; түүнчлэн (ii) Гүйцэтгэгч нь үндсэн техник хэрэгсэл болон бараа материал нь Гэрээний шаардлагад нийцэж байгаа тухай зохих нотолгоог Захиалагчид хүргүүлсэн бол; (b) Гүйцэтгэгч нь Захиалагчийн зааварчилгааны дагуу үндсэн техник хэрэгсэл болон бараа материалыг Захиалагчийн өмч гэж тэмдэглэсэн.
8.12 **Түр зогсолтын хугацаа сунжрах**		Хэрэв гэрээний 8.9-д заасны дагуух түр зогсолт нь 84 хоногоос дээш хугацаагаар үргэлжилсэн бол Гүйцэтгэгч нь ажлаа үргэлжлүүлэх зөвшөөрөл хүссэн Мэдэгдлийг Захиалагчид гаргах эрхтэй. Хэрэв Захиалагч нь энэхүү хэсгийн дагуу Гүйцэтгэгчийн Мэдэгдлийг хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор гэрээний 8.13 дахь хэсгийн дагуу Мэдэгдэл өгөхгүй бол Гүйцэтгэгч нь: (a) түр зогсолтыг цаашид үргэлжлүүлэхийг харилцан тохиролцох ба энэ тохиолдолд Талууд түр зогсолт үргэлжлэх хугацаанд гарсан нэмэлт хугацаа тогтоолт болон ашиш шингэсэн үнийн төлбөрийг (хэрвээ Гүйцэтгэгчээс Зардал гарсан бол) болон/эсхүл түр зогсолтод хамрагдсан үндсэн техник хэрэгсэл болон/эсхүл бараа материалын төлбөрийн асуудлаар харилцан тохиролцож болно; эсхүл (хэрвээ Талууд дээрхи (a) хэсгийн дагуу тохиролцоонд хүрч чадаагүй бол) (b) Захиалагчид хоёр дахь мэдэгдэл хүргүүлсний дараа энэхүү түр зогсолтыг, гэрээний 8.9-ын дагуу хамгаалж, хадгалах ба аюулгүй байлгах цаашдын аливаа үүргээс чөлөөлөх асуудлыг хамруулсан шууд нөлөө бүхий, Ажлын нөлөөнд өртсөн хэсгийг (гэрээний 13.3.1-ийн дагуу зааварчилсан мэтээр) орхигдуулсан алдаа гэж үзнэ. Хэрэв түр зогсолт нь Ажилд бүхэлд нь нөлөөлсөн бол, Гүйцэтгэгч нь гэрээний 16.2-ын дагуу гэрээг цуцлах Мэдэгдэл өгч болно.
8.13		Гүйцэтгэгч Захиалагчаас түр зогсоосон ажлыг үргэлжлүүлэх тухай мэдэгдлийг хүлээн авсны дараа

Ажлыг үргэлжлүүлэх		аль болох богино хугацаанд түр зогссон ажлыг дахин үргэжлүүлнэ. Энэхүү мэдэгдэлд заасан хугацаанд (хэрэв заагаагүй бол Гүйцэтгэгч энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа шууд) Гүйцэтгэгч болон Захиалагч нь түдгэлзүүлэхэд нөлөөлсөн ажил, үйлдвэр, материалын шалтгааныг хамтран шалгана. Захиалагч нь түр зогсолтын хугацаанд ажил, үндсэн тоног төхөөрөмж болон материалын эвдрэл, гэмтэл, элэгдэл, хорогдлыг шалган бүртгэж энэ тухай тайлан мэдээллийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ. Гүйцэтгэгч тэдгээр эвдрэл, гэмтэл, элэгдэл хорогдолыг ажил дуусаны дараа Гэрээнд нийцтэй байхаар даруй засч залруулах үүрэгтэй.
9. ХЯНАЛТ, ТУРШИЛТ		
9.1 **Гүйцэтгэгчийн үүрэг**		Гүйцэтгэгч нь 5.6 болон 5.7-д заасан баримт бичгийг хүргүүлсний дараа энэхүү зүйл болон 7.4-д заасны дагуу Хяналт, Туршилтыг хийж гүйцэтгэнэ. Гүйцэтгэгч нь Хяналт, Туршилтыг эхлүүлэхээр төлөвлөж буй өдрөөс 42-оос доошгүй хоногийн өмнө эдгээр туршилтуудад шаардагдах хугацаа, нөөцийг тусгасан нарийвчилсан туршилтын хөтөлбөрийг Захиалагчид хүргүүлнэ. Захиалагч нь уг хөтөлбөрийг хянах мөн хөтөлбөрт Гэрээнд нийцэхгүй зүйл гарсан тохиолдолд Гүйцэтгэгчид мэдэгдэл хүргүүлэх эрхтэй. Гүйцэтгэгч энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гэрээнд нийцээгүй асуудлыг засаж залруулна. Хэрэв Захиалагч туршилтын төлөвлөгөөг (эсхүл шинэчилсэн хөтөлбөрийг) хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор дээрх мэдэгдэлийг ирүүлээгүй бол Захиалагчийг Зөвшөөрсөн тухай мэдэгдэл хүргүүлсэн гэж үзнэ. Гүйцэтгэгч нь Захиалагчийг Зөвшөөрсөн тухай мэдэгдэл хүргүүлэх хүртэл Хяналт, Туршилтыг эхлүүлэхгүй. Туршилтын хөтөлбөрт заасан огнооноос гадна Гүйцэтгэгч нь Захиалагчид туршилт бүрийг гүйцэтгэхэд бэлэн байх хугацаанаас 21-ээс доошгүй хоногийн дараа мэдэгдэл хүргүүлнэ. Гүйцэтгэгч нь уг өдрөөс хойш 14 хоногийн дотор эсхүл Захиалагчаас зааварчилгаа өгсөн тохиолдолд Ажил дуусмагц хийх туршилтыг Захиалагчийн Зөвшөөрсөн тухай

		мэдэгдэл хүргүүлсэн (эсхүл хүргүүлсэн гэж үзсэн) төлөвлөгөөний дагуу эхлүүлнэ. Захиалагчийн шаардлагад өөрөөр зааснаас бусад тохиолдолд Хяналт, Туршилтыг дараах дараалын дагуу гүйцэтгэнэ. Үүнд: a) Ашиглалтад оруулахын өмнөх туршилт (Ажлын талбайд эсхүл Ажлын талбайн гадна). Энэ туршилтад Ажил эсхүл Хэсэг ажлын бүрдэл тус бүр нь дараагийн буюу (b) шатанд ороход аюулгүй болохыг харуулах зохих хяналт шалгалт болон ("хуурай" эсхүл "хүйтэн") үйл ажиллагааны туршилтууд хамаарна. b) Ашиглалтад орох үеийн туршилт. Үүнд Ажил болон Хэсэг ажил нь Захиалагчийн шаардлагад заасан нөхцөлийн дагуу аюулгүй явагдаж байгаа гэдгийг харуулах Захиалагчийн шаардлагад заасан ашиглалтын туршилт багтана. Мөн c) Шалгалтын үйл ажиллагаа (үйл ажиллагааны хүчин төгөлдөр нөхцөлд заасан хэмжээний дагуу) нь Ажил эсхүл Хэсэг ажил нь Гэрээнд заасны дагуу найдвартай явагдсан гэдгийг харуулна. Дээрх (b) ба (c) хэсэгт заасан үе шат бүрийн туршилтыг Ажил эсхүл Хэсэг ажил нь өмнөх үе шатыг давах хүртэл эхлүүлэхгүй. Туршилтын/Шалгалтын үйл ажиллагааны үед Ажил эсхүл Хэсэг ажил тогтвортой нөхцөлд явагдаж байгаа тохиолдолд Гүйцэтгэгч нь гүйцэтгэлийн туршилт болон Ажил дуусмагц хийх туршилтад бэлэн болсон тухайгаа илэрхийлсэн Мэдэгдлийг Захиалагчид хүргүүлнэ. Гүйцэтгэлийн туршилтыг Ажил эсхүл Хэсэг ажил нь Захиалагчийн шаардлага болон чанарын үзүүлэлтэд заасантай нийцсэн эсэхийг харуулж байхаар гүйцэтгэнэ. Туршилтын/Шалгалтын үйл ажиллагаа болон гүйцэтгэлийн туршилт нь 10-д заасны дагуу ажил хүлээн авахад хамаарахгүй. Ажлын үр дүнд үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн, үүнээс олсон орлого бусад ашиг нь Захиалагчийн өмч байна. Ажил болон Хэсэг ажлууд нь энэхүү зүйлийн (a)-(c) хэсэгт заасан Хяналт, Туршилтын үе шат тус бүрийг амжилттай давсан тохиолдолд Гүйцэтгэгч нь эдгээр Туршилтын үр дүнгийн баталгаажсан тайланг Захиалагчид хүргүүлнэ. Захиалагч нь уг тайлан бүрийг хянах мөн Гэрээнд нийцэхгүй туршилтын үр

		дүн илэрсэн тохиолдолд Гүйцэтгэгчид мэдэгдэл хүргүүлнэ. Хэрэв Захиалагч туршилтын үр дүнг (эсхүл шинэчилсэн хөтөлбөрийг) хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор дээрх мэдэгдэлийг ирүүлээгүй бол Захиалагчийг Зөвшөөрсөн тухай мэдэгдэл хүргүүлсэн гэж үзнэ. Хяналт, Туршилтын үр дүнг дүгнэхдээ Захиалагч нь бүтээмжид нөлөөлөх Ажлын (аливаа бүрдлийн) аливаа Захиалагчийн ашиглалтын нөлөөлөл, үр дагаврыг болон Ажлын бусад шинж чанаруудыг харгалзан үзэх шаардлагатай.
9.2 **Хойшлогдсон Туршилтууд**		Хэрэв Гүйцэтгэгч нь Ажил эсхүл Хэсэг ажил (нөхцөл байдлаас хамаарч) нь Хяналт, Туршилтад бэлэн тухай 9.1-ийн дагуу мэдэгдэл хүргүүлсэн боловч энэхүү туршилтуудыг Захиалагчийн ажилтнууд үндэслэлгүйгээр хойшлуулсан эсхүл Захиалагчийн буруутай үйлдлээс болж үндэслэлгүйгээр хойшилсон бол 10.3-ийг мөрдөнө. Хяналт, Туршилтыг Гүйцэтгэгч үндэслэлгүй хойшлуулсан тохиолдолд Захиалагч нь Гүйцэтгэгчид мэдэгдэл хүргүүлнэ. Гүйцэтгэгч мэдэгдэл хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор Туршилтыг явуулахыг Гүйцэтгэгчээс шаардана. Гүйцэтгэгч нь туршилтыг өөрөө тогтоож болох бөгөөд энэ тухай Мэдэгдлийг Захиалагчид 7 хоногийн дотор хүргүүлж, дээрх 21 хоногийн доторх тухайлсан өдөр буюу өдрүүдэд явуулна. Гүйцэтгэгч нь Хяналт, Туршилтыг 21 хоногийн дотор гүйцэтгээгүй тохиолдолд: (a) Захиалагч Гүйцэтгэгчид хоёр дахь Мэдэгдлийг хүргүүлсний дараа Захиалагчийн ажилтнууд туршилтыг үргэлжлүүлж болно; (b) эдгээр туршилтад Гүйцэтгэгч оролцож гэрчилж болно; (c) Туршилтуудыг гүйцэтгэж дууссанаас хойш 28 хоногийн дотор Захиалагч нь туршилтын үр дүнгийн хуулбарыг Гүйцэтгэгчид илгээнэ; мөн (d) Хэрэв Захиалагч нь эдгээр туршилтаас шалтгаалан нэмэлт зардал гаргасан бол зохих байдлаар гаргасан зардлыг 20.2-ийн дагуу Гүйцэтгэгчээр төлүүлэх эрхтэй байна.

		Хяналт, Туршилтад Гүйцэтгэгч оролцсон эсэхээс үл хамааран эдгээр туршилтыг Гүйцэтгэгч байхад явуулсан мөн туршилтын үр дүнг үнэн зөв хэмээн үзнэ.
9.3 **Давтан туршилт**		Ажил болон Хэсэг ажил нь Ажил дуусмагц хийх туршилтад тэнцээгүй тохиолдолд 7.5-ийг баримтална. Захиалагч эсхүл Гүйцэтгэгч нь амжилтгүй болсон туршилт, аливаа ажилтай холбоотой Хяналт, Туршилтыг өмнөх туршилттай ижил нөхцөл, болзолтойгоор давтан хийхийг шаардаж болно.
9.4 **Хяналт, Туршилтад тэнцэхгүй байх**		Хэрэв 9.3-д заасны дагуу давтан хийсэн Хяналт, Туршилтад Ажил эсхүл Хэсэг ажил нь тэнцээгүй бол Захиалагч нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд: a) 9.3-д заасны дагуу Ажил дуусмагц хийх туршилтыг дахин хийх даалгаврыг өгөх; b) Туршилтад тэнцээгүй явдал нь Захиалагчийн тухайн Ажил эсхүл Хэсэг ажлаас олох байсан ашгийг бүхэлд нь авах боломжгүй болох үр дагаварт хүргэсэн бол 11.4-ийн (d) хэсэгт заасан эрхийг эдэлж, Ажлаас татгалзах; c) Хэсэг ажлын туршилтанд тэнцээгүй явдал нь тухайн Хэсэг ажлыг Гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглах боломжгүй болгосон бол Захиалагч нь 11.4-ийн (c) хэсэгт заасан эрхийг эдэлж, Хэсэг ажлаас татгалзах; d) Захиалагчийн хүсэлтийн дагуу Ажил хүлээн авах гэрчилгээг олгох. Энэ зүйлийн (d) хэсгийн заалтыг хэрэглэх тохиолдолд Гүйцэтгэгч нь Гэрээний дагуу хүлээсэн бусад бүх үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх бөгөөд Захиалагч нь 20.2-ийн дагуу Гүйцэтгэгчийн төлбөрийг төлөх эсхүл 11.4-ийн (b)(i) болон (b)(ii) хэсэгт заасны дагуу Гэрээний үнийг бууруулах эрхтэй. Энэхүү эрх нь Захиалагчийн Гэрээгээр эдлэх эрх болон холбогдох бусад эрхийг үл хөндөнө.
10. ЗАХИАЛАГЧ АЖЛЫГ ХҮЛЭЭН АВАХ		
10.1 **Ажил болон Хэсэг ажлыгхүлээн авах**		9.4 болон 10.2-д зааснаас бусад тохиолдолд Захиалагч нь дараах тохиолдолд Ажлыг хүлээн авна. a) Хяналт, Туршилтад тэнцсэн байх, энэ хэсгийн (i) хэсэгт заасан шаардлагыг хангасан байх мөн Ажлыг Гэрээнд заасны дагуу гүйцэтгэсэн тохиолдолд;

		b) Захиалагч 5.6-ийн (a) хэсэгт заасны дагуу ажлын гүйцэтгэлийн тэмдэглэлд Зөвшөөрсөн тухай мэдэгдэл хүргүүлсэн (эсхүл хүргүүлсэн гэж үзсэн) тохиолдолд; c) Захиалагч 5.7-д заасны дагуу ажлын үйл ажиллагааны ашиглалт болон засвар үйлчилгээний гарын авлагад Зөвшөөрсөн тухай мэдэгдэл хүргүүлсэн (эсхүл хүргүүлсэн гэж үзсэн) тохиолдолд; d) Захиалагч 5.5-д заасан сургалтыг явуулсан тохиолдолд; e) Ажил хүлээн авах гэрчилгээг олгосон, эсхүл энэ зүйлд заасны дагуу олгосон гэж үзсэн тохиолдолд. Гүйцэтгэгч нь ажлыг бүрэн гүйцэтгэж хүлээлгэн өгөхөд бэлэн болсон хэмээн үзсэн өдрөөс 14 хоногоос доошгүй хоногийн өмнө Ажил хүлээн авах гэрчилгээ олгохыг хүссэн Мэдэгдлийг Захиалагчид хүргүүлнэ. Хэрэв Ажлыг нь Хэсэг ажилд хуваасан бол Гүйцэтгэгч нь Хэсэг ажил тус бүрт Ажил хүлээн авах гэрчилгээ авахаар хүсэлт гаргаж болно. Хэрэв 10.2-д заасны дагуу ажлын бүрдэл хэсгийг хүлээн авсан бол Ажлын үлдсэн бүрдэл хэсгийг энэ зүйлийн (a)-аас (e) хүртэл хэсэгт заасан нөхцөлүүдийг хангах хүртэл хүлээн авахгүй. Захиалагч нь Гүйцэтгэгчийн хүсэлтийг хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор: i. Ажил болон Хэсэг ажлыг түүний зориулалтын дагуу ашиглахад (тухайн доголдлыг арилгах болон ажлыг гүйцэтгэж дуусах хүртэл) ноцтой нөлөө үзүүлэхгүй ажил, доголдолтой Ажил болон Хэсэг ажлыг гүйцэтгэж дуусгасан хугацааг Гэрээнд заасны дагуу тусгасан Ажил хүлээн авах гэрчилгээг олгоно; ii. Гүйцэтгэгчид түүний хүргүүлсэн хүсэлтэд татгалзсан үндэслэлийг тусгасан Мэдэгдэлийг хүргүүлнэ. Мэдэгдэлд Ажил хүлээн авах гэрчилгээг олгоход гүйцэтгэх шаардлагатай ажил, арилгах шаардлагатай доголдол эсвэл Гүйцэтгэгчээс ирүүлэх шаардлагатай баримт бичгийн талаар тусгайлан заасан байна. Гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан дараагийн Мэдэгдэлийг хүргүүлэхээс өмнө эдгээр дутуу ажлуудыг гүйцэтгэж дуусгасан байна. Хэрэв Захиалагч нь 28 хоногийн дотор Ажил хүлээн авсан тухай гэрчилгээг олгоогүй эсхүл Гүйцэтгэгчийн хүргүүлсэн хүсэлтэд татгалзаагүй бөгөөд энэ зүйлийн

		(a)-ээс (d) хүртэлх хэсэгт заасан болзол хангагдсан бол Захиалагч Гүйцэтгэгчийн хүргүүлсэн Мэдэгдлийг хүлээн авснаас хойш 14 дэх хоногт Гэрээнд заасны дагуу Ажил эсхүл Хэсэг ажлыг гүйцэтгэж дууссан гэж үзэж ажлыг хүлээн авах гэрчилгээг олгосон гэж үзнэ.
10.2 **Ажлын бүрдэл хэсгийг хүлээн авах**		Захиалагчийн шаардлагад зааснаас бусад эсхүл Гэрээний талууд харилцан тохиролцсоноос бусад тохиолдолд Захиалагч нь Ажлын бүрдэл хэсгүүд (“Ажлын Хэсэг” гэж томъёолсноос ялгаатай)-ийг хүлээн авах эсхүл ашиглахгүй.
10.3 **Хяналт, Туршилт саатах**		Хяналт, Туршилт нь Захиалагчийн эсвэл Захиалагчийн ажилтаны хариуцлагаас шалтгаалж 14 хоногоос дээш хугацаагаар (тасралтгүй үргэлжилсэн хугацаа эсхүл хэд хэдэн удаагийн тохиолдлоор нийт 14 хоногоос дээш хугацаагаар) саатсан бол: a) Гүйцэтгэгч нь Доголдол мэдэгдэх хугацаа дуусахаас өмнө нэн даруй Хяналт, Туршилтыг гүйцэтгэх; мөн b) Хэрэв Гүйцэтгэгч ийнхүү саатсаны улмаас Зардал гаргасан бол Гүйцэтгэгч нь 20.2 -д заасны дагуу хугацаа сунгуулах эсхүл ашиг шингэсэн үнийг нэхэмжлэх эрхтэй. .
11. Ажил хүлээн авсны дараах доголдол		
11.1 Дутуу ажлыг гүйцээж, доголдлыг арилгах		Ажил, Гүйцэтгэгчийн баримт бичгүүд болон Хэсэг ажлыг Гэрээнд заасан шаардлага хангасан нөхцөлд (хэвийн элэгдэл хорогдлыг тооцно) байлгахын тулд Гүйцэтгэгч нь холбогдох Доголдол мэдэгдэх хугацаанд багтаан эсхүл аль болох боломжит хугацаанд дараах ажлыг хийж гүйцэтгэнэ: (a) Аливаа ажил нь холбогдох Ажил дуусах огноондоо багтаж дуусаагүй тохиолдолд тухайн ажлыг Ажил хүлээн авсан гэрчилгээнд заагдсан хугацаанд, эсхүл Захиалагчаас зааварчилсан үндэслэл бүхий хугацаанд багтаан гүйцэтгэж дуусгах, ба (b) Захиалагчаас (эсхүл түүний нэрийн өмнөөс) Гүйцэтгэгчид хүргүүлсэн мэдэгдэлд дурдсан аливаа доголдол эсхүл эвдрэл гэмтлийг засаж залруулах бүхий л ажлыг тухайн

		Ажил эсхүл Хэсэг Ажилд (тухайн нөхцөл байдлаас хамааран) хамаарах Доголдол мэдэгдэх хугацаа дуусахад эсхүл дуусахаас өмнө хийж гүйцэтгэх үүрэгтэй. Хэрэв холбогдох Доголдол мэдэгдэх хугацаанд доголдол илэрсэн эсхүл бий болсон бол Захиалагч нь Гүйцэтгэгчид (эсхүл түүний нэрийн өмнөөс) зохих Мэдэгдлийг хүргүүлнэ. Үүний дараагаар: (i) Гүйцэтгэгч болон Захиалагчийн ажилтнууд нь хамтран доголдол эсхүл эвдрэл гэмтлийн үзлэг шалгалтыг хийнэ; (ii) дараа нь Гүйцэтгэгч шаардлагатай засварын ажлын саналаа бэлтгэж, хүргүүлэх; ба (iii) 7.5-ийн хоёр, гурав болон дөрөв дэх цогцолборыг хэрэглэнэ.
11.2 Доголдлыг арилгах зардал		Хэрэв тухайн ажил нь дараах зүйлүүдэд хамаарч буй тохиолдолд, 11.1-ийн (b) заалтад дурдсан бүх ажлыг Гүйцэтгэгч өөрийн зардлаар гүйцэтгэж, эрсдэлийг хүлээнэ: (a) Захиалагчийн хариуцах зураг төслийн хэсгээс бусад Ажлын зураг төсөл (хэрэв байгаа бол) (b) Үндсэн техник хэрэгсэл, Бараа материал эсхүл Ажлын ур чадвар нь гэрээнд заасан шаардлагыг хангахгүй байгаа; (c) Гүйцэтгэгч (5.5, 5.6 эсхүл 5.7-ын дагуу, эсхүл өөр байдлаар) хариуцлагыг нь хүлээх асуудлуудад хамааралтай алдаатай үйл ажиллагаа, эсхүл засвар үйлчилгээ; эсхүл (d) Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлээгүй тохиолдолд. Хэрэв Гүйцэтгэгч нь өөр бусад шалтгаантай гэж үзсэн бол Захиалагчид нэн даруй Мэдэгдэл хүргүүлэх бөгөөд Захиалагчийн төлөөлөгч нь үүнийг зөвшөөрөх эсхүл шийдвэрлэхдээ 3.5-ийг дагаж мөрдөнө (мөн, 3.5.3-д нийцүүлэх үүднээс, тус Мэдэгдлийн огноо нь 3.5.3 хэсэгт заасны дагуу хэлцлийн хугацааны хязгаарын эхлэх огноо байна.) Хэрэв дээр дурдсанаас өөр бусад шалтгаан ажилд хамааралтай болохыг харилцан зөвшөөрч, эсхүл тогтоосон бол тухайн ажлыг Захиалагчийн зааварчилгааны дагуу гүйцэтгэх ёстой байсан хэмээн үзэж 13.3.1-ийг дагаж мөрдөнө.

11.3 Доголдол мэдэгдэх хугацааг сунгах		Захиалагч нь дараах тохиолдолд Ажил, Хэсэг ажил (10.2-ыг хэрэглэсэн тохиолдолд Ажлын бүрдэл хэсэг)-ийн Доголдол Мэдэгдэх хугацааг сунгах эрхтэй. Үүнд: (a) Хэрэв Ажил, Ажлын хэсэг, (эсхүл Ажлын бүрдэл хэсэг) эсхүл үндсэн техник хэрэгсэлийн гол нэр төрөл нь (ажил хүлээн авсны дараа болон нөхцөл байдлаас хамааран) 11.2-ийн (a)-аас (d) дэх заалтуудын дагуух аливаа асуудалд хамааралтай доголдол эсхүл эвдрэл гэмтлээс шалтгаалан зориулалтаараа ашиглагдах боломжгүй болсон тохиолдолд (b) 20.2 -д хамааралтай бол. Гэсэн хэдий ч Доголдол мэдэгдэх хугацааг Гэрээний өгөгдөлд заасан Доголдол мэдэгдэх хугацаа дууссанаас хойш 2 жилээс илүүгээр сунгахгүй. Хэрэв үндсэн техник хэрэгсэл бэсхүл Материалыг хүлээлгэн өгөх ба угсрах ажиллагаа нь 8.9-ийн дагуу (Ажлын түр зогсолт нь Гүйцэтгэгчээс шалтгаалснаас бусад тохиолдолд) эсхүл 16.1-д зааснаар түр зогссон тохиолдолд Ажлын Доголдол мэдэгдэх хугацаанаас хойш 2 жил өнгөрсний дараа үүссэн аливаа эвдрэл, гэмтэл, доголдолд энэ хэсэгт заасан Гүйцэтгэгчийн үүрэгт хамаарахгүй ба үндсэн техник хэрэгсэл эсхүл Материалын баталгаат хугацаа дууссан гэж үзнэ.
11.4 Доголдлыг арилгаж чадахгүй байх		Хэрэв аливаа доголдол эсхүл эвдрэл, гэмтлийг 11.1-ийн дагуу арилгах ажлыг Гүйцэтгэгч хэтэрхий удааж, саатуулсан бол Захиалагч (эсхүл түүний нэрийн өмнөөс) тухайн доголдлыг арилгах хугацааг буюу хэдий хугацаанд арилгасан байх ёстойг тогтоож болно. Энэхүү тогтоосон хугацааны талаарх Мэдэгдлийг Захиалагч нь (эсхүл түүний нэрийн өмнөөс) Гүйцэтгэгчид хүргүүлэх бөгөөд эвдрэл, гэмтэл, доголдлыг арилгахад шаардлагатай хэмээн үзсэн үндэслэл бүхий хугацааг (холбогдох бүх нөхцөл байдлыг харгалзан үзнэ) уг Мэдэгдлээр Гүйцэтгэгчид олгоно. Хэрэв Гүйцэтгэгч нь Мэдэгдэлд заасан хугацаанд доголдол эсхүл эвдрэл, гэмтлийг арилгаж чадаагүй ба 11.2-ын дагуу Гүйцэтгэгч өөрийн зардлаар доголдлыг засах ажлыг хийж гүйцэтгэх байсан бол Захиалагч нь (Захиалагч өөрийн үзэмжээр):

		(a) Гэрээнд заасан шаардагдах арга хэлбэрийн дагуу, Гүйцэтгэгчийн зардлаар тухайн ажлыг өөрөө үргэлжлүүлэн гүйцэтгэх эсхүл бусдаар гүйцэтгүүлэх (аливаа туршилтыг хамруулан) бөгөөд энэ тохиолдолд Гүйцэтгэгч нь тухайн ажилд хариуцлага хүлээхгүй. Доголдол эсхүл эвдрэл, гэмтлийг арилгах ажилтай холбоотой Захиалагчид үүссэн үндэслэл бүхий зардлыг Захиалагч нь 20.2-ын дагуу Гүйцэтгэгчээр төлүүлэх эрхтэй. (b) Доголдолтой ажлыг хүлээн авах тохиолдолд Захиалагч нь 20.2-ын дагуу (i) Гүйцэтгэгч тухайн доголдлыг бүрэн арилгасан тохиолдолд Гүйцэтгэлийн хохирлыг төлөх; эсхүл (ii) Гэрээний дагуу чанарын үзүүлэлт байхгүй, эсхүл холбогдох Гүйцэтгэлийн хохирол байхгүй тохиолдолд Гэрээний үнийг бууруулна. Энэхүү үнийн бууруулалт нь зөвхөн тухайн алдааг арилгахад хүрэлцэхүйц байх ба тус алдаанаас үүдэн Захилагчид учирсан холбогдох үнийн бууралтыг нөхөхтэй ижил хэмжээний байна. (c) Ажлын аливаа хэсгийг Гэрээнд заагдсан зориулалтын дагуу ашиглах боломжгүй болж, тэр нь хэрэв 13.3.1-д заасан хасалттай холбоотой бол тэрхүү хасалтыг хийлгэхийг; эсхүл (d) Хэрэв доголдол нь Захиалагчийг тухайн ажлаас бодит ашиг хүртэх боломжгүй болгосон бол Гэрээг бүхэлд нь нэн даруй цуцална (ба 15.2-ыг хэрэглэхгүй). Үүний дараа Захиалагч нь 20.2-д заасны дагуу Ажилд зарцуулсан нийт төлбөр, нэмэлт санхүүжилтийн зардал болон задалж, буулгах зардал, Талбайг чөлөөлөх зардал мөн үндсэн техник хэрэгсэл, Материалыг Гүйцэтгэгчид эргүүлэн өгөх зардлуудыг Гүйцэтгэгчээр нөхөн төлүүлэх эрхтэй. Дээрх (c) эсхүл (d) хэсгийн дагуу Захиалагч өөрийн үзэмжээрээ хандах үйл ажиллагаа нь Захиалагчид Гэрээгээр болон өөрөөр олгогдсон аливаа эрхийг хөндөхөөргүй байна.
11.5 Доголдлыг ажлын талбайн гадна арилгах		Хэрэв Гүйцэтгэгч нь Доголдол мэдэгдэх хугацаанд үндсэн техник хэрэгсэлийн доголдол нь ажлын талбай дээр шуурхай засагдаж чадахгүй хэмээн үзэж байгаа бол тухайн шалтгааныг дурдсан Мэдэгдлийг Захиалагчид хүргүүлэн, үндсэн техник хэрэгсэлийн

		доголдлыг ажлын талбайгаас гаргаж засварлах зөвшөөрлийг хүснэ. Тухайн Мэдэгдэлд доголдолтой үндсэн техник хэрэгсэлийг нэг бүрчлэн дурдах ба дараах дэлгэрэнгүй тайлбарыг тусгана: (a) засах шаардлагатай доголдол; (b) доголдолтой үндсэн техник хэрэгсэлийг засварлахаар аваачих газар; (c) тухайн үндсэн техник хэрэгсэлийг зөөвөрлөх тээврийн хэрэгсэл (болон тухайн тээврийн хэрэгслийн даатгал) (d) талбайн гадна хийхээр төлөвлөсөн хяналт шалгалт ба туршилт; (e) засварлагдсан үндсэн техник хэрэгсэлийг ажлын талбайд буцаан авч ирэхээс өмнө шаардагдах төлөвлөгөөт хугацаа; ба (f) засварлагдсан үндсэн техник хэрэгсэлийг дахин суурилуулах болон давтан туршихад шаардагдах төлөвлөсөн хугацаа (7.4 эсхүл 9-ийн (хэрэв шаардлагатай бол) дагуу); Гүйцэтгэгч нь Захиалагчаас зохих журмаар нэмэлтээр шаардаж болох аливаа нарийвчилсан мэдээллээр хангах үүрэгтэй. Гүйцэтгэгч нь Захиалагч зөвшөөрөл өгмөгц (энэхүү зөвшөөрөл нь Гүйцэтгэгчийн энэ зүйлд заасан аливаа үүрэг хариуцлагаас чөлөөлөхгүй) доголдолтой үндсэн техник хэрэгсэлийг ажлын талбайгаас гаргаж болно. Энэхүү зөвшөөрлийн нөхцөл болгон Захиалагч нь Гүйцэтгэгчийг доголдолтой үндсэн техник хэрэгсэлийг бүрэн солих хэмжээний үнийн дүнгээр Гүйцэтгэлийн баталгааг нэмэгдүүлэхийг шаардаж болно.
11.6 Доголдлыг арилгасны дараах туршилтууд		Аливаа ажлын доголдлыг арилгаснаас хойш 7 хоногийн дотор Гүйцэтгэгч нь Ажил, Хэсэг ажил ба/эсхүл үндсэн техник хэрэгсэлийн засварлагдсан байдлын тухай болон санал болгож буй давтан туршилтын талаарх (гэрээний 9 эсхүл 12-ын дагуу хэрэглэх тохиолдолд) Мэдэгдлийг Захиалагчид хүргүүлнэ. Хэрэв Захиалагч нь тухайн Мэдэгдлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор ийнхүү санал болгож буй дахин туршилтыг хийхээс татгалзсан тухай ба/эсхүл засварлагдсан Ажил, Хэсэг ажил ба/эсвэл үндсэн техник хэрэгсэл нь Гэрээнд заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгахын тулд зайлшгүй хийгдэх ёстой давтан туршилт явуулахыг зааварчилсан Мэдэгдлийг хүргүүлээгүй бол

		Захиалагчийг Гүйцэтгэгчийн санал болгосон давтан туршилтыг хийхийг зөвшөөрсөн хэмээн үзнэ. Хэрэв Гүйцэтгэгч 7 хоногийн дотор Мэдэгдэл хүргүүлээгүй бол Захиалагч нь доголдол засварлагдсанаас хойш 14 хоногийн дараа засварлагдсан Ажил, Хэсэг ажил ба/эсхүл үндсэн техник хэрэгсэл нь Гэрээнд заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгахын тулд зайлшгүй хийгдэх ёстой давтан туршилт явуулахыг зааварчилсан Мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ. 11.2-ын дагуу засварын ажлын зардлыг хариуцах тал нь эрсдэл болон зардлыг хариуцахаас бусдаар энэхүү Зүйлээр явуулж буй бүх давтан туршилт нь өмнөх туршилтад хэрэглэгдэж байсан нөхцөлөөр хийгдэнэ.
11.7 Ажил хүлээн авсны дараа ажлын талбайд нэвтрэх эрх		Гүйцэтгэлийн гэрчилгээг олгосноос хойш 28 хоногийн хугацаанд Захиалагчаас аюулгүй байдлыг хангах зорилготой хязгаарлалт тавьснаас бусад тохиолдолд Гүйцэтгэгч нь Ажлын талбайн бүхий л хэсэгт болон Ажлын засвар, үйлчилгээ болон гүйцэтгэлийн бүртгэлтэй үзэж, танилцах эрхтэй байна. Холбогдох Доголдол мэдэгдэх хугацаанд Гүйцэтгэгч нь Ажлын талбайн аль нэг хэсэгт нэвтрэх үедээ: (a) Гүйцэтгэгч нь Захиалагчид ажлын талбайн нэвтрэн орох гэж буй хэсэг ба/эсвэл үзэж танилцах бүртгэлийг ийнхүү нэвтрэх, үзэж танилцах шалтгаан ба Гүйцэтгэгчийн санал болгож буй нэвтрэх огноо зэргийг дурдсан Мэдэгдлийг Захиалагчид хүргүүлэн, нэвтрэх хүсэлт гаргана. Энэхүү Мэдэгдлийг Захиалагчаас тавьсан аюулгүй байдлыг хангах зорилготой хязгаарлалт зэрэг холбогдох бүхий л нөхцөл байдлыг харгалзан үзэж ажлын талбайд нэвтрэхээр санал болгосон өдрөөс өмнө, тохиромжтой хугацаанд өгсөн байх ёстой. (b) Захиалагч нь Гүйцэтгэгчийн Мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор, Гүйцэтгэгчид дараах хариу Мэдэгдлийг хүргүүлнэ: (i) Гүйцэтгэгчийн хүсэлтийг зөвшөөрсөн тухай Захиалагчийн зөвшөөрлийг; эсхүл (ii) Үндэслэл бүхий өөр өдөр (өдрүүдийг) санал болгон, холбогдох шалтгаанаа дурдана. Хэрэв Захиалагч нь 7 хоногийн дотор энэхүү Мэдэгдлээ хүргүүлээгүй бол түүнийг Гүйцэтгэгчийн Мэдэгдэлд тусгасан

		нэвтрэхээр санал болгосон огноонд нэвтрэх эрхийг Гүйцэтгэгчид олгосон хэмээн үзнэ. Хэрэв, Ажилд болон бүртгэлд Гүйцэтгэгч нэвтрэн орохыг зөвшөөрөхдөө Захиалагчаас гаргасан аливаа үндэслэлгүй саатлаас шалтгаалан Гүйцэтгэгч нь нэмэлт зардал гаргасан бол 20.2-ын дагуу аливаа ашиг шингэсэн үнийг төлүүлэх эрхтэй.
11.8 Гүйцэтгэгч судалгаа хийх		Гүйцэтгэгч нь Захиалагчийн зааврааp доголдол үүссэн шалтгааныг түүний удирдлага доор судална. Гүйцэтгэгч нь судалгаагаа Захиалагчийн заавар болгосон өдөр (өдрүүд)-д эсхүл Захиалагчтай тохиролцсон өдөр (өдрүүд)-д хийнэ. 11.2-ын дагуу Гүйцэтгэгч нь зардлыг хариуцахааргүй бол 20.2-д заасны дагуу судалгаатай холбоотой үүсэх ашиг шингэсэн үнийг авах эрхтэй. Хэрэв Гүйцэтгэгч нь энэхүү Зүйлийн дагуу судалгааг хийгээгүй бол Захиалагчийн ажилтан уг судалгааг хийж болно. Ийнхүү судалгаа хийгдэх бол Гүйцэтгэгчид судалгаа хийгдэх өдрийн талаар Мэдэгдэл хүргүүлэх бөгөөд Гүйцэтгэгч өөрийн зардлаараа тус судалгаанд оролцож болно. Хэрэв 11.2-ын дагуу доголдол нь Гүйцэтгэгчийн зардлаар засварлагдсан бол Захиалагч нь 20.2-ын дагуу Захиалагчаас судалгаатай холбоотой үндэслэлтэйгээр гарсан зардлыг Гүйцэтгэгчээр төлүүлэх эрхтэй
11.9 Гүйцэтгэлийн гэрчилгээ		Захиалагч нь Гүйцэтгэгчид Гүйцэтгэгчийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж дууссан өдрийг заасан Гүйцэтгэлийн гэрчилгээг гардуулан өгөх хүртэл Гүйцэтгэгчийг гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн гэж үзэхгүй. Захиалагч нь Гүйцэтгэгчид Доголдол мэдэгдэх хугацаа дууссанаас хойш 28 хоногийн дараа эсхүл Гүйцэтгэгч нь дараах нөхцөлүүдийг хангамагц аль болох хурдан хугацаанд Гүйцэтгэлийн гэрчилгээг олгоно (Маргаанаас Зайлсхийх, Шийдвэрлэх Зөвлөлд илгээх хуулбар хувийн хамт): (a) Гүйцэтгэгчийн бүх баримт бичгийг хүргүүлсэн; ба хэрэглэсэн тохиолдолд Захиалагч нь зөвшөөрсөн тухай Мэдэгдлийг 5.6-ын (b) хэсгийн дагуу өгсөн бол; болон

		(b) Гэрээнд заасны дагуу бүх ажлыг дуусгаж, туршилт явуулсан (илэрсэн аливаа доголдлыг зассанг хамааруулна) Хэрэв Захиалагч нь 28 хоногийн дотор Гүйцэтгэлийн гэрчилгээг гардуулаагүй бол энэхүү Зүйлийн дагуу Гүйцэтгэлийн гэрчилгээг гардуулах ёстой байсан өдрөөс хойш 28 дахь хоногт Гүйцэтгэлийн гэрчилгээг олгогдсон хэмээн үзнэ. Ажил хүлээн авсан гэдгийг зөвхөн Гүйцэтгэлийн гэрчилгээгээр нотолно.
11.10 Гүйцэтгээгүй үүрэг		Гүйцэтгэлийн гэрчилгээг олгосны дараа тухайн үед биелэгдээгүй үлдсэн аливаа үүргээ биелүүлэх талууд тус бүрийн үүрэг хариуцлага хэвээр үлдэнэ. Биелэгдээгүй ажил үүргийн хэмжээ болон нөхцөл байдлыг тодорхойлохын тулд Гэрээг хүчинтэй хэвээр хэмээн үзнэ. Гэсэн хэдий ч үндсэн техник хэрэгсэлийн хувьд хуулиар хориглосон, залилан үйлдсэн, хайхрамжгүй хандсан, санаатайгаар алдаа гаргах, эсхүл зүй бус үйлдлээс бусад тохиолдолд Гүйцэтгэгч нь үндсэн техник хэрэгсэлийн Доголдол мэдэгдэх хугацаа дуусгавар болсноос хойш 2 жилээс дээш хугацааны дараа үүссэн аливаа доголдол, эсхүл эвдрэл, гэмтэлд хариуцлага хүлээхгүй.
11.11 Ажлын талбайг чөлөөлөх		Гүйцэтгэгч нь Гүйцэтгэлийн гэрчилгээг хүлээн авсан даруйдаа: (a) Гүйцэтгэгчийн үлдсэн тоног төхөөрөмж, илүүдэл материал, эвдэрхий сэг, хог, ажлын талбай дээр түр хийгдсэн ажлуудыг цэвэрлэн; (b) ажил гүйцэтгэх явцад Гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд өртсөн ба Байнгын ажил явагдаагүй ажлын талбайн бүх хэсгийг нөхөн сэргээж; (c) ажлын талбайг Захиалагчийн шаардлагад заасан (хэрэв заагаагүй бол аюулгүй, цэвэрхэн) нөхцөлтэй болгон үлдээнэ. Хэрэв Гүйцэтгэгч нь Гүйцэтгэлийн гэрчилгээг хүргүүлснээс хойш 28 хоногийн дотор дээрх (a), (b) ба/эсхүл (c) заалтуудыг хэрэгжүүлээгүй бол Захиалагч нь ажлын талбай дээр үлдсэн аливаа зүйлийг худалдаж (холбогдох хууль тогтоомжоор

		зөвшөөрсөн хэмжээгээр), эсхүл өөр байдлаар арилгаж болох ба/эсхүл Ажлын талбайг (шаардлагатай бол) Гүйцэтгэгчийн зардлаар цэвэрлэж эсхүл нөхөн сэргээж болно. Захиалагч нь дээрх зүйлсийг худалдах, эсхүл өөр байдлаар ашиглах, эсхүл ажлын талбайг цэвэрлэх, нөхөн сэргээхтэй холбогдон, эсхүл тэдгээрт хамааралтайгаар, үндэслэлтэйгээр гаргасан зардлаас тэдгээрийг худалдсанаас олсон мөнгөтэй тэнцүү дүнг хассан (хэрэв худалдсан бол) зардлыг 20.2-ын дагуу Гүйцэтгэгчээр төлүүлэх эрхтэй.
12. ЗҮГШРҮҮЛЭЛТ, ТОХИРУУЛГА		
12.1 **Зүгшрүүлэлт, тохируулгын журам**		Зүгшрүүлэлт, тохируулгыг Захиалагчийн шаардлагад заасан тохиолдолд энэхүү зүйлийг баримтлана. Захиалагч Ажил болон Хэсэг ажил (тухайн тохиолдолд)-ыг хүлээн авснаас хойш нэн даруй Зүгшрүүлэлт, тохируулгыг гүйцэтгэнэ. Захиалагч нь Зүгшрүүлэлт, тохируулгад шаардлагатай бүхий л эрчим хүч, ус, бохир зайлуулах шугам (боломжтой тохиолдолд), бараа материал болон Захиалагчийн ажилтнууд болон Байгууламжаар хангана. Захиалагч нь: a) Зүгшрүүлэлт, тохируулгыг үр дүнтэй, зүй ёсоор гүйцэтгэхэд шаардагдах бүх машин механизм, туслалцаа, дэмжлэг, баримт бичиг мөн бусад холбоотой мэдээлэл, тоног төхөөрөмж, хөдөлмөр болон шаардлага хангасан мэдлэг туршлагатай ажилтнуудаар хангана; b) Гүйцэтгэгч Зүгшрүүлэлт, тохируулгыг гүйцэтгэхээр эхлэхээс өмнө 42 хоногийн дотор Захиалагчид энэхүү туршилтыг гүйцэтгэхэд шаардагдах хугацаа болон эх сурвалжийг тусгасан нарийвчилсан туршилтын хөтөлбөрийг хүргүүлнэ. Захиалагч нь нарийвчилсан туршилтын хөтөлбөрийг хянах ба Гэрээнд заасантай нийцээгүй зүйл гарсан тохиолдолд Гүйцэтгэгчид мэдэгдэл хүргүүлнэ. Мэдэгдэл хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор Гүйцэтгэгч нь туршилтын хөтөлбөрт тусгасан Гэрээнд нийцээгүй асуудлыг засаж залруулна. Захиалагч туршилтын төлөвлөгөөг (эсхүл шинэчилсэн хөтөлбөрийг) хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор дээрх мэдэгдэлийг ирүүлээгүй бол Захиалагчийг

		Зөвшөөрсөн тухай мэдэгдэл хүргүүлсэн гэж үзнэ. c) Туршилтын хөтөлбөрт заасан огнооноос гадна Гүйцэтгэгч нь Зүгшрүүлэлт, тохируулгыг гүйцэтгэхэд бэлэн байх хугацаанаас хойш 21 хоногийн дотор Захиалагчид мэдэгдэл хүргүүлнэ. d) Гүйцэтгэгчийн боловсруулсан туршилтын төлөвлөгөөг Захиалагч хянаж, Зөвшөөрсөн тухай мэдэгдэл хүргүүлэх (хүргүүлсэн гэж үзсэн) хүртэл Ажил дуусаны дараах туршилтыг эхлүүлэхгүй; e) Гүйцэтгэгч нь энэ зүйлийн (c) хэсэгт заасан Мэдэгдэлд тусгасан өдрөөс хойш 14 хоногийн дотор эсхүл Захиалагчаас зааварчилгаа өгсөн хугацаанд Зүгшрүүлэлт, тохируулгыг эхлүүлнэ. f) Зүгшрүүлэлт, тохируулгыг дараах баримт бичигт заасны дагуу гүйцэтгэнэ: i. Захиалагчин Зөвшөөрсөн тухай мэдэгдэл хүргүүлсэн (хүргүүлсэн гэж үзсэн) Гүйцэтгэгчийн туршилтын хөтөлбөр; ii. Захиалагчийн шаардлага; мөн iii. 5.7-д заасны дагуу Захиалагчийн Зөвшөөрсөн тухай мэдэгдэл хүргүүлсэн (хүргүүлсэн гэж үзсэн) Ашиглалт болон засвар үйлчилгээний гарын авлага; мөн Захиалагчийн ажилтан эсвэл Гүйцэтгэгчийн ажилтан биеэр оролцож байгаа тохиолдолд тэдний гаргасан хүсэлтийн дагуу Зүгшрүүлэлт, тохируулгыг гүйцэтгэнэ. Зүгшрүүлэлт, тохируулгын үр дүн нь Гэрээний талуудаар дамжиж үнэлэгдсэн байна. Захиалагч Ажлыг ашиглахын өмнө шаардлагатай арга хэмжээг авна.
12.2 **Туршилт хойшлох**		Хэрэв Гүйцэтгэгч нь 12.1-ийн (c) хэсэгт заасан Ажил болон Хэсэн ажил нь Зүгшрүүлэлт, тохируулгад бэлэн болсон тухай Мэдэгдлийг хүргүүлсэн ба Зүгшрүүлэлт, тохируулгыг гүйцэтгэхийг сануулсан эсвэл Захиалагч болон Захиалагчийн ажилтнаас шалтгаалж эдгээр туршилтууд нь үндэслэлгүй хойшлогдсон бол: a) Гүйцэтгэгч нь доголдол мэдэгдэх хугацаа дуусахаас өмнө Зүгшрүүлэлт, тохируулгыг нэн даруй гүйцэтгэнэ; мөн b) Хэрэв Гүйцэтгэгч нь сануулах арга хэмжээний үр дүнд зардал гаргасан бол 20.2-д заасны дагуу ашиг шингэсэн үнийг нэхэмжлэх эрхтэй.

		Гүйцэтгэгчид хамааралгүй шалтгааны улмаас Ажил дуусаны дараах туршилтыг доголдол мэдэгдэх хугацааны үед (Гэрээний талуудын тохиролцсон аливаа хугацааны дотор) гүйцэтгээгүй тохиолдолд Ажил болон Хэсэг ажлыг Зүгшрүүлэлт, тохируулганд тэнцсэн гэж үзнэ.
12.3 **Дахин туршилт явуулах**		12.4-д заасны дагуу Ажил болон Хэсэг ажил нь Зүгшрүүлэлт, тохируулгад тэнцээгүй тохиолдолд: a) 11.1-ийн (b) хэсгийг баримтална; мөн b) Аливаа доголдол болон гэмтлийг засаж залруулсны дараа 11.6-ыг баримтална. Хэрэв 11.2-ын (a)-аас (d) хүртэлх хэсэгт заасан үндэслэлээр туршилтад тэнцээгүй эсвэл дахин туршилт явуулсан мөн Захиалагчийг нэмэлт зардал гаргахад хүргэсэн бол Захиалагч нь 20.2-д заасны дагуу Гүйцэтгэгчээс зардлаа төлүүлэхээр нэхэмжлэх эрхтэй.
12.4 **Зүгшрүүлэлт, тохируулгад тэнцэхгүй байх**		Хэрэв: a) Ажил болон Хэсэг ажил нь Зүгшрүүлэлт, тохируулгад тэнцээгүй бол; мөн b) Гүйцэтгэлийн доголдлыг чанарын үзүүлэлтэд тусгасан бол Захиалагч нь 20.2-д заасны дагуу Гүйцэтгэгчээс Гүйцэтгэлийн доголдлыг бүрэн нэхэмжлэх эрхтэй. Хэрэв Гүйцэтгэгч нь Захиалагчид уг зардлыг доголдол мэдэгдэх хугацааны үед төлж барагдуулсан бол Ажил болон Хэсэг ажлыг Зүгшрүүлэлт, тохируулгад тэнцсэн гэж үзнэ. Хэрэв Ажил болон Хэсэг ажил нь Зүгшрүүлэлт, тохируулгад тэнцээгүй бол мөн Захиалагчид Мэдэгдэл хүргүүлснээр Гүйцэтгэгч нь эдгээр Ажил болон Хэсэг ажилд тохируулга болон өөрчлөлт оруулах санал гаргасан бол: i. Захиалагч нь Гүйцэтгэгчид хүргүүлэх Мэдэгдэлдээ тухайн Ажил эсвэл Хэсэг ажил руу нэвтрэх эрхийг Захиалагчийн тохиромжтой гэж үзэх цаг хүртэл олгох боломжгүй болохыг зааж өгч болно; ii. Гүйцэтгэгч нь энэ зүйлийн (i) хэсэгт заасан Мэдэгдлийг хүлээн авснаас хойш боломжит хугацааны дотор тохируулга болон өөрчлөлтийг хийж, энэхүү Туршилтад тэнцэх үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэсээр байна; мөн

		iii. Хэрэв Гүйцэтгэгч нь энэ зүйлийн (i) хэсэгт заасан Мэдэгдэлийг доголдол мэдэгдэх хугацааны үед хүлээн аваагүй бол Гүйцэтгэгч нь ийм тохируулга болон өөрчлөлт хийх үүргээс чөлөөлөгдөх бөгөөд Ажил болон Хэсэг ажлыг (тохиолдлын дагуу) Зүгшрүүлэлт, тохируулгад тэнцсэн гэж үзнэ. Хэрэв Зүгшрүүлэлт, тохируулгад тэнцээгүй шалтгааныг судлах эсхүл аливаа тохируулга болон өөрчлөлт оруулахад мөн Гүйцэтгэгчийн Ажил болон Хэсэг ажилд нэвтрэх эрхийг Захиалагч үндэслэлгүйгээр хойшлуулсанаас үүдэж Гүйцэтгэгч зардал гаргахад учирсан бол Гүйцэтгэгч нь 20.2-д заасны дагуу ашиг шингэсэн үнийг нэхэмжлэх эрхтэй.
13. Ажлын өөрчлөлт болон Үнийн тохируулга		
13.1 Ажилд өөрчлөлт оруулах эрх		Захиалагч нь Ажил хүлээн авсан гэрчилгээг олгохоос өмнө, хэдийд ч 13.3-ын дагуу Ажилд өөрчлөлт оруулахыг санаачилж болно. 11.4-д зааснаас бусад тохиолдолд Ажлын өөрчлөлт нь, Захиалагчийн, эсхүл Талууд өөрөөр тохиролцоогүй бол бусад этгээдийн гүйцэтгэх аливаа ажлын орхигдуулалтаас бүрдэх ёсгүй. Гүйцэтгэгч нь доорх зүйлсийг (нарийвчилсан нэмэлт мэдээллийн хамт) тусгасан Мэдэгдлийг Захиалагчид цаг тухайд нь өгөөгүйгээс бусад тохиолдолд, 13.3.1-ийн дагуу зааварчлагдсан аливаа Ажлын өөрчлөлтийг оруулах үүрэгтэй ба Ажлын өөрчлөлтийг сааталгүй бөгөөд зохих хэмжээнд шуурхай оруулна: (a) Захиалагчийн шаардлагад тодорхойлсон ажлын цар хэмжээ ба шинж чанарыг харгалзан үзэхэд, өөрчлөгдсөн ажил нь Урьдчилан мэдэх боломжгүй нөхцөл байдал байсан; (b) Гүйцэтгэгч нь Ажлын өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд шаардлагатай Барааг шуурхай олж бэлтгэх боломжгүй; (c) энэ нь 4.8 ба/эсхүл 4.18-ыг даган биелүүлэх Гүйцэтгэгчийн боломж нөхцөлд сөргөөр нөлөөлөх байсан. (d)Чанарын үзүүлэлтэд сөргөөр нөлөөлөх байсан. (e) Гүйцэтгэгч нь 4.1-д заасан Ажлыг гүйцэтгэж дуусгах үүргээ биелүүлэхэд нь сөргөөр нөлөөлж болзошгүй

		Энэхүү Мэдэгдлийг хүлээн авсны дараа Захиалагч нь зааварчилгаагаа цуцалсан, баталгаажуулсан, эсхүл өөрчилсөн тухай Мэдэгдлийг Гүйцэтгэгчид нэн даруй хариу илгээнэ. Ийнхүү баталгаажуулсан, эсхүл өөрчилсөн талаарх аливаа зааварчилгааг 13.3.1-ийн дагуу өгсөн зааварчилгаа гэж үзнэ.
13.2 Инженерчлэлийн үр ашиг		Гүйцэтгэгч нь хэдийд ч Захиалагчид бичгээр үйлдсэн саналыг (гүйцэтгэгчийн бодлоор) хүргүүлэх эрхтэй, хэрэв батлагдвал: (a) ажлыг дуусгах явцыг хурдасгах; (b) Ажлыг гүйцэтгэх, ашиглах болон засвар арчлалтыг хийх Захиалагчийн зардлыг бууруулах; (c) хийгдэж дууссан ажлын үр ашиг эсхүл үнэ цэнийг Захиалагчийн талд нэмэгдүүлэх; эсхүл (d) өөр байдлаар Захиалагчид үр ашиг өгөх. Саналыг Гүйцэтгэгчийн зардлаар бэлтгэх ба тус санал нь 13.3.1-ийн (a)-аас (c) заалтад тусгасан зүйлсийг багтаасан байна. Захиалагч нь ийм саналыг хүлээн авсны дараа, өөрийн зөвшөөрлийг олгосон Мэдэгдлийг аль болох боломжит хурдан хугацаанд Гүйцэтгэгчид илгээн, эсхүл өөр байдлаар хариу өгнө. Захиалагчийн зөвшөөрөл, эсхүл бусад шийдвэрээр өгөх хариу нь дан ганц Захиалагчийн үзэмжээр шийдэгдэнэ. Гүйцэтгэгч нь хариу хүлээж байхдаа ямар ч ажлыг саатуулах ёсгүй. Хэрэв Захиалагч нь тухайн саналд өөрийн зөвшөөрлийг тайлбартайгаар, эсхүл тайлбаргүйгээр өгсөн бол, дараа нь Ажлын өөрчлөлт оруулах зааварчилгааг Захиалагч өгнө. Үүний дараа: (i) Гүйцэтгэгч нь Захиалагчаас үндэслэлтэйгээр шаардаж болох нэмэлт дэлгэрэнгүй мэдээллүүдийг хүргүүлэх; болон (ii) Тусгай нөхцөлд тусгагдсан Талуудын хооронд үр ашиг, зардал ба/эсхүл саатлыг хуваарилах (хэрэв байгаа бол) асуудлыг Захиалагч авч үзэхийг багтаасан 13.3.1-ийн гурав дахь цогцолборыг хэрэглэнэ.

13.3 Ажлын өөрчлөлт оруулах журам		Захиалагч нь 13.1-тэй уялдуулан, доорх заалтуудын аль нэгийн дагуу Ажлын өөрчлөлтийг гаргана: <u>13.3.1 Зааварчилгаагаар Ажлын өөрчлөлт оруулах</u> Захиалагч нь (оруулах шаардлагатай өөрчлөлт болон Зардлыг бүртгэхэд тавигдах аливаа шаардлагуудыг тусгасан) Мэдэгдлийг 3.4-ийн дагуу Гүйцэтгэгчид хүргүүлэн, Ажлын өөрчлөлт оруулахыг зааварчилж болно. Гүйцэтгэгч нь Ажлын өөрчлөлтийг оруулж эхлэх ба Захиалагчийн зааварчилгааг хүлээн авснаас хойш 28 хоногийн (эсхүл Гүйцэтгэгч санал болгож, Захиалагч зөвшөөрсөн өөр хугацаанд) дотор доорх зүйлсийг хамруулсан нарийвчилсан мэдээллийг Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ: (a) Гүйцэтгэгчийн хэрэглэж буй, эсхүл хэрэглэх нөөц болон ажлын аргачлалыг багтаасан гүйцэтгэсэн, эсхүл гүйцэтгэх гэж буй өөрчлөгдсөн ажлын нэр төрөл; (b) ажлыг гүйцэтгэх нарийвчилсан төлөвлөгөө ба 8.3-ын дагуу Ажлын календарчилсан төлөвлөгөөнд болон Ажил дуусах хугацаанд оруулах аливаа шаардлагатай өөрчлөлтүүдийн (хэрэв байгаа бол) талаарх Гүйцэтгэгчийн санал; ба (c) Ажлын өөрчлөлтөд үнэлгээ, тооцоог хийх байдлаар Гэрээний үнэд тохируулга хийх Гүйцэтгэгчийн саналыг холбогдох мэдээллийн хамт. Орхигдуулсан аливаа ажил нь Ажлын өөрчлөлтийн хэсгийг (эсхүл бүхлээр нь) бүрдүүлж болгож байгаа болон хэрвээ: • Хэрэв тухайн ажлыг хасаагүй байсан бол Гэрээний хэлэлцээрт заасны дагуу Гэрээний үнийн бүрдлээс нөхөгдөх боломжтой байсан Гүйцэтгэгчид учирсан эсхүл ирээдүйд учирч болох зардлыг; ба • Тухайн Ажлын хасалт нь Гэрээний үнийг бүрдүүлэхгүй байхад нөлөөлсөн эсхүл нөлөөлөх. Энэхүү зардал нь Гүйцэтгэгчийн саналд багтсан байж болно (хэрэв багтсан бол энэ тухай тодорхой тусгана). Хэрэв Талууд нь бусад этгээдийн гүйцэтгэх аливаа ажлын орхигдуулалтыг тохиролцсон бол, орхигдуулалтаас шалтгаалан Гүйцэтгэгчид учирсан (эсхүл учирч болох) аливаа ашгийн алдагдал болон

		бусад алдагдал ба хохирлын дүнг Гүйцэтгэгчийн саналд мөн оруулж болно. Үүний дараа Гүйцэтгэгч нь Захиалагчийн төлөөлөгчөөр үндэслэлтэйгээр шаардаж болох аливаа нэмэлт мэдээллийг хүргүүлнэ. Үүний дараа Захиалагчийн төлөөлөгч нь доорх зүйлсийг хэлэлцэж, зөвшилцөх, эсхүл шийдвэрлэхээр 3.5-д заасны дагуу үргэлжлүүлэн ажиллана: i. Хугацаа сунгах, хэрэв байгаа бол; ба/эсхүл ii. Гэрээний үнийн болон Төлбөрийн хуваарьт тохируулга (ба 3.5.3-ын хангах зорилгоор, Гүйцэтгэгчийн танилцуулгыг (шаардсан аливаа нэмэлт мэдээллийг оролцуулан) Захиалагчийн төлөөлөгч хүлээн авсан огноо нь 3.5.3-д заасан огноо байна.) Гүйцэтгэгч нь 20.2-ыг дагаж мөрдөх ямар нэгэн шаардлагагүйгээр, энэхүү Хугацаа сунгалтын ба/эсхүл Гэрээний үнийн тохируулгын эрхтэй байна. Хэрэв Гэрээнд Үнийн задаргааг заагаагүй бол дээрх (ii) дахь хэсэгт заасны дагуу хийгдэх тохиргоог ажил гүйцэтгэх явцад бий болсон Ашиг шингэсэн үнээс гарган авна. Хэрэв Үнийн задаргааг заагаагүй бол энэхүү 13.3.1-ийн доорх хэсэгт заасан нь дээрх (ii) дахь хэсэгт заасны дагуу тохиргоог хийнэ. Ажлын өөрчлөлтийн хэсгийг (эсхүл бүхлээр нь) бий болгож буй зүйлийн хувьд тухайн зүйлийн зохимжит хувь хэмжээ буюу үнэ нь Үнийн задаргаанд заасан тухайн зүйлийн хувь хэмжээ буюу үнэ байна. Хэрэв ийм үнэ буюу хувь хэмжээг тодорхой заагаагүй бол түүнтэй төстэй ажилд холбогдох хувь хэмжээ буюу үнийг хэрэглэнэ. Гэсэн хэдий ч хэрэв Үнийн задаргаанд тухайн зүйлд холбогдох тодорхой хувь хэмжээ буюу үнийг тусгаагүй ба тухайн ажилтай ижил төсөөтэй биш, эсхүл Гэрээнд тусгагдсан ямар ч зүйлтэй ижил төрлийн нөхцөлөөр гүйцэтгээгүй тохиолдолд тодорхой заасан хувь хэмжээ болон үнийг хэрэглэх боломжгүй бол шинэ хувь хэмжээ буюу үнийг тогтоон хэрэглэнэ. Шинэ хувь хэмжээ буюу үнийг Үнийн задаргаа дахь холбогдох хувь хэмжээ буюу үнээс гаргаж авах бөгөөд холбогдох бүх нөхцөл байдлыг харгалзан боломжит

		тохируулгыг хийнэ. Хэрэв шинэ хувь хэмжээ буюу үнийг гаргахад ямар нэгэн хувь хэмжээ буюу үнэ хамаарахгүй бол уг ажлыг гүйцэтгэх явцад гарсан Ашиг шингэсэн үнээс гаргана. Дээрх (ii) дахь хэсэгт заасан зохицуулалтыг тохиролцох эсхүл шийдвэрлэх хүртэл хугацаанд Захиалагч нь 14.6-ын дагуу явц дундын төлбөрийн зорилгоор түр хугацааны хувь хэмжээ буюу үнийг ноогдуулна. <u>13.3.2 Санал ирүүлэх хүсэлтээр Ажлын өөрчлөлт оруулах</u> Захиалагч нь (төлөвлөж буй өөрчлөлтийг тодорхой тусгасан) Мэдэгдлийг Гүйцэтгэгчид өгөн, Ажлын өөрчлөлт оруулахыг зааварчлахаас өмнө, түүнээс саналаа ирүүлэх хүсэлт тавьж болно. Гүйцэтгэгч нь энэхүү Мэдэгдлийг хүлээн авснаас хойш аль болох түргэн хугацаанд, доор дурдсаны аль нэгээр нь хариу өгнө: (a) 13.3.1-ийн (a)-аас (c) хэсэгт заасан асуудлуудыг тусгасан саналаа хүргүүлэх; эсхүл (b) 13.1-ийн (a)-аас (e) хэсэгт заасан асуудлуудыг үндэслэн, яагаад Гүйцэтгэгч дагаж мөрдөх боломжгүй талаарх шалтгаануудаа (хэрэв үнэхээр тийм бол) хүргүүлэх. Захиалагч нь ийм саналыг хүлээн авсны дараа, өөрийн зөвшөөрлийг олгосон Мэдэгдлийг аль болох боломжит хурдан хугацаанд Гүйцэтгэгчид илгээн, эсхүл өөр байдлаар хариу өгнө. Гүйцэтгэгч нь хариу хүлээж байхдаа ямар ч ажлыг саатуулах ёсгүй. Хэрэв Захиалагч нь тухайн саналд өөрийн зөвшөөрлийг тайлбартайгаар, эсхүл тайлбаргүйгээр өгсөн бол, дараа нь Ажлын өөрчлөлт оруулах зааварчилгааг Захиалагч өгнө. Үүний дараа Гүйцэтгэгч нь Захиалагчаас үндэслэлтэйгээр шаардаж болох нэмэлт дэлгэрэнгүй мэдээллүүдийг хүргүүлэх ба 13.3.1-ийн гурав дахь цогцолборыг хэрэглэнэ. Хэрэв Захиалагч нь тухайн саналд тайлбартайгаар, эсхүл тайлбаргүйгээр зөвшөөрөл өгөөгүй ба, хэрэв Гүйцэтгэгч нь саналаа хүргүүлснээс шалтгаалан Зардал

		гаргасан бол, Гүйцэтгэгч нь 20.2-ын дагуу энэ Зардлаа төлүүлэх эрхтэй.
13.4 Нөөц хөрөнгө		Нөөц хөрөнгө тус бүрийг зөвхөн Захиалагчийн зааварчилгааны дагуу бүхлээр нь буюу хэсэгчилсэн байдлаар хэрэглэх ба Гэрээний үнэд зохих байдлаар тохируулга хийгдэнэ. Гүйцэтгэгчид төлөгдсөн нийт үнийн дүнд гагцхүү Захиалагчаас зааварчилсан Нөөц хөрөнгийн дүнтэй холбоотой ханган нийлүүлэлт эсхүл ажил үйлчилгээний дүнг хамруулан тооцно. Нөөц хөрөнгө тус бүрд Захиалагч дараах зүйлсийг зааварчилж болно: (a) Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэх ажил (Үндсэн техник хэрэгсэл, Материал эсхүл үзүүлэх үйлчилгээг оролцуулан) ба 13.3.1-ийн дагуу тохиролцох эсхүл шийдвэрлэх ёстой Гэрээний үнийн өөрчлөлт болон Төлбөрийн Хуваарь; (b) Санал болгосон туслан гүйцэтгэгчээс (4.5-д заасны дагуу) эсхүл бусад байдлаар нийлүүлсэн, Гүйцэтгэгч худалдаж авах Үндсэн техник хэрэгсэл, Материал, ажил эсхүл үзүүлэх үйлчилгээнүүд; болон эдгээрийн үнийн дүнг Гэрээний үнэд дараах байдлаар тусгаж оруулна: (i) Гүйцэтгэгчийн төлсөн (эсхүл төлөх ёстой) бодит дүн; ба (ii) холбогдох Төлбөрийн хуваарьт тусгагдсан зохих хувь хэмжээг (хэрэв байгаа бол) ашиглан, эдгээр бодит дүнгээс хувилан тооцож гаргасан, нэмэгдэл зардал болон ашгийн дүн. Хэрэв ийм хувь байхгүй бол Гэрээний өгөгдөлд заасан хувийг ашиглана. Хэрэв Захиалагч нь дээрх (a) ба/эсхүл (b) хэсгийн дагуу Гүйцэтгэгчид зааварчилсан бол энэхүү зааварчилгаанд, хийгдэх ажлын, эсхүл худалдан авах Үндсэн техник хэрэгсэл, Материал, ажил болон үйлчилгээний бүх (эсхүл зарим) нэр төрөлд өгөх Гүйцэтгэгчийн ханган нийлүүлэгчдийн ба/эсхүл Туслан гүйцэтгэгчдийн үнийн саналыг хүргүүлэхтэй холбогдсон Гүйцэтгэгчийн шаардлагыг оруулж болно. Дараа нь, Захиалагч нэг бол, эдгээр үнийн саналын нэгийг зөвшөөрөхийг (гэхдээ, энэхүү зааварчилгааг 4.5-ын дагуу зааварчилгаа гэж үзэхгүй) Гүйцэтгэгчид зааварчилсан, эсхүл зааварчилгаа хүчингүй болгосон Мэдэгдлийг илгээн, хариу өгч болно. Хэрэв Захиалагч нь үнийн саналыг хүлээн авснаас хойш 7 хоногийн

		дотор хариу өгөөгүй бол, Гүйцэтгэгч нь эдгээр үнийн саналын алийг нь ч өөрийн үзэмжээр сонгох эрхтэй. Нөөц хөрөнгөтэй холбоотой Төлбөрийн нэхэмжлэл бүрд холбогдох нэхэмжлэл, ваучер, дансны болон төлбөрийн баримт зэргийг Нөөц хөрөнгийн нотолгоо болгон хавсаргана.
13.5 Өдрөөр тооцох төлбөр		Хэрэв Гэрээнд Өдрөөр тооцох төлбөрийн хуваарь тусгагдаагүй бол, Энэхүү Зүйлийг хэрэглэхгүй. Бага хэмжээний буюу туслах чанарын ажлын хувьд Ажлын өөрчлөлтийг Өдрөөр тооцох төлбөрийн хуваарьт үндэслэн гүйцэтгэхийг Захиалагч зааварчилж болно. Ийм тохиолдолд ажлыг, Өдрөөр тооцох төлбөрийн хуваарийн дагуу үнэлж, өртгийг тодорхойлох ба дараах журмыг баримтална. Гүйцэтгэгч нь энэхүү ажилд хэрэглэх Барааг (Өдрөөр тооцох төлбөрийн хуваарьт тусгагдсан аливаа Бараанаас бусад) захиалахаасаа өмнө, Гүйцэтгэгчийн ханган нийлүүлэгчдийн ба/эсхүл Туслан гүйцэтгэгчдийн нэг, эсхүл түүнээс дээш үнийн саналыг Захиалагчид хүргүүлнэ. Үүний дараа Захиалагч эдгээр үнийн саналын нэгийг зөвшөөрөхийг (гэхдээ, энэхүү зааварчилгааг 4.5-ын дагуу зааварчилгаа гэж үзэхгүй) Гүйцэтгэгчид зааварчилж болно. Хэрэв Захиалагч нь үнийн саналыг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор ийнхүү зааварчлаагүй бол, Гүйцэтгэгч нь эдгээр үнийн саналын алийг нь ч өөрийн үзэмжээр хүлээн зөвшөөрөх эрхтэй. Гүйцэтгэгч нь, Өдрөөр тооцох төлбөрийн хуваариар төлбөр нь хийгдэх болоогүй аливаа зүйлээс бусад, өмнөх өдрийн ажлыг гүйцэтгэхэд хэрэглэсэн нөөцийн бүртгэлийг (6.10-д тодорхойлсны дагуух) дотроо багтаасан, үнэн зөв гаргасан төлбөрийн нэхэмжлэлийн хуулбар хувийг (ба нэг цахим хувийг) өдөр бүр Захиалагчид хүргүүлнэ. Хэрэв төлбөрийн нэхэмжлэл нь үнэн зөв бөгөөд түүнийг зөвшөөрсөн бол, Захиалагч гарын үсэг зурж, төлбөрийн нэхэмжлэл тус бүрийн нэг хувийг Гүйцэтгэгчид нэн даруй буцаана. Хэрэв төлбөрийн нэхэмжлэл нь алдаа мадагтай, эсхүл түүнийг зөвшөөрөөгүй бол, Захиалагчийн төлөөлөгч дараа нь ашигласан нөөцийг тохиролцох, эсхүл шийдвэрлэхээр 3.5-ын дагуу үргэлжлүүлэн ажиллах

		(ба 3.5.3-ын зорилгоор, энэхүү Зүйлийн дагуух Ажлын өөрчлөлтөд хамаарах ажлыг Гүйцэтгэгч хийж дуусгасан огноо нь 3.5.3-д заасан огноо байна). Дараагийнхаа Төлбөрийн нэхэмжлэлд Гүйцэтгэгч нь тохиролцсон эсхүл шийдвэрлэсэн нөөцийг үнэлж, өртгийг тодорхойлсон тооцоог, Өдрөөр тооцох төлбөрт ашиглагдсан аливаа Барааны (Өдрөөр тооцох төлбөрийн хуваарьт үнэ нь тусгагдсан аливаа Бараанаас бусад) нотолгоо болгосон бүх холбогдох нэхэмжлэх, ваучер, дансны болон төлбөрийн баримтуудын хамт тусган Захиалагчид хүргүүлнэ. Өдрөөр тооцох төлбөрийн жагсаалтад өөрөөр заагаагүй бол, Өдрөөр тооцох төлбөрийн хуваарьт байгаа үнэ ба тариф нь үнэлгээнд татвар хураамж, нэмэгдэл зардал ба ашгийг шингээсэн гэж үзнэ.
13.6 Хууль, тогтоомжид орсон өөрчлөлттэй холбогдолтой тохируулга		Энэхүү зүйлийн дараах заалтуудыг баримтлан, Суурь огнооны дараа хийгдсэн ба/эсхүл Суурь огнооны дараа албан ёсоор хэвлэгдсэн бөгөөд Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь Гүйцэтгэгчид нөлөөлсөн, доор дурдсан зүйлүүдэд орсон өөрчлөлтийн үр дүнд үүссэн Зардлын аливаа өсөлт, эсхүл бууралтыг харгалзан Гэрээний үнэд тохируулга хийнэ: (a) Тухайн Улсын Хууль, (хууль тогтоомжийг шинээр батлах болон хуулийг шинэчлэн найруулах, хуульд өөрчлөлт оруулах зэрэг багтана) тогтоомжид; (b) Дээрх (a) хэсэгт заасантай холбоотойгоор гарсан шүүхийн эсхүл төр захиргааны албан ёсны тайлбар эсхүл хэрэгжүүлэлтэд; (c) 1.12-ын (a) эсхүл (b) заалтуудад тус бүр харгалзан Захиалагчийн, эсхүл Гүйцэтгэгчийн олж авсан аливаа зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, лиценз болон бусад албан ёсны эрх олгосон баримт бичгүүд; эсхүл (d) 1.12-ын (b) хэсгийн дагуу Гүйцэтгэгчийн олж авах аливаа зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, лицензэд тавигдах шаардлагууд ба/эсхүл бусад албан ёсны эрх олгосон баримт бичгүүд; Энэхүү Зүйлд “Хууль, тогтоомжид орсон өөрчлөлт” гэж дээрх (a), (b), (c) ба (d) хэсгийн дагуух аливаа өөрчлөлтийг хэлнэ.

		Хэрэв Гүйцэтгэгч нь Хууль, тогтоомжид орсон өөрчлөлтөөс шалтгаалан сааталтай тулгарсан ба/эсхүл нэмэгдэл Зардал гаргасан бол Гүйцэтгэгч нь 20.2-ын дагуу энэ Зардлаа төлүүлэх эсхүл хугацаа сунгах эрхтэй. Хэрэв Хууль, тогтоомжид орсон өөрчлөлтөөс шалтгаалан зардлын бууралт бий болсон бол, Захиалагч нь 20.2-ын дагуу Гэрээний үнийг бууруулах эрхтэй. Хэрэв Хууль тогтоомжид орсон өөрчлөлтөөс шалтгаалан ажлыг гүйцэтгэхэд ямар нэгэн тохируулга хийх шаардлагатай болвол (дагалдах нарийвчилсан мэдээлэл бүхий): (i) Гүйцэтгэгч нь Захиалагчид Мэдэгдлийг нэн даруй хүргүүлнэ, эсхүл (ii) Захиалагч нь Гүйцэтгэгчид Мэдэгдлийг нэн даруй хүргүүлнэ. Үүний дараа Захиалагч нь нэг бол 13.3.1-ийн дагуу Ажлын өөрчлөлт оруулах зааварчилгааг өгнө, эсхүл 13.3.2-ын дагуу санал ирүүлэх хүсэлтийг илгээнэ.
13.7 Зардалд орсон өөрчлөлттэй холбоотой тохируулга		Хэрэв Тусгай нөхцөлд Зардлын индексжүүлэлтийн жагсаалт тусгагдаагүй бол энэ Зүйлийг хэрэглэхгүй. Хөдөлмөрийн хөлс, Бараа болон Ажлын бусад бүрдлийн зардлын өсөлт ба бууралтыг тооцон, Тусгай нөхцөлд заасан Зардлын индексжүүлэлтийн жагсаалтын дагуу гарсан дүнг нэмэх, эсхүл хасах замаар Гүйцэтгэгчид төлбөл зохих төлбөрийн дүнг тохируулна. Энэхүү Зүйлийн эсхүл эдгээр нөхцөлийн бусад Зүйлд тусгагдаагүй зардлын аливаа өсөлт эсхүл бууралтын бүрэн нөхөн олговрын тухайд уг зардлын өсөлт болон бууралттай холбоотой магадалшгүй зардлын үнийн дүнг Гэрээний хэлэлцээрт тусгагдсан Гэрээний үнийн дүнд багтаасан гэж үзнэ. 14-д зааснаас өөр байдлаар Гүйцэтгэгчид төлөх дүнд хэрэглэх тохируулгыг Гэрээний үнийн төлбөрийг хийх мөнгөн тэмдэгт тус бүрээр тооцоолж гаргана. Зардал, эсхүл өнөөгийн үнийг үндэслэж үнэлсэн ажилд ямар ч тохируулга хийхгүй. Өнөөгийн үнийн индекс тус бүрийг тодорхой болох хүртэл, 14-ийн дагуу Явц дундын төлбөрийг олгохын

		тулд Захиалагч нь түр хугацааны индексийг хэрэглэнэ. Өнөөгийн үнийн индекс тодорхой болмогц тохируулгыг зохих ёсоор дахин тооцоолно. Хэрэв Гүйцэтгэгч нь ажил дуусах хугацааны дотор дуусгаагүй бол, үнийн тохируулгыг доор дурдсанаас Захиалагчид илүү тохиромжтой аль нэгийг нь сонгон хийнэ: (a) Ажил дуусах хугацааг дуусгавар болохоос 49 хоногийн өмнөх өдрийн индекс, эсхүл үнэ тус бүрийг; эсхүл (b) өнөөгийн индекс, эсхүл үнийг.
14. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БОЛОН ТӨЛБӨР		
14.1 **Гэрээний үнэ**		Тусгай нөхцөлд өөрөөр заагаагүй бол: (a) Гэрээний төлбөр нь Гэрээний хэлэлцээрт заасан бүх зардлыг тооцсон тогтмол нийт гэрээний үнэ (the lump sum) дээр хийгдэх ба Гэрээнд заасны дагуу аливаа тохируулга (өөрчлөлт), нэмэлт (эдгээр Гэрээний нөхцөлийн дагуу Гүйцэтгэгчийн авах эрх бүхий Зардал эсхүл Ашиг шингэсэн үнийг багтаана) эсхүл/болон хасалт зэргийг хийж болно. (b) Гүйцэтгэгч нь Гэрээний дагуу төлөхөөр үүрэг хүлээсэн бүхий л татвар, хураамж, төлбөрийг төлөх үүрэгтэй бөгөөд Гэрээний үнэд гэрээний 13.6-д зааснаас бусад тохиолдолд ямар нэгэн тохируулга хийгдэхгүй. Хэрэв аливаа тоо хэмжээ нь Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан бол Гүйцэтгэгчийн гүйцэтгэхээр үүрэг хүлээсэн Ажлын тоо хэмжээг бодит болон зөв тоо хэмжээгээр тооцохгүй ба уг тоо хэмжээ нь зөвхөн Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөнд заасан зорилгоор ашиглагдана.
14.2 **Урьдчилгаа төлбөр**		Хэрэв Гэрээний өгөгдөлд урьдчилгаа төлбөрийн дүн тусгагдаагүй бол энэхүү хэсэг хэрэглэгдэхгүй. Энэхүү хэсгийн дараах заалтуудыг баримтлан, Захиалагч нь ажлыг эхлүүлэх болон зураг төсөлд зориулан урьдчилгаа төлбөрийг хүүгүй зээл хэлбэрээр олгоно. Төлөгдөх ёстой урьдчилгаа төлбөрийн дүн болон мөнгөн тэмдэгтүүд нь Гэрээний өгөгдөлд заасны дагуу байна.
14.2.1		<u>Урьдчилгаа төлбөрийн баталгаа</u> Гүйцэтгэгч нь урьдчилгаа төлбөртэй тэнцүү хэмжээний мөнгөн дүн болон төлбөр хийгдэх мөнгөн

		тэмдэгтээр гаргасан Урьдчилгаа төлбөрийн баталгааг (өөрийн зардлаар) гаргуулж авах ба түүнийг Захиалагчид хүргүүлнэ. Энэхүү баталгааг тухайн улс орны (эсхүл бусад хууль тогтоомжоор) Захиалагчийн зөвшөөрсөн хуулийн этгээдээр гаргуулах бөгөөд тендерийн баримт бичгээр өгөгдсөн маягт эсхүл Захиалагчийн зөвшөөрсөн маягтыг ашиглана (гэхдээ энэхүү зөвшөөрөл болон/эсхүл хэлцэл нь Гүйцэтгэгчийг энэ хэсгийн дагуу хүлээх аливаа үүрэг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй). Гүйцэтгэгч нь урьдчилгаа төлбөр эргэн төлөгдөж дуусах хүртэл Урьдчилгаа төлбөрийн баталгааг хүчин төгөлдөр байлгах үүрэгтэй бөгөөд түүний дүн нь Гүйцэтгэгчээс эргэн төлөгдсөн төлбөрийн хэмжээгээр үе шаттайгаар буурч болно. Хэрэв Урьдчилгаа төлбөрийн баталгаанд хүчин төгөлдөр байх хугацаа заагдсан бөгөөд тухайн хүчин төгөлдөр байх эцсийн хугацаанаас өмнө 28 хоногт багтаан урьдчилгаа төлбөрийг төлж барагдуулаагүй бол: (a) Гүйцэтгэгч нь энэхүү баталгааны хүчинтэй хугацааг урьдчилгаа төлбөр төлөгдөж дуустал сунгана; (b) Гүйцэтгэгч нь энэхүү сунгалтыг нотолсон баримтыг Захиалагчид нэн даруй хүргүүлнэ; мөн (c) Хэрэв уг сунгалтыг нотолсон баримтыг энэхүү баталгааны хүчинтэй хугацаа дуусахаас 7 хоногийн өмнө Захиалагч хүлээж аваагүй бол Захиалагч нь урьдчилгаа төлбөрөөс төлөгдөөгүй дүнг нэхэмжлэх эрхтэй. Урьдчилгаа төлбөрийн баталгааг ирүүлэхдээ Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийг авах хүсэлтээ (Төлбөрийн нэхэмжлэл хэлбэрээр) хамт өгнө.
14.2.2		<u>Урьдчилгаа төлбөр</u> Захиалагч нь доорх нөхцөлүүд бүрдсэний дараа 14 хоногийн дотор, урьдчилгаа төлбөрийг хийнэ. Үүнд: (a) Захиалагч нь гэрээний 4.2.1 болон 14.2.1-д тус тус заасны дагуу маягт болон холбогдох хуулийн этгээдээс олгогдсон Гүйцэтгэлийн баталгаа болон Урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авснаас хойш; Захиалагч нь 14.2.1-д заасан хэсгийн дагуу Гүйцэтгэгчийн Урьдчилгаа төлбөр авах хүсэлтийг хүлээн авснаас хойш.

14.2.3		<u>Урьдчилгаа төлбөрийн буцаан төлөлт</u> Гэрээний 14.6-д заасны дагуу явц дундын төлбөрөөс тодорхой хувиар суутгах замаар урьдчилгаа төлбөрийг буцаан төлүүлнэ. Хэрэв Гэрээний өгөгдөлд өөр хувь хэмжээ тусгагдаагүй бол: (a) Урьдчилгаа төлбөрийн мөнгөн тэмдэгттэй ижил мөнгөн тэмдэгт бүхий завсрын төлбөрийн (урьдчилгаа төлбөр, хасалтууд/суутгал, барьцаанаас чөлөөлсөн мөнгөний дүн орохгүй) нийлбэр дүн нь, Багцаалсан дүнг хассан Гэрээний мөн ижил мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдсэн, Гэрээний хэлэлцээрт заасан Гэрээний үнийн арван хувиас (10%)-иас давсан хэмжээтэй Явц дундын төлбөрөөс суутгал хийгдэж эхэлнэ, мөн; (b) Урьдчилгаа төлбөр төлөгдөж дуустал, Явц дундын төлбөр тус бүрийн дүнгийн (урьдчилгаа төлбөр, хасалтууд/суутгал, барьцааны чөлөөлсөн мөнгөний дүн орохгүй) дөрөвний нэг буюу 25%-тай тэнцэх өр барагдуулах хувиар урьдчилгаа төлбөрийн мөнгөн тэмдэгт болон харьцаагаар хасалт/суутгалыг хийнэ. Хэрвээ Ажил хүлээн авах гэрчилгээг олгохоос өмнө эсхүл гэрээний 15, 16 болон 18-д заасны дагуу гэрээг цуцлахаас өмнө урьдчилгаа төлбөр төлөгдөөгүй бол Гүйцэтгэгч нь үлдэгдэл нийт төлбөрийг Захиалагчид нэн даруй буцаан төлөх үүрэгтэй.
14.3 **Явц дундын төлбөрийн хүсэлт**		Гүйцэтгэгч нь Гэрээний өгөгдөлд заасан төлбөрийн хугацаа дуусаны дараах өдөрт (хугацаа заагаагүй бол сар бүрийн эцэст) Төлбөрийн нэхэмжлэлийг Захиалагчид хүргүүлнэ. Төлбөрийн нэхэмжлэл бүр доор дурдсаны дагуу байна: (a) Захиалагчийн хүлээн зөвшөөрсөн маягтын дагуу байна; (b) Гэрээний өгөгдөлд заасны дагуу 1 цаасан эх хувь, 1 цахим хувь болон нэмэлт цаасан хуулбарууд (хэрэв заагдсан бол) байдлаар хүргүүлнэ; (c) Гүйцэтгэгчийг авах эрхтэй гэж үзсэн дүнг нарийвчлан харуулах бөгөөд эдгээр дүнг гэрээний 4.20-д заасны дагуу явцын холбогдох тайлангийн хамт Захиалагч судлахад хангалттай дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан дагалдах баримт бичгийн хамт байх ёстой. Төлбөрийн нэхэмжлэл нь дор дурдсан жагсаалтын дагуу холбогдох зүйлсийг агуулсан байх бөгөөд

		тэдгээр нь төлөгдөх ёстой Гэрээний үнэд заасан өөр өөр мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдсэн байна. Үүнд: 1. Төлбөрийн хугацааны сүүлийн өдөр хүртэл Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэл (гэрээний үнээр тооцоолсон) болон Гүйцэтгэгчийн боловсруулсан баримт бичгийн гэрээний тооцоолсон үнэ (Гэрээний Ажлын өөрчлөлтүүдийг тусгах бөгөөд доорх (ii) – (x) хэсгүүдэд заасан зүйлсийг тусгахгүй); 2. Гэрээний 13.6 болон 13.7-д заасны дагуу хийгдсэн Хуулийн өөрчлөлтөөс үүдэлтэй аливаа нэмэгдсэн болон/эсхүл хасагдсан дүн; 3. Захиалагчийн суутган барьсан мөнгөний дүн нь Гэрээний өгөгдөлд заасан суутган барих мөнгөн дүн (хэрэв байгаа бол)-ий дээд хязгаарт хүрэх хүртэл энэ хэсгийн (1),(2) болон (6) хэсэгт заасны дагуу дээр дурдсан нийт мөнгөн дүнг Гэрээний өгөгдөлд заасан суутган барих мөнгөн хөрөнгийг дээр дурдсан нийт мөнгөн дүнд хамруулж тооцоолон суутгах барьцаа хөрөнгийн дүн; 4. Гэрээний 14.2-т заасны дагуу урьдчилгаа төлбөр болон буцаан төлөлтөд нэмэгдэх болон/эсхүл хасагдах аливаа дүн; 5. Гэрээний 14.5-д заасны дагуу үндсэн техник хэрэгсэл болон бараанд нэмэгдэх болон/эсхүл хасагдах аливаа дүн; 6. Гэрээнд зааснаар болон бусад өөр байдлаар заасны дагуу, мөн гэрээний 3.5-д заасны дагуу бусад нэмэгдэх болон/эсхүл хасагдах аливаа дүн; 7. Гэрээний 13.4-д заасны дагуу нөөц хөрөнгөд нэмэгдэх дүн; 8. Гэрээний 14.9-д заасны дагуу суутган барих мөнгөн дүнг чөлөөлөхөд нэмэгдэх аливаа дүн; 9. Гэрээний 4.19-д заасны дагуу Захиалагчаас нийлүүлсэн үйлчилгээг Гүйцэтгэгч ашигласантайгаар холбоотой хасагдах аливаа дүн; Гэрээний 14.7-д заасны дагуу Гүйцэтгэгчийн өмнө нь төлсөн дүнгийн хасалт.
14.4 **Төлбөрийн хуваарь**		Хуваарьт өөрөөр заагаагүй бол Гэрээний үнийн төлбөрийг хэсэгчилсэн байдлаар хийх нөхцөлтэй Төлбөрийн хуваарийг Гэрээнд тусгасан бол: (a) Гэрээний 14.5-д заасны хүрээнд гэрээний 14.3-ын (1) хэсэгт заасныг хангах зорилгоор Төлбөрийн хуваарьт заасан хэсэгчлэн төлбөрийг гэрээний тооцоолсон үнэ гэж үзнэ; (b) Хэрвээ:

		(i) Ажлыг гүйцэтгэл дэх бодит явц, үр дүнд үндэслэн эдгээр хэсэгчлэн төлбөрийг тогтоогоогүй; ба (ii) ажлыг бодит явц нь энэхүү Төлбөрийн хуваарийг үндэслэсэн гүйцэтгэлээс зөрүүтэй байгааг Захиалагч олж тогтоосон бол, Захиалагчийн төлөөлөгч нь гэрээний хэсэгчилсэн төлбөрийн шинэчилсэн хувилбарыг зөвшөөрөх эсхүл шийдвэрлэхийн тулд гэрээний 3.5-д заасны дагуу үргэлжлүүлэн ажиллана (мөн гэрээний 3.5.3-д заасан зорилгоор дээр дурдсан (ii) хэсгийн дагуух зөрүүг Захиалагч олж тогтоосон огноо нь гэрээний 3.5.3-д заасан огноо байна). Энэхүү шинэчилсэн хэсэгчлэн төлөх төлбөрийн хэмжээг төлбөрийн хуваарьт ажлын явцтай харьцуулан шийдвэрлэнэ. Хэрвээ Гэрээнд төлбөрийн хуваарь тусгагдаагүй бол Гүйцэтгэгч нь 3 сар тутамд түүнд төлөгдөх ёстой гэж үзэж байгаа төлбөрийн албан бус тооцоогоо хүргүүлнэ. Эхний тооцоог Ажил эхлүүлэх огнооноос хойш 42 хоногийн дотор ирүүлнэ. Хянаж, шинэчилсэн тооцоог Ажлыг хүлээн авах гэрчилгээ гаргах хүртэл 3 сарын давтамжтайгаар хүргүүлнэ.
14.5 **Ажилд зориулсан үндсэн техник хэрэгсэл болон бараа материал**		Гэрээний өгөгдөлд ачуулсан болон/эсвэл хүргэх үед төлөх төлбөрт ямар ч үндсэн техник хэрэгсэл ба/эсхүл бараа материал байхгүй бол энэхүү хэсгийг хэрэглэхгүй. Гүйцэтгэгч нь гэрээний 14.3-ын (5) хэсэгт заасны дагуу дараах дүнг тусгана: - Байнгын ажлын бүрдэлд оруулахаар Ажлын талбай руу ачуулсан эсхүл хүргэгдсэн (нөхцөл байдлаас хамааруулан) үндсэн техник хэрэгсэл болон бараа материалд нэмэгдэх дүн; мөн - Гэрээний 14.3-ын (1) хэсэгт заасны дагуу тухайн үндсэн техник хэрэгсэл болон бараа материалын гэрээний үнэ нь үндсэн ажлын хэсгээр тусгагдсан учраас хасагдах дүн. Хэрвээ дараах нөхцөлүүд хангагдсан (мөн гэрээний 3.5.3-ыг хангах үүднээс эдгээр нөхцөлүүдийг хангах хугацааг 3.5.3-д заасан огноо байна) бол Захиалагч нь үндсэн техник хэрэгсэл болон бараа материалтай холбоотой нэмэгдэх дүн тус бүрийг тохиролцох эсхүл шийдвэрлэх зорилготойгоор гэрээний 3.5-ыг дагаж мөрдөнө: (a) Гүйцэтгэгч нь:

		(i) Захиалагчийн зүгээс үзлэг шалгалтыг хийх боломжийг ханган хангалттай бүртгэл, тайланг (мөн захиалгын хуудас, орлого зарлагын баримтууд, зардал болон үндсэн техник хэрэгсэл болон бараа материалуудын ашиглалтын бүртгэл зэргийг үүнд багтаана) бүрдүүлж хөтөлсөн байна. (ii) Үндсэн техник хэрэгсэл болон бараа материалууд нь Гэрээнд бүрэн нийцэж буй тухай нотлох баримтуудыг (үүнд гэрээний 7.4-д заагдсан туршилт/чанарын гэрчилгээ, болон/эсхүл гэрээний 4.9.2-т заасан тохирлын баримт бичгүүдийг оруулах боломжтой) Захиалагчид хүргүүлсэн байна; (iii) Үндсэн техник хэрэгсэл болон бараа материалыг олж авах ба Ажлын талбай руу ачуулах, эсхүл хүргүүлэх (нөхцөл байдлаас хамааруулан) Зардлын төлбөрийн нэхэмжлэлээ шаардлага хангасан нотлох баримтуудын хамт хүргүүлсэн байна; (b) Холбогдох үндсэн техник хэрэгсэл болон бараа материал нь: (i) тээвэрлэлт хийх үед төлбөр хийгдэхээр Гэрээний өгөгдөлд тусгасан зүйлс орсон байна; (ii) тэдгээр нь Гэрээний дагуу тухайн Улс руу ачигдсан, Ажлын талбайд хүрэх замдаа яваа; ба (iii) тэдгээр нь доор дурдсан зүйлсийн хамт Захиалагчид танилцуулагдсан ачилтын, эсхүл хүргэлтийн баримт бичигт заагдсан зүйл байсан: • Ачаа тээврийн болон даатгалын төлбөрийн баримтууд; • Захиалагчаас шаардсан аливаа бусад баримт бичгүүд; • Захиалагчийн зөвшөөрсөн маягтаар, мөн түүний зөвшөөрсөн хуулийн этгээдийн гаргасан, (гэхдээ, энэхүү зөвшөөрөл нь энэ заалтын дараах нөхцөлүүдэд заасан үүргээс Гүйцэтгэгчийг чөлөөлөхгүй) энэхүү хэсгийн дагуу төлбөл зохих дүнтэй тэнцүү, энд заасан мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдсэн банкны баталгааг, (дараачийн Төлбөрийн нэхэмжлэлийг хүргүүлэхээс өмнө) ирүүлэх талаар Гүйцэтгэгчээс бичгээр үйлдсэн хэлцэл. Мөн энэхүү баталгаа нь гэрээний 14.2.1-д заасан баталгааны маягттай ижил төстэй маягтаар гаргасан байж

		болох бөгөөд үндсэн техник хэрэгсэл болон бараа материалыг Ажлын талбай дээр зохих ёсоор байршуулж, эвдрэл, гэмтэл, алдагдлаас сэргийлэн, хадгалж хамгаалах хүртэл хүчин төгөлдөр байна; эсхүл (c) Холбогдох үндсэн техник хэрэгсэл болон бараа материал нь: (i) Ажлын талбайд хүргэгдэх үед төлбөр хийгдэхээр Гэрээний өгөгдөлд тусгагдсан; (ii) Ажлын талбайд хүргэгдэн зүй зохистой хадгалагдаж, аливаа эвдрэл, гэмтэл, элэгдэл хорогдол зэргээс хамгаалагдсан бөгөөд Гэрээний шаардлагыг хангасан хэмжээнд байгаа. Ингэж тохиролцсон, эсхүл шийдвэрлэсэн дүнд энэхүү хэсгийн дагуу шаардагдах нотолгоо болон баримт бичгийг, түүнчлэн үндсэн техник хэрэгсэл болон бараа материалын гэрээний үнийг харгалзан үзнэ. Хэрэв дээрх (b) хэсгийг хэрэглэх бол, Захиалагч дээрх (b)-ийн (iii)-н дагуу банкны баталгааг хүлээн авах хүртэл Захиалагч нь энэхүү хэсгийн дагуу аливаа төлбөрийг баталгаажуулах үүрэг хүлээхгүй. Захиалагчийн төлөх Явц дундын төлбөрийн нийлбэр дүн нь харилцан тохиролцсон эсхүл шийдвэрлэсэн үнийн дүнгийн наян (80%) хувьтай тэнцүү хэмжээтэй байна. Энэхүү баталгаажуулсан дүнг төлөх мөнгөн тэмдэгт нь гэрээний 14.3-ын (1)-р хэсгийн дагуу гэрээний үнэнд багтах төлбөр хийгдэх мөнгөн тэмдэгттэй ижил байна. Энэ үед Явц дундын төлбөрт зохих хасалтыг тусгах ёстой бөгөөд энэ хасалтын дүн нь холбогдох үндсэн техник хэрэгсэл болон бараа материалын нэмэгдэл дүнтэй тэнцүү бөгөөд ижил мөнгөн тэмдэгт ба харьцаатай байна.
14.6 **Явц дундын төлбөр**		Дараах нөхцөлүүд хангагдах хүртэл Гүйцэтгэгчид ямар ч мөнгөн дүнг төлөхгүй. Үүнд: (a) Захиалагч нь гэрээний 4.2.1-д заасны дагуу холбогдох маягтаар болон хуулийн этгээдээс гаргасан Гүйцэтгэлийн баталгааг хүлээн авсан; ба Гүйцэтгэгч нь гэрээний 4.3-д заасны дагуу Гүйцэтгэгчийн төлөөлөгчийг томилсон.
14.6.1		<u>Явц дундын төлбөрийн мэдэгдэл</u>

		Захиалагч нь Төлбөрийн нэхэмжлэл болон холбогдох баримт бичгийг хүлээн авснаас хойш 28 хоногт багтаан Гүйцэтгэгчид мэдэгдэл хүргүүлнэ. Энэхүү мэдэгдэлд: (a) Захиалагчийн зүгээс явц дундын төлбөрт бодитой гэж үзсэн төлбөрийн дүнг, болон (b) Гэрээ болон бусад байдлаар эсхүл гэрээний 3.5-д заасны дагуу төлөх шаардлагатай аливаа нэмэлт болон/эсхүл суутгал/хасалтыг тусгана. Мөн холбогдох дэлгэрэнгүй баримт бичгүүдийг (эдгээр нь баталгаажсан дүн болон Төлбөрийн нэхэмжлэл дэх холбогдох дүнгийн хоорондын аливаа ялгааг эсхүл зөрүүг тодорхойлох болон уг ялгаа эсхүл зөрүүний учир шалтгааныг тайлбарласан байх шаардлагатай) хавсаргана.
14.6.2		<u>Явц дундын төлбөрийг (түүний тодорхой дүнг) түр хойшлуулах</u> Захиалагч нь хэрвээ Явц дундын төлбөрийн тодорхой дүн нь (барьцааны болон бусад хасалт/суутгалуудын дараах) Гэрээний өгөгдөлд заасан Явц дундын төлбөрийн хамгийн бага дүнгээс бага бол тэрхүү дүнг түр хойшлуулах эрхтэй. Энэ тохиолдолд Захиалагч нь холбогдох мэдэгдлийг Гүйцэтгэгчид нэн даруй хүргүүлнэ. Явц дундын төлбөрийг аливаа бусад шалтгаанаар хойшлуулах эрхгүй боловч дараах тохиолдолд болно. Үүнд: (a) Хэрвээ Гүйцэтгэгчийн нийлүүлсэн аливаа зүйл эсхүл хийж гүйцэтгэсэн ажил нь Гэрээнд нийцэхгүй байгаа бол уг алдааг засаж залруулах эсхүл солих ажлыг бүрэн хийж дуусах хүртэл тухайн алдааг засах эсхүл солиход шаардагдах зардлыг хойшлуулах эрхтэй. (b) Хэрвээ Гүйцэтгэгч нь Гэрээнд заасан аливаа ажил, үйлчилгээ, үүргээ гүйцэтгээгүй эсхүл гүйцэтгэхгүй байгаа бол уг ажил үйлчилгээ эсхүл үүрэг хариуцлагатай холбогдох дүнг тухайн ажил үйлчилгээ, үүрэг хариуцлагыг биелүүлж дуусах хүртэл хойшлуулах эрхтэй. Энэ тохиолдолд Захиалагч нь гаргасан алдаа дутагдал болон хойшлуулсан төлбөрийн дүнгийн талаарх дэлгэрэнгүй нэмэлт мэдээллийг тусгасан Мэдэгдлийг Гүйцэтгэгчид шуурхай өгнө.

		(c) Хэрвээ Захиалагч нь Гүйцэтгэгчийн Төлбөрийн нэхэмжлэл болон бусад холбогдох баримт бичгүүдэд зөрүүтэй байдал эсхүл ноцтой алдааг илрүүлсэн бол энэхүү зөрүү эсхүл алдааг дараагийн Төлбөрийн нэхэмжлэлээр засаж залруулах хүртэл уг зөрүү эсхүл алдаа нь Төлбөрийн нэхэмжлэлийн дүнг зохих ёсоор судалж хянахад хир зэрэг саад болсон, эсхүл хор хохиролтой байсныг Явц дундын төлбөрийн дүнд харгалзан үзнэ. Захиалагч нь хойшлуулсан дүн тус бүрд зориулан, тухайн дүнг бодсон өөрийн тооцоо болон хойшлуулах болсон шалтгааныг Явц дундын төлбөрийн нэмэлт мэдээлэлдээ нарийвчлан тусгасан байх ёстой.
14.6.3		<u>Засварлах, өөрчлөлт хийх</u> Захиалагч нь өмнөх Явц дундын төлбөрт зохих ёсоор хийгдэх байсан аливаа залруулга, эсхүл өөрчлөлтийг аль ч Явц дундын төлбөрт хийнэ. Явц дундын төлбөр нь Захиалагчийн зүгээс аливаа Гүйцэтгэгчийн баримт бичиг эсхүл ажлыг (аливаа бүрдэл хэсгийг) хүлээн зөвшөөрсөн, баталгаажуулсан, зөвшөөрөл өгсөн эсхүл Зөвшөөрсөн мэдэгдлийн илэрхийлэл гэж үзэхгүй. Хэрэв Гүйцэтгэгчийн авах эрхтэй аливаа дүн нь Явц дундын төлбөрт тусгагдаагүй гэж Гүйцэтгэгч нь үзсэн тохиолдолд эдгээр дүнг (энэ хэсэгт зааснаар "тодорхойлсон дүнгүүд”) дараагийн Төлбөрийн нэхэмжлэлд тусгана. Захиалагч нь дараагийн Явц дундын төлбөрт хийгдэх шаардлагатай зохих засвар эсхүл өөрчлөлтийг хийнэ. Түүний дараа: (a) Гүйцэтгэгч дараагийн Явц дундын төлбөрт тусган оруулсан дүнд сэтгэл хангалуун бус байгаа; мөн (b) Тодорхойлсон дүнгүүд нь Захиалагчийн төлөөлөгч нь гэрээний 3.5-ын дагуу өөрийн үүргийг аль хэдийнээ биелүүлж байгаа асуудалд хамааралгүй тохиолдолд, Гүйцэтгэгч нь дээрхтэй холбоотой асуудлаар Захиалагчийн төлөөлөгчид Мэдэгдэл хүргүүлэх эрхтэй бөгөөд гэрээний 3.5-д заасан хэсгийн заалтууд үйлчилнэ (гэрээний 3.5.3-аар хэсгийн зорилгоор, Захиалагчийн төлөөлөгч энэхүү Мэдэгдлийг хүлээн авсан огноо нь гэрээний 3.5.3-д заасан огноо байна).

14.7 **Төлбөр**		Захиалагч нь дараах төлбөрүүдийг Гүйцэтгэгчид төлөх үүргийг хүлээнэ. Үүнд: (a) Гэрээний 14.2.2-т заасан хугацааны дотор төлөх урьдчилгаа төлбөр (b) Явц дундын төлбөрийг дараах зүйлсийн дагуу хийнэ. Үүнд: (i) гэрээний 14.6-д заасны дагуу Захиалагч Төлбөрийн нэхэмжлэл болон холбогдох баримт бичгүүдийг хүлээн авснаас хойш Гэрээний өгөгдөлд заагдсан (хэрвээ заагаагүй бол 56 хоногт багтаан) хугацаанд багтаан; эсхүл (ii) гэрээний 14.13-д заасны дагуу Захиалагч нь Хэсэгчлэн тохиролцсон эцсийн төлбөрийн нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш (эсхүл Хэсэгчлэн тохиролцсон эцсийн Төлбөрийн нэхэмжлэл гэж үзсэн эцсийн Төлбөрийн нэхэмжлэлийн төслийг Захиалагч хүлээн авснаас хойш 84 хоногийн дотор гэрээний 14.13-ын ii дахь хэсгийг хэрэглэх бол) Гэрээний өгөгдөлд заасан хугацаанд багтаан; мөн (c) Захиалагч дараах зүйлсийг хүлээн авснаас хойш Гэрээний өгөгдөлд заасан хугацааны дотор гэрээний 14.13-ын дагуу төлөх эцсийн төлбөр дагуу: (i) Эцсийн Төлбөрийн нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш (эсхүл Эцсийн төлбөрийг тодорхойлсон Төлбөрийн нэхэмжлэлийг Захиалагч олгосноос хойш 14 хоногийн хугацаа дууссаны дараа гэрээний 14.13-ын ii хэсгийг хэрэглэх бол); мөн (ii) Гэрээний 14.12-ын дагуу хаалтын баримт бичгийг хүлээн авснаас хойш (эсхүл Гүйцэтгэгч гаргасан гэж үзнэ). Төлбөл зохих төлбөрийн дүн тус бүрийг Гэрээнд заагдсан төлбөр хийгдэх улсын (тухайн мөнгөн тэмдэгтийн хувьд) бөгөөд Гүйцэтгэгчийн нэрлэсэн банкны дансанд мөнгөн тэмдэгт бүрээр шилжүүлнэ.
14.8 **Хойшлуулсан төлбөр**		Хэрвээ Гүйцэтгэгч нь гэрээний 14.7-д заасны дагуу төлбөрийг хүлээн аваагүй бол Гүйцэтгэгч нь тухайн хойшлуулсан хугацааны туршид, төлөгдөөгүй дүн дээр сар тутам нэмэгдэх санхүүжилтийн алданги нэхэмжилж авах эрхтэй. Гэрээний өгөгдөлд өөрөөр заагаагүй бол эдгээр төлбөрийн алдангийг доор дурдсан жилийн гурван хувийн (3%) хүүгээр тооцно:

		(a) Төлбөр төлөгдөх газрын бөгөөд төлбөрийн мөнгөн тэмдэгтээр тооцох бөгөөд үндсэн зээлдэгч нарт олгодог банкны богино хугацааны зээлийн дундаж хүү; эсхүл (b) тухайн газарт уг хүү тодорхой бус бол төлбөрийн мөнгөн тэмдэгт бүхий улсын зохих хүү, эсхүл (c) аль ч газарт ийм хүү байхгүй бол, төлбөрийн мөнгөн тэмдэгтийн улсын хуулийн дагуу тогтоосон зохих хүү дээр. Гүйцэтгэгч нь: (i) Захиалагчид албан ёсны мэдэгдэл эсхүл Төлбөрийн нэхэмжлэл (үүнд 20.2-т заасан аливаа шаардлагууд) ирүүлэхгүйгээр; мөн аливаа бусад эрх болон эрх зүйн эрхийг хөндөхгүйгээр хүсэлт гарган төлбөрийн алдангийг Захиалагчаар төлүүлэх эрхтэй.
14.9 **Суутган барих мөнгөн дүнг суллах**		Ажил хүлээн авсан гэрчилгээг: (a) нийт Ажилд зориулж олгосны дараа Гүйцэтгэгч нь Суутган барих мөнгөн дүнгийн эхний хагасыг Төлбөрийн нэхэмжлэлд тусгана; эсхүл (b) Ажлын бүрдэл хэсэгт зориулж олгосны дараа Гүйцэтгэгч нь Суутган барих мөнгөн дүнгийн эхний хагасын холбогдох хувийг Төлбөрийн нэхэмжлэлд тусгана. Доголдол мэдэгдэх хугацааны хүчинтэй байх сүүлчийн өдрийн дараа, Гүйцэтгэгч нь Суутган барих мөнгөн дүнгийн хоёрдох хагасыг Төлбөрийн нэхэмжлэлд тухайн сүүлчийн өдрийн дараа нэн даруй тусгана. Хэрвээ Ажил хүлээн авсан гэрчилгээ нь Ажлын бүрдэл хэсэгт олгогдсон (эсхүл олгогдсон гэж үзсэн тохиолдолд) бол Гүйцэтгэгч нь Суутган барих мөнгөн дүнгийн хоёрдох хагасын холбогдох хувийг тухайн Ажлын бүрдэл хэсэгт зориулсан ДМХ-ны дуусгавар болох хугацааны дараа нэн даруй Төлбөрийн нэхэмжлэлд тусгана. Аливаа ижил төстэй Төлбөрийн нэхэмжлэлийг Захиалагч нь хүлээн авснаас хойших дараачийн явц дундын төлбөрт Захиалагч нь Суутган барих мөнгөний холбогдох дүнг чөлөөлнө. Гэхдээ гэрээний 14.6-д заасны дагуу Суутган барих мөнгийг чөлөөлөх үед хэрвээ гэрээний 11 эсхүл 12-т заасны дагуу гүйцэтгэж дуусаагүй ямар нэгэн ажил үлдсэн бол энэхүү дутуу ажлыг гүйцэтгэж дуустал Захиалагч нь

		тэрхүү ажилд хамаарах тооцоолсон зардлын түр хойшлуулах эрхтэй. Ажлын бүрдэл хэсэг тус бүрд холбогдох хувь нь Гэрээний өгөгдөлд заасан Ажлын бүрдэл хэсгийн хувь хэмжээ байна. Хэрвээ Гэрээний өгөгдөлд Ажлын бүрдэл хэсгийн хувь хэмжээг тусгаагүй бол тухайн Ажлын бүрдэл хэсгийн хувьд уг Суутган барих мөнгөн дүнгийн аль ч хагасыг энэ хэсэгт заасны дагуу буцаан олгохгүй.
14.10 **Ажил дуусcаны дараах төлбөрийн нэхэмжлэл**		Гүйцэтгэгч нь Ажил дуусах огнооноос хойш 84 өдөрт багтаан гэрээний 14.3-д заасны дагуу ажил дуусcаны дараах төлбөрийн нэхэмжлэлийг холбогдох баримт бичгүүдийн хамтаар Захиалагчид хүргүүлэх бөгөөд үүндээ доор дурдсан мэдээллүүдийг заавал тусгасан байна. Үүнд: (a) Ажил дуусах огноо хүртэл Гэрээний дагуу гүйцэтгэсэн нийт ажлын дүн; (b) Ажил дуусах огноо хүртэл хугацаанд Гүйцэтгэгч авах эрхтэй гэж үзэж байгаа аливаа бусад дүнгүүд; (c) Гэрээнд болон бусад байдлаар заасны дагуу Ажил дуусах огнооноос хойш Гүйцэтгэгч авахаар тооцсон эсхүл авах эрх бүхий гэж үзэж буй аливаа бусад тооцоолсон дүнгүүд; Эдгээр тооцоолсон дүнгүүдийн тус бүрээр нь (дээр дурдсан (a) ба (b) хэсгүүдэд заасан) харуулах бөгөөд мөн дараах тооцоолсон дүнгүүдийг багтаана. Үүнд: (i) Гүйцэтгэгчээс гэрээний 20.2-т заасны дагуу мэдэгдлээр хүргүүлсэн шаардлагуудын дүнгүүд; (ii) гэрээний 21.4-д заасны дагуу МЗШЗ-д хүргүүлсэн аливаа асуудлуудтай холбоотой дүнгүүд; (iii) гэрээний 21.4-д дагуу хүргүүлсэн Татгалзсан мэдэгдэл тусгагдсан аливаа асуудлын дүн зэрэг орно. Дараа нь Захиалагч нь гэрээний 14.6-д заасны дагуу үргэлжлүүлэн ажиллана.
14.11 **Эцсийн төлбөр нэхэмжлэх**		Энэхүү хэсгийн дараах заалтуудын дагуу Гүйцэтгэгчээс хүргүүлэх аливаа Төлбөрийн нэхэмжлэлийг гэрээний 21.4 эсхүл 21.6-д холбоотой аливаа шалтгаанаар хойшлуулж/түдгэлзүүлж үл болно.

14.11.1		<u>Эцсийн төлбөрийн нэхэмжлэлийн төсөл</u> Гүйцэтгэлийн гэрчилгээг олгосноос хойш 56 өдөрт багтаан Гүйцэтгэгч нь Захиалагчид Эцсийн төлбөрийн нэхэмжлэлийн төслийг хүргүүлнэ. Энэхүү төлбөрийн нэхэмжлэлд: (a) гэрээний 14.3-д заасны дагуу өмнө хүргүүлсэн Төлбөрийн нэхэмжлэлтэй ижил маягтаар хийнэ; (b) нэг цаасан эх хувь, нэг цахим хуулбар болон Гэрээний өгөгдөлд заасны дагуу нэмэлт цаасан хуулбаруудын (хэрвээ байвал) хамтаар хүргүүлнэ; (c) холбогдох баримт бичгүүдийн хамт доорх зүйлсийг дэлгэрэнгүй харуулсан: (i) Гэрээний дагуу гүйцэтгэсэн нийт ажлын дүн; (ii) Гэрээнд болон бусад байдлаар заасны дагуу, Гүйцэтгэлийн гэрчилгээг олгосон өдрийг хүртэл Гүйцэтгэгч нь авах эрхтэй гэж үзэж буй аливаа бусад дүнгүүд; (iii) Гэрээнд болон бусад байдлаар заасны дагуу Гүйцэтгэгч нь Гүйцэтгэлийн гэрчилгээг олгосноос хойш авах ёстой эсхүл авахаар төлөвлөсөн гэж үзэж буй аливаа бусад тооцоолсон дүнгүүд бөгөөд үүнд гэрээний 14.10-ын (c) хэсгийн (i)-аас (iii)-д заасны дагуу тооцсон үнийн дүнгүүдийг багтаана. Эдгээр тооцсон дүнгүүдийг (дээр дурдсан (i) ба (ii)-д заасан) тус бүрээр нь харуулна. Дээрх (iii) дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд, хэрвээ Захиалагч нь Эцсийн төлбөрийн нэхэмжлэлийн төслийн аливаа хэсгийг хүлээн зөвшөөрөхгүй эсхүл баталгаажуулж/нотолж чадаагүй бол энэ тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид нэн даруй хүргүүлнэ. Дараа нь Гүйцэтгэгч Захиалагчаас бодитойгоор шаардсаны дагуу холбогдох нэмэлт мэдээллийг уг Мэдэгдэлд заасан хугацаанд хүргүүлэх ба Эцсийн төлбөрийн нэхэмжлэлийн төсөлд Талууд харилцан тохиролцсоноор өөрчлөлтүүдийг тусгана.
14.11.2		<u>Батлагдсан эцсийн төлбөрийн нэхэмжлэл</u> Хэрвээ гэрээний 14.11.1-ийн (iii) хэсэгт хамаарал бүхий дүн байхгүй бол Гүйцэтгэгч нь Эцсийн төлбөрийн нэхэмжлэлийг (эдгээр Гэрээний нөхцөлд “Эцсийн төлбөрийн нэхэмжлэл” гэх) харилцан зөвшилцсөнийхөө дагуу бэлтгэн боловсруулж Захиалагчид хүргүүлнэ.

		Гэхдээ хэрвээ: a) гэрээний 14.11.1-ийн (iii) хэсэгт хамаарал бүхий дүн байхгүй; болон/эсхүл b) Захиалагч болон Гүйцэтгэгч нь Эцсийн төлбөрийн нэхэмжлэлийн төсөлд тусгагдсан аливаа дүнгийн талаар харилцан зөвшилцөлд хүрэх боломжгүй гэдэг нь тогтоогдвол, Гүйцэтгэгч нь харилцан зөвшилцсөн дүнгүүд, тооцоолсон дүнгүүд, үл тохиролцсон дүнгүүд зэргийг тус бүрээр тусгасан төлбөрийн нэхэмжлэлийг (энэхүү Гэрээний нөхцөлд "Хэсэгчлэн тохиролцсон эцсийн төлбөрийн нэхэмжлэл" гэх) бэлтгэн Захиалагчид хүргүүлнэ.
14.12 **Төлбөрийн үүрэг дуусгавар болсон тухай мэдэгдэл**		Гүйцэтгэгч нь Эцсийн төлбөрийн нэхэмжлэлийг эсхүл Хэсэгчлэн тохиролцсон эцсийн төлбөрийн нэхэмжлэлийг (тухайн нөхцөл байдлаас хамаарч) хүргүүлэхдээ энэхүү Төлбөрийн нэхэмжлэлийн нийт дүн нь Гэрээний дагуу, эсхүл Гэрээтэй холбогдуулан Гүйцэтгэгчид төлбөл зохих бүх мөнгөний хувьд бүрэн бөгөөд эцсийн тооцоо гэдгийг нотолсон, хаалтын баримт бичгийг хүргүүлнэ. Төлбөрийн нэхэмжлэлийн нийт дүн нь МЗШЗ-ийн хүрээнд хэлэлцэж байгаа эсхүл гэрээний 21.6-д заасны дагуу арбитрын үйл ажиллагаа явагдаж буй аливаа Маргаантай холбоотойгоор төлөгдөж болох аливаа төлбөртэй хамааралтай ба/эсхүл энэ бичиг нь, Гүйцэтгэгч доорх зүйлсийг хүлээн авсны дараа хүчин төгөлдөр болохыг Хаалтын баримт бичигт заасан байж болно. Үүнд: (a) Эцсийн төлбөрийн нэхэмжлэлд заасан нийт мөнгөн дүнгийн бүрэн төлбөрийг; ба (b) Гүйцэтгэлийн баталгааг. Хэрвээ Гүйцэтгэгч нь хаалтын баримт бичгийг хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол уг мэдүүлгийг хүргүүлсэн гэж үзэх бөгөөд энэхүү хэсгийн (a) болон (b) хэсгүүдэд заасан нөхцөлүүд хангагдахад хүчин төгөлдөр болсон гэж үзнэ. Хэрвээ ямар ч Эцсийн төлбөрийн нэхэмжлэл Гүйцэтгэгчид хүргүүлээгүй ба энэхүү хэсгийн 14.13-ын хоёр дахь цогцолбор хэрэглэгдэхээр бол Гүйцэтгэгч нь уг 14.13-ын хоёр дахь цогцолбор болон Гүйцэтгэлийн баталгааны дагуу Эцсийн төлбөрийг хүлээн авсны дараа хаалтын баримт бичгийг Гүйцэтгэгч гаргасан гэж үзнэ.

		Энэхүү хэсгийн дагуух Хаалтын баримт бичиг нь МЗШЗ-ийн хүрээнд хэлэлцэж буй аливаа Маргаан болон гэрээний 21-д заасны дагуу явагдаж буй аливаа арбитрын үйл ажиллагаанд хамаарах болон холбоотой Талуудын аливаа хариуцлага болон эрхийг хөндөхгүй.
14.13 **Эцсийн төлбөр**		Эцсийн төлбөрийн нэхэмжлэл эсхүл Хэсэгчлэн тохиролцсон эцсийн төлбөрийн нэхэмжлэл (тухайн нөхцөл байдлаас хамаарч) болон гэрээний 14.12-т заасны дагуу Хаалтын баримт бичгийг хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор Захиалагч нь Гүйцэтгэгчид мэдэгдэл хүргүүлэх бөгөөд уг мэдэгдэлд дараах зүйлсийг тусгана. Үүнд: (a) Захиалагчийн зүгээс зохих ёсны гэж тооцож буй сүүлийн төлбөрийн дүн ба энэ дүнд Гэрээнд болон бусад байдлаар заасан эсхүл гэрээний 3.5-д заасан аливаа нэмэлт болон/эсхүл суутгал/хасалтыг тусгасан байна; (b) Захиалагчийн өмнө нь төлсөн нийт дүн болон Захиалагчийн эрх бүхий нийт дүн зэргийг баталгаажуулсны/нотолсны дараа, мөн Гүйцэтгэгчийн өмнө нь төлсөн болон/эсхүл Гүйцэтгэлийн баталгааны дагуу Захиалагч хүлээн авсан нийт дүнг (хэрвээ байвал) баталгаажуулсны/нотолсны дараа тус тус Захиалагчаас Гүйцэтгэгчид төлөх үлдэгдэл төлбөр (хэрвээ байвал) эсхүл тухайн нөхцөл байдлаас хамааран Гүйцэтгэгчээс Захиалагчид төлөх нийт үлдэгдэл төлбөрийн дүнг холбогдох дэлгэргүй мэдээллийн хамт; Хэрвээ Гүйцэтгэгч нь гэрээний 14.11.1-д заагдсан хугацаанд Эцсийн төлбөрийн нэхэмжлэлийн төслийг хүргүүлээгүй бол Захиалагч энэхүү үүргээ биелүүлэхийг шаардсан хүсэлтийг илгээнэ. Хэрвээ үүний дараа 28 өдөрт багтаан Гүйцэтгэгч нь Эцсийн төлбөрийн нэхэмжлэлийн төслийг хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол хугацааны хязгаар дуусан өдрөөс хойш 28 хоногийн дотор Захиалагч нь Гүйцэтгэгчид Эцсийн төлбөрийн талаар заасан мэдэгдлийг холбогдох дэлгэрэнгүй мэдээллийн хамт хүргүүлнэ. Хэрвээ: (i) Гүйцэтгэгч гэрээний 14.11.2-т заасны дагуу Хэсэгчлэн тохиролцсон эцсийн төлбөрийн нэхэмжлэлийг хүргүүлсэн бол; эсхүл (ii) Гүйцэтгэгч Хэсэгчлэн тохиролцсон эцсийн төлбөрийн нэхэмжлэлийг хүргүүлээгүй боловч

		Гүйцэтгэгчээс хүргүүлсэн Эцсийн төлбөрийн нэхэмжлэлийн төсөлд дурдсан төлбөрийг Захиалагч нь Хэсэгчлэн тохиролцсон эцсийн төлбөрийн нэхэмжлэл хэмээн адилтган үзсэн тохиолдолд Захиалагч нь Явц дундын төлбөрийг Гүйцэтгэгчид төлж барагдуулахаар гэрээний 14.6 болон 14.7-д заасны дагуу үргэлжлүүлэн ажиллана.
14.14 **Захиалагч төлбөрийн үүргээс чөлөөлөгдөх**		Гүйцэтгэгч нь тухайн асуудалтай холбогдолтой дүнг доорх төлбөрийн нэхэмжлэлүүдэд тусгайлан оруулахаас бусад тохиолдолд, Гэрээний дагуу эсхүл Гэрээтэй буюу Ажлыг гүйцэтгэхтэй холбогдолтой аливаа асуудал, эсхүл зүйлд Захиалагч нь Гүйцэтгэгчийн өмнө хариуцлага хүлээхгүй: (a) Эцсийн төлбөрийн нэхэмжлэл эсхүл Хэсэгчлэн тохиролцсон эцсийн төлбөрийн нэхэмжлэл; ба (b) гэрээний 14.10-д заасан мэдэгдэл (Ажил авсан тухай гэрчилгээг гаргасны дараа үүссэн аливаа асуудал эсхүл зүйлс хамаарахгүй). Гүйцэтгэгч Эцсийн төлбөрийг хүлээн авснаас хойш 56 хоногийн дотор Эцсийн төлбөрт багтсан аливаа төлбөрийн дүнтэй холбоотой гэрээний 20.2-т заасан шаардлага гаргаагүй эсхүл үйлдээгүй бол Гүйцэтгэгчийг уг Эцсийн төлбөрийг үнэн зөв гэж хүлээн зөвшөөрснөөр тооцно. Энэ тохиолдолд Захиалагч нь Гүйцэтгэгчид Гүйцэтгэлийн баталгааг буцаан өгөхөөс бусад хариуцлага үүрэхгүй. Гэхдээ энэхүү хэсгийн заалтууд нь Захиалагчийн хохирол нөхөн төлөх үүрэг хариуцлагыг хязгаарлахгүй бөгөөд Захиалагчийн үйлдсэн аливаа хууран мэхлэлт, залилан, хариуцлагагүй байдал, санаатай болон санамсаргүйгээр гаргасан алдаа, зөрчлөөс үүсэх хариуцлагаас чөлөөлөхгүй болно.
14.15 **Төлбөр төлөх мөнгөн тэмдэгт**		Гэрээний үнийг Гэрээний өгөгдөлд заасан мөнгөн тэмдэгтээр эсхүл мөнгөн тэмдэгтүүдээр төлнө. Хэрэв Гэрээний өгөгдөлд хоёр болон түүнээс их мөнгөн тэмдэгт заагдсан бол дараах хэсгүүдийн заалтуудыг баримтална. Үүнд: (a) Хэрэв Гэрээний хэлэлцээрт заасан Гэрээний үнийг зөвхөн Дотоод мөнгөн тэмдэгтээр, эсхүл зөвхөн Гадаад мөнгөн тэмдэгтээр илэрхийлсэн бол: (i) Талууд өөрөөр харилцан тохиролцоогүй бол төлбөр хийх Дотоодын болон Гадаадын мөнгөн тэмдэгтийн харьцаа/хувь хэмжээг

		эсхүл дүн болон төлбөрийг тооцоход ашиглах мөнгөн тэмдэгтийн тогтмол ханш зэрэг нь Гэрээний өгөгдөлд зааснаар байна; (ii) Гэрээний 13.4 болон 13.6-д заасны дагуу хийгдэх төлбөр ба суутгал/хасалтыг холбогдох мөнгөн тэмдэгтээр ба харьцаа/хувь хэмжээгээр хийнэ. (iii) Гэрээний 14.3-ын (1) - (4) хэсэгт заасны дагуу хийгдэх бусад төлбөр болон хасалт/суутгал нь дээрх (i) хэсэгт заасан мөнгөн тэмдэгт ба харьцаа/хувь хэмжээгээр хийнэ. (b) Гэрээний 13.2 эсхүл 13.3-ын дагуу Талууд тохируулгыг зөвшилцсөн эсхүл шийдвэрлэсэн тохиолдол тус бүрд холбогдох мөнгөн тэмдэгт тус бүрээр төлөх дүнг зааж тусгана. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд энэхүү хэсгийн дээр дурдсан (a)(i) хэсэгт заасан төрөл бүрийн ажлын зардлын бодит эсхүл хүлээгдэж буй мөнгөн тэмдэгтийн харьцаа болон төрөл бүрийн мөнгөн тэмдэгтийн харьцаа/хувь хэмжээг тодорхойлсон заавар/жишгийг тогтоосон байх шаардлагатай. (c) Алдангийг Гэрээний өгөгдөлд заасан мөнгөн тэмдэгт болон хувь хэмжээгээр төлнө. (d) Чанарын үзүүлэлтэд нийцээгүйн торгуулийг Гүйцэтгэлийн баталгааны хуваарьт заасан мөнгөн тэмдэгт болон хувь хэмжээгээр төлнө. (e) Гүйцэтгэгчийн Захиалагчид төлөх бусад төлбөрийг Захиалагчийн зарцуулсан мөнгөн тэмдэгтээр эсхүл Талуудын харилцан тохиролцсон мөнгөн тэмдэгтээр хийнэ. (f) Хэрвээ тухайн мөнгөн тэмдэгтээр Гүйцэтгэгчээс Захиалагчид төлбөл зохих аливаа төлбөрийн хэмжээ нь уг мөнгөн тэмдэгтээр Захиалагчаас Гүйцэтгэгчид төлбөл зохих нийт дүнгээс их гарсан бол Захиалагч нь энэхүү дүнгийн зөрүүг өөр мөнгөн тэмдэгтээр Гүйцэтгэгчид төлбөл зохих дүнгээс буцаан авч болно. (g) Хэрэв валютын ханшийг Гэрээний өгөгдөлд заагаагүй бол Суурь огнооны өдөр тухайн улсын Төв банкнаас зарласан албан ёсны валютын ханшаар тооцно.
15. ЗАХИАЛАГЧИЙН САНААЧИЛГААР ГЭРЭЭГ ЦУЦЛАХ		
15.1		Хэрэв Гүйцэтгэгч нь Гэрээгээр хүлээх аливаа үүргээ биелүүлээгүй бол Захиалагч нь Гүйцэтгэгчийг заасан хугацаанд үүргийн зөрчлийг арилгахыг шаардсан

Үүргийн зөрчил арилгах тухай мэдэгдэл		тухай Мэдэгдлийг хүргүүлнэ. (Энэхүү нөхцөлд “Үүргийн зөрчлийг арилгах тухай мэдэгдэл” гэх) Үүргийн зөрчил арилгах тухай мэдэгдэлд: a) Гүйцэтгэгчийн үүргийн зөрчлийг тайлбарлах; b) Гүйцэтгэгчийн биелүүлэх үүрэгтэй холбогдох Гэрээнд заасан зүйл, заалт, хэсгийг дурдах; c) Гүйцэтгэгчийн үүргийн зөрчлийг арилгах хугацааг тодорхойлох бөгөөд энэхүү хугацаа нь үүргийн зөрчлийн шинж байдал болон/эсхүл тухайн алдааг засаж залруулахад авах шаардлагатай арга хэмжээнүүдийг харгалзан үндэслэл бүхий боломжит хугацаа тогтооно. Гүйцэтгэгч нь Үүргийн зөрчил арилгах тухай Мэдэгдлийг хүлээн авснаас хойш Захиалагчид нэн даруй хариу Мэдэгдэл хүргүүлнэ. Гүйцэтгэгч нь уг Мэдэгдэлдээ тухайн зөрчлийг арилгахад авах шаардлагатай арга хэмжээ болон Захиалагчийн хүргүүлсэн Мэдэгдэлд дурдсан хугацааны дотор аль зөрчлийг арилгах талаар тусгасан байна. Үүргийн зөрчил арилгах тухай Мэдэгдэлд заасан хугацаа нь Ажил дуусах хугацааг хойшлуулахад үл хамаарна.
15.2 **Гүйцэтгэгч буруугаас үүдэн гэрээг цуцлах**		Энэ зүйлд заасан Гэрээг цуцлах зохицуулалт нь Гэрээнд эсхүл холбогдох баримт бичигт заасан Захиалагчийн эдлэх бусад эрхийг үл хөндөнө.
15.2.1		<u>Мэдэгдэл</u> Захиалагч нь өөрийн санаачилгаар Гэрээг цуцлах эсхүл энэ хэсгийн (f), (g) болон (h) хэсэгт заасан нөхцөл бий болсон тохиолдолд Гүйцэтгэгчид гэрээг цуцлах хүсэл зоригоо илэрхийлсэн Мэдэгдэл (Мэдэгдлийг энэ зүйлийн 15.2.1-д заасны дагуу хүргүүлсэн болохыг дурдана)-ийг хүргүүлэх эрхтэй. Гүйцэтгэгч нь: (a) Дараах зүйлүүдийг биелүүлээгүй тохиолдолд: i. Үүргийн зөрчил арилгах тухай мэдэгдэл; ii. Гэрээний 3.5-д заасан заавал биелүүлэх шинжтэй эвлэрэл эсхүл эцсийн болон заавал биелүүлэх шийдвэр iii. Гэрээний 21.4-д заасан МЗШЗ-ын шийдвэр (заавал биелүүлэх шинжтэй

		эсхүл заавал биелүүлэх шинжтэй болон эцсийн); Мөн эдгээр зөрчил нь Гэрээнд заасны дагуу Гүйцэтгэгчийн үүргийн материаллаг зөрчил гэж тогтоогдсон тохиолдолд; (b) Гэрээнд заасан Ажлыг хаясан/орхисон эсхүл бусад байдлаар үүргээ биелүүлэхгүй байх хүсэл зоригоо илт илэрхийлсэн; (c) Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээний 8-д заасны дагуу Ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд эсхүл Гэрээний өгөгдөлд заасан Алданги байгаа тохиолдолд Гүйцэтгэгчийн гэрээний 8.2-т заасныг биелүүлээгүй зөрчил нь Захиалагч тухайн дээд хэмжээг давсан Алдангийг хойшлуулах эрхтэй болно. (d) Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээний 7.5-д заасан Захиалагчаас ирүүлсэн Татгалзсан тухай Мэдэгдлийг биелүүлээгүй эсхүл 7.6-д заасан Захиалагчийн өгсөн зааварчилгааг хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор биелүүлээгүй тохиолдолд; (e) Гэрээний 4.2-т заасныг биелүүлээгүй; (f) Гэрээний 4.4-ийг зөрчиж Ажлыг бүхэлд нь буюу зарим хэсгийг гүйцэтгүүлэхээр туслан гүйцэтгэх гэрээ байгуулсан эсхүл 1.7-д заасны дагуу шаардлагатай тохиролцоо хийлгээгүйгээр Гэрээний эрхийг шилжүүлсэн; (g) дампуурсан эсхүл төлбөрийн чадваргүй болсон бол; татан буугдсан, зохион байгуулалт өөрчлөгдсөн, үйл ажиллагааг нь зогсоосон, үйл ажиллагааг цуцалсан бол; хуулийн дагуу төлөөлөгч, менежер эсхүл итгэмжлэгч зэргийг томилох этгээд болсон бол; Гүйцэтгэгчийн зээлдүүлэгч нартай төлбөрийн чадварын талаар хэлэлцээрт орсон эсхүл гэрээ байгуулсан бол; эсхүл холбогдох Хууль тогтоомжийн дагуу өмнө дурдсантай ижил төстэй үйлчлэл бүхий аливаа үйлдэл хийгдсэн, эсхүл аливаа үйл явдал болсон бол; Эсхүл Гүйцэтгэгч нь түншлэлийн хэлбэртэй бол: i. Эдгээр асуудлын аль нэг нь хамтарсан компанийн гишүүнд хамаарна; мөн ii. Тухайн гишүүдийн Гэрээний дагуу хүлээсэн үүрэг нь Гэрээнд нийцсэн байдлаар

		биелэгдэнэ гэдгийг бусад гишүүд нь гэрээний 1.13-ын (a) хэсэгт заасны дагуу Захиалагчид шуурхай нотлоогүй; эсхүл Ажил эсхүл Гэрээний бүхий л цаг үед авлига авсан, залилан мэхэлсэн, хуйвалдаан зохион байгуулсан, бусдыг албадлагын үйл ажиллагаа явуулсан нь үндэслэл бүхий нотлох баримтаар тогтоогдсон.
15.2.2		<u>Гэрээг цуцлах</u> Гүйцэтгэгч гэрээний 15.2.1-д заасан Мэдэгдлийг хүлээн авснаас 14 хоногийн дотор уг Мэдэгдэлд заасан зөрчлийг засаж залруулаагүй бол Захиалагч нь Гүйцэтгэгчид хоёр дахь Мэдэгдлийг хүргүүлснээр Гэрээг цуцалж болно. Гэрээг цуцлах огноо нь Гүйцэтгэгч хоёр дахь Мэдэгдлийг хүлээн авсан огноо байна. Харин 15.2.1-ийн (f), (g) эсхүл (h) хэсэгт заасан нөхцөл байдал бий болсон тохиолдолд Захиалагч нь Гүйцэтгэгчид 15.2.1-д заасны дагуу Мэдэгдэл хүргүүлснээр Гэрээг цуцалж болно. Гэрээг цуцлах огноо нь Гүйцэтгэгч хоёр дахь Мэдэгдлийг хүлээн авсан огноо байна.
15.2.3		<u>Гэрээг цуцалснаас хойш</u> Гэрээний 15.2.2-т заасны дагуу Гэрээг цуцалснаас хойш Гүйцэтгэгч нь: (a) Энэ зүйлд заасны дагуу Захиалагчийн хүргүүлсэн Мэдэгдэлд заасан аливаа зааварчилгааг яаралтай дагаж мөрдөх: i. Аливаа Туслан гүйцэтгэгчийн даалгавартай холбоотой; мөн ii. Хүний амь нас, эд хөрөнгийг хамгаалах, Ажлын аюулгүй байдлыг хангахтай холбоотой; (b) Захиалагчид дараах зүйлсийг хүргүүлнэ: i. Захиалагчийн шаардсан аливаа бараа; ii. Гүйцэтгэгчийн бүхий л баримт бичиг; мөн iii. Гүйцэтгэгчийн боловсруулсан эсхүл түүнд зориулан боловсруулсан бүхий л зураг төслийн баримт бичиг; мөн (c) Ажлын талбайг орхино. Мөн Гүйцэтгэгч Ажлын талбайг орхиогүй тохиолдолд Захиалагч түүнийг албадан явуулах эрхтэй.

15.2.4		<u>Ажлыг гүйцэтгэж дуусах</u> Энэ зүйлд заасны дагуу Гэрээг цуцалсны дараа Захиалагч нь Ажлыг гүйцэтгэж эсхүл бусад этгээдээр гүйцэтгүүлж болно. Захиалагч болон/эсхүл бусад этгээд нь Ажлыг гүйцэтгэж дуусгах зорилгоор Гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс боловсруулсан эсхүл Гүйцэтгэгчийн боловсруулсан баримт бичиг, бусад зураг төслийн баримт бичиг, бараа Г хэрэглэж болно. Ажлыг гүйцэтгэж дууссаны дараа Захиалагч нь Гүйцэтгэгчид дахин өөр Мэдэгдэл хүргүүлнэ. Уг мэдэгдэлд Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж, Түр ажлыг Ажлын талбайд эсхүл ойролцоо хүлээлгэн өгөх тухай тусгана. Гүйцэтгэгч нь эрсдэл, зардлыг Гүйцэтгэгч өөрөө хариуцан нэн даруй зайлуулах ажлыг зохион байгуулна. Гэхдээ, хэрэв энэ хугацаанд Захиалагчид төлбөл зохих төлбөрийг Гүйцэтгэгч төлөөгүй байвал, Захиалагч энэхүү төлбөрөө нөхөж авах зорилгоор, эдгээр зүйлүүдийг (мөрдөж буй хууль, тогтоомжийн зөвшөөрөх хэмжээнд) зарж, борлуулж болно. Энэхүү орлогоос ямар нэгэн зөрүү гарвал түүнийг Гүйцэтгэгчид төлөх ёстой.
15.3 **Гүйцэтгэгчийн буруугаас үүдэн гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэсэн ажлын төлбөрийг тооцох**		Гэрээний 15.2-ын дагуу Гэрээг цуцалсны дараа Захиалагчийн төлөөлөгч Үндсэн ажил, бараа болон Гүйцэтгэгчийн баримт бичгийн үнэ өртгийг, мөн түүнчлэн Гэрээний дагуу гүйцэтгэсэн ажилд нь Гүйцэтгэгчид төлбөл зохих бусад төлбөрийг тохиролцох, эсхүл шийдвэрлэхээр гэрээний 3.5-ын дагуу үргэлжлүүлэн ажиллана (Гэрээний 3.5.3-д заасан зорилгоор, гэрээ цуцлагдсан огноо нь 3.5.3-д заасан огноо байна). Ажлын өртгийг ийнхүү тодорхойлохдоо, гэрээний 14.13-ын (a) ба (b) хэсэгт тусгасан асуудлуудад хамааралтай аливаа нэмэгдэл ба/эсхүл суутгалыг, мөн зөрүүг (хэрэв байгаа бол) оруулж өгнө. Үндсэн ажил, үндсэн техник хэрэгсэл болон бараа, Гүйцэтгэгчийн баримт бичгийн үнэ өртгийг, Гэрээний шаардлагад нийцэхгүй байгаа тэр хэмжээгээр нь энэхүү ажлын өртөгт оруулахгүй.
15.4		Захиалагч нь энэхүү зүйлийн доор заалтуудад тодорхойлсон бүх зардал, алдагдал ба хохирлыг (хэрэв байгаа бол) тогтоох хүртэл гэрээний 15.3-ын

Гүйцэтгэгчийн буруугаас үүдэн гэрээг цуцалсан тохиолдолд төлөх төлбөр		дагуу тохиролцсон, эсхүл шийдвэрлэсэн мөнгөн дүнгийн Гүйцэтгэгчид хийгдэх төлбөрийг төлөхгүй барьж болно. Гэрээний 15.2-ын дагуу Гэрээ цуцлагдсаны дараа Захиалагч нь, доорх зүйлсийг гэрээний 20.2-ын дагуу Гүйцэтгэгчээр төлүүлэх эрхтэй: (a) Гэрээний 15.3-д заасны дагуу Гүйцэтгэгчид төлбөл зохих аливаа дүнг зөвшөөрсний дараагаар, Ажлыг гүйцэтгэх нэмэлт зардал болон Захиалагчаас зохих байдлаар гаргасан бусад (гэрээний 11.11-ийн дагуу Талбайг цэвэрлэх ба нөхөн сэргээхэд зарцуулсан зардлыг оролцуулан) зардлыг; (b) Ажлыг дуусгахдаа Захиалагчийн хүлээсэн аливаа алдагдал ба хохирлыг; болон Хэрэв Ажлыг, эсхүл Ажлын бүрдэл хэсгийг гэрээний 10.1-ийн дагуу хүлээн аваагүй, мөн гэрээний 15.2-ын дагуух гэрээ цуцлагдсан огноо нь Ажил, эсхүл Ажлын бүрдэл хэсгийн Ажил дуусах хугацаанаас хойш тохиосон бол, Алдангийг төлүүлнэ. Энэхүү Алданги нь дээрх хоёр огнооны хооронд өнгөрсөн өдөр бүр төлөгдөнө.
15.5 **Захиалагчийн санаачилгаар гэрээг цуцлах**		Захиалагч нь гэрээг цуцлах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлснээр (үүнийг гэрээний 15.5-д заасны дагуу өгч байгааг Мэдэгдэлд заасан байх ёстой) өөрийн санаачилгаар хэдийд ч Гэрээг цуцлах эрхтэй байна. Энэхүү зүйлийн дагуу гэрээг цуцлах Мэдэгдэл өгсний дараа Захиалагч нь нэн даруй: (a) Гүйцэтгэгч төлбөрөө авсан, эсхүл төлбөр хийх ёстойгоос бусад тохиолдолд Гүйцэтгэгчид буцаагдах ёстой Гүйцэтгэгчийн баримт бичгийг цаашид ашиглах эрхгүй болно; (b) Хэрэв гэрээний 4.6 хэрэглэгдэх бол, Гүйцэтгэгчийн аливаа тоног төхөөрөмж, Түр ажил, нэвтрэх хэрэгслүүд ба/эсхүл Гүйцэтгэгчийн бусад хэрэгслүүд, эсхүл үйлчилгээг үргэлжлүүлэх ашиглах (хэрэв байгаа бол) эрхгүй болно; ба (c) Гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэгчид буцаах арга хэмжээг авна. Энэхүү зүйлийн дагуу гэрээг цуцалсан нь Гүйцэтгэгч энэхүү Мэдэгдлийг авсан огнооны, эсхүл Захиалагч нь Гүйцэтгэлийн баталгааг буцаасан огнооны аль сүүлд тохиосноос нь хойш 28 хоногийн дараагаас

		хүчин төгөлдөр болно. Гүйцэтгэгч нь гэрээний 15.6-д заасны дагуу төлөгдвөл зохих төлбөрөө аваагүй болон авах хүртэл Захиалагч нь Ажлыг (аль нэг хэсгийг) өөрөө гүйцэтгэхгүй, эсхүл бусад этгээдээр гүйцэтгүүлэхгүй. Гэрээ ийнхүү цуцлагдсаны дараа Гүйцэтгэгч нь гэрээний 16.3-ын дагуу үргэлжлүүлэн ажиллана.
15.6 **Захиалагчийн санаачилгаар гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэсэн ажлын төлбөрийг тооцох**		Гэрээний 15.5-ын дагуу гэрээ цуцлагдсаны дараа Гүйцэтгэгч нь доорх зүйлстэй холбогдолтой нарийвчилсан нэмэлт мэдээллийг (Захиалагчаас үндэслэлтэйгээр шаардсаны дагуу), аль болох боломжийн хурдан хугацаанд танилцуулна: (a) Дараах асуудлуудыг хамруулсан, гүйцэтгэсэн ажлын үнэ, өртөг нь: 1. Гэрээний 18.5-ын (a) ба (e) хэсэгт заасан асуудлуудыг, ба 2. Гэрээний 14.13-ын (a) ба (b) хэсэгт заасан асуудлуудад хамааралтай аливаа нэмэгдэл ба/эсхүл суутгалыг, мөн зөрүүг (хэрэв байгаа бол); ба (b) Гэрээ ийнхүү цуцлагдсанаас шалтгаалан Гүйцэтгэгчид учирсан аливаа олох ёстой байсан орлого, эсхүл бусад алдагдал ба хохирлын дүн байна. Дараа нь Захиалагчийн төлөөлөгч дээрх (a) ба (b) хэсэгт тодорхойлсон асуудлуудыг тохиролцох, эсхүл шийдвэрлэхээр гэрээний 3.5-ын дагуу үргэлжлүүлэн ажиллана (гэрээний 3.7.3-ын зорилгоор, энэхүү зүйлийн дагуу танилцуулсан Гүйцэтгэгчийн нарийвчилсан нэмэлт мэдээллийг Захиалагчийн төлөөлөгч хүлээн авсан огноо нь 3.7.3-ын дагуух эвлэрлийн сүүлийн хугацааны эхлэх огноо болно). Захиалагч нь тохиролцсон, эсхүл шийдвэрлэсэн мөнгөн дүнгийг, Гүйцэтгэгчээс Төлбөрийн нэхэмжлэл ирүүлэхийг шаардахгүйгээр төлнө.
15.7 **Захиалагчийн санаачилгаар гэрээг цуцалсны дараах төлөх төлбөр**		Захиалагч нь гэрээний 15.6-ын дагуу эвлэрсэн эсхүл шийдвэрлэсэн мөнгөн дүнг, тухайн зүйлийн дагуу Гүйцэтгэгч танилцуулсан материалыг Захиалагч хүлээн авснаас хойш 112 хоногийн дотор Гүйцэтгэгчид төлнө.
16. ГҮЙЦЭТГЭГЧ ГЭРЭЭГ ЦУЦЛАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ		

16.1 **Гүйцэтгэгч ажлыг түр зогсоох**		Хэрэв: (a) Захиалагч нь гэрээний 2.4-ийн дагуу үндэслэл бүхий нотлох баримтаар хангаагүй; (b) Захиалагч гэрээний 14.7-г дагаж биелүүлээгүй; эсхүл (c) Захиалагч нь доорх зүйлсийг дагаж биелүүлээгүй бол: 1. Гэрээний 3.5-ын дагуух заавал биелүүлэх эвлэрлийг, эсхүл эцсийн бөгөөд заавал биелүүлэх шийдвэрийг; эсхүл 2. Гэрээний 21.4-ийн дагуух МЗШЗ-ийн шийдвэрийг (заавал биелүүлэх, эсхүл эцсийн бөгөөд заавал биелүүлэх аль нь ч байсан) ба энэхүү алдаа, дутагдал нь Захиалагчийн Гэрээний дагуу хүлээсэн үүргийн томоохон хэмжээний зөрчлийг бүрдүүлж байгаа бол, Гүйцэтгэгч нь, Захиалагчид Мэдэгдэл (үүнийг энэхүү гэрээний 16.1-ийн дагуу өгч байгааг Мэдэгдэлд заасан байх ёстой) өгснөөс хойш 21-ээс доошгүй хоногт, Захиалагч тухайн зөрчлийг арилгаагүй болон арилгах хүртэл ажлыг түр зогсоож (эсхүл ажлын эрчийг сааруулж) болно. Энэ үйлдэл нь гэрээний 14.8-ын дагуу санхүүжилтийн торгуулийг нэхэмжлэх болон гэрээний 16.2-ын дагуу гэрээг цуцлах зэрэг Гүйцэтгэгчийн эрхэд саад учруулах ёсгүй. Хэрэв Гүйцэтгэгч гэрээний 16.2-т заасны дагуу гэрээг цуцлах Мэдэгдэлд өгөхөөс өмнө Захиалагч дээрх Мэдэгдэлд заасан зөрчлийг арилгасан бол Гүйцэтгэгч нь аль болох боломжийн түргэн хугацааны дотор ажлаа дахин гүйцэтгэж эхэлнэ. Хэрэв Гүйцэтгэгч нь энэхүү зүйлийн дагуу ажлаа түр зогсоосноос (эсхүл ажлын эрчийг сааруулснаас) болж хугацаа хоцорсон ба/эсхүл Зардал гаргасан бол Гүйцэтгэгч нь гэрээний 20.2-ын дагуу хугацаа сунгах ба/эсхүл Ашиг шингэсэн үнийг төлүүлэх эрхтэй.
16.2 **Гүйцэтгэгч гэрээ цуцлах**		Энэхүү зүйлийн дагуу гэрээг цуцлах нь Гүйцэтгэгчийн гэрээний дагуу, эсхүл өөр байдлаар эдлэх бусад эрхийг хөндөхгүй.
16.2.1		<u>Мэдэгдэл</u>

		Хэрэв дараах нөхцөл байдал үүссэн бол Гүйцэтгэгч нь гэрээг цуцлах тухай хүсэл зоригоо илэрхийлсэн (энэхүү гэрээний 16.2.1-ийн дагуу өгч байгааг түүнд тусгасан байх ёстой) Мэдэгдлийг, эсхүл доор дурдсан (f)-ийн (ii)-р, (g), (h) эсхүл (i) хэсгүүдтэй холбогдолтой тохиолдолд, гэрээ цуцлах Мэдэгдлийг Захиалагчид өгөх эрхтэй: (a) Гүйцэтгэгч нь гэрээний 2.4-ийг дагаж мөрдөөгүйтэй холбогдуулан, 16.1-ийн дагуу Мэдэгдэл өгснөөс хойш 42 хоногийн дотор зохих үндэслэл бүхий нотлох баримтыг хүлээн аваагүй; (b) Гүйцэтгэгч нь гэрээний 14.7-ийн дагуу төлөгдвөл зохих төлбөрийг 14.7-д заасан хугацааг дууссанаас хойш 42 хоногийн дотор хүлээн аваагүй; (c) Захиалагч нь доорх зүйлсийг дагаж биелүүлээгүй: 1. Гэрээний 3.5-ын дагуух заавал биелүүлэх эвлэрлийг, эсхүл эцсийн бөгөөд заавал биелүүлэх шийдвэрийг; эсхүл 2. Гэрээний 21.4-ийн дагуух МЗШЗ-ийн шийдвэрийг (заавал биелүүлэх, эсхүл эцсийн бөгөөд заавал биелүүлэх аль нь ч байсан) ба энэхүү зөрчил нь Захиалагчийн Гэрээний дагуу хүлээсэн үүргийн материалаг зөрчлийг бүрдүүлж байгаа бол; (d) Захиалагч нь гэрээгээр хүлээсэн үүргийнхээ ихэнхийг биелүүлээгүй ба энэхүү зөрчил нь Захиалагчийн гэрээний дагуу хүлээсэн үүргийн материаллаг зөрчлийг бүрдүүлж байгаа; (e) Талууд Гэрээний хэлэлцээрт гарын үсэг зурснаас хойш 84 хоногийн дотор, гэрээний 8.1-ийн дагуух Ажил эхлүүлэх огнооны талаарх Мэдэгдлийг Гүйцэтгэгч хүлээн аваагүй; (f) Захиалагч нь: 1. Гэрээний 1.6-г дагаж мөрдөөгүй; эсхүл 2. Гэрээний 1.7-ийн дагуух шаардлагатай тохиролцоогүйгээр Гэрээг шилжүүлсэн; (g) Гэрээний 8.12-ын (b) хэсэгт тодорхойлсончлон Түр зогсолт сунжирч байгаа нь Ажилд бүхэлд нь нөлөөлсөн; (h) Захиалагч нь дампуурсан, эсхүл төлбөрийн чадваргүй болсон; татан буугдах, захиран зарцуулагдах, дахин зохион байгуулагдах, устгалд орох, эсхүл тараагдахад хүрч байгаа; татан буулгах комисс, хүлээн авагч, захиран зарцуулагч, менежер, эсхүл итгэмжлэгчийг

		томилох этгээд болж байгаа; өөрийнхөө зээлдүүлэгчидтэй зохион байгуулалтад, эсхүл тохиролцоонд орсон; эсхүл мөрдөгдөж буй Хууль, тогтоомжийн дагуу хийсэн ямар нэгэн үйлдэл буюу тохиосон аливаа үйл явдал нь дээр дурдсан үйлдлүүдийн аль нэгэнтэй адил, эсхүл төсөөтэй үр нөлөөтэй байсан; эсхүл Захиалагч нь Ажилтай, эсхүл Гэрээтэй холбоотойгоор ямар ч үед, авлига, залилан, үгсэн хуйвалдсан, эсхүл хүч хэрэглэсэн үйл явдалд оролцсон нь зохиох нотлох баримтын үндсэн дээр илэрхий болсон.
16.2.2		<u>Гэрээг цуцлах</u> Хэрэв Захиалагч нь Мэдэгдэл хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор, гэрээний 16.2.1-ийн дагуу өгсөн Мэдэгдэлд заасан асуудлуудыг засаж залруулаагүй бол, Гүйцэтгэгч нь хоёр дахь Мэдэгдлийг Захиалагчид өгөн, гэрээг нэн даруй цуцалж болно. Гэрээ цуцлагдах огноо нь Захиалагч энэхүү хоёр дахь Мэдэгдлийг хүлээн авсан огноо байна. Гэхдээ, гэрээний 16.2.1-ийн (f)-ийн (ii)-р, (g), (h) эсхүл (i) хэсэгт дурдсан нөхцөл байдал бий болсон тохиолдолд, Гүйцэтгэгч нь гэрээний 16.2.1-ийн дагуу Мэдэгдэл өгснөөр Гэрээг шууд цуцалж болох ба Гэрээ цуцлагдах огноо нь Захиалагч энэхүү Мэдэгдлийг хүлээн авсан огноо байна. Хэрэв Гүйцэтгэгч нь дээр дурдсан 14 хоногийн үеэр хугацаа хоцорсон ба/эсхүл Зардал гаргасан бол, Гүйцэтгэгч нь гэрээний 20.2-ын дагуу нэмэлт хугацаа тогтоолгох ба/эсхүл ийм Ашиг шингэсэн үнийг төлүүлэх эрхтэй.
16.3 **Гэрээ цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгчийн хүлээх үүрэг**		Гэрээний 15.5, 16.2, эсхүл 18.5-ын дагуу гэрээ цуцлагдсаны дараа, Гүйцэтгэгч нь доорх арга хэмжээг яаралтай авна. Үүнд: (a) Хүний амь нас, өмч хөрөнгө, Ажлын аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор Захиалагчийн зааварчилсан ажлаас бусад цаашдын бүх ажлаа зогсооно. Хэрэв Гүйцэтгэгч нь энэхүү зааварчилсан ажлыг гүйцэтгэснээс шалтгаалан Зардал гаргасан бол, Гүйцэтгэгч нь гэрээний 20.2-ын дагуу Ашиг шингэсэн үнийг төлүүлэх эрхтэй; (b) Гүйцэтгэгчийн баримт бичиг, үндсэн техник хэрэгсэл, барааны болон Гүйцэтгэгч төлбөрийг

		нь авсан бусад ажлыг Захиалагчид хүлээлгэн өгнө; түүнчлэн Аюулгүй байдлыг хангахад шаардлагатайгаас бусад Бараа, материалыг Талбайгаас зөөж зайлуулах ба Талбайг орхиж явна.
16.4 **Гүйцэтгэгч гэрээ цуцалсны дараа төлөх төлбөр**		Гэрээний 16.2-ын дагуу Гэрээг цуцалснаас хойш Захиалагч нь нэн даруй дараах арга хэмжээг авна. Үүнд: (a) Гэрээний 18.5-ын дагуу Гүйцэтгэгчид төлбөр хийнэ; мөн Гүйцэтгэгч нь гэрээний 20.2-ыг дагаж мөрдсөн тохиолдолд, гэрээг цуцалснаас үүдэн Гүйцэтгэгчид учирсан аливаа ашгийн алдагдал, эсхүл бусад алдагдал болон хохирлын хэмжээг Гүйцэтгэгчид төлж барагдуулна.
17. Ажлыг арчилж хамгаалах ба нөхөн төлбөр		
17.1 Ажлыг арчилж, хамгаалах үүрэг		Хэрэв эдгээр Нөхцөлийн дагуу, эсхүл өөр байдлаар Гэрээ цуцлагдаагүй бол Гүйцэтгэгч нь, Ажил, Бараа болон Гүйцэтгэгчийн баримт бичгийг арчилж хамгаалах үүргийг 17.2-ын дагуу ажлыг Ажил эхлэх огнооноос, Ажил дуусах огноо хүртэл буюу дээрх үүрэг Захиалагчид шилжих хүртэл бүрэн хүлээнэ. Хэрэв, Ажлыг хүлээн авсан гэрчилгээ нь Ажлын бүрдэл хэсэг, эсхүл Ажлын бүрэлдэхүүн хэсэгт олгогдсон (эсхүл олгосон гэж үзсэн) бол, энэхүү Ажлын бүрдэл хэсэг, эсхүл Ажлын бүрэлдэхүүн хэсэгт нягт нямбай хандаж арчилж хамгаалах үүрэг Захиалагчид шилжинэ. Хэрэв Гэрээ нь эдгээр Нөхцөлийн дагуу, эсхүл өөр байдлаар цуцлагдсан бол Гүйцэтгэгч нь гэрээ цуцлагдсан өдрөөс Ажлыг арчилж хамгаалах үүрэг хүлээхээ болино. Уг үүрэг зохих ёсоор Захиалагчид шилжсэний дараа, Гүйцэтгэгч нь Ажил дууссан огноогоор таслагдсан дуусаагүй үлдсэн ажлыг арчилж хамгаалах үүргийг, эдгээр дуусаагүй ажил дуустал хүлээнэ. Хэрэв Ажил, Бараа болон Гүйцэтгэгчийн баримт бичгийг арчилж хамгаалах үүрэг хүлээсэн хугацаанд нь тэдгээрт, 17.2-т тусгагдсанаас бусад аливаа шалтгаанаас ямар нэгэн эвдрэл, эсхүл хохирол үүссэн бол,

		Гүйцэтгэгч нь эдгээр эвдрэл, хохирлыг өөрийн эрсдэл ба зардлаар, тухайн Ажил, Бараа, болон Гүйцэтгэгчийн баримт бичиг нь (нөхцөл байдлаас хамаарч) Гэрээний шаардлагад нийцсэн байх хэмжээнд засварлаж, арилгана.
17.2 Ажлыг арчилж, хамгаалах хариуцлага		Гүйцэтгэгч нь Ажил хүлээн авсан гэрчилгээг олгосноос хойш Гүйцэтгэгчээс шалтгаалан Ажил, Бараа болон Гүйцэтгэгчийн баримт бичигт үүссэн аливаа эвдрэл, эсхүл хохирлыг хариуцна. Гүйцэтгэгч нь Ажил хүлээн авсан гэрчилгээг олгохоос өмнө нь түүний хариуцлага хүлээж байсан үйл явдлаас үүдэлтэй бөгөөд Ажил хүлээн авсан гэрчилгээг олгосноос хойш ил болсон аливаа эвдрэл, эсхүл хохирлын хариуцлагыг мөн хүлээнэ. Ажил, Бараа болон Гүйцэтгэгчийн баримт бичигт доор дурдсан үйл явдлын аль нэг (эдгээр Ажил, Бараа болон Гүйцэтгэгчийн баримт бичгээс Захиалагч нь доор дурдсан үйл явдлуудын аль нэг нь тохиохоос өмнө, 7.5-ын дагуу татгалзсанаас бусад тохиолдолд) шалтгаанаас үүссэн аливаа эвдрэл, эсхүл хохиролд, нөхөн төлбөрөөр эсхүл өөр байдлаар Гүйцэтгэгч ямар нэг хариуцлага хүлээхгүй: (a) Ажлыг Гэрээний дагуу гүйцэтгэсний зайлшгүй үр дүн болсон (Гүйцэтгэгчийн барилга угсралтын ажлын аргачлалаас үүдэлтэйгээс бусад) дурын нэвтрэх эрх, гэрэл, агаар, ус, эсхүл бусад ашиглах эрх бүхий түр, эсхүл байнгын нөхцөл байдал; (b) Үндсэн ажлын, Гэрээнд тусгагдсан байж болохоос бусад аливаа хэсгийг Захиалагч ашигласан, эсхүл эзэмшсэн; (c) Гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу Гүйцэтгэгч боловсруулсан зураг төслөөс бусад, Захиалагчийн боловсруулсан Ажлын зураг төслийн ямар нэгэн бүрэлдэхүүн хэсэгт гарсан, эсхүл алдаа, дутагдал, доголдол, эсхүл орхигдсон зүйл; (d) Урьдчилсан мэдэх боломжгүй, эсхүл түүний эсрэг авах хангалттай урьдчилан сэргийлэх арга хэмжээг туршлагатай гүйцэтгэгчээс ч зохих байдлаар хүлээх боломжгүй байсан байгалийн хүчний (Гүйцэтгэгчид зориулан Гэрээний өгөгдөлд тусгаснаас бусад) аливаа үйлчлэл;

		(e) 18.1-ийн (a)-аас (f) заалтад жагсаасан үйл явдал, эсхүл нөхцөл байдлын аль нэг; (f) Захиалагчийн ажилтан, эсхүл Захиалагчийн бусад гүйцэтгэгчдийн аливаа үйлдэл, эсхүл зөрчил. Хэрэв Ажил, Бараа болон Гүйцэтгэгчийн баримт бичигт дээрх (a)-аас (f) заалтад тодорхойлсон үйл явдлаас аль нэг нь тохиолдсон ба эвдрэл, хохиролд хүргэсэн тохиолдолд, Гүйцэтгэгч нь 18.4-д хамааруулан, Захиалагчид яаралтай Мэдэгдэл өгнө. Үүний дараа Гүйцэтгэгч нь, Захиалагчийн зааварчилсан хэмжээнд үүсэж болох аливаа тийм эвдрэл ба/эсхүл хохирлыг засаж, арилгана. Ийм зааварчилгааг 13.3.1-ийн дагуу өгөгдсөн гэж үзнэ. Хэрэв Ажил, Бараа болон Гүйцэтгэгчийн баримт бичгийн эвдрэл, эсхүл хохирол нь доорх зүйлсийн нэгдлээс үүдэлтэй бол: (i) Дээр заасан (a)-аас (f) заалтад дурдсан ямар нэгэн үйл явдал, ба (ii) Гүйцэтгэгч хариуцлага хүлээх шалтгаанаас, ба Гүйцэтгэгч энэхүү эвдрэл, хохирлыг засаж, арилгаснаас болж хугацаа хоцорсон ба/эсхүл Зардал гаргасан бол Гүйцэтгэгч нь, дээр дурдсан аливаа үйл явдал нь энэхүү саатал ба/эсхүл Зардалд нөлөөлсөн тийм хэмжээгээр Хугацаа сунгах ба/эсхүл Ашиг шингэсэн үнийг 20.2-ын дагуу нэхэмжлэх эрхтэй.
17.3 Оюуны болон аж үйлдвэрийн өмчийн эрх		Энэхүү Зүйлд “зөрчил” гэдэг нь Ажилтай холбогдолтой аливаа зохиогчийн эрхийн гэрчилгээний, бүртгэгдсэн зураг төслийн, зохиогчийн эрхийн, худалдааны тэмдгийн, худалдааны нэрийн, худалдааны нууцын, эсхүл бусад оюуны болон аж үйлдвэрийн өмчийн эрхийн зөрчил (эсхүл сэжигтэй зөрчил) гэсэн утгыг илэрхийлнэ; түүнчлэн “шаардлага” гэж дээр дурдсан эрхийг зөрчсөн гэж үзсэн гуравдагч этгээдийн нэхэмжлэлийг (эсхүл гуравдагч этгээдийн шаардлагыг дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг) хэлнэ. Хэрэв нэг Тал нь шаардлага хүлээн авсан боловч түүнээс хойш 28 хоногийн дотор Нөгөө Талдаа ямар нэгэн нэхэмжлэлийн талаар мэдэгдэл өгөөгүй бол, Тухайн шаардлагыг хүлээн авсан Талыг энэхүү

		хэсгийн дагуух хохирлыг нөхөн төлүүлэх аливаа эрхээсээ татгалзсан гэж үзнэ. Захиалагч нь зөрчсөн гэж үзсэн бөгөөд доор дурдсан үр дагавар болж байгаа, эсхүл болсон аливаа шаардлагын хариуцлагаас (шүүхийн шимтгэл болон зардлыг хамруулсан) Гүйцэтгэгчийг ангид байлгаж, хохиролгүй болгох үүрэгтэй: (a) Гүйцэтгэгч нь Захиалагчийн шаардлага ба/эсхүл аливаа Ажлын өөрчлөлтийг дагаж мөрдсөний гарцаагүй үр дагавар; эсхүл (b) Захиалагчаас ямар нэгэн Ажлыг дараах байдлаар ашигласны үр дагавар: (i) Гэрээнд зааснаас, эсхүл Гэрээнээс үндэслэлтэйгээр үүсэж болохоос өөр зорилгоор, эсхүл (ii) хэрэв тухайн ашиглалтын талаар Суурь огнооноос өмнө Гүйцэтгэгчид мэдэгдээгүй, эсхүл Гэрээнд энэ талаар тусгаагүй бол, Гүйцэтгэгчийн ханган нийлүүлээгүй аливаа зүйлтэй холбоотойгоор. Гүйцэтгэгч нь зөрчсөн гэж үзсэн бөгөөд доор дурдсан зүйлээс, эсхүл түүнтэй холбоотойгоор гарсан аливаа бусад шаардлагын хариуцлагаас (хууль, эрх зүйн шимтгэл болон зардлыг хамруулсан) Захиалагчийг ангид байлгах ба хохиролгүй болгох үүрэгтэй: (i) Гүйцэтгэгчийн Ажлын гүйцэтгэл; эсхүл (ii) Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг ашигласан. Хэрэв нэг Тал нь энэхүү Зүйлийн дагуу нөхөн төлбөр авах эрхтэй бол, нөхөн төлбөр барагдуулах Тал нь (нөхөн төлбөрийг барагдуулж буй Талын өөрийн зардлаар) шаардлагыг/нэхэмжлэлийг шийдэх хэлэлцээрийг хийх, ба/эсхүл үүнээс үүсэж болох аливаа маргаан таслах болон арбитрын үйл ажиллагааг зохицуулах бүх хариуцлагыг өөртөө авна. Нөгөө Тал нь нөхөн төлбөрийг барагдуулж буй Талын хүсэлтийг харгалзан, түүний зардлаар, нэхэмжлэлийн маргаанд туслалцаа үзүүлнэ. Хэрэв нөхөн төлбөрийг барагдуулж буй Тал нь нөгөө Талаас ингэх хүсэлт гаргасны дараа, ямар нэгэн хэлэлцээр хийх, маргаан таслах болон арбитрын үйл ажиллагааг зохицуулах бүх хариуцлагыг өөртөө шуурхай аваагүй бол, энэхүү нөгөө Тал

		(ба нөхцөл байдлаас хамааран, Гүйцэтгэгчийн ажилтан эсхүл Захиалагчийн ажилтнууд) нь нөхөн төлбөрийг барагдуулах Талд хор хохирол учруулж болох ямар нэгэн хүлээн зөвшөөрсөн үйлдэл хийх ёсгүй.
17.4 Гүйцэтгэгчийн нөхөн төлбөр		Гүйцэтгэгч нь доорх асуудлуудтай холбогдолтойгоор гарсан гуравдагч этгээдийн бүх нэхэмжлэл, шаардлага, хохирол, алдагдал, зардал (шүүхийн шимтгэл болон зардлыг хамруулсан)-ын хариуцлагаас Захиалагч, Захиалагчийн ажилтнууд, тэдгээрийн холбогдох төлөөлөгчдийг ангид байлгаж ба хохиролгүй болгох үүрэг хүлээнэ: (a) Захиалагч, Захиалагчийн ажилтнууд, тэдгээрийн холбогдох төлөөлөгчдийн аливаа хайхрамж, болгоомжгүй байдал, дур зоргоороо буюу санаатай үйлдэл болон Гэрээний нөхцөлийг зөрчсөнтэй хамааралтайгаас бусад, Гүйцэтгэгчийн Ажлыг гүйцэтгэлээс, эсхүл Ажлыг гүйцэтгэх үед, эсхүл Гүйцэтгэгч Ажлыг гүйцэтгэсэн шалтгаанаар тохиолдсоны аль нь ч байсан, хэн нэгэн гэмтэж бэртэх, өвчлөх, нас барах; ба (b) дараах нөхцөлөөс үүдэлтэй бөгөөд тийм хэмжээний аливаа хөдлөх болон үл хөдлөх (Ажлаас бусад) өмч, хөрөнгөд гарсан эвдрэл, учирсан хохирол: (i) Гүйцэтгэгчийн Ажлын гүйцэтгэлээс, эсхүл Ажлыг гүйцэтгэх үед, эсхүл Гүйцэтгэгч Ажлыг гүйцэтгэсэн шалтгаанаар, ба (ii) Гүйцэтгэгч, Гүйцэтгэгчийн ажилтнууд, тэдгээрийн холбогдох төлөөлөгчдийн, эсхүл энд дурдагдсан этгээдүүдийн шууд ба шууд бусаар хөлсөлсөн хэн нэгний аливаа хайхрамж, болгоомжгүй байдал, санаатай үйлдэл болон Гэрээний нөхцөлийг зөрчсөнд хамааруулж болох. Гүйцэтгэгч нь Ажил (эсхүл Ажлын бүрдэл хэсэг, эсхүл Ажлын бүрэлдэхүүн хэсэг, эсхүл Үндсэн техник хэрэгслийн томоохон хэсэг) нь хийгдэж дууссаныхаа дараа 4.1-ийн дагуу төлөвлөгдсөн зорилгод тохирохгүй байхад хүргэсэн, зураг төслийн үүргээ биелүүлэхдээ Гүйцэтгэгчийн гаргасан бүх үйлдэл, алдаа, эсхүл орхигдуулалтаас Захиалагчийг ангид байлгах ба хохиролгүй болгох үүрэг хүлээнэ.

17.5 Захиалагчийн нөхөн төлбөр		Захиалагч нь доорх асуудлуудтай холбогдолтойгоор гарсан гуравдагч этгээдийн бүх нэхэмжлэл, шаардлага, хохирол, алдагдал, зардал (шүүхийн шимтгэл болон зардлыг хамруулсан)-ын хариуцлагаас, Гүйцэтгэгч, Гүйцэтгэгчийн ажиллагсад, тэдгээрийн холбогдох төлөөлөгчдийг ангид байлгах ба хохиролгүй болгох үүрэгтэй: (a) Захиалагч, Захиалагчийн ажилтнууд, тэдгээрийн холбогдох төлөөлөгчдийн аливаа хайхрамж, болгоомжгүй байдал, дур зоргоороо буюу санаатай үйлдэл болон Гэрээний нөхцөлийг зөрчсөнтэй хамааралтай хэн нэгний гэмтэл бэртэл, өвчин, нас баралт, эсхүл Ажлаас бусад өмч, хөрөнгөд гарсан эвдрэл, учирсан хохирол; ба (b) 17.2-ын (a)-аас (f) хэсэгт тодорхойлсон аливаа нөхцөл байдал, үйл явдлаас үүдэн гарсан аливаа хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгөд (Ажилд хамааралгүй бусад) гарсан эвдрэл, хохирол.
17.6 Хувиарлагдах нөхөн төлбөр		17.4-ийн ба/эсхүл 17.3-ын дагуу Захиалагчид нөхөн төлбөр төлөх Гүйцэтгэгчийн үүргийг, 17.2-ын (a)-аас (f) хэсгүүдэд тодорхойлсон аливаа үйл явдалтай холбоотой аливаа эвдрэл, хохирол, эсхүл гэмтлийн нөхөн төлбөрийн хэмжээгээр хувь тэнцүүлэн бууруулна. Үүнтэй нэгэн адилаар, 17.5-ын дагуу ба/эсхүл 17.3-ын дагуу Гүйцэтгэгчид нөхөн төлбөр төлөх Захиалагчийн үүргийг, 17.1-ийн ба/эсхүл 17.1-ийн дагуу Гүйцэтгэгч хариуцлага хүлээх аливаа үйл явдлаас дээрх эвдрэл, хохирол, эсхүл гэмтэлд нөлөөлсөн байж болох хэмжээгээр хувь тэнцүүлэн бууруулна.
18. Онцгой нөхцөл байдал		
18.1 Онцгой нөхцөл байдал		Онцгой нөхцөл байдал гэж: (i) аль нэг талын хяналтаас давсан; (ii) тухайн Тал Гэрээнд гарын үсэг зурахаас өмнө, зогсоох боломжит арга хэмжээ авах боломжгүй байсан; (iii) үүссэн үед нь тухайн Тал зайлсхийх, эсхүл даван туулж чадахгүй; ба (iv) нөгөө Талд үндсэн хамааралгүй

		үйл явдал, эсхүл нөхцөл байдлыг хэлнэ. Дээрх (1)-ээс (4)-д дурдсан заалтууд хангагдаж байгаа нөхцөлд, Онцгой нөхцөл байдал нь дараах үйл явдал, эсхүл нөхцөл байдлын алинаас ч бүрдэж болох ба гэхдээ эдгээрээр хязгаарлагдахгүй: (a) дайн, байлдааны үйл ажиллагаа (дайн гэж зарлагдсан эсэхээс үл хамааран), халдлага, гадны дайсны аливаа үйлдэл; (b) босого, алан хядах үйл ажиллагаа, хувьсгал, үймээн самуун, цэргийн болон булаан эзлэгчдийн эргэлт, иргэний дайн; (c) гүйцэтгэгчийн ажилтнууд, өмнө Гүйцэтгэгчийн болон түүний Туслан гүйцэтгэгчдийн ажиллуулж буй бусад ажилчдаас өөр этгээдийн гаргасан нийгмийн хэв журмын зөрчил, үймээн самуун, эмх замбараагүй байдал; (d) Гүйцэтгэгчийн ажилтнууд, мөн Гүйцэтгэгчийн болон түүний Туслан гүйцэтгэгчдийн ажиллуулж буй бусад ажилчдыг зөвхөн хамруулаагүй ажил хаялт, эсхүл ажилчдыг олноор нь халах ажиллагаа; (e) Гүйцэтгэгчийн хэрэгцээнд хамааруулж болох зэр зэвсэг, тэсрэх материал, цацраг туяа, эсхүл цацраг идэвхт бодисоос бусад дайн байлдааны зэр зэвсэг, тэсрэх материал, ионжсон цацраг туяа буюу цацраг идэвхт бодисоор бохирдох тохиолдолд; (f) газар хөдлөлт, далайн шуурга, хуй салхи, галт уулын дэлбэрэлт гэх мэт байгалийн сүйрэл, гамшиг.
18.2 Онцгой нөхцөл байдлын талаарх Мэдэгдэл		Хэрэв нэг Тал нь (энэхүү Зүйлд “нөлөөлөлд өртсөн Тал” гэх) Онцгой нөхцөл байдлын улмаас Гэрээний дагуу хүлээсэн ямар нэгэн үүргээ биелүүлээгүй, эсхүл биелүүлэхгүйд хүрэхээр байгаа бол, нөлөөлөлд өртсөн Тал нь нөгөө Талдаа энэхүү Онцгой нөхцөл байдлын талаарх Мэдэгдэл өгөн, биелүүлээгүй, эсхүл биелүүлэхгүйд хүрэхээр байгаа үүргийг (энэхүү Зүйлд “саатсан үүрэг” гэх) тодорхой дурдсан байна. Нөлөөлөлд өртсөн Тал нь Онцгой нөхцөл байдлыг олж мэдсэнээс, эсхүл олж мэдэх ёстой байснаас хойш 14 хоногийн дотор энэхүү Мэдэгдлийг өгсөн байх ба нөлөөлөлд өртсөн Тал дараа нь Онцгой нөхцөл байдлаас болж энэхүү үүрэг саатсан огнооноос эхлэн, саатсан үүргийн биелэлтийг хүлээхгүй болно. Хэрэв энэ Мэдэгдлийг нөгөө Тал нь дээрх 14 хоногийн

		хугацаа өнгөрсний дараа хүлээн авсан бол, нөлөөлөлд өртсөн Тал нь нөгөө Талын энэхүү Мэдэгдлийг хүлээн авсан огнооноос эхлэн, саатсан үүргийн биелэлтийг хүлээхгүй болно. Үүнээс дараа, энэхүү Онцгой нөхцөл байдал нь нөлөөлөлд өртсөн Талыг үүргээ биелүүлэхэд нь саад болсон хугацаагаар, нөлөөлөлд өртсөн Тал нь саатсан үүргийн биелэлтийг хүлээхгүй болно. Нөлөөлөлд өртсөн Тал нь саатсан үүргийг биелүүлэхээс бусад, Гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэхээс чөлөөлөгдөхгүй. Гэсэн хэдий ч, нөгөө Талдаа Гэрээний дагуу зохих төлбөр хийх аль ч Талын үүргийг Онцгой нөхцөл байдлаар чөлөөлөхгүй.
18.3 Ажлын саатлыг хамгийн бага хэмжээнд байлгах үүрэг		Онцгой нөхцөл байдлын үр дагавраас шалтгаалан Гэрээний биелэлтэд үүсэх аливаа саатлыг хамгийн бага хэмжээнд байлгах бүхий л боломжит хүчин чармайлтыг Тал тус бүр, ажлын нийт хугацааны туршид гаргаж ажиллах ёстой. Хэрэв Онцгой нөхцөл байдал нь үргэлжилсэн нөлөөтэй байвал, нөлөөлөлд өртсөн Тал нь 18.2-ын дагуу эхний Мэдэгдэл өгснөөс хойш 28 хоног тутамд, тухайн нөлөөллийг тодорхой дурдсан нэмэлт Мэдэгдлийг өгч байна. Нөлөөлөлд өртсөн Тал нь Онцгой нөхцөл байдлын нөлөөлөл зогссон үед нөгөө Талдаа яаралтай Мэдэгдэл өгнө. Хэрэв нөлөөлөлд өртсөн Тал нь яаралтай мэдэгдээгүй бол, нөлөөлөлд өртсөн Талын үүргийн биелэлт нь цаашид Онцгой нөхцөл байдлаар дахин саатахгүй гэж нөгөө Тал үзэж буйгаа, шалтгааны хамт тодорхой дурдсан Мэдэгдлийг нөгөө Тал нь нөлөөлөлд өртсөн Талд өгнө.
18.4 Онцгой нөхцөл байдлын үр дагавар		Хэрэв Гүйцэтгэгч нь нөлөөлөлд өртсөн Тал бөгөөд, 18.2-ын дагуу тэрээр Мэдэгдэл өгсөн Онцгой нөхцөл байдлаас үүдсэн шалтгаанаар, сааталтай тулгарсан ба/эсхүл Зардал гаргасан бол Гүйцэтгэгч нь 20.2-ын дагуу: (a) Хугацаа сунгах; (b) хэрэв Онцгой нөхцөл байдал нь 18.1-ийн (a)-(e) хэсэгт тодорхойлсон төрлийнх ба, мөн тус хэсгийн (b)-ээс (e) хэсэгт

		тодорхойлсон төрлийнх ба, тухайн Улсад болсон тохиолдолд, энэхүү Зардлаа төлүүлэх эрхтэй.
18.5 Гэрээ цуцлах эрх		Хэрэв явагдаж байсан бүх ажлын ихэнх хэсгийн гүйцэтгэл нь, 18.2-ын дагуу Мэдэгдэлд өгөгдсөн Онцгой үйл явдлаас шалтгаалан 84 хоногийн хугацаанд үргэлжлэн зогссон, эсхүл мөн дээрх мэдэгдсэн Онцгой нөхцөл байдлаас болж, хэсэгчилсэн хугацаагаар хэд хэдэн удаа давтагдан, нийтдээ 140 хоногоос илүү хугацаанд зогссон бол, аль ч Тал нь нөгөө Талдаа Гэрээг цуцлах мэдэгдэл өгч болно. Энэ тохиолдолд, Гэрээг цуцлах огноо нь нөгөө Тал Мэдэгдэл хүлээн авснаас хойших 7 хоногийн дараах огноо байх ба Гүйцэтгэгч нь 16.3-ын дагуу үргэлжлүүлэн ажиллана. Гүйцэтгэгч нь гэрээ цуцлагдсан өдрөөс хойш, гүйцэтгэсэн ажлын өртгийн, доорх зардлуудыг хамруулсан нарийвчилсан нэмэлт мэдээллүүдийг (Захиалагчийн төлөөлөгчөөс үндэслэлтэйгээр шаардсаны дагуу) аль болох боломжтой богино хугацаанд хүргүүлнэ: (a) Хийж гүйцэтгэсэн аливаа ажлын Гэрээнд заасан дүнгээр тооцсон төлбөл зохих дүн; (b) Гүйцэтгэгчид хүргүүлсэн, эсхүл өөр дээрээ хүлээн авах хариуцлагыг Гүйцэтгэгч хүлээх, Ажилд зориулан захиалсан Үндсэн техник хэрэгсэл болон Материалын Зардал. Захиалагч төлбөрийг нь хийснээр эдгээр Үндсэн техник хэрэгсэл болон Материал нь Захиалагчийн (эрсдэлийг өөрөө хүлээнэ) өмч болох ба Гүйцэтгэгч нь тэдгээрийг Захиалагчийн мэдэлд байршуулна; (c) Ажил дуусахыг хүлээх хооронд, үүссэн нөхцөл, байдалд Гүйцэтгэгчээс үндэслэлтэйгээр гаргасан бусад зардал, эсхүл хүлээсэн өр төлбөр; (d) Түр ажил болон Гүйцэтгэгчийн Тоног төхөөрөмжийг Талбайгаас нүүлгэж тэдгээр зүйлсийг Гүйцэтгэгчийн улсад байгаа түүний ажил руу (эсхүл өөр бусад байршил руу, илүү зардал гаргахгүйгээр) буцаах Зардал; ба (e) Гэрээ цуцлагдсан өдөр хүртэл ажилтай холбогдуулан хөлслөн ажиллуулж байсан

		Гүйцэтгэгчийн ажилчдыг бүгдийг нь эх оронд нь буцаахтай холбоотой зардал. Дараа нь Захиалагчийн төлөөлөгч нь хийсэн ажлын өртгийг тохиролцох, эсхүл шийдвэрлэхээр 3.5-ын дагуу үргэлжлүүлэн ажиллах (ба 3.5.3-ын зорилгоор, энэхүү Зүйлийн дагуу хүргүүлсэн Гүйцэтгэгчийн нарийвчилсан нэмэлт мэдээллийг Захиалагчийн төлөөлөгч хүлээн авсан огноо нь 3.5.3-д заасан огноо байна.) Захиалагч нь, ийнхүү тохиролцсон, эсхүл шийдвэрлэсэн мөнгөн дүнд Гүйцэтгэгчээс Төлбөрийн нэхэмжлэл шаардахгүйгээр, 14.6.1-ийн дагуу Мэдэгдлийг олгоно.
18.6 Үүрэг биелүүлэхээс Хуулийн дагуу чөлөөлөх		Энэхүү Зүйлийн аливаа бусад заалт дээр нэмээд, хэрэв Талуудын хяналтаас давсан ямар нэгэн тохиолдол буюу нөхцөл байдал (Онцгой нөхцөл байдлыг оролцуулан, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй) үүссэн бөгөөд тэр нь: (a) аль нэг Талыг, эсхүл хоёр Талыг хоёуланг нь Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй, эсхүл хууль бус болгож байгаа; эсхүл (b) Гэрээг цаашид биелүүлэхээс чөлөөлөгдөх эрхийг, Гэрээг зохицуулах хуулиар Талуудад олгож байгаа, ба хэрэв Талууд нь Гэрээг үргэлжлүүлэн биелүүлэх боломж олгох байсан гэрээний нэмэлт өөрчлөлтийг тохиролцож чадаагүй бол, ийм тохиолдол буюу нөхцөл байдлын талаарх Мэдэгдлийг аль нэг Тал нь нөгөө Талдаа өгсний дараа: (i) урьд нь Гэрээг зөрчсөн аливаа зөрчилтэй холбоотой аль нэг Талын эрхийг хөндөхгүйгээр, Талууд цаашид үүргээ биелүүлэхээс чөлөөлөгдөнө; түүнчлэн Захиалагчаас Гүйцэтгэгчид төлбөл зохих дүн нь 18.5-ын дагуу төлөгдөх байсан дүнтэй ижил байх ба Захиалагч нь энэхүү дүнг, Гэрээ тухайн зүйлийн дагуу цуцлагдсан хэмээн үзэж төлнө.
19. Даатгал		
19.1 Ерөнхий шаардлагууд		Гүйцэтгэгч нь аль ч Талын Гэрээгээр хүлээсэн үүрэг эсхүл хариуцлагыг хязгаарлахгүйгээр, Гүйцэтгэгч хариуцлага хүлээх бүх даатгалыг Захиалагчийн

		зөвшөөрсөн даатгагч болон нөхцөлөөр хийлгэж, түүний хүчинтэй байдлыг хариуцна. Эдгээр нөхцөлүүд нь талууд Гэрээний ерөнхий хэлэлцээрт гарын үсэг зурах өдрөөс өмнө хоёр Тал тохиролцсон аливаа нөхцөлүүдтэй (хэрэв байгаа бол) тохирч байх ёстой. Энэхүү Зүйлийн дагуу заавал хамрагдах шаардлагатай даатгалууд нь Захиалагчаас шаардах хамгийн энгийн даатгалууд бөгөөд Гүйцэтгэгч нь өөрийн зардлаар Гүйцэтгэгчид шаардагдах бусад даатгалуудад нэмж даатгуулж болно. Захиалагчаас шаардсан үед Гүйцэтгэгч нь Гэрээний дагуу заавал хийлгэх шаардлагатай гэрээний нөхцөлийг боловсруулна. Даатгалын хураамж төлөгдсөн тохиолдолд бүрд Гүйцэтгэгч нь даатгалын төлбөрийн баримтын хуулбарыг эсхүл тухайн хураамж төлөгдсөн тухай даатгагчаас баталгаажуулсан баримтыг Захиалагчид нэн даруй хүргүүлнэ. Хэрэв Гүйцэтгэгч нь Гэрээний 19.2-ийн дагуу шаардагдах аливаа даатгалыг хийлгэж, хүчинтэй байлгах үүргээ биелүүлээгүй бол, ийм аливаа тохиолдолд, Захиалагч нь эдгээр даатгалыг хийлгэн, хүчинтэй байлгах, мөн шаардлагатай байж болох даатгалын хураамжийг төлөх бөгөөд Гүйцэтгэгчид төлбөл зохих аливаа мөнгөнөөс ийнхүү төлсөн дүнг үе үе суутгах замаар түүнийгээ Гүйцэтгэгчээс нөхөж авах, эсхүл Гүйцэтгэгчийн өр төлбөр хэлбэрээр өөр байдлаар эргэн төлүүлэх эрхтэй. Энэхүү Гэрээний 20-д заасан зохицуулалтыг хэрэглэхгүй. Хэрэв Гэрээний дагуу хийгдсэн даатгалын аливаа нөхцөлийг Гүйцэтгэгч, эсхүл Захиалагчийн аль нэг дагаж мөрдөөгүй бол, ийнхүү дагаж мөрдөөгүй Тал нь тухайн зөрчлөөс үүссэн бүх шууд хохирол ба нэхэмжлэлийг (шүүхийн шимтгэл болон зардлыг хамруулсан) нөгөө Талдаа нөхөн төлнө. Мөн Гүйцэтгэгч нь дараах үүрэг, хариуцлагыг хүлээнэ: (a) Ажлын шинж байдал, цар хэмжээнд, эсхүл түүнийг гүйцэтгэх төлөвлөгөөнд орсон аливаа өөрчлөлтийг даатгалын байгууллагад мэдээлэх; ба

		(b) Гэрээг гүйцэтгэх бүхий л хугацааны туршид Гэрээний дагуу даатгалын хүрэлцээтэй болон хүчин төгөлдөр байдлыг тогтмол хангах. Аливаа гэрээнд зөвшөөрсөн хасаж тооцож болох зөвшөөрөгдсөн хязгаар нь Гэрээний мэдээлэлд заасан дүнгээс (хэрэв заагаагүй бол, Захиалагчтай тохиролцсон дүн байна) хэтрэх ёсгүй. Хэрвээ Гүйцэтгэгч эсхүл Захиалагч нь энэхүү зүйлийг зөрчсөнөөс үүсгэгдээгүй ба даатгалын байгууллагаас нөхөн төлбөр хийгдэхгүй, хуваагдмал хариуцлага байгаа үед хохирлыг Талуудын хүлээх хариуцлагын дагуу хуваарь барагдуулна. Даатгалын байгууллагаас нөхөн төлбөр хийгдэхгүй нь дээрх зөрчлөөс шалтгаалсан бол, үүссэн хохирлыг тухайн зөрчил гаргасан Тал нь хариуцна.
19.2 Гүйцэтгэгчийн хийлгэх даатгал		Гүйцэтгэгч нь дараах даатгалыг хийлгэнэ: **<u>19.2.1 Ажлын даатгал</u>** Гүйцэтгэгч нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хамтарсан нэр дээр Ажил эхлэх огноонд заагдсан өдрөөс Ажил хүлээн авсан гэрчилгээг олгох өдөр хүртэл хугацаанд дараах нөхцөлүүдийг ханган даатгуулах ба даатгалтай байлгана: (a) Ажлыг ба Гүйцэтгэгчийн баримт бичгийг, Ажилд нийлүүлсэн үндсэн тоног төхөөрөмж ба материалын хамт, тэдгээрийг бүрэн солих үнийн дүнгээр. Зураг төсөл нь алдаатай хийгдсэн, эсхүл доголдолтой материалаар, хийц муутай хийгдсэний улмаас элементүүдийн ажиллагаа доголдсоноос үүссэн Ажлын ямар нэгэн бүрдэл хэсгийн эвдрэл ба хохирлыг хамруулахын тулд даатгалын хэмжээг нэмэгдүүлэх ёстой; ба (b) эвдэрсэн зүйлийг нурааж буулгах болон барилгын хог хаягдлыг зөөж зайлуулах зардал, мэргэжилтнүүдийн зардлыг багтаасан, эвдрэл, эсхүл хохирлыг засаж арилгахад зориулах аливаа дагалдах нэмэлт зардлыг нөхөхөд шаардлагатай, дээрх бүрэн солих үнээс арван таван (15%) хувиар тооцсон нэмэгдэл дүн (эсхүл, Гэрээний мэдээлэлд тусгагдсан байж болох бусад ийм дүн).

		Даатгалын нөхөн төлбөр нь аливаа шалтгаанаар үүссэн бүх эвдрэл, эсхүл хохирлоос Захиалагч болон Гүйцэтгэгчийг, Ажил хүлээн авсан гэрчилгээг олгох огноо хүртэл хамгаална. Үүнээс хойш, Ажил хүлээн авсан гэрчилгээг олгохоос өмнө бий болсон аливаа шалтгаанаар үүссэн эвдрэл, эсхүл хохиролтой, мөн түүнчлэн Гүйцэтгэгчээс гэрээний 11 дүгээр зүйл болон "Ажил дууссаны дараах туршилт"-ыг дагаж мөрдөх зорилгоор хийсэн аливаа үйлдлийн явцад түүний буруугаас үүссэн аливаа эвдрэл, эсхүл хохиролтой холбогдолтой аливаа дуусаагүй ажлын хувьд даатгал нь Гүйцэтгэлийн гэрчилгээг олгох хүртэл үргэлжилнэ. Гэсэн хэдий ч, Ажилд Гүйцэтгэгчийн хийлгэсэн даатгалын нөхцөл төлбөрт дараах зүйлсийн аль нэгийг хамруулахгүй байж болно: (1) тухайн зардал ба үл нийцэлд хамаарах Ажлын аливаа бусад бүрдэл хэсэгт, эвдрэл эсхүл хохирлыг засаж арилгах зардлыг хасаж тооцоогүй тохиолдолд, доголдолтой (хангалтгүй хийц эсхүл чанарын доголдолтой материалыг оролцуулан), эсхүл өөр байдлаар Гэрээний шаардлагад нийцэхгүй байгаа Ажлын ямар нэгэн бүрдэл хэсгийг засаж сайжруулах зардал: (2) Гэрээний үнэд хийгдсэн саатлаас үүдэлтэй аливаа хасалтыг оролцуулсан шууд бус буюу хөндлөнгийн эвдрэл, эсхүл хохирол; (3) элэгдэл хорогдол, дутагдал ба хулгай; болон (4) Гэрээний мэдээлэлд өөрөөр заагаагүй бол, давагдашгүй хүчин зүйлээс үүдэлтэй эрсдэлүүд. **<u>19.2.2 Бараа, материалын даатгал</u>** Гүйцэтгэгч нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хамтарсан нэр дээр Гэрээний мэдээлэлд тусгасан дүнгээр ба/эсхүл заасан дүнгээр (хэрвээ тогтоогоогүй эсхүл заагаагүй бол Ажлын талбайд хүргэх зардлыг багтааж тооцсон тэдгээрийг бүрэн солих үнийн дүнгээр) Гүйцэтгэгчээс Ажлын талбайд оруулсан Бараа болон бусад эд зүйлсийг даатгалд хамруулах үүрэгтэй. Гүйцэтгэгч нь энэхүү даатгалыг, Бараа материалыг Ажлын талбай дээр авчирсан огнооноос тэдгээр нь

		Ажилд цаашид шаардлагагүй болох хүртэл хүчинтэй байлгана. **<u>19.2.3 Мэргэжлийн үүргээ зөрчсөний хариуцлагын даатгал</u>** Гүйцэтгэгч нь Байнгын ажлын бүрдэл хэсгийн зураг төслийн хариуцлагыг гэрээний 4.1-т заасны дагуу ба/эсхүл, аливаа бусад зураг төслийнхийг гэрээний дагуу хүлээх ба Гэрээний 17 дугаар зүйлд тодорхойлсон баталгаанд нийцүүлж байгаа тохиолдолд, хэрэв байгаа бол: (a) Гүйцэтгэгч нь зураг төслийн үүргээ биелүүлэхдээ түүний гаргасан аливаа үйлдэл, алдаа, эсхүл орхигдуулалтаас үүссэн хариуцлагаас хамгаалах мэргэжлийн хариуцлагын даатгалыг, Гэрээний мэдээлэлд зааснаас багагүй дүнгээр (хэрэв тусгаагүй бол, Захиалагчтай тохиролцсон дүнгээр) хийлгэх ба хүчинтэй байлгана; (b) хэрэв Гэрээний мэдээлэлд заасан бол мэргэжлийн хариуцлагын ийм даатгал нь Гүйцэтгэгчийн Гэрээний дагуу хүлээсэн зураг төслийн үүргээ биелүүлэхдээ гаргасан аливаа үйлдэл, алдаа, эсхүл орхигдуулалтаас үүдэн Ажил нь (эсхүл Хэсэг ажил, эсхүл ажлын бүрдэл хэсэг, эсхүл үндсэн тоног төхөөрөмжийн томоохон хэсэг, хэрэв байгаа бол) хийгдэж дууссаныхаа дараа Гэрээний 4.1-ийн дагуу төлөвлөгдсөн зорилгодоо тохирохгүй байгаагаас үүдэх хариуцлагаас мөн хамгаална. Гүйцэтгэгч нь энэхүү даатгалыг Гэрээний мэдээлэлд заасан хугацааны туршид хүчинтэй байлгана. **19.2.4 <u>Хүмүүсийн бэртэл, гэмтэл ба эд хөрөнгийн эвдрэл, хохирлын даатгал</u>** Гүйцэтгэгч нь давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалсан эвдрэл, эсхүл хохирлоос бусад Гүйцэтгэлийн гэрчилгээг олгохоос өмнө, Гэрээг гүйцэтгэх явцад тохиолдсон аливаа хүний амь нас эрсдэх, бэртэл, гэмтэл, эсхүл үүссэн аливаа эд хөрөнгийн (Ажлаас бусад) эвдрэл, эсхүл хохиролд хүлээх хариуцлагыг Гүйцэтгэгч ба Захиалагчийн хамтарсан нэр дээр даатгуулна.

		Гүйцэтгэгч ба Захиалагчийг тус тусад нь даатгуулагч гэж үзэн даатгалыг хэрэглэх тийм харилцан хариуцлагын заалтыг даатгалын гэрээнд оруулсан байна. Гүйцэтгэгч Ажлын талбай дээр ямар нэгэн ажил эхлэхээс өмнө энэхүү даатгалыг хийлгэсэн байх ба Гүйцэтгэлийн гэрчилгээг олгох хүртэл хүчинтэй байх ёстой бөгөөд Гэрээний мэдээлэлд зааснаас багагүй дүнтэй (хэрэв дүн заагаагүй бол, Захиалагчтай тохиролцсон дүнтэй) байна. **19.2.5 <u>Ажилчдын бэртэл, гэмтлийн даатгал</u>** Ажлыг гүйцэтгэх явцад Гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас үүдэлтэй, Гүйцэтгэгчийн хөлслөн ажиллуулж буй хүмүүс, эсхүл Гүйцэтгэгчийн бусад аливаа ажилчдын бэртэл, гэмтэл, өвчин, амь нас эрсдэх, хохирол, нэхэмжлэл ба зардлыг (шүүхийн шимтгэл болон зардлыг хамруулсан) нөхөн төлөх хариуцлагын даатгалыг Гүйцэтгэгч хийлгэх ба хүчинтэй байлгана. Захиалагчийн өөрийн, эсхүл Захиалагчийн ажилчдын аливаа үйлдэл, эсхүл хайнга хандлагаас үүссэн хохирол ба нэхэмжлэлийг энэхүү даатгалд хамруулахгүйгээс бусад тохиолдолд, Захиалагч нь даатгалын гэрээний дагуу мөн нөхөн төлбөр авна. Ажлыг гүйцэтгэхэд Гүйцэтгэгчийн ажилчид оролцох бүхий л хугацааны туршид даатгалыг хүчинтэй хэвээр байлгана. Туслан гүйцэтгэгчийн хөлсөлсөн аливаа ажилчид Туслан гүйцэтгэгч өөрөө даатгалыг хийлгэж болох боловч, энэхүү Гэрээний Туслан гүйцэтгэгч дагаж мөрдөх асуудалд Гүйцэтгэгч хариуцлага хүлээнэ. **19.2.6 <u>Хуулиар болон орон нутгийн эрх зүйгээр шаардагдах бусад даатгал</u>** Ажил (түүний ямар нэгэн бүрдэл хэсэг) хийгдэж байгаа улсын Хууль, тогтоомжоор шаардагдах бусад бүх даатгалыг Гүйцэтгэгч нь өөрийн зардлаар хийлгэнэ. Орон нутгийн эрх зүйгээр шаардагдах бусад даатгалыг (хэрэв байгаа бол) гэрээний мэдээлэлд нарийвчлан зааж тусгах ба Гүйцэтгэгч нь даатгалыг нарийвчилсан заалтад нийцүүлэн өөрийн зардлаар хийлгэнэ.

20. Захиалагчийн ба Гүйцэтгэгчийн Шаардлага		
20.1 Шаардлага		Доор дурдсан нөхцөлд Шаардлага гаргаж болно: (a) хэрэв Захиалагч нь Гүйцэтгэгчээс ямар нэгэн нэмэлт төлбөр авах, (эсхүл Гэрээний үнийг бууруулах) ба/эсхүл Доголдол мэдэгдэх хугацааг сунгуулах эрхтэй гэж үзэж байгаа бол; (b) хэрэв Гүйцэтгэгч нь Захиалагчаас ямар нэгэн нэмэлт төлбөр авах ба/эсхүл Хугацаа сунгах шаардлага гаргах эрхтэй гэж үзэж байгаа бол; эсхүл (c) хэрэв аль нэг Тал нь нөгөө Талаасаа өөр бусад эрх, эсхүл хөнгөлөлт эдлэх эрхтэй гэж үзэж байгаа бол. Ийм өөр эрх, эсхүл хөнгөлөлт нь дээрх (a) ба/эсхүл (b) дэд хэсгүүдэд заасан эрхэд хамааралтайгаас бусад тохиолдолд, ямар ч төрлийнх (Захиалагчийн төлөөлөгчийн аливаа санал, эсхүл үнэлгээ, Мэдэгдэл, гэрчилгээ, тодорхойлолт, зааварчилгаатай холбогдолтой) байж болно. Шаардлагыг дээр дурдсан (a) эсхүл (b) заалтын дагуу гаргасан тохиолдолд, Гэрээний 20.2-ийг хэрэглэнэ. Шаардлагыг дээр дурдсан (c) заалтын дагуу гаргасан тохиолдолд, нөгөө Тал эсхүл Захиалагчийн төлөөлөгч нь хүссэн эрх, эсхүл хөнгөлөлтийг зөвшөөрөөгүй (эсхүл, хэрэв тэдгээр нь зохих хугацааны дотор хариу өгөөгүй тул үл зөвшөөрсөн гэж үзсэн) бол Маргаан үүссэн гэж үзэхгүй, гэвч шаардлага гаргаж буй Тал нь Захиалагчийн төлөөлөгчид Мэдэгдэл өгөн, Шаардлагаа хангуулахаар хандаж болох ба Гэрээний 3.7 хэрэглэгдэнэ. Үл зөвшөөрлийг (эсхүл санал зөрсөн гэж үзсэнийг) шаардлага гаргагч Тал мэдсэн дариудаа энэхүү Мэдэгдлийг өгөх бөгөөд түүнд шаардлага гаргагч Талын шаардлага ба нөгөө Тал, эсхүл Захиалагчийн төлөөлөлгчийн үл зөвшөөрлийн (эсхүл санал зөрсөн гэж үзсэн) талаар дэлгэрэнгүй тусгасан байна.
20.2 Төлбөрийн ба/эсхүл Хугацаа сунгах шаардлага		Хэрэв аль нэг Тал нь Гэрээтэй холбогдуулан эдгээр Нөхцөлийн аливаа Зүйлийн дагуу, эсхүл Гэрээтэй хамааралтай өөр байдлаар нөгөө Талаасаа ямар нэгэн нэмэлт төлбөр авах (эсхүл, Захиалагч байх тохиолдолд, Гэрээний үнийг бууруулах) ба/эсхүл Хугацаа сунгах шаардлагагын (Гүйцэтгэгч байх

		тохиолдолд), эсхүл Доголдол мэдэгдэх хугацааг сунгуулах (Захиалагч байх тохиолдолд) эрхтэй гэж үзэж байгаа бол, Шаардлага гаргахад дараах журмыг баримтална: **20.2.1 <u>Шаардлага гаргах мэдэгдэл</u>** Шаардлага гаргагч Тал нь аль болох боломжит богино хугацаанд Шаардлага гаргах болсон үндэслэл болох зардал, хохирол, саатал, эсхүл Доголдол мэдэгдэх хугацааны сунгалтыг бий болгож буй үйл явдал буюу нөхцөл байдлыг тодорхой дурдсан Мэдэгдлийг (эдгээр Нөхцөлд "Шаардлага гаргах мэдэгдэл" гэх), тухайн үйл явдал буюу нөхцөл байдал шаардлага гаргагч Тал мэдсэн, эсхүл мэдэж ёстой байснаас хойш 28 хоногийн дотор Захиалагчийн төлөөлөгчид өгнө. Хэрэв шаардлага гаргагч Тал нь энэ 28 хоногийн хугацаанд Шаардлага гаргах тухай мэдэгдлийг өгөөгүй тохиолдолд, шаардлага гаргагч Тал нь нэмэлт төлбөр авах, Гэрээний үнийг бууруулах (Захиалагч нь шаардлага гаргагч Тал байх тохиолдолд) эрхгүй, Ажил дуусах хугацааг (Гүйцэтгэгч нь шаардлага гаргагч Тал байх тохиолдолд) сунгуулах эрхгүй, эсхүл Доголдол Мэдэгдэх хугацааг (Захиалагч нь шаардлага гаргагч Тал байх тохиолдолд) сунгахгүй ба нөгөө Тал нь Шаардлага шалтгаан болсон үйл явдал эсхүл нөхцөл байдалтай холбогдолтой аливаа хариуцлагаас чөлөөлөгдөнө. **20.2.2 <u>Урьдчилсан дүгнэлт</u>** Хэрэв, шаардлага гаргагч Тал Шаардлагын тухай Мэдэгдлийг Гэрээний 20.2.1-ийн дагуу 28 хоногийн хугацаанд багтаж өгөөгүй гэж гэрээний нөгөө тал үзвэл, Шаардлага гаргасан тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор, (шалтгааныг дурдсан) мэдэгдлийг шаардлага гаргагч Талд хүргүүлнэ. Хэрэв гэрээний нөгөө тал уг мэдэгдлийг 14 хоногийн дотор хүргүүлээгүй бол Шаардлага гаргасан тухай мэдэгдлийг хүчин төгөлдөр Мэдэгдэл гэж үзнэ. Хэрэв шаардлага гаргагч Тал нь гэрээний нөгөө талаас энэхүү Гэрээний дагуу Мэдэгдэл хүлээн авсан бөгөөд уг мэдэгдэлтэй санал нийлэхгүй байгаа, эсхүл Шаардлага гаргасан тухай мэдэгдлийг хүндэтгэн үзэх шалтгаантайгаар хугацаанд нь хүргүүлээгүй бол,

		Гэрээний 20.2.4-ийн дагуу Нарийвчилсан шаардлагадаа энэ талаар тодорхой тусгасан байна. **20.2.3 <u>Зэрэгцээ гаргасан бүртгэл</u>** Энэхүү Гэрээний 20.2-т "Зэрэгцээ гаргасан бүртгэл" гэж Шаардлага гаргахад хүргэсэн үйл явдал, эсхүл нөхцөл байдалтай нэгэн зэрэг, эсхүл түүний дөнгөж дараа нь бэлтгэгдсэн, эсхүл бий болсон бүртгэлийг хэлнэ. Шаардлага гаргагч Тал нь ийм зэрэгцээ гаргасан бүртгэлийг Шаардлагыг нотлоход шаардлагатай байж магадгүй хэмээн бүртгэлийг хөтөлнө. Захиалагчийн төлөөлөгч нь Захиалагчийн хариуцлагыг оруулахгүйгээр, Гүйцэтгэгчийн зэрэгцээ гаргасан бүртгэл хөтлөлтийг үзэж шалгах ба/ эсхүл нэмэлт бүртгэлийг хөтлөх зааварчилгааг Гүйцэтгэгчид өгч болно. Гүйцэтгэгч нь эдгээр бүх бүртгэлийг ажлын ердийн цагаар (эсхүл, Гүйцэтгэгчтэй тохиролцсон бусад цагт) үзэж шалгахыг Захиалагчийн төлөөлөгчид зөвшөөрөх ба хэрэв зааварчилсан бол, тэдгээрийн хувийг Захиалагчийн төлөөлөгчид өгнө. Захиалагчийн төлөөлөгчөөс ийнхүү үзэж шалгах, хянах, эсхүл зааварчлах (хэрэв байгаа бол) нь Гүйцэтгэгчийн зэрэгцээ гаргасан бүртгэлийн үнэн зөвийг эсхүл бүрэн бүтэн гэдгийг зөвшөөрсний илэрхийлэл биш болно. **20.2.4 <u>Дэлгэрэнгүй шаардлага</u>** Энэхүү Гэрээний 20.2-т "Дэлгэрэнгүй шаардлага" гэж доорх зүйлсийг хамруулсан Шаардлагыг хэлнэ: (a) Шаардлагыг гаргах шалтгаан болсон үйл явдал эсхүл нөхцөл байдлын дэлгэрэнгүй тайлбар; (b) Шаардлагын гэрээний ба/эсхүл бусад хууль зүйн дагуух үндэслэл бүхий мэдэгдэл; (c) шаардлага гаргагч Талын гаргасан бүх зэрэгцээ гаргасан бүртгэлүүд; ба (d) нэхэмжилж буй нэмэлт төлбөрийн (эсхүл Захиалагч нь шаардлага гаргагч Тал байх тохиолдолд, Гэрээний үнийг бууруулах дүн) дүнтэй ба/эсхүл Ажил дуусгах хугацааны (Гүйцэтгэгч нь шаардлага гаргагч Тал байх тохиолдолд) сунгалттай, эсхүл Доголдол мэдэгдэх хугацааг (Захиалагч нь

		шаардлага гаргагч Тал байх тохиолдолд) сунгалттай холбогдолтой дэлгэрэнгүй нэмэлт мэдээллийг. Доор заасан хугацаанд: (1) Шаардлага гаргах шалтгаан болсон үйл явдал эсхүл нөхцөл байдлын талаар шаардлага гаргагч Тал мэдсэн (эсхүл мэдэх ёстой байснаас) хойш 84 хоногийн дотор, эсхүл (2) шаардлага гаргагч Тал санал болгож, Захиалагчийн төлөөлөгч зөвшөөрсөн тодорхой өөр хугацааны дотор (хэрэв байгаа бол) шаардлага гаргагч Тал нь Дэлгэрэнгүй шаардлагыг Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ. Хэрэв шаардлага гаргагч Тал нь дээр дурдсан (b) заалтын дагуух мэдэгдлийг энэхүү хугацааны хязгаарт багтаан хүргүүлээгүй бол, Шаардлагын тухай мэдэгдлийг хугацаа дуусан бөгөөд цаашид хүчин төгөлдөр бус Мэдэгдэл гэж үзэх ба Захиалагчийн төлөөлөгчид нь энэхүү хугацааны хязгаар дуусанаас хойш 14 хоногийн дотор шаардлага гаргагч Талд зохих ёсоор мэдэгдэл өгнө. Хэрэв Захиалагчийн төлөөлөгч ийм мэдэгдлийг 14 хоногийн дотор өгөөгүй бол, Шаардлагын тухай мэдэгдлийг хүчин төгөлдөр Мэдэгдэл гэж үзнэ. Хэрэв нөгөө Тал нь энэхүү хүчин төгөлдөр гэж үзсэн мэдэгдэлтэй санал нийлэхгүй байвал, үл зөвшөөрсөн тухайгаа дэлгэрэнгүй дурдсан мэдэгдлийг Захиалагчийн төлөөлөгчид өгнө. Үүний дараа, Гэрээний 20.2.5-ийн дагуу хийгдсэн Шаардлага шийдвэрлэсэн эсхүл эвлэрүүлсэн тохиолдолд энэхүү үл зөвшөөрлийг Захиалагчийн төлөөлөгчөөс нягталсан байдлыг тусгаж өгнө. Хэрэв шаардлага гаргагч Тал нь Захиалагчийн төлөөлөгчөөс энэхүү Гэрээний 20.2.4-ийн дагуу Мэдэгдэл хүлээн авсан ба хэрэв тухайн Тал энэхүү Мэдэгдэлтэй санал нийлэхгүй байгаа, эсхүл дээрх (b) заалтын дагуух мэдэгдлийг оройтуулж хүргүүлснээ зөвтгөх нөхцөл байдал байна гэж үзэж байгаа бол, Дэлгэрэнгүй шаардлагадээ энэхүү үл зөвшөөрсөнтэй холбогдолтой нарийвчилсан мэдээллийг, эсхүл оройтуулж хүргүүлснээ яагаад зөвтгөж байгаа тухайгаа (нөхцөл байдлаас хамааруулан) тусгасан байна.

		Хэрэв Шаардлагыг гаргах шалтгаан болсон үйл явдал эсхүл нөхцөл байдал нь үргэлжилсэн үр нөлөөтэй байвал, Гэрээний 20.2.6-ийг хэрэглэнэ. **20.2.5 <u>Эвлэрэх эсхүл шийдвэрлэх</u>** Дэлгэрэнгүй шаардлагыг Гэрээний 20.2.4-ийн дагуу, эсхүл явц дундын болон эцсийн Дэлгэрэнгүй шаардлагыг Гэрээний 20.2.6-ийн аль нэгнийх нь дагуу хүлээн авсны дараа Захиалагчийн төлөөлөгч нь Гэрээний 3.7-ийн дагуу үргэлжлүүлэн ажиллаж, шаардлага гаргагч Тал нь Гэрээний дагуу эдлэх эрхтэй доорх зүйлсийг тохиролцож, эсхүл шийдвэрлэнэ: (a) шаардлага гаргагч Тал авах эрхтэй нэмэлт төлбөрийг (хэрэв байгаа бол), эсхүл Гэрээний үнийн бууруулалтыг (Захиалагч нь шаардлага гаргагч Тал байх тохиолдолд); ба/эсхүл (b) Ажил дуусгах хугацааны (түүний хүчинтэй байх огнооноос өмнө, эсхүл хойно) сунгалтыг (хэрэв байгаа бол) (Гүйцэтгэгч нь шаардлага гаргагч Тал байх тохиолдолд), гэрээний 8.5-ийн дагуу, эсхүл Доголдол мэдэгдэх хугацааны (түүний хүчинтэй хугацаа дуусах огнооноос өмнө) сунгалтыг (хэрэв байгаа бол) (Захиалагч нь шаардлага гаргагч Тал байх тохиолдолд), Гэрээний 11.3-ийн дагуу. Хэрэв Захиалагчийн төлөөлөгч нь Гэрээний 20.2.2 эсхүл Гэрээний 20.2.4-ийн дагуу Мэдэгдэл өгсөн хэдий ч Шаардлагыг энэхүү Гэрээний 20.2.5-ийн дагуу эвлэрүүлж эсхүл шийдвэрлэнэ. Дэлгэрэнгүй шаардлагад ийм Мэдэгдлээр тусгасан шаардлага гаргагч Талын үл зөвшөөрсөнтэй холбоотой (хэрэв байгаа бол) эсхүл оройтуулж хүргүүлснээ яагаад зөвтгөж байгаа талаарх (нөхцөл байдлаас хамааруулан) нарийвчилсан мэдээллийг харгалзан, Шаардлагын тухай Мэдэгдлийг хүчин төгөлдөр Мэдэгдэл гэж үзэх эсэхийг Шаардлагыг эвлэрүүлэх эсхүл шийдвэрлэхдээ тусгана. Анхааран үзэж болох (гэхдээ заавал дагах албагүй) нөхцөл байдалд дараах зүйлсийг хамруулж болно: ● Оройтуулж хүргүүлснийг хүлээн зөвшөөрсөн нь нөгөө Талд хохирол учруулах эсэх, эсхүл ямар хэмжээнд хохирол учруулах ● Гэрээний 20.2.1-ийн дагуу хугацааны хязгаартай тохиолдолд, шаардлага гаргагч Тал нь өөрийн нэмэлт мэдээлэлдээ хамруулж болох,

		Шаардлагыг гаргах шалтгаан болсон үйл явдал эсхүл нөхцөл байдлын талаарх нөгөө Талын урьд нь мэдэж байсан аливаа нотолгоо; ба/эсхүл ● Гэрээний 20.2.4-ийн дагуу хугацааны хязгаартай тохиолдолд, шаардлага гаргагч Тал нь өөрийн нэмэлт мэдээлэлдээ хамруулж болох, Шаардлагын гэрээний ба/эсхүл бусад хууль зүйн дагуух үндэслэлийн талаарх нөгөө Талын урьд нь мэдэж байсан аливаа нотолгоо. Хэрэв, Дэлгэрэнгүй шаардлагыг Гэрээний 20.2.4-ийн дагуу, эсхүл явц дундын болон эцсийн Дэлгэрэнгүй шаардлагыг Гэрээний 20.2.6-ийн дагуу хүлээн аваад Захиалагчийн төлөөлөгчид нэмэлт мэдээлэл шаардлагатай болвол Захиалагчийн төлөөлөгч нь: (1) нэмэлт мэдээллүүд болон тэдгээрийг шаардах болсон шалтгаанаа тодорхой дурдсан Мэдэгдлийг шаардлага гаргагч Талд яаралтай өгнө; (2) бусад нөхцөл байдлаас үл шалтгаалан Гэрээний 3.7.3-ийн дагуух тохиролцох хугацааны хязгаарт багтаан шаардлага гаргагч Талд Мэдэгдэл өгөн, Шаардлагын гэрээний ба/ эсхүл бусад хууль зүйн дагуух үндэслэлд өөрийн хариугаа өгнө; (3) шаардлага гаргагч Тал нь дээрх (1)-р заалтын дагуу Мэдэгдэл хүлээн авснаасаа хойш аль болох боломжит богино хугацаанд нэмэлт мэдээллүүдийг хүргүүлнэ; (4) Дараа нь Захиалагчийн төлөөлөгч дээрх (a) ба/ эсхүл (b) заалтад тусгасан зүйлсийг тохиролцох, эсхүл шийдвэрлэхээр Гэрээний 3.7-ийн дагуу үргэлжлүүлэн ажиллах (ба Гэрээний 3.7.3-ийн зорилгоор, шаардлага гаргагч Талаас нарийвчилсан нэмэлт мэдээллийг Захиалагчийн төлөөлөгч хүлээн авсан огноо нь Гэрээний 3.7.3-ын дагуух тохиролцох хугацааны хязгаарын эхлэх огноо болно.) **20.2.6 <u>Үргэлжилсэн нөлөөллийн шаардлага</u>** Хэрэв энэхүү Гэрээний 20.2-ын дагуу Шаардлага гаргах шалтгаан болсон үйл явдал эсхүл нөхцөл байдал нь үргэлжилсэн нөлөөлөлтэй байвал: (a) Гэрээний 20.2.4-ийн дагуу хүргүүлсэн Дэлгэрэнгүй шаардлагыг явц дундын шаардлага гэж үзнэ; (b) энэхүү анхны явц дундын Дэлгэрэнгүй шаардлагатай холбогдуулан, Захиалагчийн төлөөлөгч нь Гэрээний 3.7.3-ийн дагуух тохиролцох хугацааны хязгаарт багтаан шаардлага гаргагч Талд

		Мэдэгдэл өгөн, Шаардлагын гэрээний ба/эсхүл бусад хууль зүйн дагуух үндэслэлд өөрийн хариугаа өгнө; (c) анхны явц дундын Дэлгэрэнгүй шаардлагыг танилцуулсны дараагаас шаардлага гаргагч Тал нь нэхэмжилсэн нэмэлт төлбөрийн хуримтлагдсан дүнг (эсхүл Захиалагч нь шаардлага гаргагч Тал байх тохиолдолд, Гэрээний үнийг бууруулах дүнг) ба/ эсхүл нэхэмжилсэн хугацааны сунгалтыг (Гүйцэтгэгч нь шаардлага гаргагч Тал байх тохиолдолд), эсхүл Доголдол мэдэгдэх хугацааны сунгалтыг (Захиалагч нь шаардлага гаргагч Тал байх тохиолдолд) илэрхийлсэн цаашдын явц дундын Дэлгэрэнгүй шаардлагыг сарын зайтайгаар хүргүүлнэ. (d) шаардлага гаргагч Тал нь үйл явдал эсхүл нөхцөл байдлаас шалтгаалсан нөлөөлөл дуусанаас хойш 28 хоногийн дотор, эсхүл шаардлага гаргагч Тал санал болгож, Инженер зөвшөөрч болох тийм өөр хугацааны дотор эцсийн Дэлгэрэнгүй шаардлагыг хүргүүлнэ. Энэхүү эцсийн дэлгэрэнгүй шаардлага нь нэхэмжилсэн нэмэлт төлбөрийн нийт дүнг (эсхүл Захиалагч нь шаардлага гаргагч Тал байх тохиолдолд, Гэрээний үнийг бууруулах дүнг) ба/эсхүл нэхэмжилсэн хугацааны сунгалтыг (Гүйцэтгэгч нь шаардлага гаргагч Тал байх тохиолдолд), эсхүл Доголдол мэдэгдэх хугацааны сунгалтыг (Захиалагч нь шаардлага гаргагч Тал байх тохиолдолд) илэрхийлнэ. **20.2.7 <u>Ерөнхий шаардлага</u>** Захиалагчийн төлөөлөгч нь Шаардлагын тухай мэдэгдлийг хүлээн авсны дараа, Шаардлагыг Гэрээний 20.2.5-ийн дагуу тохиролцох, эсхүл шийдвэрлэх хүртэл, Гэрээний холбогдох заалтын дагуу шаардлага гаргагч Талд төлөгдөхөөр аливаа Шаардлагад зохих ёсоор батлагдсан тийм дүнг Төлбөрийн гэрчилгээ бүрд оруулж өгнө. Захиалагч нь энэхүү Гэрээний 20.2-ыг даган биелүүлэхдээ зөвхөн, Гүйцэтгэгчээс ямар нэгэн төлбөр нэхэмжлэх ба/эсхүл Доголдол мэдэгдэх хугацааг сунгуулах, эсхүл Гүйцэтгэгчид төлбөл зохих аливаа дүнгээс тооцоо хийж авах, эсхүл ямар нэгэн суутгал хийх эрхтэй. Энэхүү Гэрээний 20.2-ийн шаардлагууд нь Шаардлагад хэрэглэгдэж болох бусад аливаа Гэрээний шаардлага дээр нэмэлт болж өгнө. Хэрэв шаардлага гаргагч Тал нь Шаардлагатай холбоотой энэ болон өөр аливаа бусад Гэрээнийийг зөрчсөн бол, аливаа нэмэлт

		төлбөрт ба/эсхүл аливаа Хугацаа сунгах-д (Гүйцэтгэгч нь шаардлага гаргагч Тал байх тохиолдолд), эсхүл Доголдол мэдэгдэх хугацааны сунгалтад (Захиалагч нь шаардлага гаргагч Тал байх тохиолдолд) уг зөрчил нь Шаардлагыг Захиалагчийн төлөөлөгчөөс сайтар судалж шалгахад саад учруулсан, эсхүл нөлөөлсөн хир хэмжээг (хэрэв байгаа бол) харгалзан үзнэ.
21. МАРГААН БА АРБИТРЫН АЖИЛЛАГАА		
21.1 МЗШЗ байгуулах		Талуудын хооронд маргаан үүссэн тохиолдолд 21.4-ийн дагуу МЗШЗ-өөр шийдвэрлүүлнэ. Талууд гэрээний ерөнхий хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс хойш Гэрээний мэдээлэлд заагдсан хугацааны (заагаагүй бол 28 өдрийн) дотор Талууд хамтран МЗШЗ-ийн гишүүн(д)-ийг томилно. Гэрээний мэдээлэлд заагдсаны дагуу МЗШЗ нь шаардлага хангасан нэг (цаашид “нэг гишүүн” гэх) эсхүл гурван гишүүн (цаашид “гишүүд” гэх)-ий бүрэлдэхүүнтэй байна. Хэрвээ гишүүнийг тоог урьдчилан тогтоогоогүй бөгөөд Талууд татгалзаагүй бол МЗШЗ нь гурван гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Гишүүн эсхүл гишүүдийг (тухайн нөхцөл байдлаас хамаарч) Гэрээний мэдээлэлд дурьдсан нэрсийн жагсаалтаас МЗШЗ-ийн гишүүнээр томилогдохоос татгалзсан эсхүл боломжгүй этгээдээс бусад этгээдийг сонгож, томилно. Хэрвээ МЗШЗ нь гурван гишүүний бүрэлдэхүүнтэй бол Талууд нөгөө Талтайгаа харилцан зөвшилцөж тус бүр нэг гишүүнийг сонгоно. Тэдгээр сонгогдсон гишүүдтэй Талууд харилцан зөвшилцөж гурав дахь гишүүнийг сонгох бөгөөд энэхүү гурав дахь гишүүн нь МЗШЗ-ийн даргаар томилогдоно. Талууд болон МЗШЗ-ийн нэг гишүүн эсхүл гурван гишүүн (тухайн нөхцөл байдлаас хамаарч) тус бүр МЗШЗ байгуулах гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсанаар МЗШЗ байгуулагдсанд тооцно. МЗШЗ-ийн нэг гишүүн эсхүл гурван гишүүний цалин хөлсний дүн дээр аливаа МЗШЗ-ийн экспертийн цалин хөлсийг багтаан Талууд МЗШЗ байгуулах гэрээг батлах үедээ харилцан зөвшилцөж

		шийдвэрлэнэ. Энэхүү цалин хөлсийг Талууд тэнцүү байдлаар хуваж төлөх үүргийг хүлээнэ. Хэрвээ МЗШЗ-ийн нэг эсхүл түүнээс олон гишүүдийг өөрчилж томилох талаар Талууд харилцан зөвшилцсөн тохиолдолд зохих шаардлага хангасан хүн эсхүл хүмүүсийг Талууд хэдийд ч нэр дэвшүүлж томилох эрхтэй. Талууд өөрөөр тохиролцсоноос бусад тохиолдолд гишүүн нь ажил үүргээ биелүүлэхээс татгалзах, нас барах, өвчний улмаас, хөгжлийн бэрхшээлийн асуудал, огцрох, томилгооны хугацаа дуусгавар болсон зэрэг нөхцөл байдал бий болсон бол МЗШЗ-ийн гишүүнийг өөрчлөх томилгоог хийнэ. Шинээр томилогдох гишүүн нь Энэхүү заалтад заасны дагуу сонгогдож, зөвшөөрөгдсөн байвал зохино. МЗШЗ-ийн гишүүний томилгоог аль нэг тал нь дангаараа цуцлах шийдвэр гаргах эрхгүй бөгөөд уг асуудлаар Талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ. Талууд өөрөөр тохироогүй бол, МЗШЗ-ийн (гишүүн тус бүрийн томилгооны хугацаа) хугацаа нь дараах тохиолдолдуудын аль сүүлд бий болсон тохиолдолд дуусгавар болно: (a) ажлаас халах шийдвэр нь хүчин төгөлдөр үйлчлэх өдөр эсхүл 14.12-т заасан өдөр хүчин төгөлдөр үйлчилнэ, эсхүл (b) Энэхүү томилолт дуусгавар болох хугацаа хүчин төгөлдөр үйлчилж эхлэхээс өмнө 21.4-т заасны дагуу холбогдох бүх маргааныг МЗШЗ шийдвэрлэж, шийдвэрээ талуудад хүргүүлсэнээс хойш 28 өдрийн дараа, Хэрвээ дараах нөхцөлүүдийн аль нэг заалтын дагуу болон бусад байдлаар Гэрээ цуцлагдсан бол МЗШЗ (гишүүдийн томилгоо) дараахь хэсгүүдэд тогтоосон өдрийн аль түрүүлж тохиолдсоноос хойш 28 өдрийн дараа дуусгавар болно: (i) МЗШЗ нь гэрээний хүрээн дэх бүхий л маргааныг шийдвэрлэн 21.4-т заасны дагуу гэрээ цуцлагдсан өдрөөс хойш 224 өдрийн дотор хүргүүлсэн бол, эсхүл (ii) Талууд Гэрээг цуцлахтай холбоотой бүхий л асуудлаар (Гэрээний төлбөр, тооцоотой холбоотой

		асуудал үүнд хамаарна) харилцан зөвшилцөж эцсийн тохиролцоонд хүрсэн өдөр;
21.2 МЗШЗ-ийн гишүүний (гишүүдийн) томилгоо амжилтгүй болох		Дор дурьдсан нөхцлүүдэд: a. МЗШЗ нь нэг гишүүнээс бүрдэх бөгөөд 21.1 хэсгийн эхний цогцолборт заасан хугацаанд багтан Талууд нь харилцан зөвшилцөж томилж чадаагүй бол; эсхүл b) МЗШЗ нь гурван гишүүнээс бүрдэх бөгөөд 21.1-ийн эхний цогцолборт заасан хугацаанд багтан: i. Аль нэг Тал нь гишүүнийг сонгож чадаагүй бол; ii. Аль нэг Тал нь нөгөө Талын сонгосон гишүүнийг зөвшөөрөөгүй бол; iii. Талууд нь МЗШЗ-ийн (даргаар ажиллах) гуравдагч гишүүний томилгоог тохиролцож чадаагүй бол; c) МЗШЗ-ийн гишүүн нас барсан, өвчтэй, хөдөлмөрийн чадварыг алдсан, халагдсан, эсхүл томилолтыг цуцалсан зэрэг шалтгаанаар ажил үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон эсхүл ажил үүргээ гүйцэтгэхээс татгалзсан өдрөөс хойш 42 өдөрт багтаан гишүүнийг нөхөн томилох тал дээр Талууд нь харилцан зөвшилцөж чадаагүй бол; d) Хэрвээ Талууд МЗШЗ-ийн гишүүнийг (гишүүдийг) томилох эсхүл нөхөн томилох талаар харилцан зөвшилцсөн боловч уг гишүүнийг томилох эсхүл нөхөн томилох талаар аль нэг Талаас саналаа ирүүлснээс хойш 14 өдөрт багтаан нөгөө Тал нь МЗШЗ байгуулах гэрээнд гарын үсэг зурахаас татгалзах эсхүл гарын үсэг зурах үүргээ биелүүлээгүйн улмаас тухайн томилолт хүчин төгөлдөр болж үйлчлэхгүй нөхцөл байдал үүссэн бол Гэрээний мэдээлэлд нэр заасан хуулийн этгээд эсхүл эрх бүхий этгээд нь аль нэг эсхүл хоёр Талын хүсэлтээр Талуудтай харилцан зөвшилцөн МЗШЗ-ийн гишүүн (гишүүд)-ийг (энэхүү 21.2 дахь хэсгийн (d) заалтад дурьдсан нөхцөл байдлын хувьд талуудын харилцан зөвшилцсөн гишүүн (гишүүд)-ийг) томилно.

		Энэхүү томилгоо нь эцсийн шийдвэр бөгөөд заавал дагаж мөрдөх үүрэгтэй. Үүний дараа, Талууд болон томилогдсон гишүүн (гишүүд) нь МЗШЗ байгуулах гэрээнд гарын үсэг зурсанд тооцох ба МЗШЗ байгуулах гэрээний дагуу дараах үүргүүдийг хүлээнэ: (i) сар бүрийн болон өдөр тутмын ажил үйлчилгээний цалин хөлсийг МЗШЗ-ийг томилсон шийдвэрт зааснаар олгоно, (ii) МЗШЗ-ийн хэрэглэх хууль тогтоомж нь Гэрээний 1.4-т заасан хууль, тогтоомжууд байна. Талууд МЗШЗ-ийн зардлыг тэнцүү төлөх үүрэгтэй. Хэрвээ Гүйцэтгэгч нь тухайн зардлыг бүрэн гаргасан бол зардлын нийт дүнгийн тал хувийг Мэдэгдэлд эргэн төлөгдөхөөр тусгах бөгөөд дараа нь уг төлбөрийг Захиалагч Гэрээний дагуу Гүйцэтгэгчид төлж барагдуулна. Хэрвээ Захиалагч нь уг зардлыг бүрэн гаргасан бол Захиалагчийн төлөөлөгч нь тухайн төлбөрийн дүнгийн тал хувийг 14.6.1 [IPC] заалтын (b)-д заасны дагуу хасалт хийж тооцно.
21.3 Маргаанаас зайлсхийх		Хэрэв Талууд харилцан зөвшөөрсөн тохиолдолд Гэрээний явцад тэдний хооронд үүссэн үл ойлголцол эсхүл санал зөрөлдөөнийг шийдвэрлэх зорилгоор туслалцаа, дэмжлэг авах болон/эсхүл албан бусаар хэлэлцэхийг хүсч МЗШЗ-д хамтарсан хүсэлт (бичгин хэлбэрээр) гаргах эрхтэй. Хэрэв МЗШЗ нь талуудын хооронд ямар нэгэн байдлаар үл ойлголцол эсхүл санал зөрөлдөөн бий болсон талаар мэдсэн тохиолдолд талуудыг уг хүсэлтийг гаргахыг санал болгож болно. Талууд өөрөөр тохиролцсоноос бусад тохиолдолд Талуудын хооронд үүссэн аливаа маргаан эсхүл санал зөрөлдөөнтэй асуудлаар Захиалагчийн төлөөлөгч нь гэрээний 3.7-д заасны дагуу асуудал шийдвэрлэх үүргээ гүйцэтгэж байгаагаас бусад тохиолдолд Талууд дээр дурьдсан хамтарсан хүсэлтийг гаргах эрхтэй. Энэ албан бус дэмжлэг туслалцаа, хэлэлцээрийг аливаа уулзалтын үеэр, Ажлын талбайд ажиллах болон бусад байдлаар хэрэгжүүлж болно. Хэрвээ Талууд өөрөөр тохиролцоогүй бол

		Талууд тэрхүү албан бус хэлэлцээрт /уулзалт, зөвлөлгөөн, үйл ажиллагаанд/ заавал байлцах үүрэгтэй. Энэхүү албан бус хэлэлцээрийн /уулзалт, зөвлөлгөөн, үйл ажиллагаанд/ үед гаргасан аливаа зөвлөмж, зөвлөлгөөг Талууд заавал биелүүлэх үүрэг хүлээхгүй ба мөн МЗШЗ нь албан бус хэлэлцээрийн үед гаргасан аливаа үзэл бодол эсхүл зөвлөмж зөвлөлгөөг амаар болон бичгээр гаргасан эсэхээс үл хамааран цаашдын Маргааныг шийдвэрлэх процесс болон шийдвэрт тусгах үүргийг мөн адил хүлээхгүй болно.
21.4 МЗШЗ-н шийдвэрлэх		Хэрвээ Талуудын хооронд Маргаан үүссэн тохиолдолд МЗШЗ-д аль ч Тал хандаж болох бөгөөд (21.3 дахь хэсэгт заасан албан бус яриа, хэлэлцээр өрнөсөн эсэхээс үл хамаарна) үүнд дараах заалтуудыг баримтлана. **21.4.1 <u>МЗШЗ-д хандах</u>** Талууд МЗШЗ-д хандаж маргааныг шийдвэрлүүлэхдээ дараах заалтуудыг дагаж мөрдөнө: (a) Хэрвээ Маргааны агуулга нь 3.7-д хамаарах бөгөөд 3.5.5-д заасны дагуу Татгалзасан мэдэгдлийг 42 өдөрт багтаан хүргүүлсэн эсхүл мэдэгдлийг хүлээн авсан бол МЗШЗ-д хандах эрхтэй байна. Хэрвээ энэхүү 42 өдөрт багтааж Маргааныг МЗШЗ-д гаргаж чадаагүй бол тэрхүү Үл зөвшөөрөх мэдэгдлийн хугацааг дууссан гэж үзэх бөгөөд цаашид хүчингүйд тооцно. (b) Энэхүү хэсэгт заасан нөхцөл байдал үүссэн болохыг тодорхойлж дурьдана. (c) Маргаантай холбоотой асуудлаар өөрийн нөхцөл байдлыг тодорхойлж тусгана. (d) Бичгээр үйлдэх бөгөөд гэрээний нөгөө Талд хуулбарыг хүргүүлнэ. (e) Гурван гишүүнтэй МЗШЗ-ийн хувьд албан ёсоор ирүүлсэн бүртгэлийн огноог МЗШЗ-ийн даргын хүлээн авсан өдрөөр бүртгэнэ. Хуулиар хориглоогүй бол энэхүү хэсэгт заасны дагуу МЗШЗ-д Маргаан гарах нь тоологдож буй аливаа хөөн хэлэлцэх хугацаа түр зогсох үндэслэл болно.

		21.4.2 <u>Маргаан үүссэнээр Талуудын хүлээх үүрэг</u> Талууд МЗШЗ-аас уг Маргааныг (21.4.1 дэх заалтын дагуу) шийдвэрлэхэд шаардагдах бүхий л мэдээлэл, Ажлын талбай болон зохих байгууламжуудад нэвтрэх эрхийг МЗШЗ-д олгоно. Гэрээ цуцлагдсан эсхүл Гэрээний үүргээ биелүүлээгүйгээс бусад тохиолдлуудад Талууд нь Гэрээнд заасан ажил үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх үүрэгтэй. **21.4.3 <u>МЗШЗ-ийн шийдвэр</u>** МЗШЗ нь доор заасан хугацаанд багтаан шийдвэрээ гаргаж, хүргүүлнэ: a) холбогдох баримт бичиг, мэдээллүүдийг хүлээн авснаас хойш 84 өдөрт багтаан; эсхүл (b) Шийдвэрлэх хугацааг МЗШЗ-ийн зүгээс санал болгож болох бөгөөд Талууд зөвшөөрсөн байх шаардлагатай. Дээр заасан хугацаа дуусгавар болох үед, хэрвээ аль нэг МЗШЗ-ийн гишүүний төлбөр/цалин олгох хугацаа дуусгавар болсон бөгөөд тэрхүү төлбөр төлөгдөөгүй үлдэгдэлтэй байвал МЗШЗ нь тухайн төлбөрийн үлдэгдэл төлөгдөж дуустал МЗШЗ-ийн шийдвэрийг хүлээлгэн өгөх үүргийг хүлээхгүй. Үлдэгдэл төлбөр төлөгдсөний дараа МЗШЗ шийдвэрээ аль болох шуурхай хүлээлгэн өгнө. МЗШЗ нь МЗШЗ-ийн шийдвэрийг Талуудад бичгээр хүргүүлэх бөгөөд уг шийдвэр нь үндэслэлтэй байх ба энэхүү Хэсэгт заасны дагуу хүргүүлж буйг дурьдах ёстой. Энэхүү Хэсэгт заасны дагуу шийдвэрийг гаргасантай холбогдуулан аль нэг Тал нь Үл зөвшөөрөх мэдэгдэл хүргүүлсэн эсэхээс үл хамааран Талууд уг шийдвэрийг нэн даруй дагаж мөрдөх, заавал биелүүлэх үүргийг хүлээнэ. Хэрвээ нэг Тал нь нөгөө Талд аливаа төлбөрийг барагдуулахаар МЗШЗ-ийн шийдвэрт тусгагдсан бол: (i) Доорх (ii) дэд хэсэгт заасныг харгалзан, уг төлбөрийг нэн даруй төлж барагдуулах үүрэгтэй бөгөөд аливаа баталгаа эсхүл Мэдэгдэл шаардахгүй.

		(ii) Тал нь хүсэлт гаргасан бөгөөд Төлбөрийн хүлээн авагч тал нь 21.6-д заасны дагуу шийдвэр цуцлагдсан тохиолдолд тухайн төлбөрийн дүнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг буцаан төлөх боломжгүй гэх үндэслэл бүхий шалтгаантай гэж МЗШЗ-ийн зүгээс гагцхүү үзсэн тохиолдолд МЗШЗ нь төлбөрийн дүнтэй тэнцэх хэмжээний зохих төлбөрийн баталгааг (МЗШЗ өөрийн үзэмжээр шийднэ) гаргахыг төлбөрийг хүлээн авагч талаас хүсэх (шийдвэрийн нэг хэсэг байдлаар) эрхтэй. МЗШЗ-ын ажиллагааг арбитрын ажиллагаа гэж үзэхгүй бөгөөд МЗШЗ нь арбитр(арбитрууд)ын ажил үүргийг гүйцэтгэх эрхгүй ба тэдний эрхийг эдлэхгүй. **21.4.4 <u>МЗШЗ-ийн шийдвэрийг үл зөвшөөрөх</u>** Хэрвээ МЗШЗ-ийн шийдвэрийг аль нэг Тал нь үл зөвшөөрвөл: (a) Үл зөвшөөрсөн Тал нь нөгөө Талдаа Үл зөвшөөрөх мэдэгдлийг хүргүүлэх бөгөөд МЗШЗ-д хуулбарыг хүргүүлнэ; (b) Уг мэдэгдлийн тэргүү нь “МЗШЗ-ийн шийдвэрийг үл зөвшөөрөх тухай” байх бөгөөд Маргаан бүхий асуудлууд болон үл зөвшөөрөх болсон шалтгаан(ууд)-ыг тодорхой дурьдана; (c) Энэхүү мэдэгдлийг МЗШЗ-ийн шийдвэрийг хүлээн авснаас хойш 28 өдрийн дотор хүргүүлнэ. Хэрвээ МЗШЗ нь 21.4.3 хэсэгт заасан хугацаанд багтаж шийдвэрээ хүргүүлээгүй бол аль нэг Тал нь энэхүү хугацаа дууссан өдрөөс хойш 28-н өдрийн дотор нөгөө Талдаа Үл зөвшөөрөх мэдэгдлийг дээр дурьдсан (a) болон (b) заалтуудад заасны дагуу хүргүүлнэ. 3.5.5 дахь хэсгийн сүүлийн цогцолбор, 21.7 болон 21.8 дугаар хэсгүүдэд тус тус зааснаас бусад тохиолдолд, тухайн Маргаантай холбоотойгоор 21.4.4-т заасны дагуу Үл зөвшөөрөх мэдэгдлийг гаргалгүйгээр гэрээний аль нэг Талаас Маргааныг шийдвэрлүүлэхээр арбитрт хандах эрхгүй. Хэрвээ МЗШЗ нь Маргаантай холбоотой шийдвэрээ Талуудад хүргүүлсэн бөгөөд Талууд МЗШЗ-ийн шийдвэрийг хүлээн авснаас хойш 28-н

		өдрийн дотор энэхүү 21.4.4-т заасны дагуу Үл зөвшөөрөх мэдэгдэл (ҮЗМ)-ийг ирүүлээгүй бол уг шийдвэрийг талууд хүлээн зөвшөөрсөнд тооцож, Талууд заавал биелүүлэх эцсийн шийдвэр болно. Хэрвээ үл зөвшөөрсөн мэдэгдэл гаргасан Тал нь МЗШЗ-ийн шийдвэрийн зөвхөн зарим хэсгийг үл зөвшөөрсөн бол: (i) уг үл зөвшөөрч буй хэсгийг Үл зөвшөөрөх мэдэгдэлд тодорхой тусгана; (ii) энэхүү үл зөвшөөрч буй хэсэг(хэсгүүд), мөн хамаарал бүхий эсхүл хөндөгдөх бусад хэсгүүдийг уг шийдвэрийн бусад хэсгүүдээс тусад нь тусгайлан авч үзнэ; (iii) үл зөвшөөрөх Мэдэгдэлд хамааралгүй Шийдвэрийн хэсгүүд нь Үл зөвшөөрөх мэдэгдэл (ҮЗМ) ирүүлсэн эсэхээс үл хамааран Талууд заавал биелүүлэх эцсийг шийдвэр байна.
21.5 Маргааныг эвийн журмаар шийдвэрлэх		21.4 дүгээр хэсэгт заасны дагуу Үл зөвшөөрөх мэдэгдлийг хүргүүлснээс хойш Талууд Арбитрийн ажиллагааг эхлүүлэхээс өмнө Маргааныг эвээр зохицуулахыг зорьж ажиллах үүрэгтэй. Гэвч, Талууд өөрөөр тохиролцсоноос бусад тохиолдолд Маргааныг эвээр зохицуулах оролдлого хийсэн эсэхээс үл хамааран Үл зөвшөөрөх мэдэгдлийг (ҮЗМ) хүргүүлснээс хойш 28 дахь өдөрт эсхүл түүнээс хойш арбитрын ажиллагааг эхлүүлж болно.
		Гэрээний 3.5.5, 21.4.4, 21.7, 21.8-д тус тус заасны дагуу эсхүл талууд эвээр шийдвэрлэснээс бусад тохиолдолд эцсийн шийдвэр болж албажаагүй МЗШЗ-ийн шийдвэртэй холбоотой аливаа Маргаан нь олон улсын арбитраар эцэслэгдэн шийдвэрлэнэ. Талууд өөрөөр тохиролцоогүй бол: a. Олон Улсын Худалдааны Танхимын Арбитрын ажиллагааны дүрмийн дагуу Маргааныг эцэслэн шийдвэрлэнэ; b. Тус Дүрмийн дагуу томилогдсон нэг эсхүл гурван арбитрчийн бүрэлдэхүүнтэйгээр Маргааныг эцэслэн шийдвэрлэнэ; c. Арбитрын ажиллагааг 1.4-т заасан хэлээр явуулна; Арбитрч нь аливаа гэрчилгээ, дүгнэлт (заавал болон эцсийн дүгнэлтээс бусад), заавар,

		Захиалагчийн төлөөлөгчийн санал эсхүл үнэлгээ /тодорхойлолт/ зэргийг болон Маргаантай холбоотой аливаа МЗШЗ-ийн шийдвэрийг (хүчин төгөлдөр эцсийн шийдвэрүүдээс бусад) хянах, өөрчлөх бүрэн эрхийг эдэлнэ. Захиалагчийн төлөөлөгч нь Маргаантай холбоотой аливаа асуудлаар арбитрт гэрчээр дуудагдах болон баримт нотолгоо гаргах бүрэн эрхтэй. Арбитрын ажиллагааны зардлыг хувиарлахдаа арбитрын зүгээс 21.1 болон 21.2 хэсгүүдэд заасны дагуу аль МЗШЗ-ийг томилоход аль Тал нь үүргээ биелүүлээгүй болохыг (хэрвээ байвал) харгалзан үзнэ. Арбитрын хянан шийдвэрлэх ажиллагаа нь МЗШЗ-ийн шийдвэрийг гарахаас өмнөх Талуудын гаргасан баримт болон нотолгоонууд, эсхүл 21.4 хэсэгт заасны дагуу Талуудын Үл зөвшөөрөх мэдэгдэл (ҮЗМ)-д дурьдагдсан үл зөвшөөрсөн тухай шалтгаануудаар үл хязгаарлагдана. МЗШЗ-ийн аливаа шийдвэр нь арбитрын ажиллагаанд нотлох баримт болно. Арбитрын ажиллагааг Ажлыг гүйцэтгэж дуусгахаас өмнө эсхүл дуусаны дараа эхлүүлж болно. Ажлын гүйцэтгэх явцад хийгдсэн аливаа арбитрын ажиллагаа нь Талууд, Инженер, МЗШЗ-ийн гэрээгээр хүлээсэн үүрэг, хариуцлага өөрчлөгдөх үндэслэл болохгүй. Хэрвээ нэг Тал нь нөгөө Талдаа төлбөр төлөх шийдвэр гарсан бол уг төлбөрийг дахин нэмэлт гэрчилгээ эсхүл Мэдэгдэл шаардалгүйгээр нэн даруй төлж барагдуулна.
21.7 МЗШЗ-н шийдвэрийг үл биелүүлэх		Гэрээний аль нэг Тал нь МЗШЗ-ийн заавал биелүүлэх аливаа шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд нөгөө Тал нь 21.6 хэсэгт заасны дагуу гомдолоо арбитрт шууд гаргах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд 21.4 болон 21.5 дахь хэсгүүд хамаарахгүй. Арбитрын хурлаас (21.6 дахь хэсэгт заасны дагуу) тодорхой заасан болон түр хугацаагаар дүгнэлт болон бусад шуурхай арга хэмжээг авах, тушаал шийдвэр гаргах (холбогдох хууль тогтоомжийн дагуу), улмаар тэрхүү шийдвэрээ даган мөрдүүлэх эрхтэй.

		Эцсийн бус байдлаар гаргасан МЗШЗ-ийн заавал даган биелүүлэх шийдвэр нь тодорхой болон түр хугацааны арга хэмжээ, шийдвэр нь Маргааныг бүрэн шийдвэрлэсэн шийдвэр гартал МЗШЗ-ийн шийдвэрийг хэрэгжүүлэхийг тогтоосон аливаа тодорхой эсхүл түр хугацааны шийдвэр буюу дүгнэлтийг биелүүлээгүй тохиолдолд тухайн шийдвэр, дүгнэлтийн заавал биелүүлэх эсхүл эцсийн эсэх байдлаас үл хамааран тухайн шийдвэр, дүгнэлтийг хохирлыг барагдуулах эсхүл нөхөн төлбөрийн шийдвэр, дүгнэлтэд тусгах эрхтэй.
21.8 МЗШЗ байгуулагдаагүй тохиолдол		Хэрвээ Талуудын хооронд Гэрээтэй холбоотой эсхүл Ажлыг гүйцэтгэхтэй холбоотой асуудлаар Маргаан өрнөсөн буюу үүссэн үед МЗШЗ бүрдээгүй (эсхүл байгуулагдаагүй) тохиолдолд, МЗШЗ-ийг томилох хугацааг дууссан гэж үзэх бөгөөд: a) 21.4 болон 21.5 дахь хэсгүүд үйлчлэхгүй; b) Талууд 21.6-д заасны дагуу арбитрт шууд хандан Маргаан үүсгэх эрхтэй.

МОНГОЛ УЛС

МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

БОЛОН

…….. УЛСЫН

“……” ХХК

НАРЫН ХООРОНД БАЙГУУЛСАН

НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТОД “ТУУЛЫН ХУРДНЫ ЗАМ” БАРИХ АЖЛЫН ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР

ГЭРЭЭНИЙ ДУГААР .....

ГЭРЭЭНИЙ ДУГААР .....

УЛААНБААТАР ХОТ

2025 он

ЗАХИАЛАГЧ ГҮЙЦЭТГЭГЧ

НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТОД “ТУУЛЫН ХУРДНЫ ЗАМ” БАРИХ АЖЛЫН ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР

2025 оны ... сарын ...-ны өдөр | Дугаар ... Дугаар .... | Улаанбаатар хот

Энэхүү **ГЭРЭЭГ** дор дурдсан **ТАЛУУД** харилцан тохиролцож байгуулав.

Нэг талаас: Монгол улс, Улаанбаатар, Хан-Уул дүүрэг,23-р хороо, Арцатын ам, Наадамчдын зам 1200 тоот хаягт байрлах Нийслэлийн Засаг даргын тамгын газар (цаашид "Захиалагч" гэх), түүнийг төлөөлж ……;

Нөгөө талаас: …… хаягт байрлах “……” ХХК (цаашид “Гүйцэтгэгч” гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал …… нар

A. Монгол Улсын Их Хурлын ……

B. Монгол улсын Засгийн газрын ……

C. Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ……

D. Нийслэлийн засаг даргын …….. тогтоол, шийдвэрийг

E. Захиалагч нь 2025 оны .. сарын …-ны өдрийн …….. дугаартай тендер зарласныг

F. Гүйцэтгэгчийн 2025 оны … сарын …-ны өдрийн ……. Дугаартай тендер ирүүлсэнийг

G. Захиалагчийн зүгээс 2025 оны … сарын …-ны өдөр Гүйцэтгэгч болох …….. нь тус тендер шалгарсан талаарх мэдэгдлийг хүргүүлсэнийг тус тус үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

Талууд дараах гол нөхцөлийг тохиролцов. Үүнд:

1. Гэрээний ерөнхий хэлэлцээрийн үг хэллэг нь Гэрээний нөхцөлийн үг, хэллэгтэй утга болон агуулгын хувьд нэг байна.
2. Гэрээг бүрдүүлж буй баримт бичгүүд нэг нь нөгөөгөө тайлбарлах бөгөөд баримт бичгийн давуу байдлын хувьд дараах байдлаар эрэмбэлэгдэнэ.
   - 2.1. Эрх бүхий этгээдээс олгосон зөвшөөрөл;
   - 2.2. Тендерт шалгарсан талаарх мэдэгдэл;
   - 2.3. Гэрээний ерөнхий хэлэлцээр;
   - 2.4. Гэрээний тусгай нөхцөл;
   - 2.5. Гэрээний ерөнхий нөхцөл (ГЕН);
   - 2.6. Гэрээний нөхцөлийн хавсралт 1 [*Захиалагчийн шаардлага*];
   - 2.7. Гэрээний нөхцөлийн хавсралт 2 [*Гэрээний үнэ, төлбөр, ажлын тоо хэмжээ*];
   - 2.8. Гэрээний нөхцөлийн хавсралт 3 [Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон нийгмийн удирдлага];
   - 2.9. Гэрээний нөхцөлийн хавсралт 4 [Ажил гүйцэтгэхэд шаардагдах зөвшөөрөл, арга хэмжээг авч хэрэгжүүлэхтэй холбоотой үүргийн матриц];
   - 2.10. Гэрээний нөхцөлийн хавсралт 5 [Ажлын хуваарь];
   - 2.11. Гэрээний нөхцөлийн хавсралт 6 [Дотоодын нөөц ашиглах шаардлага];

2.12. Тендер шалгаруулалтын баримт бичиг;

2.13. Гүйцэтгэгчийн зүгээс гаргасан тендер;

2.14. Гэрээний нөхцөлийн бусад хавсралтууд;

2.15. Дагалдах бусад баримт бичиг

3. Энэхүү **Гэрээний нийт үнэ нь** НӨАТ орсон, нийт үнэд үндэслэсэн (LUMP SUM) …….. (……..) төгрөг байна.

4. Энэхүү хэлэлцээрийн 7-д заасан үнээс Гүйцэтгэгчид төлөх Ажлын нийт төлбөр нь Захиалагчийн хяналтын зардал, Магадлашгүй ажлын зардал /Магадлашгүй ажил гараагүй тохиолдолд/ хассан дүн байх бөгөөд Захиалагч гэрээт Ажлын төлбөрийг Гэрээнд заасан нөхцөлөөр Гүйцэтгэгчид бүрэн төлөх үүрэг хүлээнэ.

5. Энэхүү хэлэлцээр Талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

6. Гэрээг Монгол хэлээр 2 эх хувь үйлдэх бөгөөд Талууд тус бүр нэг хувийг хадгалагдана.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧ НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:	ГҮЙЦЭТГЭГЧ “.....” ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	

.....

2025 оны ... дугаар сарын ...-ний өдөр

2. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЭРЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

Зүйл, заалт	Нөхөх мэдээлэл	Мэдээлэл
1.1.14	Гүйцэтгэгчийн талаарх мэдээлэл	**Нэр**: **Хаяг**: **Утас**: **Цахим шуудан**:
1.1.24	Доголдол мэдэгдэх хугацаа	36 сар
1.1.27	Захиалагчийн мэдээлэл	**Нэр:** “Нийслэлийн засаг даргын тамгын газар” **Хаяг:** Монгол улс, Улаанбаатар, Хан-Уул дүүрэг,23-р хороо, Арцатын ам, Наадамчдын зам 1200 **Утас:** (+976) 11-328922 **Цахим шуудан:** …
1.1.30	Захиалагчийн төлөөлөгчийн талаарх мэдээлэл	Нийслэл Улаанбаатар хотын автозамын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн төслийн менежер ..... Хаяг: Цахим шуудан:
1.1.37	Гадаадын мөнгөн тэмдэгт	Ам.доллар
1.1.76	Ажил дуусах хугацаа	2027 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр 24 сар буюу 720 хоног
1.3 (a)(ii)	Цахим баримт бичиг илгээх арга	Гэрээний мэдээлэлд заасан албаны цахим шуудан
1.3 (d)	Захиалагчийн холбоо барих хаяг	Гэрээний мэдээллийн 1.1.27-д заасан албан ёсны хаяг
	Захиалагчийн төлөөлөгчийн холбоо барих хаяг	Тусгай зохицуулалтын 1.1.30-д заасан албан ёсны хаяг
	Гүйцэтгэгчийн холбоо барих хаяг	Гэрээний мэдээллийн 1.1.14-т заасан албан ёсны хаяг
1.4	Хэрэглэгдэх хууль тогтоомж	Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж
	Гэрээний хэл	Монгол хэл, Англи хэл
	Талуудын харилцах хэл	Монгол хэл
1.8	Гүйцэтгэгчийн баримт бичгийг үйлдэх тоо	Цаасан 3 хувь, цахим 1 хувь
2.1	Гүйцэтгэгчид ажлын талбайд нэвтрэх эрх олгох өдөр	Ажил эхлүүлэх өдрөөс хойш 14 хоногт багтаан ажлын талбайг хүлээлгэн өгөх
4.2	Гүйцэтгэлийн баталгаа гэрээний нийт үнийн дүнгийн	5%
4.4 (a)	Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болох ажлын дээд хэмжээ	Гэрээний нийт үнийн дүнгийн 20%

4.4 (b)	Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхийг хориглох ажлын жагсаалт	• Гүүрийн барилгын ажил • Асфальтбетон хучилтын ажил
4.20	Явцын тайланг хүргүүлэх цаасан нэмэлт хувийн тоо	3 хувь
8.3	Ажлын график төлөвлөгөөг хүргүүлэх нэмэлт цаасан хувийн тоо	3 хувь
8.8	Хоногт тооцох алдангийн хэмжээ:	Гэрээний нийт үнийн дүнгийн 100 сая төгрөг
	Алдангийн дээд хязгаар:	Гэрээний нийт үнийн дүнгийн 10 хувь
14.2	Урьдчилгаа төлбөрийн дүн	Гэрээний нийт үнийн дүнгийн 10 хувь
	Урьдчилгаа төлбөрийг төлөх мөнгөн тэмдэгт	Төгрөг
14.3 iii	Суутган барих мөнгөн дүнгийн хэмжээ	Төлбөр тус бүрийн 5 хувь
14.3 iii	Суутган барих мөнгөн дүнгийн дээд хязгаар	Гэрээний нийт үнийн дүнгийн 5 хувь
14.6.2	Явц дундын төлбөрийн хүсэлт хүргүүлэх хамгийн бага хэмжээ	Гэрээний нийт үнийн дүнгийн 3 хувь
14.11. (b)	Эцсийн төлбөрийн хүсэлтийн төсөл хүргүүлэх хувь	Цаасан 3 хувь, цахим 1 хувь
14.15	Төлбөр төлөх мөнгөн тэмдэгт	Төгрөг
21.1	МЗШЗ-ийн бүрэлдэхүүн	3 гишүүнтэй байна.

2.(Б). ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1.1.18. Тухайн улс /өөрчлөх/	“**Тухайн улс**” гэж Монгол Улсыг ойлгоно.
1.1.19 Маргаан шийдвэрлэх зөвлөл /өөрчлөх/	Маргаан шийдвэрлэх зөвлөл буюу МШЗ нь Гэрээний тусгай нөхцөлд заасан эсхүл 21 дүгээр зүйлийн дагуу томилогдсон гурван гишүүнийг хэлнэ. Энэхүү гэрээнийн ерөнхий нөхцөлд МЗШЗ гэж заасныг МШЗ хэмээн ойлгоно.
1.4 Гэрээний хэл болон хууль	Гэрээний энэхүү заалтын төгсгөлд дараах агуулгыг нэмэх: Ажлын тайлан, гүйцэтгэлийн зураг, гүйцэтгэлийн тайлан, техникийн баримт бичиг, зураг төсөл, гарын авлага зэрэг Ажлыг улсын комисст хүлээлгэн өгөхөд шаардлагатай бүхий л баримт бичгийг Англи, Монгол хэлээр үйлдэнэ.
1.7. Эрх шилжүүлэх	Гэрээний энэхүү заалтын (b) хэсгийг хасахаар тохиролцов.
1.8. Баримт бичгийг хадгалах, шилжүүлэх	Энэ хэсгийн сүүлийн догол мөрийн араас дараахь нэмэлтийг оруулах: Гүйцэтгэгч нь энэхүү хэсэгт дурдсан баримт бичгүүдээр хязгаарлагдахгүйгээр Гэрээний дагуу хүлээсэн үүрэгтэйгээ холбоотойгоор олж авсан, өөрөө бий болгосон, эсхүл өөрийн нэрийн өмнөөс хийлгэсэн бичгээр үйлдсэн бүх баримт бичиг, зураг, Техникийн шаардлагууд, график материал, гэрэл зураг, загвар (3D бодит загварыг оруулаад) болон бусад бүх мэдээллүүдэд нэвтрэх боломжоор Захиалагчийг хангана. Захиалагч нь ажлын талбай дээр хадгалагдаж буй баримт бичигтэй танилцахын тулд шаардлагатай үед, эсхүл ажлын цагаар нэвтрэх эрхтэй бөгөөд Гүйцэтгэгч нь цахим хэлбэрээр хагдалагдсан барим бичигтэй танилцах үед компьютер, программ хангамж болон шаардлагатай бусад хэрэгслээр хангах үүрэгтэй.
1.9. Гүйцэтгэгчийн баримт бичгийг Захиалагч ашиглах	Гэрээний энэхүү хэсэгт дараах зохицуулалтыг нэмэх. Гэрээ болон ажил гүйцэтгэхтэй холбоотой Гүйцэтгэгчийн боловсруулсан баримт бичгийг Захиалагч шаардан авах эрхтэй бөгөөд Гэрээний хүрээнд Гүйцэтгэгчийн боловсруулж Захиалагч, төрийн эрх барих байгууллага, албан тушаалтанд хүргүүлж буй аливаа баримт бичиг нь Монгол хэл дээр байна. Монгол хэлээс өөр гадаад хэлээр бэлтгэсэн аливаа баримт бичгийг албан ёсны орчуулгын эрх бүхий этгээдээр Монгол хэлрүү орчуулан, тамга даруулж баталгаажуулна.
1.12. Хууль тогтоомжид нийцүүлэх	Гэрээний энэхүү заалтын (b) хэсэгт дараах агуулгыг нэмэхээр тохиролцов.

	“Хүсэлт” гэж Гүйцэтгэгч гэрээгээр өөрийн болон Захиалагчийн төрийн байгууллагаас авсан тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийг сунгахтай холбоотой аливаа албан хүсэлт, албан бичгийг ойлгоно.
2.4. Захиалагчийн санхүүжилт	Гэрээний 2.4 дүгээр зүйлийг дараах байдлаар өөрчлөхөөр тохиролцов. Гүйцэтгэгч төслийг бүхэлд нь буюу төслийн зураг төсөл, худалдан авалт, барилга угсралтын санхүүжилтийг өөрийн эх үүсвэрээр урьдчилан санхүүжүүлэх бөгөөд ийнхүү урьдчилан санхүүжүүлсэн мөнгөн дүнг явц дундын төлбөрийн гэрчилгээгээр баталгаажуулна. Захиалагч Гүйцэтгэгчийн өөрийн эх үүсвэрээр урьдчилан санхүүжүүлсэн төлбөрийг гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 4 жилийн хугацаанд төсөвт хуваан суулгаж аливаа хүү, шимтгэл, нэмэгдэлгүйгээр хуваан төлнө.
4.4 Туслан гүйцэтгэгч	Гэрээний 4.4 дүгээр зүйлийн төгсгөлд дараах агуулгыг нэмэхээр тохиролцов. Гүйцэтгэгч нь гэрээгээр хийж гүйцэтгэхээр тохиролцсон ажилд ашиглах машин, механизмын 60-аас доошгүй, үндсэн бараа, материалын 20-иос доошгүй хувийг Монгол улсад бүртгэлтэй, Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг дотоодын нийлүүлэгчээс авна.
4.20. Ажлын явцын тайлан	Энэхүү хэсэгт дараах зохицуулалтыг сүүлийн догол мөрийн араас дараах агуулгыг нэмэх: Дээр дурдсан тайлангуудаас гадна Гүйцэтгэгч нь Гэрээний Хавсралт 1 [Захиалагчийн шаардлага]-д дурдсан тайлангуудыг, түүнд заасан хугацаанд боловсруулан Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
5.1 Зураг төслийн ерөнхий үүрэг	5.1 дүгээр зүйлийн араас дараах агуулгыг нэмэх: Гүйцэтгэгч өөрийн боловсруулсан зураг төслийг Монгол хэлээр орчуулан, холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцэж байгаа эсэхийг дотоодын зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр хянуулахтай холбоотойгоор дараах үүргийг хүлээнэ. Үүнд: Захиалагч нь төрийн эрх барих байгууллагаас ажлын даалгаварыг авч гүйцэтгэгчид өгөх бөгөөд төрийн эрх барих байгууллага, албан тушаалтнаас авах холбогдох зөвшөөрөл, шийдвэрт дэмжлэг үзүүлнэ. Гүйцэтгэгч нь Монгол улсын хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн байдлаар зураг төслийг боловсруулж холбогдох төрийн эрх барих байгууллага, албан тушаалтнаар батлуулах, шаардлагатай бусад арга хэмжээг авах үүрэгтэй.

	Захиалагчийн зүгээс Гүйцэтгэгчид хүлээлгэн өгсөн аливаа зураг төслийн үнэн зөв байдлыг Захиалагч хариуцахгүй бөгөөд Гүйцэтгэгч нь тухайн зураг төслийг хянах, шалгах, шаардлагатай тохиолдолд засварлах үүргийг хүлээнэ.
5.2.1 Гүйцэтгэгчийн бэлтгэл ажил	5.2.1 дэх зүйлийн төгсгөлд дараах агуулгыг нэмэх. Гүйцэтгэгч нь Монгол улсын хууль тогтоомжид заасан шаардлагатай баримт бичгийг Архивт хүлээлгэн өгөх зорилгоор Монгол хэл дээр орчуулж, боловсруулж, хадгална.
5.2.3 Барилга угсралт	Бүхий л далд ажлыг дотоодын зураг төсөл зохиогч, Захиалагчийн төлөөлөгч холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхд хяналт тавьж, баталгаажуулсаны дараагаар барилга угсралтыг гүйцэтгэнэ.
6.7. Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал	Энэ хэсгийн сүүлийн догол мөрийн араас дараах зохицуулалтыг нэмэх: Гэрээний хавсралт 1 [Захиалагчийн шаардлага] ба Хавсралт 3 [Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон нийгмийн удирдлага]-д заасан Ажлын талбайд мөрдөх журмуудыг Талууд боловсруулан, дагаж мөрдүүлнэ. Гүйцэтгэгч эдгээр журмуудыг туслан гүйцэтгэгч болон Ажлын талбайд ажиллаж буй бусад этгээдүүдэд хуулбарлан өгч, дагаж мөрдүүлэх ажлыг хариуцан ажиллана. Эдгээр журмуудад дараах асуудлуудтай холбоотой журмууд багтсан байх ба үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд: a. Ажлын талбайн харуул хамгаалалт; b. Эрүүл мэнд, аюулгүй байдал; c. Галын аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх.
6.9. Гүйцэтгэгчийн ажилтан	Гэрээний энэхүү нөхцөлийн төгсгөлд дараах агуулгыг нэмэхээр тохиролцов. Гүйцэтгэгчийн нийт ажиллах хүчний 20-иос доошгүй хувь нь Монгол улсын иргэн байна.
6.12. Голлох мэргэжилтэн	Гэрээний энэхүү хэсгийн эхний өгүүлбэрийг дараах байдлаар өөрчилөхөөр тохиролцов. Гүйцэтгэгчийн голлох мэргэжилтэнүүд нь Тендер шалгаруулалтын баримт бичигт заасан Гүйцэтгэгчийн голлох мэргэжилтэний жагсаалт, түүнд тавигдах шаардлагад нийцсэн байна.
9.1. Гүйцэтгэгчийн үүрэг	Энэ хэсэгт дараах зохицуулалтыг нэмэх: Холбогдох хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандарт Гэрээний нөхцөлийн Хавсралт 1 [*Захиалагчийн шаардлага*]-т заасны дагуу Ажил болон Багц ажлын туршилтыг гүйцэтгэнэ.

9.3. Давтан хийх туршилт /Нэмэх/	Энэ хэсэгт дараах зохицуулалтыг сүүлийн догол мөрийн араас дараах агуулыг нэмэх: Гүйцэтгэгч нь давтан туршилт хийхийн өмнө Ажлын доголдолыг хэрхэн засаж, сайжруулсан талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Захиалагчид ирүүлэх ба уг сайжруулалтыг өөрийн зардлаар, боломжит богино хугацаанд хийж гүйцэтгэнэ.
10.1. Ажил буюу хэсэг ажлыг хүлээн авах /нэмэх/	Энэ хэсэгт дараах агуулгыг сүүлийн догол мөрийн араас нэмэх: Захиалагч Ажлыг хэсэгчлэн хүлээн авч болно.
13.4. Магадлашгүй ажлын зардал /өөрчлөх/	Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, төслийн ТЭЗҮ болон Гэрээний Хавсралт 2-т заасан “Магадалшгүй ажлын зардал”-ыг зарцуулах зориулалт, журам энэхүү хэсэгт үйлчилнэ.
13.7 Үнийн тохируулга	Гэрээний 13.7 дахь хэсгийн төгсгөлд дараах агуулгыг нэмэхээр тохиролцов. Гэрээний үнэд шатахуун болон Барааны (цемент, арматураас бусад бараа) зах зээлийн үнийн өөрчлөлтөөс үүдэлтэй үнийн тохируулга, өөрчлөлт оруулахгүй бөгөөд Гүйцэтгэгч шатахууны үнийн хэлбэлзлийн эрсдлийг дангаар хариуцана.
14.2.3 Урьдчилгаа төлбөрийг буцаан суутгах	Гэрээний 14.2.3-ийн (a) хэсгийн “10 хувь” гэснийг 5 хувь болгож, (b) хэсгийн “25 хувь” гэснийг 20 хувь болгож өөрчлөхөөр тохиролцов.
14.4 Төлбөрийн хуваарь /өөрчлөх/	Гэрээний энэхүү заалтыг доор дурдсан байдлаар өөрчлөхөөр тохиролцов. Гэрээний дагуу төлөх төлбөрийг Гэрээний хавсралт 2-т заасаны дагуу Захиалагч нь Гүйцэтгэгчид төлнө.
14.6. Явц дундын төлбөр	Гэрээний энэхүү заалтыг хэрэглэхгүй бөгөөд тус харилцаа Гэрээний хавсралт 2-р зохицуулагдана.
14.7. Төлбөр	Гэрээний энэхүү заалтын (b) болон (c) хэсгийг хэрэглэхгүй.
14.8 Алданги	Гэрээний энэхүү заалтыг хэрэглэхгүй.
14.13 Эцсийн төлбөр	Гэрээний энэхүү заалтыг хэрэглэхгүй.
19.1 болон 19.2. Даатгал	Талууд Барилгын тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжид заавал хамрагдахаар заасан (гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирч болзошгүй хохирлын

/өөрчлөх/	даатгал, мэргэжлийн хариуцлагын даатгал г.м) даатгалд өөрсдийн зардлаар хамрагдах үүрэг хүлээх бөгөөд ийнхүү даатгуулах үүргээ биелүүлээгүйгээс учирсан аливаа эрсдэлийн үр дагаварыг бие дааж хариуцна. Барилгын үйл ажиллагаанд оролцогч аль нэг талын даатгалд хамрагдахтай холбоотойгоор үүссэн зардал, хариуцлагыг бусад талууд хамтран хариуцахгүй. Гүйцэтгэгч нь ажлын талбай дахь үер, усны эрсдэлийг даатгуулах үүрэгтэй бөгөөд Захиалагч болон гуравдагч этгээдийг тухайн эрсдэлээс шалтгаалсан аливаа эрсдэл, хохиролоос ангид байлгана.
21.1.[1] Маргааныг урьдчилан шийдвэрлэх /нэмэх/	Талуудын хооронд Маргаан үүссэн тохиолдолд Талууд энэ талаар нөгөө Талдаа бичгээр мэдэгдэл хүргүүлж, харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэх ажиллагааг эхлүүлнэ. Дээр дурдсаны дагуу Маргаан үүссэн тухай мэдэгдэл хүргүүлснээс хойш 14 хоногт багтаан тухайн Маргааныг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэж чадаагүй бол, аль нэг Тал тухайн Маргааныг Тал тус бүрийн гүйцэтгэх удирдлага, түүнээс дээш түвшний удирдлагыг хэрэгжүүлэгч нараас ус тус тэнцүү тоогоор бүрдсэн удирдлагын хороогоор шийдвэрлүүлэх хүсэлтийг нөгөө Талдаа бичгээр гаргана. Үүний дагуу тухайн хүсэлтийг бичгээр хүргүүлснээс хойш 21 хоногийн дотор үүссэн Маргааны талаар бичгээр шийдвэр гаргахаар Талуудын тохиролцож тогтоосон газарт цуглан хуралдана. Удирдлагын хороо Маргааныг дүгнэсэн шийдвэр гаргах хугацааг харилцан тохиролцож сунгаж болно. Удирдлагын хороо уг 21 хоног эсхүл харилцан тохиролцож сунгасан хугацаандаа багтаан Маргаантай асуудлаар санал нэгдэж чадвал энэ тухай шийдвэрээ бичгээр гаргаж, тус хорооны нийт гишүүд маргааныг шийдвэрлэсэн болохоо илэрхийлж гарын үсэг зурж баталгаажуулна. Удирдлагын хороо Маргааныг ийнхүү шийдвэрлэж чадаагүй эсхүл хорооны шийдвэрийн талаар талууд маргасан тохиолдолд, маргааныг ГЕН-ийн 21.1 дэх хэсэгт заасан журмыг баримтлан шийдвэрлүүлэх ажиллагааг явуулах бөгөөд уг урьдчилсан шийдвэрлэх ажиллагааг Маргаан шийдвэрлэх зөвлөл ажиллуулахаас өмнө явуулсан байна.
21.1. МШЗ-ийг томилох /өөрчлөх/	Маргаан шийдвэрлэх зөвлөл 3 (гурван) гишүүнтэй байна. Талууд Маргаан шийдвэрлэх зөвлөлийн гишүүнийг ФИДИК-ийн албан ёсны цахим хуудаст байршуулсан маргаан шийдвэрлэгч нараас сонгох бөгөөд ийнхүү сонгохдоо Талууд тус бүр нөгөө Талтайгаа харилцан зөвшилцөж тус бүр нэг гишүүнийг санал болгоно. Тэдгээр сонгогдсон гишүүдтэй Талууд зөвшилцсөний үндсэн дээр гурав дахь гишүүнийг сонгох бөгөөд энэхүү гурав дахь гишүүн нь МШЗ-ийн даргаар томилогдоно. Маргаан үүсгэж буй тал МШЗ-ийн зардалыг хариуцна.
21.2. МШЗ-ийн гишүүдийг томилон ажиллуулахтай	Энэ хэсгийг дараах агуулгаар өөрчлөх: Маргаан шийдвэрлэх зөвлөлийг Талууд харилцан зөвшилцөж томилж чадаагүй тохиолдолд ФИДИК-ийн Ерөнхийлөгч эсхүл

холбоотойгоор санал зөрөх /өөрчлөх/	түүнээс эрх олгосон этгээдээр МШЗ-ийн гишүүнийг сонгуулж томилно.
21.3. Маргаанаас зайлсхийх	Гэрээний ерөнхий нөхцөлийн энэ заалтыг хэрэглэхгүй.
21.4. МШЗ-ийн шийдвэрийг гардан авах	Тус зүйлийн эхний догол мөрийн “Хэрэв талуудын хооронд маргаан үүссэн тохиолдолд” гэсний араас “МШЗ томилогдсоны дараагаар” хэмээн нэмэх; “(21.3 дахь хэсэг [Маргаанаас зайлсхийх]-т заасан албан бус яриа, хэлэлцээр өрнөсөн эсэхээс үл хамаарна)” гэснийг хасах
21.6. Арбитр /өөрчлөх/	Энэ хэсгийг дараах агуулгаар өөрчлөх: Энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой бүх маргааныг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ. Арбитр нь аливаа гэрчилгээ, дүгнэлт, заавар, Инженерийн санал эсхүл үнэлгээ /тодорхойлолт/ болон Маргаантай холбоотой аливаа МШЗ-ийн шийдвэрийг хянах, өөрчлөх бүрэн эрхийг эдэлнэ. Инженер нь Маргаантай холбоотой аливаа асуудлаар арбитрт гэрчээр дуудагдах болон баримт нотолгоо гаргах бүрэн эрхтэй. Арбитрын ажиллагааны зардлыг хувиарлахдаа арбитрын зүгээс 21.1 [МШЗ байгуулах] эсхүл 21.2 [МШЗ-ийн гишүүний томилгоо амжилтгүй болох] хэсгүүдэд заасны дагуу аль МЗШЗ-ийг томилоход аль Тал нь үүргээ биелүүлээгүй болохыг харгалзан үзнэ.

ЭНЭХҮҮ ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛТЭЙ ТАНИЛЦАЖ,
ЗӨВШӨӨРСӨН ТАЛУУДЫН ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД:

ЗАХИАЛАГЧ НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:	ГҮЙЦЭТГЭГЧ “.....” ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

.....

2025 оны ... дугаар сарын ...-ний өдөр

ЗАХИАЛАГЧ ГҮЙЦЭТГЭГЧ

ХАВСРАЛТ №1

ЗАХИАЛАГЧИЙН ШААРДЛАГА

/“.....” болон “.....” ХХК-ийн хооронд 2025 оны __ дугаар сарын __-ны өдөр байгуулав./

ХАВСРАЛТЫН БҮРДЭЛ ХЭСЭГ

А хэсэг. Ерөнхий шаардлага

Б хэсэг. Техникийн шаардлага

ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛИЙН ХАВСРАЛТ №1-А ХЭСЭГ.
ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

1. ТӨСЛИЙН СУУРЬ МЭДЭЭЛЭЛ БА ЗОРИЛГО

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 08 сарын 23-ны өдрийн 307 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/1326 тоот захирамжаар Туулын хурдын замыг барихаар шийдвэрлэсэн. Туулын хурдны замын зураг төсөл, барилга угсралт, худалдан авалтын ажил нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт болон эрх бүхий байгууллагаас гаргасан тушаал, тогтоолд нийцүүлэн гүйцэтгэнэ.

Захиалагч нь Туулын хурдны замын техник эдийн засгийн үндэслэл (“ТЭЗҮ”)-ийг 2025 оны 01 дүгээр сард батлуулж, магадлуулсан. Энэхүү ТЭЗҮ нь төслийн гол баримтлах баримт бичиг байна.

Улаанбаатар хотод бүртгэлтэй автомашины тоо 2023 онд 697.870 мянга хүрсэн нь бол энэ тоо 2014 онд 443.793 мянга байсан, өөрөөр хэлбэл өнгөрсөн 9 жилд хотын автомашины тоо 57% өссөн байна. Улаанбаатар хотын төв болон туслах замын хөдөлгөөний эрчим ба нэвтрүүлэн өнгөрүүлэх чадварын харьцаа VCR нь 1-тэй ойролцоо буюу 1-ээс их болж, хотын төвийн хэсгийн гудамжны хөдөлгөөний аяллын хурд 5-20 км/цаг хүртэл унаж, үйлчилгээний чанарын үзүүлэлт LOS “F” түвшинд хүртэл байна. Энэ нь хотын хөдөлгөөний аюулгүйн нөхцөл бүрэн алдагдаж, хотын ихэнх замын үйлчилгээний шаардлага хангахаа больсон байна. Улаанбаатар хотод хөдөлгөөний түгжрэл гамшгийн хэмжээнд хүрч байна.

Энэ бүхнийг харгалзан Туулын хурдын замын хөдөлгөөний зурвасыг 6 эгнээ болгох, трассын зарим хэсэгт өөрчлөлт оруулах зэрэг өөрчлөлтүүд тусган зураг төслийг өөрчлөх хэрэгцээ шаардлага үүссэн бөгөөд энэ нь “20 минутын хот”, “алсны хараа 2050”, “бүсчилсэн хөгжлийн бодлого зорилт” зэрэг төрийн бодлого хөтөлбөрүүдэд нийцэж, Улаанбаатар хотыг 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд Улаанбаатар хот хурдын замын сүлжээтэй байхаар тусгагдсан бөгөөд түүний нэг хэсэг нь Туулын хурдын зам юм.

Туулын хурдны зам нь Налайхын замын Улиастайн буцаж эргэх хэсгээс Дархан, Эмээлтийн замын уулзвар хүртэл 32 орчим км урттай, 6 эгнээтэй, 7 олон түвшний орц, гарцны огтлолцлуудтай, 3 олон түвшний огтлолцолтой, 9877.88 метр орчим урт гүүртэй, 7 туннелтэй 100 км/ц хурдлах боломжтой, хамгийн бага радиус 800 метр, хамгийн их радиус 4500 метр, авто машины зорчих хэсгийн өргөн 12.5 метртэй, Монгол Улсад мөрдөгдөж буй Авто зам төсөллөх “БНбД 32-01-16” норм ба дүрэмд зааснаар 1А зэрэглэлийн хурдны авто зам байна.

Төслийн иж бүрдэлд дараах ажлууд багтана. Үүнд:

1. Газар шорооны ажил (Далан, ухмал, суваг шуудуу)
2. Хиймэл байгууламж (Гүүр, хоолой, туннель)
3. Авто замын дагуух үерийн хамгаалалтын далан
4. Авто замын гэрэлтүүлэг, авто замын трасст орсон ЦШС-г хамгаалах, шилжүүлэх, дэд станц шилжүүлэх, шинээр барих ажил

5. Мэдээлэл холбооны төлөвлөлт /холбооны сувагчлал, кабель шилжүүлэх, шинээр барих, камержуулалт, тоног төхөөрөмж, программ хангамж/-ийн ажил
6. Археологи, палеонтологи, түүх угсаатны хайгуул, судалгаа, авран хамгаалах, малтлагын ажил
7. Байгаль орчин хамгаалах ажил

2. ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. Ерөнхий

Туулын хурдны замын зураг төсөл, худалдан авалт, барилга угсралтын ажлыг (Хавсралт №2-т заасан) гүйцэтгэх ажлыг Хавсралт №5-д заасан хуваарийн дагуу гүйцэтгэж Захиалагчид хүлээлгэн өгөхтэй холбоотой гэрээний харилцаанд тавигдах Захиалагчийн шаардлагыг энэхүү хавсралтаар тодорхойлно. Хууль, Гэрээнд өөрөөр заагаагүй бол, Гүйцэтгэгч ТЭЗҮ-д заасан бүхий л зураг төсөл, худалдан авалт, барилга угсралтын ажлыг чандлан мөрдөн, баримталж гүйцэтгэнэ. Захиалагч ТЭЗҮ-ийг Гүйцэтгэгчид өгөх ба Гүйцэтгэгч ТЭЗҮ-г бүрэн судалсан байна.

Гүйцэтгэгч нь дээр дурдсан бүтээн байгуулалтын Ажлыг Гэрээний нөхцөлийн Хавсралт №1-Б хэсэгт заасан техникийн шаардлагад нийцүүлэн гүйцэтгэхдээ дээр дурдсан зорилгыг бүрэн ухамсарлаж, үүсэх үүрэг, хариуцлага, эрсдэлийг хүлээн зөвшөөрч дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- Зураг төсөл, худалдан авалт, барилга угсралтын ажлын хүрээнд Хавсралт №2-т заасан тоо хэмжээнд үндэслэн Туулын хурдны авто зам түүний иж бүрдлийн зураг төсөл, худалдан авалт, барилга угсралт, үйлдвэрлэл, суурилуулалт, туршилтыг гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгөх, зүгшрүүлэх, доголдол арилгах;
- Гүйцэтгэгч нь авто замын ажлыг бусад дэд бүтэц, бүтээн байгуулалттай уялдуулан барилгын ажлыг хийж гүйцэтгэх;
- Гүйцэтгэгч нь дээрх гүйцэтгэсэн ажлыг Захиалагчид бүхэлд нь хүлээлгэн өгөх, зүгшрүүлэлтийг Захиалагчийн хяналтан дор хариуцан гүйцэтгэх;
- Гэрээний Хавсралт №5-т заасан хугацаанд Захиалагчийн шаардлагийг бүрэн хангасан хурдны авто замын иж бүрдэлийг Захиалагчид хүлээлгэн өгөх.

Зураг төсөл, худалдан авалт, барилга угсралт, суурилуулалт, туршилт ба хүлээлгэн өгөх, зүгшрүүлэх, доголдол арилгах ажлыг Монгол Улсын хууль, дүрэм, журам, норм, холбогдох стандарт, Захиалагчийн шаардлага, Засгийн газрын зохицуулалтын дагуу гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч нь Ажилд гарсан алдаа доголдлыг бүрэн хариуцаж Гэрээнд заасан хугацаанд холбогдох стандарт, норм, дүрэм, шаардлагын дагуу засаж залруулан Захиалагчид бичгээр мэдэгдэнэ.

2.2. Үндсэн шаардлагууд

Гүйцэтгэгч нь Захиалагчийн өгсөн баримт бичгийг ашиглахаас өмнө тухайн мэлээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг нягталж, баталгаажуулна. Гүйцэтгэгч

нь зураг төсөл, барилгын ажилд зайлшгүй шаардлагатай гэж үзсэн нэмэлт хэмжилт, хайгуул судалгаа зэргийг өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч нь зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлыг Гэрээний нөхцөлийн Хавсралт №5-д заасан болон Гэрээнд заасны дагуу сунгасан хугацаанд гүйцэтгэнэ. Гүйцэтгэгч нь Ажил бүрийн болон нийт Ажлын хугацааг дурдаж, Ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний өөрийн хэсэгт хамаарах хэсгээр Ажлыг гүйцэтгэх үе шатны дэлгэрэнгүй төлөвлөгөөг боловсруулж Захиалагчид хүргүүлнэ.

Гүйцэтгэгч нь Гэрээний нөхцөлийн Хавсралт №4-т өөрөөр заагаагүй бол, шаардлагатай бүхий л гэрчилгээ, зөвшөөрлийг холбогдох төрийн болон орон нутгийн эрх бүхий байгууллагаас авах үүрэг хүлээх ба үүнд зураг төсөл, барилга угсралт, Ажлыг хүлээлгэн өгөх болон бусад зөвшөөрлүүд багтана. Мөн Ажилд гарсан алдаа доголдлыг Гэрээнд заасан хугацаанд холбогдох стандарт, шаардлагын дагуу засаж залруулна.

Гүйцэтгэгч, ажил эхлэх мэдэгдэл хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор Ажил гүйцэтгэх төлөвлөгөө, Ажлын аргачлалыг Захиалагчид хүргүүлж, батлуулсан байна.

Барилга угсралтын ажлын өмнө болон явцад Гүйцэтгэгч бүх ажилд техникийн шаардлага, аргачлал, норм, дүрэм, стандартыг боловсруулж Захиалагчаар батлуулсан байна.

Гүйцэтгэгч Ажлыг Захиалагчийн төлөөлөгч, инженерийн хяналт дор гүйцэтгэх ба энэхүү инженер нь Захиалагчийн нэрийн өмнөөс Гэрээний баримт бичгийн дагуу Ажлыг хянаж, баталгаажуулна.

Гүйцэтгэгч нь Хавсралт №6-д заасанчлан уг төсөлд ажиллах хүний нөөц, машин механизм, худалдан авах үндсэн бараа материалын доор заасан хувь хэмжээнээс багагүй хувийг тухайн орон нутгийн зах зээлээс заавал авч ажиллана. Үүнд:

Хүснэгт 1. Орон нутгаас авах хувь, хэмжээ

Д/д	Нэр	Хувь, хэмжээ
1	Ажиллах хүч	20-иос доошгүй хувь
2	Үндсэн бараа, материал	20-иос доошгүй хувь
3	Машин механизм	60-аас доошгүй хувь

2.3. Зураг төслийн шаардлагууд

Гүйцэтгэгч нь Туулын хурдны авто замын барилгын ажлын зураг төслийг Захиалагчийн шаардлага, техникийн үндсэн үзүүлэлт, техникийн шаардлага, Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, дүрэм, журам, норм, стандарт эсхүл Олон улсын шаардлагад нийцсэн стандартын дагуу гүйцэтгэж, Захиалагчийн шаардлагыг боловсронгуй болгож ажиллана.

Гүйцэтгэгч нь Гэрээ болон захиалагчийн шаардлагад нийцүүлэн стандарт, ажил гүйцэтгэх аргачлал, техникийн шаардлага, ажлын журам, төлөвлөгөө, техникийн болон ажлын зураг төсөл, барилгын зураг төсөл, гүйцэтгэлийн зураг, шалгалт ба туршилтын журам, гарын авлага болон засвар үйлчилгээний

төлөвлөгөө зэрэг шаардлагатай баримт бичгийг боловсруулж зураг төсөл болон барилгын үе шатанд Захиалагчийн төлөөлөгчид зөвшөөрөл авахаар хүргүүлнэ.

Хэрэв ТЭЗҮ-д тусгагдсан ажил, бараа, үйлчилгээ, техникийн шаардлагад нэмэлт, өөрчлөлт орох зайлшгүй шаардлага үүссэн тохиолдолд тухай бүр Захиалагчид албан бичгээр мэдэгдэж, харилцан зөвшилцсөний үндсэн дээр зохих өөрчлөлтийг хийнэ.

2.4. Ажлын цар хүрээ

2.4.1. Нийтлэг үндэслэл

Гэрээний дагуу гүйцэтгэх Ажлын цар хүрээ (цаашид “Ажлын цар хүрээ” гэх) нь 2025 оны 01 сард батлуулж магадлуулсан, ТЭЗҮ-д туссан бүхий л ажилд үндэслэх бөгөөд Налайхын замын Улиастайн буцаж эргэх цэгээс Дархан, Эмээлтийн замын уулзварын цэг хүртэл 32 орчим км урттай, 6 эгнээтэй, 7 олон түвшний орц, гарцын огтлолцлуудтай, 3 олон түвшний огтлолцолтой, 9877.88 метр орчим урт гүүртэй, 7 туннелтэй 100 км/ц хурдлах боломжтой, хамгийн бага радиус 800 метр, хамгийн их радиус 4500 метр, авто машины зорчих хэсгийн өргөн 12.5 метртэй хурдны авто замын газар шороо, гүүр, хоолой, туннель, суваг шуудуу; авто зам дагуух үерийн хамгаалалтын далан; ус хангамж, дулаан хангамж, ариутгах татуургын барилгын ажил; гэрэлтүүлэг, ЦШС-г хамгаалах, шилжүүлэх, дэд станцыг шилжүүлэх, шинээр барих ажил; холбооны сувагчлал, кабель шилжүүлэх, шинээр барих, камержуулалт, тоног төхөөрөмж, программ хангамжийн ажил; археологи, палеонтологи, түүх угсаатны хагуул, судалгаа, авран хамгаалах, малтлагын ажил; байгаль орчин хамгаалах зэрэг ажлын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил, тэдгээрийн туршилт, зүгшрүүлэлт болон ашиглалтад хүлээлгэн өгөх ажлаас бүрдэх хэдийн ч үүгээр хязгаарлагдахгүй. Мөн зураг төсөлд тусгагдсан бусад бүхий л ажлуудыг гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч нь барилгын ажлыг техникийн шаардлагад нийцүүлэн гүйцэтгэнэ. Гэрээний дагуу зүгшрүүлэх болон гомдлын шаардлага гаргах хугацаанд гүйцэтгэх засвар үйлчилгээ, ашиглалтын ажилчдын сургалт зэрэг нь Гүйцэтгэгчийн ажлын цар хүрээнд багтана.

2.4.2. Авто зам /олон түвшний уулзварын хамт/-ын барилгын ажил

a) Түр барилга ба үйлдвэрлэлийн бэлтгэл ажил;
b) Замын трасс, талбайн цэвэрлээний ажил;
c) Замын чиг сэргээх, гадаслах ажил;
d) Түр болох туслах замын ажил;
e) Замын далан, ухмалын ажил;
f) Замын суурийн ажил;
g) Замын хучилтын ажил;
h) Замын хайрган хөвөө байгуулах ажил;
i) Замын ус зайлуулах энгийн байгууламжийн ажил;
j) Замын тоноглолын ажил;
k) Замын тэмдэглэгээний ажил;
l) Тулц хананы ажил;
m) Замын зурвасыг цэвэрлэх, зүлэгжүүлэх ажил;

n) Авто зам, замын байгууламжийг улсын ашиглалтад оруулах ажил;

2.4.3. Авто замын үерийн хамгаалалтын далангийн барилгын ажил

a) Үерийн хамгаалалтын далангийн ажил

b) Голын гольдролд суваг татах ажил

2.4.4. Төмөр бетон гүүрийн ажил

a) Түр барилга ба үйлдвэрлэлийн бэлтгэл ажил

b) Гүүрийн тулгуурын энгийн суурь

c) Захын болон завсрын тулгуур байгуулах

d) Алгасалын бүтээц байрлуулах ба байгуулах

e) Арматур хүчитгэх

f) Зорчих хэсэг байгуулах

g) Хэв гажилтын заадас байгуулах

h) Далан сувгийн бэхэлгээ

i) Гүүрийн байгууламжийг улсын ашиглалтад оруулах

2.4.5. Туннелийн барилгын ажил

a) Түр барилга ба үйлдвэрлэлийн бэлтгэл ажил

b) Туннель

2.4.6. Авто замын трасст орсон ус хангамж, дулаан хангамж, ариутгах татуургын ажил

2.4.7. Авто замын гэрэлтүүлэг, авто замын трасст орсон ЦШС-г хамгаалах, шилжүүлэх, дэд станц шилжүүлэх, шинээр барих ажил

2.4.8. Мэдээлэл холбооны төлөвлөлт / холбооны сувагчлал, кабель шилжүүлэх, шинээр барих, камержуулалт, тоног төхөөрөмж, программ хангамж/-ийн зардал

a) Холбооны сувагчлал, кабель шилжүүлэх

b) Холбооны сувагчлал, кабель /шинээр камер/

c) Камержуулалт

d) Тоног төхөөрөмж

e) Программ хангамж

2.4.9. Археологи, палеонтологи, түүх угсаатны хагуул, судалгаа, авран хамгаалах, малтлагын ажил

2.4.10. Байгаль орчин хамгаалах ажил

3. БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛТАЙ ХОЛБООТОЙ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

3.1. Төсөл хэрэгжүүлэх тогтолцоо

Гүйцэтгэгч нь Гэрээний дагуу Ажил, үүргийг гүйцэтгэхтэй холбоотой Ажлын талбай дээр ашиглах төслийн менежментийн төлөвлөгөө, зураг төсөл, техникийн шаардлага, ажлын аргачлал, ажил гүйцэтгэх төлөвлөгөө, аюулгүй ажиллагааны журам, чанарын хяналтын баримт бичиг зэргийг тусгасан “Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г Захиалагчид гаргаж өгөх ба шаардлагатай тохиолдолд нэмэлт тодотгол хийж болно. Гүйцэтгэгч нь шаардлагатай шинэчлэлтийг хийх ба Захиалагч хянан, баталгаажуулна.

Хэрэв эцсийн хугацааг өөрөөр заагаагүй бол Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөг Захиалагчаар хянуулж, зөвшөөрөл авахаар Ажил эхлүүлэх мэдэгдэл авсан өдрөөс хойш 28 хоногийн дотор Захиалагчид өгнө.

Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөнд дараах төлөвлөгөө багтана. Үүнд :

1. Төсөл хэрэгжүүлэх менежментийн төлөвлөгөө
2. Зураг төслийн менежментийн төлөвлөгөө
3. Ажлын аргачлалын төлөвлөгөө
4. Чанарын хяналтын төлөвлөгөө
5. Баримт бичиг хянах төлөвлөгөө
6. Ханган нийлүүлэлтийн төлөвлөгөө
7. Гүйцэтгэгчийн удирдлага болон хүний нөөцийн төлөвлөгөө
8. Түр байгууламжийн төлөвлөгөө
9. Сургалтын төлөвлөгөө
10. Төслийн үзүүлэлтийн болон хоног, 7 хоног, сарын мэдээ гаргах төлөвлөгөө
11. Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй болон нийгмийн удирдлагын төлөвлөгөө
12. Тээвэр, ложистикийн төлөвлөгөө
13. Ажил гүйцэтгэх төлөвлөгөө, хуваарь
14. Туршилтын төлөвлөгөө
15. Ашиглалтад оруулах, хүлээлгэн өгөх төлөвлөгөө.

Ажлын гүйцэтгэлийг чанаржуулах хурдасгах нөхцөл үүссэн үед инженерингийн зөв шийдлийг Гүйцэтгэгч боловсруулан тухай бүрт Захиалагчтай хэлэлцэн, зөвшөөрөл авсан үед хэрэгжүүлж болно.

3.2. Баримт бичиг боловсруулах, хүргэх болон хариу өгөх журам

3.2.1 <u>Баримт бичиг боловсруулах</u>

Гүйцэтгэгч нь Захиалагчийн шаардлагын дагуу төслийн баримт бичгийг бүрэн бүтэн, цаг тухай бүрт боловсруулж, хянан нягтлан, баталгаажуулан Захиалагчид хүргүүлнэ.

Гүйцэтгэгч нь баримт бичгийг боловсруулахдаа баримт бичиг дээр огноо, баримт бичгийн дугаар, нэр болон бусад мэдээллийг тусгасан байх ба хүргүүлж буй баримт бичиг нь дараах шаардлагыг хангаж байгаа эсэхийг урьдчилан хянасан байна. Үүнд:

a) Захиалагчийн шаардлага холбогдох шаардлагад нийцэж байгаа эсэх;
b) Хянах боломжтой бөгөөд нотлогдож, батлагдсан тооцоолол, эсхүл зураг төслийн дагуу байгаа, эсхүл түүнд үндэслэсэн эсэх;
c) Баримт бичгийн бүрэн гүйцэд, үнэн зөв бөгөөд хүчин төгөлдөр байдлыг хангах зорилгоор Гүйцэтгэгч төслийн чанарын хяналтын төлөвлөгөөний дагуу боловсруулсан эсэх;
d) Эрх бүхий байгууллага буюу ижил төрлийн байгууллагаас зөвшөөрөл авах үндэслэл бүхий холбогдох шаардлагыг хангасан эсэх;
e) Бүхий л холбогдох шаардлагыг хангаж байгаа эсэх.

Гүйцэтгэгчийн баримт бичиг Захиалагчид цахим байдлаар хүргэгдэх ба Талууд баримт бичгийг цахим байдлаар хадгална. Бичиг баримтууд архив, албан хэрэг хөтлөлтийн шаардлага хангаж байх ёстой.

3.2.2 Баримт бичиг хүргэх

Гүйцэтгэгч нь Гэрээ болон түүний бүрдэл хэсэгт өөрөөр заагаагүй бол төслийн баримт бичгийг төслийн талбай эсхүл төв оффист байрлах Захиалагчийн төлөөлөгчид холбогдох хувь хэмжээ, төрлөөр хүргүүлэх ба хүлээн авсан талаар тэмдэглэл, баталгаажуулалтыг хийнэ.

3.2.3 Захиалагчийн хариу

Захиалагч нь хүсэлтийг хүлээн авснаас хойш энгийн баримт бичигт хуанлийн

хоногийн дотор хариу өгнө.

Захиалагч нь багц баримт бичигт дараах гурван төрлийн аль нэгээр хариу өгнө:

a) Зөвшөөрсөн мэдэгдэл;
b) Санал бүхий зөвшөөрсөн мэдэгдэл;
c) Татгалзсан мэдэгдэл (үндэслэл бүхий тайлбартай)

Хариуны тодорхойлолт:

a) **"Зөвшөөрсөн мэдэгдэл":** Захиалагч нь хүргүүлсэн баримт бичгийг хянасны дараа Гэрээний дагуу аливаа зөрчилгүй бол албан ёсны "Зөвшөөрсөн мэдэгдэл"-ийг Гүйцэтгэгчид өгнө. Захиалагчийн “Зөвшөөрсөн мэдэгдэл” нь Гүйцэтгэгчийн хүргүүлсэн баримт бичигтэй холбоотой Гэрээг дагаж биелүүлэхтэй холбоотой аливаа хариуцлагаас чөлөөлөхгүй. “Зөвшөөрсөн мэдэгдэл” нь төлөвлөсөн ажлын дараагийн үе шатыг эхлүүлэх эрхийг Гүйцэтгэгчид олгоно.
b) **"Санал бүхий зөвшөөрсөн мэдэгдэл":** Захиалагч нь хүргүүлсэн баримт бичгийг хянасны дараа ноцтой биш гэж үзсэн зөрүү, алдаа илрүүлбэл “Санал бүхий зөвшөөрсөн мэдэгдэл" өгнө. Гүйцэтгэгч нь "Барилгын ажил"-д холбогдох саналыг тусгахаас өмнө Захиалагчтай зөвшилцөж, оруулсан саналд хариу өгнө. Захиалагчийн зүгээс “Санал бүхий зөвшөөрсөн мэдэгдэл” хүргүүлсэн бол Гүйцэтгэгч нь Захиалагчийн саналыг тусгах, тайлбар хүргүүлэх үүрэгтэй ба төлөвлөсөн ажлын дараагийн үе шатны ажлыг эхлүүлэх эрхтэй болно.
c) **"Татгалзсан мэдэгдэл (үндэслэл бүхий тайлбартай):** Захиалагч нь хүргүүлсэн баримт бичгийг хянасны дараа ноцтой гэж үзсэн зөрчил, зөрүү, эс үйлдэл зэргийг илрүүлбэл үндэслэл бүхий тайлбартай "Татгалзсан мэдэгдэл" өгнө. Гүйцэтгэгч нь тус үндэслэлийг нягталж, зөвшөөрсөн бол Захиалагчийн саналыг тусган, баримт бичгийг засаж, Захиалагчид дахин хүргүүлнэ. Захиалагчийн зүгээс дахин хариу хүргүүлсний дараа “Зөвшөөрсөн мэдэгдэл” эсхүл “Санал бүхий зөвшөөрсөн мэдэгдэл” өгөх хүртэл Гүйцэтгэгч нь холбогдох хэсгийн ажлын дараагийн үе шатыг эхлүүлэх эрхгүй. Харин Гүйцэтгэгч нь Захиалагчийн “Татгалзсан мэдэгдэл”-ийг үндэслэлгүй гэж үзсэн бол нотолгоо, тайлбарын хамт тухайн баримт бичгийг дахин хүргүүлнэ.

3.3 Чанарын хяналт

3.3.1 Нийтлэг зүйл

Гүйцэтгэгч нь дотоодын Чанар, хяналтын нэгжтэй байна. Гүйцэтгэгч нь Захиалагч, Захиалагчийн төлөөлөгчид ба бусад холбогдох аливаа гуравдагч этгээдтэй хамтран ажиллана. Захиалагч болон Захиалагчийн төлөөлөгчидтэй байнга албан бичгээр болон шаардлагатай тохиолдолд бусад хэрэгслээр харилцах ба төслийн хугацаа, чанар, аюулгүй байдал, барилгын явц, өртөг ба гэрээний асуудлаар үнэн, зөв мэдээллийг дамжуулна.

Мөн зураг төсөл, барилга угсралт, үйлдвэрлэл, ашиглалтад хүлээлгэх өгөх ажлыг батлагдсан баримт бичгийн дагуу хянаж, Гэрээний шаардлага болон магадлагдсан зураг төсөлд нийцсэн эсэхийг баталгаажуулна.

Гүйцэтгэгч нь Чанарын хяналтын төлөвлөгөө боловсруулж, Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлж, батлуулна. “Чанарын Хяналтын Төлөвлөгөө”-ний зорилго нь Ажлын талбайд дараах баримт бичгийн дагуу Ажил гүйцэтгэж байгааг баталгаажуулахад оршино. Үүнд:

a) Зураг төсөл;
b) Стандарт ба хууль тогтоомжийн шаардлагууд;
c) Захиалагчийн шаардлага, техникийн шаардлага;
d) Аюулгүй ажиллагааны дүрэм;
e) Байгаль орчны холбогдох шаардлагууд;

Гүйцэтгэгчийн чанарын нэгж нь худалдан авах гэрээ хийгдсэн бараа материал, тоног төхөөрөмжийн баталгааг Үйлдвэрлэгчийн танилцуулгын хамт Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.

Гүйцэтгэгч нь Захиалагчийн төлөөлөгчтэй хамтран ажиллана. Үүнд:

i Хурдны авто замын зураг төсөл, үйлдвэрлэл ба туршилтыг үндсэн зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэл ба хавсралтуудын дагуу гүйцэтгэсэн эсэхийг хянана;
ii Үйлдвэрлэлд ашиглаж байгаа материал ба тоног төхөөрөмж, тэдгээрийн тоо хэмжээ, чанарыг шалгах, холбогдох стандарт, Захиалагчийн саналд нийцэж байгаа эсэхийг баталгаажуулна;
iii Үйлдвэрлэлийн гол бүтээгдэхүүнийг шалгана;
iv Үйл ажиллагааны туршилт, тоног төхөөрөмжийн ханган нийлүүлэлт, угсралт нь үндсэн зураг төсөлтэй нийцэж байгаа эсэхийг шалгах үе шат бүрийг дагаж мөрдөнө;
v Тэдгээрийн уялдаа холбоо, хяналт, туршилтын журам ба ашиглагдах материалын үр дүнг тогтмол шалган хянаж, гэрээний баримт бичигт нийцэж байгаа эсэхийг баталгаажуулна;
vi Гүйцэтгэгчийн лаборатори ба Ажлын талбайд явуулах туршилтад байлцана. Туршилтыг Гүйцэтгэгчийн техникийн үзүүлэлтэд тодорхойлсон, эсхүл Захиалагч болон Захиалагчийн төлөөлөгч хяналт хийх зорилгоор шаардсан байна;
vii Туршилтын үйл явц ба туршилтын үр дүн нь Захиалагчийн техникийн үзүүлэлт ба стандартад нийцсэн байхыг баталгаажуулна;

viii Үйл ажиллагааны нөхцөлийн системийг шалгана;

ix Шаардлагатай буюу тодорхойлон заасан тохиолдолд Захиалагчийн зөвшөөрлийг авна;

x Бүх механик ба цахилгаан тоног төхөөрөмжийг хүлээн авах туршилт, ашиглалтад хүлээлгэн өгөх журмыг хянана;

xi Аюулгүй ажиллагааны стандартын үйлчлэлд хяналт тавьж ханган нийлүүлэлтийн хугацааны туршид батлагдсан аюулгүй ажиллагааны бодлогын хэрэгжилтийг баталгаажуулна;

xii Бүхий л дуусгавар болсон ажил, бүтээгдэхүүнийг Зураг төсөл, стандартад нийцүүлэн хянана;

xiii Эдгээр бүх үйл ажиллагааны Ажлын явцын тайланг Захиалагчид тогтмол тайлагнана;

xiv Төслийн асуудалтай хэсэгт онцгой анхаарал хандуулна.

3.3.2 <u>Материал, тоног төхөөрөмжийн чанар</u>

Гүйцэтгэгч нь худалдан авах гэрээ хийгдсэн үндсэн бараа материалын үйлдвэрлэлд ашиглах түүхий эд материал, тоног төхөөрөмжийн баталгааг Үйлдвэрлэгчийн танилцуулгын хамт Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.

Энэхүү Гэрээнд заасан бүх бараа материал, тоног төхөөрөмж нь шинэ, стандартын шаардлагад нийцсэн байна. Захиалагч нь шаардлагад үл нийцэх бараа материалыг хүлээн зөвшөөрөхгүй ба Гүйцэтгэгч нь Ажлын аюулгүй ажиллагааны дүрэм журмыг баримтлал болгон мэргэжлийн өндөр төвшинд чанартай хийж гүйцэтгэнэ.

Ажил гүйцэтгэхэд шаардагдах аливаа тоног төхөөрөмжийг Ажлын талбайн нөхцөл байдалд тохируулан сонгоно.

Түүнчлэн, Гүйцэтгэгч нь чанарын туршилтын тайлан болон үйлдвэрлэгчдийн бусад шаардлагатай мэдээллийг Захиалагчид хүргүүлнэ.

Захиалагчаар батлуулахаас өмнө ханган нийлүүлсэн тоног төхөөрөмж болон баталснаас өөр зорилгоор ашигласан тоног төхөөрөмжийг хэрэглэхээс татгалзана.

3.4 Талбай ашиглалт

Ажлын хуваарь (Гэрээний нөхцөлийн Хавсралт №5)-т өөрөөр заагаагүй бол, Гүйцэтгэгч нь Гэрээ байгуулагдсан өдрөөс эхэлж Талбайд нэвтрэх ба ашиглах эрхтэй. Улмаар Гэрээний нөхцөлийн Хавсралт №5-д заасан Ажлын хуваарийн дагуу Ажлыг гүйцэтгэнэ.

3.5 Талбайн байгууламж

Гүйцэтгэгч нь өөрийн хүний нөөцийн ажиллах, амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төслийн талбай дахь оффис, ажиллагсдын түр байр нь эрүүл ахуйн шаардлага (бие засах газар, бохир ус хадгалах зайлуулах газар, халуун хоол ундаар үйлчлэх болон анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх цэг, галын аюулаас хамгаалах, багаж хэрэгсэл хадгалах сав гэх мэт) зэргийг хангасан байх шаардлагатай.

Гүйцэтгэгч нь төслийн бараа, тоног төхөөрөмж, аюултай материал хадгалах зориулалт бүхий байгууламжтай байж хамгаалалтыг хариуцах ба томилсон туслан

гүйцэтгэгчдийн бүх ийм байгууламж нь холбогдох стандарт, шаардлагыг хангаж ажиллаж байгаа эсэхэд хяналт тавина.

3.6 Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон нийгмийн удирдлага

Гүйцэтгэгч нь Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон нийгмийн удирдлагатай (Гэрээний нөхцөлийн Хавсралт №3) холбоотой Захиалагчийн удирдамж, заавар, Монгол Улсын холбогдох хууль, дүрэм, журамд нийцсэн байгаль орчны төлөвлөгөө, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төлөвлөгөө болон нийгмийн удирдлагын төлөвлөгөөг Захиалагчийн төлөөлөгчөөр батлуулж мөрдөж ажиллана. Энэхүү төлөвлөгөөг өөрийн ажилтнууд, туслан гүйцэтгэгчид, тэдгээрийн ажиллагсад, бараа, материал, хийц ханган нийлүүлэгчдийг оролцуулан ажлыг гүйцэтгэхэд оролцож буй бүх талуудад дагаж мөрдүүлэх арга хэмжээг авч, хэрэгжилтийг хангаж ажиллана.

Орон нутгийн байгаль орчин, олон нийтийн амьдрах хэв маягт үзүүлэх барилгын ажил түүнтэй холбогдох үйл ажиллагааны сөрөг нөлөөг бууруулах талаар хүчин чармайлт гарган ажиллана. Ургамал, ан амьтны аймгийг хамгаалах, тоосжилт, агаарын бохирдол, хийн ялгаруулалтыг бууруулах буюу багасгах, дуу шуугиан, бохир ус, хог хаягдлыг цэвэрлэх, гадаргын усны урсцыг хянахтай холбоотой аливаа асуудлыг Гүйцэтгэгч хариуцах ба эдгээрийг Төслийн ажлын даалгаварт багтсанд тооцно. Гүйцэтгэгч нь зөрчил арилгуулах, эсхүл холбогдох стандарт, нийтлэг жишгийг сайжруулахтай холбоотой Захиалагч буюу Захиалагчийн төлөөлөгчийн аливаа зааварчилгааг дагаж мөрдөнө.

3.7 Төлөвлөгөө ба ажлын хуваарь, тайлан

Ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөөг хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор Захиалагч татгалзсан мэдэгдэл өгөөгүй бол зөвшөөрсөнд тооцож, Гүйцэтгэгч тус төлөвлөгөөний дагуу Гэрээнд заасан Ажлыг гүйцэтгэнэ. Захиалагчийн ажилтан энэхүү төлөвлөгөөнд уялдуулж ажиллана.

Ажил эхэлснээс хойш 28 хоногийн дотор, Гүйцэтгэгч нь Захиалагчтай тохиролцсон мэдээллийг агуулсан баримт бичгийг Ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөө болон Гэрээний нөхцөлийн Хавсралт №5 [Ажлын хуваарь]-т үндэслэн боловсруулж, Захиалагчид хүргүүлнэ.

Гүйцэтгэгч нь хурдны авто замын ажлын гүйцэтгэлийн талаар Захиалагчид өдөр тутам, долоо хоног тутам, сар бүр тутмын тайланг Захиалагчтай эцэслэн тохиролцсон загварын дагуу гаргаж өгнө.

3.8 Гүйцэтгэгчийн төслийн удирдлага

Гүйцэтгэгч нь Захиалагчийн шаардлагад нийцүүлж ажлыг хийж гүйцэтгэх ба төсөл хэрэгжүүлэх мэргэжлийн багийг бүрдүүлнэ. Үүнд төслийн менежер, төслийн удирдлага хяналтын мэргэжилтнүүд, нарийн мэргэжлийн инженерүүд болон холбогдох бусад захиргааны ажилтнууд байна. Нийт ажиллах хүчний 20-оос багагүй хувьд орон нутгийн иргэд ажиллана.

Мөн Гүйцэтгэгч төслийн багийн зохион байгуулалтын болон ажил үүргийн уялдааг харуулсан схем боловсруулж, өөрчлөлтийг Сар тутмын тайланд тусгасан байна.

Хяналтын өрөө нь 24 цагийн радио холбоотой, аюулгүй ажиллагааны бүх ажилтантай холбогддог утсан холбоотой байхаас гадна дээрхээр хязгаарлагдахгүй, талбайн кемп, үйлдвэрүүд, Захиалагчийн оффис, карьер гэх мэт бусад шаардлагатай бүх хэсэг нэгжтэй холбогдох боломжтой байхаас гадна 24 цагийн харуул хамгаалалттай байна.

4. ХЯНАЛТ, ТУРШИЛТ, АШИГЛАЛТАД ХҮЛЭЭН АВАХ БА ЗҮГШРҮҮЛЭЛТ

4.1 Хяналт, туршилт

Зураг Төслийн дагуу нийлүүлэгдэж байгаа түүхий эд, тоног төхөөрөмж болон бүрдэл хэсгүүд, бүхий л ажлуудын гүйцэтгэлийг Захиалагч болон Захиалагчийн төлөөлөгч шалгаж, судална.

Туршилт нь дараах дөрвөн (4) ангилалд хуваагдана:

- Төрөл, хэлбэр, хэв загварын туршилт
- Үйлдвэрийн туршилт (ҮТ)
- Талбайн туршилт (ТТ)
- Урьдчилсан туршилт (УТ)

Бүхий л төрлийн систем, тоног төхөөрөмжийн эд анги болон түүхий эд нь Төрөл, хэлбэр, хэв загварын туршилтад хамрагдана. Дээрх туршилт нь үйлдвэрлэлийн шатанд хийгдэнэ. Хэрэв тухайн тоног төхөөрөмжийн төрөл, хэлбэр, хэв загвар нь гэрчилгээтэй буюу зохих итгэмжлэлийн баримт бичигтэй бол Гүйцэтгэгч түүнийг нотолсоны үндсэн дээр туршилт хийхгүй байж болно.

Төрөл, хэлбэр, хэв загварын туршилтийг хийж дууссаны дараа Үйлдвэрийн туршилтыг тоног төхөөрөмж болон системд хийнэ.

Талбайн туршилтыг (үүнд холимог туршилт, шинжилгээ, гүйцэтгэлийн туршилт, туршилтын явалт зэрэг багтана) түүхий эд, тоног төхөөрөмж, эсвэл системийг Ажлын талбайд хүргэгдэн, суурилуулсны дараа хийнэ.

Туршилт дуусах хүртэл аливаа хангалтгүй туршилтыг залруулах бүхий л арга хэмжээг Гүйцэтгэгч авч хэрэгжүүлнэ.

Урьдчилсан туршилт нь ашиглалтад оруулах нэгдсэн туршилт, гүйцэтгэлийн туршилт болон туршилтын явалт гэсэн үе шатуудаас бүрдэнэ.

4.2 Ашиглалтад хүлээн авах ба зүгшрүүлэлт

Гүйцэтгэгч нь төслийн бүх төрлийн туршилт, Захиалагч болон Улсын коммист хүлээлгэн өгөх ажил, зүгшрүүлэлт, сургалт зохион байгуулах нэгдсэн төлөвлөгөө боловсруулж Захиалагчид батлуулахаар хүргүүлнэ. Захиалагч нь баримт бичигт хариу өгөх заалтын дагуу тус төлөвлөгөөнд хариу хүргүүлэх ба Гүйцэтгэгч нь “Зөвшөөрсөн” мэдэгдэл ирэх хүртэл Захиалагчийн саналыг тусгана. Гүйцэтгэгч нь Захиалагчийн баталсан туршилт, хүлээлгэн өгөх, зүгшрүүлэлт болон сургалтын төлөвлөгөөг дагаж мөрдөнө.

Улсын коммист хүлээлгэн өгөхөд шаардагдах холбогдох баримт бичгийг бүрдүүлэх нь Гүйцэтгэгчийн ажлын цар хүрээнд хамаарна.

Гүйцэтгэгч нь “Барилга, Ашиглалт ба Засвар үйлчилгээний стандарт, заавар”-г боловсруулж төрийн эрх бүхий байгууллагаар батлуулна. Мөн Хавсралт №2-т заасан Ажилд шаардагдах ашиглалтын сэлбэг хэрэгсэл, тусгай багажийн жагсаалт, зааврыг боловсруулж Захиалагчаар батлуулна. Гүйцэтгэгч нь энэхүү жагсаалт, зааврыг Талуудын харилцан тохиролцсон хугацаанд Захиалагчид хүргүүлсэн байна. Тус жагсаалтад тусгагдсан ашиглалтын үеийн сэлбэг хэрэгсэл, тусгай багаж нийлүүлэх ажил нь Гүйцэтгэгчийн ажлын цар хүрээнд хамаарахгүй.

Захиалагч ажлын бүрдэл хэсгийг гэрээнд заасан хугацаанаас өмнө хэсэгчлэн хүлээн авч болно.

ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛИЙН ХАВСРАЛТ №1-Б ХЭСЭГ
ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

5. ЕРӨНХИЙ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ БА ШААРДЛАГА

Гэрээний нөхцөлийн Хавсралт 1-т заасан Ажлын техникийн үзүүлэлт, шаардлага, ажил, тоо хэмжээ энэхүү Хавсралтад тусгагдаагүй буюу тодорхой бус бол ТЭЗҮ-д заасан техникийн үзүүлэлт, шаардлагыг, ажил ба тоо хэмжээг дагаж мөрдөнө.

Хүснэгт 1. “Туулын хурдны зам” төслийн үндсэн үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	
1	Төслийн нэр:	Улаанбаатар хот. Туул голын хойд эргийн дагуу баригдах хурдны замын барилга буюу ТУУЛЫН ХУРДНЫ ЗАМ	
2	Байршил:	Улаанбаатар хот. Баянзүрх дүүрэг 10, 11, 23-р хороо, Хан-Уул дүүрэг 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11-р хороо, Баянгол дүүрэг 20-р хороо, Сонгинохайрхан, дүүрэг 20, 32-р дугаар хороодын нутаг дэвсгэр	
3	Замын эхлэлийн цэг	Налайхын замын Улиастайн буцаж эргэх	
4	Замын төгсгөлийн цэг	Дархан, Эмээлтийн замын уулзвар	
5	Замын урт	км	32 орчим
6	Замын зэрэг		Хурдны зам 1А
7	Тооцоот хурд	км/цаг	100
8	Хөдөлгөөний зурвасын тоо	ширхэг	6
9	Олон түвшний огтлолцлууд /орц, гарцтай хэсэг/	ширхэг	7
10	2 түвшний огтлолууд /орц, гарцгүй хэсэг/	ширхэг	3
11	Гүүрүүдийн урт	метр	9877.88
12	Туннелийн тоо	ширхэг	7
13	Тойруугийн тоо	ширхэг	26
14	Тойруугийн хамгийн бага радиус	метр	800
15	Тойруугийн хамгийн их радиус	метр	4500
16	Тойруугийн нийт урт	метр	12766.78
17	Тойруугийн трассад эзлэх хувь	%	39.9
18	Босоо гудгэр муруйн хамгийн бага радиус	метр	4043
19	Босоо гудгэр муруйн хамгийн их радиус	метр	21137
20	Босоо хотгор муруйн хамгийн бага радиус	метр	2461
21	Босоо хотгор муруйн хамгийн их радиус	метр	22207
22	Дагуугийн хамгийн их налуу	%	4.63
23	Дагуугийн хамгийн их налуугийн үргэлжлэх урт	метр	2301.75

24	Улаан шугамын өргөн (Тэнхлэгээс 2 тийш)	метр	40
25	Замын далангийн өргөн	метр	29
26	Авто машины зорчих хэсгийн өргөн	метр	12.5
27	Өндөрлөгөөний хажуу налуу	m:n	1:1.5
28	Ухмалын хажуу налуу	m:n	1:1.5
29	Хучилтын хийц	сантиметр	Суурийн доод үе h=40
30		сантиметр	Цементээр бэхжүүлсэн суурь h=20
31		сантиметр	Цементээр бэхжүүлсэн буталсан чулуун суурь h=20
32		сантиметр	Том ширхэгтэй асфальтбетон h=6
33		сантиметр	Жижиг ширхэгтэй асфальтбетон h=4

**Хүснэгт 1-т тусгагдсан Туулын хурдны замын техникийн үзүүлэлт нь ТЭЗҮ-д заасан мэдээлэл болно.*

Зураг 1. Туулын хурдны замын трасс



Хүснэгт 2. Туулын хурдны замын трасс

№	Км	Координат (UTM-48)		Тайлбар
		X	Y	
1	0+000.00	5306795.4786	653762.1233	Эхлэл
2	1+000.00	5307109.7054	652852.4355	
3	2+000.00	5306997.5677	651983.9638	
4	3+000.00	5306514.5949	651134.7953	
5	4+000.00	5306412.6475	650143.4330	
6	5+000.00	5306217.9548	649162.9096	

7	6+000.00	5306010.0157	648184.7678	
8	7+000.00	5305799.1882	647207.3109	
9	8+000.00	5305367.9884	646313.9218	
10	9+000.00	5305504.8645	645326.8699	
11	10+000.00	5305467.5367	644329.4707	
12	11+000.00	5305699.3270	643356.9461	
13	12+000.00	5305719.3903	642361.3634	
14	13+000.00	5305752.7370	641363.7339	
15	14+000.00	5305833.1747	640370.9033	
16	15+000.00	5305587.5841	639402.8539	
17	16+000.00	5305540.7813	638405.0970	
18	17+000.00	5305463.9203	637410.5925	
19	18+000.00	5305248.7293	636450.9674	
20	19+000.00	5304932.8916	635508.3854	
21	20+000.00	5304591.1564	634579.4602	
22	21+000.00	5304166.1942	633678.7926	
23	22+000.00	5304175.2695	632689.2184	
24	23+000.00	5304490.6755	631740.3550	
25	24+000.00	5304359.5769	630783.2806	
26	25+000.00	5304160.3014	629803.4053	
27	26+000.00	5303890.4458	628842.1072	
28	27+000.00	5303676.4524	627868.0301	
29	28+000.00	5303584.2485	626876.1844	
30	29+000.00	5304104.1991	626031.1892	
31	30+000.00	5304605.2852	625168.2939	
32	31+000.00	5305206.0570	624404.0694	
33	32+000.00	5305871.4314	624290.7870	Төгсгөл

**Хүснэгт 2-т тусгагдсан Туулын хурдны замын трасс нь ТЭЗҮ боловсруулах үед тодорхойлогдсон байршил болно.*

8.1. Хөндлөн огтлолын геометр үзүүлэлт

- Замын далангийн нийт өргөн нь 29м
- Зорчих хэсгийн өргөн 3.75мх6
- Замын хөндлөн хэвгий 2.0%,
- Хөдөлгөөн тусгаарлах төмөрбетон хашлаганы өргөн 0.82м,
- Хөвөөний бэхэлгээтэй хэсгийн өргөн 0.5мх2 байна.

Зураг 2. Хөндлөн огтлолын 1 маягийн зураг



8.2. Хучлагын хийц

Авто замын уян хучилтын бат бэхийн тооцоогоор хучилтын бүтээцийг зөвшөөрөгдөх харимхай хотойлтын нөхцөл, хучилтын бүтээцийн гулсалтын эсрэг тогтворын нөхцөл, гулзайлтад ажиллаж буй цутгамал бүтээцийн суналтын эсэргүүцлийг шалгана. Бат бэхийн тооцооны шалгуур үзүүлэлт болох бат бэхийн коэффициентыг замын ангилал, хучилтын төрөл, найдваржилтын коэффициент болон тооцооны зорилгоос хамаарч тогтооно.

Зураг 3. Хучлагын хийцийн 1 маягийн зураг



8.3. Гүүр, хоолой, туннеийн төлөвлөлт

5.3.1 Гүүрийн төлөвлөлт

Туулын хурдны замын гүүрнүүдийн зорчих хэсгийг 6 эгнээ зурвастай, нийт 28.0 м өргөнтэй төлөвлөсөн. Амгалангийн уулзварын Туул гол дээгүүр баригдах гүүрний зорчих хэсгийг 2 эгнээ зурвастай, Ажилчны уулзварын Туул гол дээгүүр баригдах гүүрний зорчих хэсгийг 4 эгнээ зурвастай, 2 талдаа 3.0 м өргөн явган хүний зам, 1.5 м өргөн дугуйн замтай төлөвлөв. Гүүрнүүдийн алгасал 25 м, 40 м урттай урьдчилан хүчитгэсэн “Т” хэлбэрийн дам нуруу, 30м, 40 м урттай урьдчилан хүчитгэсэн хайрцаган дам нурууг сонгов. Мөн гүүрэнд Ф1.5 м диаметртэй 15-20 м урттай шон суурь, захын тулгуурт цул төмөрбетон тулгуур, завсрын тулгуурт Ф1.5-2.0 м багана төлөвлөнө.

Зураг 4. 25 м-ийн “Т” хэлбэрийн дам нуруутай гүүрний алгасал байгууламжийн хөндлөн огтлол



Зураг 5. 40 м-ийн хайрцаган дам нуруутай гүүрний алгасал байгууламжийн хөндлөн огтлол



Зураг 6. 40 м-ийн “Т” хэлбэрийн дам нуруутай гүүрийн алгасал байгууламжийн хөндлөн огтлол



Зураг 7. 40 м-ийн алгасалтай гүүрний завсрын тулгуурын хийц



Зураг 8. 25 м-ийн алгасалтай гүүрний захын тулгуурын хийц



Зураг 9. 25 м-ийн алгасалтай гүүрний завсрын тулгуурын хийц



Туулын хурдны замд дараах гүүрнүүдийг төлөвлөж байна. Үүнд:

Хүснэгт 3. Гүүрийн жагсаалт

№	Нэр	Байрлал	Урт	Дам нуруу
1	Төмөр зам гүүр Т.Г-1	ПК1+933.03	142	
2	Улиастай голын гүүр Г-1	ПК2+931.3	101.08	25 м “Т” хэлбэрийн дам нуруутай
3	Туул голын гүүр Г-2	ПК9+860.5	7191.08	40 м хайрцаган дам нуруута
4	Мишээлийн зам дээгүүрх гүүр Г-3	ПК13+871	101.08	25 м “Т” хэлбэрийн дам нуруутай
5	Яармагийн зам дээгүүрх гүүр Г-4	ПК15+075	51.08	25 м “Т” хэлбэрийн дам нуруутай
6	Наадамчдын зам дээгүүрх гүүр Г-5	ПК17+283	561.08	30 м хайрцаган дам нуруутай
7	Сэлбэ гол дээгүүрх Г-6	ПК18+858	75.08	25 м “Т” хэлбэрийн дам нуруутай
8	Сонсголонгийн зам дээгүүрх гүүр Г-7	ПК21+279	551.08	25 м “Т” хэлбэрийн дам нуруутай
9	Амгалангийн уулзварын Туул гол дээгүүрх гүүр	ПК0+650.54	701.08	40 м “Т” хэлбэрийн дам нуруутай
10	Ажилчны уулзварын Туул гол Х.Г-2	ПК0+620.54	321.08	40 м “Т” хэлбэрийн дам нуруутай
11	Бохир усны суваг дээгүүрх гүүр Г-8	ПК28+369	26.08	25 м “Т” хэлбэрийн дам нуруутай
12	Цэвэрлэх байгууламжийн авто зам дээгүүрх гүүр Г-9	ПК29+845	26.08	25 м “Т” хэлбэрийн дам нуруутай

13	Эмээлтийн авто зам дээгүүрх гүүр Г-10	ПК17+283	30	30 м хайрцаган дам нуруутай
			9877.88	

**Дээрх тоо хэмжээ нь ТЭЗҮ-ийн урьдчилсан тоо хэмжээ болно.*

5.3.2 Ус зайлуулах хоолойн төлөвлөлт

Улаанбаатар хот орчмын жижиг гол, горхи сайрын янз бүрийн хангамшилтай хамгийн их урсцыг (200 км2 бага) өнгөрөх хур борооны үерийн хамгийн их урсцыг хур борооны хязгаарын эрчимшилийн аргаар тодорхойлно.
0+000 –7+300, 12+400-15+000, 15+100-28+300 хооронд зайд байгаа зам талбайн усыг хажуу тийш далангийн хажуу (гол) руу, ПК28+300-аас төгсгөл хүртэлх замын усыг далдаар Туул гол, түүний салаа руу хаяна. Гүүр дээр буусан тунадсыг гүүрний ус хаяураар зайлуулахаар тус тус төлөвлөв.
Төслийн замд ус зүйн тооцоог үндэслэн ПК29+500, ПК 30+249, ПК 30+808 дээр 1.5х1.5 м-ийн дөрвөлжин хоолой 3 цэгт, ПК31+487.7 дээр 2.5х2.0 м-ийн дөрвөлжин хоолой 1 цэгт төлөвлөсөн.

5.3.3 Туннелийн төлөвлөлт

Тус замд 4.0х5.7 м туннель 2 цэгт, (8.5х5.79)х2 м туннель 2 цэгт, (11.0х5.35)х2 м туннель 1 цэгт, 11.0х5.35 м туннель 1 цэгт, (11.0х8.0)х3 м төмөр замын туннель 1 цэгт тус тус төлөвлөв.

Хүснэгт 4. Туннель

№	Нэр	Хэмжээ	Урт, м	Байрлал
1.	УБ-Налайх чиглэлийн зам дээгүүрх	(11.0х5.35)х2	35	1+706.022
2.	О.Т огтолцол 2	(8.5х5.79)х2	45.75	5+462.8
3.	О.Т огтолцол 4	(8.5х5.79)х2	45.75	17+960
4.	Хүн, амьтан, машин гаргах зориулалттай	4х5.7	45.75	27+785.16
5.	Төмөр зам туннель	(11.0х8.0)х3	65	27+873
6.	Замын огтолцлын туннель	11х5.35	86	28+670
7.	Хүн, амьтан, машин гаргах зориулалттай	4.0х5.7	45.75	31+530.107

5.3.4 Авто зам төмөр замын огтолцлын төлөвлөлт

Туулын хурдны зам нь 2 цэгт төмөр замтай огтолцоно.
Сүхбаатар-Замын Үүдийн гол төмөр замтай огтолцох цэг төмөр замын 414-5-р зуутад байна. Зам, тээврийн яамны ажлын хэсэг талбайд 2025 оны 1-р сарын 6-ний өдөр ажиллаж энэхүү огтолцлын талаар №25/01/03 дугаар бүхий техникийн нөхцөл гаргасан.

Зураг 10. Төмөр замын гол замын гүүр



Туулын хурдны зам нь Сонгино хайрхан дүүргийн нутаг дэвсгэрт ПК27+873 байрлалд байх төмөр зам дээгүүр гарч байгаа бөгөөд зураг төсөлд урт нь 65 у/м байхаар төлөвлөсөн.

Зураг 11. Төмөр замын туннель (11.0х8.0)х3 м, 65.0 м урт туннель (Зай.27+873)

8.4. Үерийн хамгаалалтын байгууламж

Туулын хурдны замын далангийн хамгаалалтыг дараах байдлаар төлөвлөж байна. Үүнд:

1. Далан-1 - Скай хотхоны ар талын Туул голын гүүрнээс Улиастайн гүүртэй холбосон, Далангийн урт L=1685м.

2. Далан-2 - Улиастайн гүүрнээс ПК7+300 хүртэл, Далангийн урт L=4380м.

3. Далан-3 - ПК12+400-аас ПК15+000 буюу Яармагийн гүүр хүртэл, Далангийн урт L=2655м.

4. Далан-4 - Яармагийн гүүрнээс ПК16+850 хүртэл, Далангийн урт L=1765м.

5. Далан-5 - ПК18+400 буюу хотын үерийн хамгаалалтын сувгийн төгсгөл (Гүүр-12) хүртэл, Далангийн урт L=575м.

6. Далан-6 хотын үерийн хамгаалалтын сувгийн төгсгөл (Гүүр-12)-оос Сонсголонгийн гүүр хүртэл хамгаалах, Далангийн урт L=2314м.

7. Далан-7 - Сонсголонгийн гүүрнээс төлөвлөж буй замын ПК23+650 харалдаа урд талын үерийн хамгаалалтын далантай холбох Далангийн урт L=2337м.

8. Далан-8 - Төлөвлөж буй замын ПК26+420-ийн харалдаа урд талын үерийн хамгаалалтын далангаас төлөвлөж буй туннел 1 буюу замын ПК27+760-д холбох, Далангийн урт L=1457м.

9. Далан-9 – Төлөвлөж буй гүүрний баруун талын хамгаалалт, Далангийн урт L=755м гэж тус тус хамгаалахаар нийт L=17923м далан барихаар урьдчилан төлөвлөж байна.

Далангийн дотор талд угсармал төмөр бетон хавтангаар доторлоно. Далангийн хярын өндөр хамгийн их урсцыг давуулахгүй байхаар төлөвлөв. Дээд налууг хамгаалахад дараах төрлийн бэхэлгээг хэрэглэж болно. Үүнд:

а) Чулуун;

б) Цутгамал бетон, угсармал болон ердийн ба урьдчилан хүчитгэсэн арматуртай төмөр бетон;

в) Асфальтбетон;

г) Биологийн бэхэлгээ гэх мэт байж болно.

Даланг барьж байгуулах ба ашиглалтын туршлага буюу судалгааны үндэслэлээр дээд налууд бусад төрлийн бэхэлгээг хэрэглэж болно. Жишээ нь: хайрга-дайрган, хөрс цементэн г.м. Туул голын хувьд урд хийсэн хамгаалалтын байдал, урсцын хурд, зарцуулга, мөсний нөлөөлөл зэргээс хамааруулан угсармал төмөр бетон хавтангуудаар хамгаалах бөгөөд хавтанг налуудаа доош гулсаж суухаас хамгаалж ёроолд нь тулц бетон тулгуур суулгаж өгөхөөр төлөвлөж байна. Далангийн хярын өргөнийг ашиглалтын ба үйлдвэрлэлийн ажлын нөхцөлөөс хамааруулан 4м байхаар тогтоосон. Мөн хажуу налуу устай харьцах хэсэгт 1:2, гадна хэсэгт 1:1.5 хэмжээстэй байна. Далангийн ёроолыг угаагдахаас хамгаалж газрын гадаргаас h=1-1.5m гүнтэй, b=1.0m өргөнтэй , m=0.5 налуутай чулуун шүдтэй байхаар зураг төсөлд тусгав. Цутгамал буюу угсармал төмөр бетон хавтангаар хийсэн бэхэлгээний доор (нягтруулсан заадастай буюу хэсгүүдийг цутгаж холбосон) элсэрхэг буюу шаварлаг хөрстэй налууд нэг үе урвуу шүүр хийж өгнө.

Зураг 12. Далангийн 1 маягийн хөндлөн огтлол



Туул голын тохойрсон далан чиглэсэн хэсэгт голын голдирлыг 6 хэсэг суваг татан өөрчлөхөөр тусгав. Сувгийн нийт урт 4563.0 метр байна.

Зураг 13. Голдирол өөрчлөх сувгийн хөндлөн огтлол



Далан талын эргийн бэхэлгээг чулуут бэхэлгээнээс гадна габионоор хамгаалахаар төлөвлөж байна.

8.5. Холбооны шугам

Өндөр хурдтай өгөгдөл дамжуулалт: Шилэн кабель нь секундэд хэдэн терабит хүртэл мэдээлэл дамжуулах чадвартай, энэ нь камерын өндөр нягтаршилтай дүрсийг алдаагүй дамжуулах боломжийг олгоно.

Сүлжээний тогтвортой байдал: Гаднын нөлөө (цахилгаан соронзон хөндлөнгийн нөлөө, цаг агаарын нөлөө гэх мэт)-д өртөх нь бага тул найдвартай ажиллагаатай.

Урт хугацааны эдэлгээ: Шилэн кабель нь зэврэхгүй, удаан эдэлгээтэй байдаг тул засвар үйлчилгээний зардал бага.

Олон төрлийн хэрэглээнд нийцэх: Зөвхөн камерын өгөгдөл дамжуулахаас гадна IoT төхөөрөмж, хяналтын төв, мэдрэгч систем зэргийг нэг сүлжээнд холбох боломжтой байна.

PVC хоолой нь замын нягтруулах явцад тэсвэртэй байх боломжтой боловч үүнийг баталгаажуулахын тулд зөв төрлийн PVC хоолой сонгож, зөв суурилуулалт хийх шаардлагатай. Хэрэв замын доорх нөхцөл байдал болон ачаалал ихтэй бол PVC-ийн оронд HDPE (өндөр нягтралтай полиэтилен) хоолой ашиглах нь илүү тохиромжтой байж болох юм.

PVC хоолой нь замын нягтруулах явцад тэсвэртэй байж чадна, гэхдээ хангалттай хамгаалалт, зөв суурилуулалт хийх нь зайлшгүй шаардлагатай. Ердийн нөхцөлд 5-10 см диаметртэй PVC хоолой хэрэглэнэ. Харин хүнд даацын замд илүү том диаметртэй (15-20 см) болон илүү бат бөх хамгаалалттай хувилбар сонгох нь зүйтэй.

HDPE (Өндөр нягтралтай полиэтилен) хоолой нь гаднын даралт, шахалт, механик нөлөөллийг тэсвэрлэх чадвараараа онцлог бөгөөд замын доорх суурилуулалтад өргөн ашиглагддаг.

8.6. Дулаан, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ

“Туулын хурдны замын техник, эдийн засгийн үндэслэл”-ын хүрээнд төлөвлөж буй авто замын трассын дагуу авто замын тэнхлэгээс 150м зайтай байрлаж буй одоо байгаа дулаан, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг хамгаална.

Төлөвлөж буй авто замын 1-р хэсгийн трасс нийт 6.7 км үргэлжлэх ба уг трассын дагууд Улаанбаатар хотын ус хангамжийн ф800-400мм хүртэл голчтой нийт 380 м урт шугам хөндлөн болон дагуу байрлалтайгаар 4 байршилд огтлолцож байна. Мөн 3 байршилд ф500-400 мм хүртэлх голчтой төвийн бохир усны 260м урт шугам сүлжээнүүд тус тус огтлолцож байна. Үүнд:

a) ПК0+300 цэгээс ПК0+400 цэгийн хооронд манай байгууллагын эзэмшлийн төвийн бохир усны ф500мм-ийн шугам трасс хөндлөн,
b) ПК0+800 цэгээс ПК0+900 цэгийн хооронд төвийн эх үүсвэрийн ф500мм,ф600мм-ийн цуглуулах шугам трасс хөндлөн,
c) ПК0+900 цэгээс ПК1+000 цэгийн хооронд төвийн эх үүсвэрийн ф400мм-ийн цуглуулах шугам трасс хөндлөн,
d) ПК1+500 цэгээс ПК1+600 цэгийн хооронд төвийн эх үүсвэрийн ф500мм-ийн цуглуулах шугам трасс дагуу,
e) ПК1+600 цэгээс ПК1+700 цэгийн хооронд төвийн цэвэр усны хос ф800мм-ийн шугам, төвийн бохир усны ф500мм-ийн шугам шугам трасс хөндлөн,
f) ПК1+700 цэгээс ПК2+200 цэгийн хооронд төвийн эх үүсвэрийн ф500мм,ф600мм-ийн шугам, эх үүсвэрийн шилэн кабель трасс дагуу

Зураг 14. Хэсэг 1-н цэвэр ,бохир усны шугам сүлжээ



Шинээр төлөвлөж буй авто замын трассын дагуу огтлолцож буй ус хангамжийн ф800-400мм хүртэл голчтой нийт 380 м урт шугамын ган футляр хийж хүчитгэнэ. Мөн 3 байршилд байрлаж буй ф500-400 мм хүртэлх голчтой төвийн бохир усны 260 м урт шугам сүлжээг ган футляр хоолойд хийж хүчитгэнэ.

Төлөвлөж буй авто замын 2-р хэсгийн трасс нийт 13.2 км үргэлжлэх ба уг трассын дагууд Улаанбаатар хотын дулаан хангамжийн 2ф350-500мм голчтой нийт 450м урт шугам 3 байршилд хөндлөн огтлолцож байна. Ус хангамжийн ф400-300мм хүртэл голчтой нийт 462 м урт шугам 2 байршилд огтлолцож байна. Мөн 2 байршилд 2ф600-400 мм хүртэлх голчтой хос төвийн бохир усны 657м урт шугам сүлжээнүүд тус тус огтлолцож байна. Үүнд:

a) ПК9+200 цэгээс ПК9+300 цэгийн хооронд 12И магистраль 2ф350мм
b) ПК11+500 цэгээс ПК11+600 цэгийн хооронд 1А магистраль 2ф400мм
c) ПК15+100 цэгээс ПК15+200 цэгийн хооронд 10Ж магистраль 2ф500мм
d) ПК8+600 цэгээс ПК8+700 цэгийн хооронд төвийн бохир усны ф600,ф300мм-ийн шугам, цэвэр усны ф300мм-ийн шугам трасс хөндлөн
e) ПК0+700 цэгээс ПК0+800 цэгийн хооронд төвийн цэвэр усны хос ф400мм-ийн шугам трасс хөндлөн
f) ПК12+300 цэгээс ПК12+400 цэгийн хооронд төвийн бохир усны ф250мм-ийн шугам трасс хөндлөн

Зураг 15. Хэсэг-2-ийн дулаан, цэвэр ,бохир усны шугам сүлжээ



Шинээр төлөвлөж буй авто замын трасстай огтлолцож буй 12и магистрал шугамыг шинэчилж сувгийг хүчитгэхээр төлөвлөсөн. 2ф400мм хүртэл голчтой 1а магистрал шугамыг шинэчилж сувгийг хүчитгэнэ. Мөн 2ф600мм голчтой 10ж магистрал шугамыг шилжүүлж шугамыг шинэчлэх ажлыг хийхээр төлөвлөсөн. Авто замын трассын дагуу огтлолцож буй ус хангамжийн ф300-400мм хүртэл голчтой нийт 462 м урт шугамын ган футляр хийж хүчитгэхээр төлөвлөсөн. Ф600-250 мм хүртэлх голчтой төвийн бохир усны 657 м урт шугам сүлжээг ган футляр хоолойд хийж хүчитгэхээр төлөвлөсөн.

Төлөвлөж буй авто замын 3-р хэсгийн трасс нийт 12.1 км үргэлжлэх ба уг трассын дагууд Улаанбаатар хотын дулаан хангамжийн 2ф600мм голчтой 145 м урт 15Б магистал шугам, 2ф700мм голчтой нийт 117м урт 13А магистал шугамууд тус тус 2 байршилд хөндлөн огтлолцож байна. Ус хангамжийн ф80мм хүртэл голчтой нийт 234 м урт шугам огтлолцож байна. Мөн үйлдвэрийн эх үүсвэрийн 9, 10, 11-р худгууд болон цуглуулах шугам трасс дагуу байрлаж байна. Үүнд:

a) ПК19+900 цэгээс ПК20+100 цэгийн хооронд 15Б магистраль 2ф600мм
b) ПК21+200 цэгээс ПК21+300 цэгийн хооронд 13А магистраль 2ф700мм
c) ПК28+900 цэгээс ПК29+500 цэгийн хооронд үйлдвэрийн эх үүсвэрийн 9,10,11 дүгээр худгууд болон цуглуулах шугам трасс дагуу тус тус байрлаж байна.

Зураг-16. Хэсэг-3-ийн дулаан, цэвэр ,бохир усны шугам сүлжээ



Шинээр төлөвлөж буй авто замын трасстай огтлолцож буй 2ф600мм голчтой 15б магистрал шугамыг шинэчилж сувгийг хүчитгэсэн нэвтрэх сувагт төлөвлөсөн. 2ф700мм хүртэл голчтой 13а магистрал шугамыг шинэчилж сувгийг хүчитгэнэ. Авто замын трассын дагуу огтлолцож буй ус хангамжийн ф300-400мм хүртэл голчтой нийт 234 м урт шугамын ган футляр хийж хүчитгэнэ.

8.7. Авто замын тоноглолууд

Замын тэмдэг, мэдээллийн самбар, хэвтээ тэмдэглэгээ, дуу шуугианы хамгаалалт, тээврийн хэрэгслийн гэрэл ойлт сааруулагч, хөдөлгөөний чиглэл тусгаарлагч хашилт, хамгаалалтын төмөр болон бетон хашилт мөн орчин үеийн техникийн дэвшилттэй удирдлага хяналтын систем, төлбөр хураах цэг зэрэг байна.

Хөдөлгөөний аюулгүй байдлын нөхцөлийг нэмэгдүүлэхэд хөдөлгөөний эсрэг урсгалыг тусгаарлах зориулалттай хөдөлгөөн тусгаарлах аюулгүйн төмөрбетон зааглах хашлагыг төсөллөсөн.

Зураг 17. Зорчих хэсгийн голд байрлах төмөрбетон зааглах хашлага, гэрлийн гялбаа сарниулагч

Дуу шуугиан тусгаарлагч хаалтыг олон түвшний уулзвар болон барилгажилт бүхий суурин газруудтай хэсэгт байрлуулна.

Зураг 18. Дуу, шуугиан тусгаарлагч

Хурдны замын дагууд хамгаалалтын хашааг нийт уртад төлөвлөж өгсөн. Энэ нь хурдны зам руу явган зорчигч, мал амьтан орох эрсдэлээс сэргийлэх чухал ач холбогдолтой.

Зураг 19. Хамгаалалтын хашаа

Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тоноглолын нэг ган туузан хашилтыг хурдны замын нийт уртад 2 талаар төлөвлөж өгсөн. Туузан хашилтад гэрэл ойлгуур буюу катафот байрлуулна.

Зураг 20. Туузан хашилт

8.8. Цахилгаан шугам, гэрэлтүүлэг, дэд станц

5.8.1. Цахилгаан дамжуулах шугамын өөрчлөлт:

110кВ-н Яармагын А,Б агаарын шугамын тулгуур №10,11, 12, 13-ыг зөөж шилжүүлэх бөгөөд энэ хэсэгт шугамын трассын өөрчлөх ажил хийгдэнэ. Үүгээр тулгуур №10,11,12-ыг завсрын анкер тулгуур болгох бөгөөд тулгуур №13 зөөж

шилжүүлэнэ. Энэ ажлыг хэрэгжүүлэх техникийн нөхцөлд дараах тусгай заалтууд тусгагдсан бөгөөд тэдгээрийг баримтлан ажиллах шаардлагатай. Үүнд:

- Анкер тулгуурын шинэчлэлтийг сонгох
- Зураг төслөөр цахилгаан дамжуулах агаарын шугам, хурдны замтай огтлолцож байгаа хэсэгт зуны улиралд дамжуулагчийн унжилтын хамгийн доод цэг нь хурдны замаас 8м-ээс багагүй зайтай байхаар хийх;
- Шугамын дамжуулагч утсыг дүүжлэх, холбох ба татах арматур ГОСТ27396, ГОСТ Р51177-98 стандартуудтай дүйцэхүйц чанарын шаардлагыг хангахуйц байх;
- Шугамын механик тооцоог шинэчлэн бодож ЦДҮС ТӨХК-иар батлуулах;
- Хурдны замтай огтлолцож байгаа тулгууруудад 110 кВ-ын цэнэг шавхагч /ОПН/ суурилуулах;
- Шинээр суурилуулж байгаа тулгуур, утас, фундамент, холбох хэрэгслийн үйлдвэрийн баталгаа, гарал үүслийн гэрчилгээг ЦДҮС ТӨХК-д ирүүлэх;
- Цахилгаан дамжуулах агаарын шугам, хурдны замтай огтлолцож байгаа хэсгийн тулгууруудад таталтын давхар хөндийрүүлэгч элемент сонгох;
- Дамжуулагч утасны таталтын хавчаарыг НАС маркийн шахдаг хавчаараар хийх:
- Шинээр суурилуулах 110 кВ-ын ЦДАШ-ын тулгуурын үндсэн хийцүүд, аянгын тросс хөндийрүүлэгч элементүүд, утас, угсралтын тоноглолууд нь олон улсын стандартын шаардлага хангасан байх, тухайн газар орчны нөхцөл онцлогуудыг харгалзан зураг төслөөр сонгох;
- Завсрын төмөр болон бетон тулгууруудыг анкер тулгуур болгож өөрчилж байгаатай холбогдуулан тулгуурын хөндийрүүлэгч элемент, утас болон аянгын тросс угсралтын бүх тоноглолыг анкер тулгуурт таарах таталтын ачаалал тохирсон тоноглолоор таталтыг сонгож бүрэн шинэчлэх;
- Шинэчилж, зөөж шилжүүлж байгаа тулгуур бүрт машин механизм засвар үйлчилгээ явуулах боломжтой байх;
- Шинээр суурилуулах анкер тулгуурт тохирох суурийн фундаментийг зураг төслийн шатанд тооцож оновчтойгоор сонгох;
- Тулгууруудыг зөөж шилжүүлэн шугамын трасс өөрчилж байгаатай холбоотойгоор барилга угсралтын ажлын явцад 110/35/10 кВ-ын Яармаг дэд станцын цахилгаан эрчим хүчний тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах техникийн шийдлийг гаргах;
- Шинээр суурилуулах анкер тулгуурын зураг төслийг ЦДҮС ТӨХК-ийн Үйлдвэр техникийн хэлтэс, Улаанбаатар салбартай зөвшилцөх;
- Шинээр суурилуулах анкер тулгуурт нормын дагуу газардлага хийх;
- Тулгуурын зураг төсөл, угсралтын ажлыг ЦДҮС ТӨХК-тай зөвшилцөж сонгох ба зөвхөн Монгол улсад Эрчим хүчний барилга угсралтын зураг төсөл ба угсралтын ажлыг гүйцэтгэх “Тусгай зөвшөөрөл” бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;

- Шилжүүлэн зөөвөрлөх, угсралтын ажилд стандартын шаардлага хангасан шинэ материал, тоног төхөөрөмж ашиглах;
- Шинэчилж суурилуулсан анкер тулгуурт нормын дагуу газардлагын хүрээг өгөх ба эсэргүүцэл нь 10 Омоос хэтрэхгүй байх;
- 110 кВ-ын ЦДАШ-ын угсралтын ажлыг Монгол улсын “Цахилгаан байгууламжийн дүрэм”, Эрчим хүчний тоног төхөөрөмж байгууламжийн “Техник ашиглалтын дүрэм”, Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх “Аюулгүй ажиллагааны дүрэм”, Барилгын норм ба Дүрмийн цахилгаан сантехникийн ажил 3.05.06.90 ба 3-07-6-гийн заалтын дагуу гүйцэтгэх;
- Барилга угсралтын ажил дууссаны дараа буусан тулгуур №10, 11, 12 болон дагалдах сэлбэг материал, ажлын зураг, холбогдох тооцоог “ЦДҮС” ТӨХК-д хүлээлгэн өгөх;
- Тулгууруудыг шинэчлэх ажилд хаалт хашилт, тэмдэглэгээг шинэчлэх.

5.8.2. Цахилгаан түгээх шугамын өөрчлөлт ба хамгаалалт:

Туулын хурдны замын трасст цахилгаан түгээх сүлжээний нилээд шугам өртөж байгаа бөгөөд тэдгээрийг хамгаалах ажлыг 2024.12.29-ны өдөр Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрмйн өмчих хувьцаат компаний 01/06602/24 дугаар бүхий техникийн нөхцлийн дагуу хэрэгжүүлэх шаардлагатай. Энэ хүрээнд дараах ажлууд хийгдэнэ.

1. Олон улсын стандартын шаардлага хангасан, алдагдал багатай 63 кВА чадалтай, 10/0.4 кВ-ын хүчдэлийн, хүчдэл тохируулгын 5 шатлалтай трансформатор бүхий кабелийн оруулгатай дэд өртөөг /КТПН/ хурдны замын зурваст шинээр барих.

1.1 6 кВ-ын шугамтай байршлуудад олон улсын стандартын шаардлага хангасан, алдагдал багатай 63 кВА чадалтай, 6, 10 кВ-ын хүчдлийн төвшинд шилжин ажиллах боломжтой 6, 10/0.4 кВ-ын хүчдлийн, хүчдэл тохируулгын 5 шатлалтай трансформатор бүхий кабелийн оруулгатай дэд өртөөг /КТПН/ хурдны замын зурваст шинээр барих.

2. 10 кВ-ын ХААХ фипдерийн КТПН-6024-ын трансформаторын чадлыг 63 кВА болгон томсгон өргөтгөх, Дэд өртөөний трансформаторын чадлыг томсгож байгаатай холбогдуулан 10/0.4 кВ талуудад зохих өөрчлөлтүүдийг зургийн дагуу хийх;

2.1 Гадны эзэмшлийн шугам тоноглолоос холбогдох тохиолдолд зураг төсөл боловсруулах шатанд эзэмшигчээс зөвшөөрөл авч, зөвшилцсөн байх;

2.2 УБЦТС ТӨХК-ийн эзэмшлийн шугам дэд станцад хийгдэх өргөтгөлийн ажлыг харьяа түгээх төвөөр гүйцэтгүүлэх.

2.3 Өөрийн дэд станц, шугам тоноглолоос хангагчийн зөвшөөрөлгүйгээр бусад хэрэглэгчийг холбосон тохиолдолд цахилгаан хангамж хэрэглээг түдгэлзүүлнэ.

2.4 Цахилгаан хангамжийн III зэрэглэлийн шугамаас холбогдож байгаа тул цахилгаан эрчим хүч тасарсан үед тэжээх нөөц эх үүсгүүр /дизель генератор/ суурилуулах.

2.5 Дэд станц, шугам тоноглол нь хоёр талын цахилгааны эх үүсвэрээс тэжээлтэй болон автомат сэлгэн залгагч төхөөрөмж суурилуулсан мөн аварийн нөөцийг эх үүсвэр /дизель, генератор/ - тэй бол харьяа түгээх төвтэй Шуурхай ажиллагааны гэрээ байгуулах.

2.6 Шитний газардуулга болон шугам тоноглолын хэмжилт, туршилтын норм, дүрмийн дагуу хийлгэх, шалгуулах.

3. Төлөвлөж байгаа замын хэсэгт дараах агаарын болон кабель шугам, тулгуурууд, дэд өртөө нь авто замын трасстай давхацсан, зам хөндлөн гарсан, ойртсон тул батлагдсан зургийн дагуу агаарын шугамаар трасс өөрчлөн зөөх, өндөрлөх. Үүнд:

3.1 35 кВ-ын агаарын шугам:

a) 110/35/10 кВ-ын Дүнжингарав дэд станцын 35 кВ-ын Баянзүрх А, Б ЦДАШ-ын тулгуур №38-39, 40-41, 41-42, 44-45 хооронд огтлолцсон тул батлагдсан зургийн дагуу өндөрлөх.

b) 110/35/10 кВ-ын Дүнжингарав дэд станцын 35 кВ-ын Баянзүрх А, Б ЦДАШ-ын тулгуур №45 авто замын трасст орсон тул батлагдсан зураг төслийн дагуу төмөр анкер тулгуураар сольж зөөж шилжүүлэх

c) ТЭЦ-3-ийн 35 кВ-ын Сонгино А, Б ЦДАШ-ын тулгуур №10-11 хооронд огтлолцсон тул батлагдсан зургийн дагуу өндөрлөх

d) 110/10/6 кВ-ын Дундгол дэд станцын Шинэ гэр А, Б ЦДАШ-ын тулгуур №11-12 хооронд огтлолцсон тул батлагдсан зургийн дагуу өндөрлөх

e) 110/35/10 кВ-ын Цэнгэг дэд станцын 35 кВ-ын Гэрэл ЦДАШ-ын тулгуур №9-10хооронд огтлолцсон тул батлагдсан зургийн дагуу өндөрлөх

f) 110/35/10 кВ-ын Цэнгэг дэд станцын 35 кВ-ын Гэрэл ЦДАШ-ын тулгуур №9 авто замын трасст орсон тул батлагдсан зураг төслийн дагуу төмөр анкер тулгуураар сольж зөөж шилжүүлэх

g) 110/35/10 кВ-ын Цэвэрлэх дэд станцын 35 кВ-ын Рашаант ЦДАШ-ын тулгуур №38-39 хооронд огтлолцсон тул батлагдсан зургийн дагуу өндөрлөх

3.2 0.4 кВ болон 6, 10 кВ-ын кабель шугамууд:

a) 35/10 кВ-ын Гэрэл дэд станцын 10 кВ-ын Баруун туруун фидер тулгуур №20-с КТПН-6155 явсан кабель 1ш

b) 35/10 кВ-ын Гэрэл дэд станцын 10 кВ-ын Баруун туруун фидер тулгуур №21-с КТПН-976 явсан кабель 1ш

c) 35/10 кВ-ын Гэрэл дэд станцын 10 кВ-ын Баруун туруун фидер тулгуур №21-141 явсан кабель 1ш

d) 35/10 кВ-ын Гэрэл дэд станцын 10 кВ-ын Баруун туруун фидер тулгуур №20-468 явсан кабель 1ш

e) 35/10 кВ-ын Гэрэл дэд станцын 10 кВ-ын Баруун туруун фидер тулгуур №145-146 явсан кабель 1ш
f) 35/10 кВ-ын Гэрэл дэд станцын 10 кВ-ын Баруун туруун фидер тулгуур №611-с КТПН-10097 явсан кабель 1ш
g) 35/10 кВ-ын Гэрэл дэд станцын 10 кВ-ын Баруун туруун фидер тулгуур №611-с КТПН-6930 явсан кабель 1ш
h) 110/10 кВ-ын Буянт-Ухаа дэд станцын 10 кВ-ын Дэвшил фидерийн тулгуур №1 явсан кабель 1ш
i) 110/10 кВ-ын Буянт-Ухаа дэд станцын 10 кВ-ын Чулуун хийц фидерийн тулгуур №1 явсан кабель 1ш
j) 110/10 кВ-ын Буянт-Ухаа дэд станцын 10 кВ-ын Чулуун хийц фидерийн тулгуур №1-с КТПН-5960 явсан кабель 1ш
k) ТЭЦ-3-ын 6 кВ-ын Сонсголон – 1 фидерийн тулгуур №123-124 хоорондох кабель 1 ширхэг
l) ТЭЦ-3-ын Насос-1 фидерийн РП-67-ын Хийморь фидерийн оролт 10кВ-ын кабель 1 ширхэг
m) ТЭЦ-3-ын Насос-1 фидерийн РП-67-ын КТПН-4970 явсан 6 кВ-ын кабель 1 ширхэг
n) 35/6-ын Эсгийлэх дэд станцын ХБЗ фидерийн ХТП-971-ХТП-284 явсан 6 кВ-ын кабель 1ш
o) 35/6-ын Эсгийлэх дэд станцын ХБЗ фидерийн ХТП-284-ХТП-1400 явсан 6 кВ-ын кабель 1ш
p) 35/6-ын Эсгийлэх дэд станцын ХБЗ фидерийн ХТП-284-ХТП-1707 явсан 6 кВ-ын кабель 1ш
q) 35/6-ын Эсгийлэх дэд станцын ХБЗ фидерийн ХТП-284-өөс ААН явсан 0,4 кВ-ын кабель 4ш
r) 110/10/6 кВ-ын Өмнөд дэд станцаас РП-33 явсан 10 кВ-ын 2ш кабель
s) 110/10/6 кВ-ын Өмнөд дэд станцаас ХТП-5269 явсан 10 кВ-ын 2ш кабель
t) 110/35/6 кВ-ын Зайсан дэд станцын ХТП-6033 явсан 10 кВ-ын 2ш кабель
u) 110/35/6 кВ-ын Зайсан дэд станцын гаднын ХБ руу явсан 10 кВ-ын 2ш кабель

3.3 0,4 кВ болон 6, 10 кВ-ын агаарын шугам:

a) 35/10 кВ-ын Гэрэл дэд станцын 10 кВ-ын Баруун туруун фидерийн тулгуур №19 туулын хурдны замын трассд 2м ойртсон
b) 35/10 кВ-ын Гэрэл дэд станцын 10 кВ-ын Баруун туруун фидерийн тулгуур №134-136 хоорондох ЦДАШ авто замын трасстай огтлолцсон тул зураг төслийн дагуу өндөрлөх
c) 35/10 кВ-ын Гэрэл дэд станцын 10 кВ-ын Баруун туруун фидерийн тулгуур №135 авто замын трассд орсон тул батлагдсан зураг төслийн дагуу трасс өөрчлөн зөөх

d) 35/10 кВ-ын Гэрэл дэд станцын 10 кВ-ын Нефть фидерийн тулгуур №269-267 ЦДАШ авто замын трасстай огтлолцсон тул зураг төслийн дагуу өндөрлөх
e) 35/10 кВ-ын Гэрэл дэд станцын 10 кВ-ын Нефть фидерийн тулгуур №268 авто замын трасст орсон тул батлагдсан зураг төслийн дагуу трасс өөр
f) члөн зөөх
g) 35/10 кВ-ын Гэрэл дэд станцын 10 кВ-ын Нефть фидерийн тулгуур №360-362 ЦДАШ авто замын трасстай огтлолцсон тул зураг төслийн дагуу өндөрлөх
h) 35/10 кВ-ын Гэрэл дэд станцын 10 кВ-ын Нефть фидерийн тулгуур №361 авто замын трассд орсон тул батлагдсан зураг төслийн дагуу трасс өөрчлөн зөөх
i) 35/6 кВ-ын Био дэд станцын 6 кВ-ын Сонгино фидерийн тулгуур №87-89 хоорондох ЦДАШ-тай огтлолцсон тул өндөрлөх
j) 35/6 кВ-ын Био дэд станцын 6 кВ-ын Сонгино фидерийн тулгуур №88 трасст орсон тул батлагдсан зураг төслийн дагуу трасс өөрчлөн зөөх
k) 35/6 кВ-ын Био дэд станцын 6 кВ-ын Сонгино фидерийн тулгуур №97-99 хоорондох ЦДАШ-тай огтлолцсон тул өндөрлөх
l) 35/6 кВ-ын Био дэд станцын 6 кВ-ын Сонгино фидерийн тулгуур №98 трасст орсон тул батлагдсан зураг төслийн дагуу трасс өөрчлөн зөөх
m) 110/10 кВ-ын Буянт-Ухаа дэд станцын 10 кВ-ын Чулуун хийц фидерийн тулгуур №1-3 хоорондох ЦДАШ-тай огтлолцсон тул зураг төслийн дагуу өндөрлөх
n) 110/10 кВ-ын Буянт-Ухаа дэд станцын 10 кВ-ын Чулуун хийц фидерийн тулгуур №1, 2 трасст орсон тул батлагдсан зураг төслийн дагуу трасс өөрчлөн зөөх
o) 110/10 кВ-ын Буянт-Ухаа дэд станцын 10 кВ-ын Чулуун хийц фидерийн тулгуур №1-113 хоорондох ЦДАШ-тай огтлолцсон тул зураг төслийн дагуу өндөрлөх
p) 110/10 кВ-ын Буянт-Ухаа дэд станцын 10 кВ-ын Чулуун хийц фидерийн тулгуур №1 трасст орсон тул батлагдсан зураг төслийн дагуу трасс өөрчлөн зөөх
q) ТЭЦ-2-ын 6 кВ-ын Худаг фидерийн тулгуур №39-40 хоорондох ЦДАШ-тай огтлолцсон тул зураг төслийн дагуу өндөрлөх
r) ТЭЦ-2-ын 6 кВ-ын Худаг фидерийн тулгуур №38-39 хоорондох ЦДАШ-тай огтлолцсон тул зураг төслийн дагуу өндөрлөх
s) ТЭЦ-2-ын 6 кВ-ын Худаг фидерийн тулгуур №36 трасст 2м ойртсон тул батлагдсан зураг төслийн дагуу трасс өөрчлөн зөөх
t) ТЭЦ-3-ын 6 кВ-ын Сонсголон-1 фидерийн тулгуур №128-129 хоорондох ЦДАШ-тай огтлолцсон тул зураг төслийн дагуу өндөрлөх

u) ТЭЦ-3-ын 6 кВ-ын Сонсголон-1 фидерийн тулгуур №129 трасст орсон тул батлагдсан зураг төслийн дагуу трасс өөрчлөн зөөх
v) 110/35/10 кВ-ын Туул дэд станцын 10 кВ-ын Харш А, Б фидерийн тулгуур №43-44 хоорондох ЦДАШ авто замын трасстай огтлолцсон тул зураг төслийн дагуу өндөрлөх
w) 110/10 кВ-ын Амгалан дэд станц, ХБ-18-ын 10 кВ-ын Ундарга фидерийн тулгуур №33-36 хоорондох ЦДАШ-тай огтлолцсон тул зураг төслийн дагуу өндөрлөх
x) 110/10 кВ-ын Амгалан дэд станцын 10 кВ-ын ХААХ фидерийн тулгуур №176-180 хоорондох ЦДАШ-тай огтлолцсон тул зураг төслийн дагуу өндөрлөх
y) ХБ-17-ын 6 кВ-ын Харз фидерийн тулгуур №30-36 хоорондох ЦДАШ-тай огтлолцсон тул зураг төслийн дагуу өндөрлөх
z) ХБ-17-ын 6 кВ-ын Харз фидерийн ХТП-0503-ын 0,4 кВ-ын ЦДАШ-ын тулгуурыг өндөрлөх
aa) ХБ-17-ын 6 кВ-ын Цоргио фидерийн тулгуур №56-57 хоорондох ЦДАШ-тай огтлолцсон тул зураг төслийн дагуу өндөрлөх
bb) 35/10 кВ-ын Гэрэл дэд станцын 10 кВ-ын Баруун туруун фидерийн тулгуур №21-22 тулгуураас салбар авсан агаарын шугамыг буулган хэрэглэгчдэд хүлээлгэн өгөх
cc) 35/10 кВ-ын Гэрэл дэд станцын 10 кВ-ын Баруун туруун фидерийн №21-175 тулгуур хүртэл шинээр агаарын шугам татаж, хэрэглэгчдийг шилжүүлж холбох

4. Цахилгаан дамжуулах агаарын болон кабель шугамын зөөх байршлын зургийг эрх бүхий байгууллагаар хийлгэн Нийслэлийн барилга, хот байгуулалт төлөвлөлтийн газраар батлуулж, мэдээллийн санд оруулсан байх, холболт, хүчин чадлыг тус хянуулах.
5. Кабель шугамыг шилжүүлэн зөөх хэсэгт байгаа муфтьны байршлын тодруулгыг харьяа ашиглалт засварын төвөөс авч, шугамыг муфтьнаас муфтьны хооронд зөөх асуудлыг барилга угсралтын ажлын зураг төслийн шатанд УБЦТС ТӨХК-тай зөвшилцөж гүйцэтгэх.
6. Авто замын трассын уртын 50 метр тутамд зам хөндлөн ган хоолой суурилуулах. Суурилуулах ган хоолойны байршил, тоо хэмжээг зураг төслийн шатанд тус компанийн техникийн бодлогын хэлтэстэй зөвшилцөх.
7. Шинээр татах кабель шугам нь авто зам болон тохижилттой зам талбайгаар хөндлөн гарах тохиолдолд кабелийг ган хоолойнд сүвлэх ба тохижилттой зам талбайд авах боломжтой хавтан суурилуулах.
8. Батлагдсан зургийн дагуу зөөж шилжүүлэх шугамын трасс өөрчлөгдөх тохиолдолд харьяа ашиглалт засварын төвөөс дахин тодруулга авч УБЦТС ТӨХК-тай зөвшилцөх.
9. Газар шорооны ажил хийж байхдаа кабель шугамыг гэмтээсэн тохиолдолд тухайн кабель гэмтээд зогсохгүй бусад тоног төхөөрөмж гэмтэх,

хэрэглэгчдийн цахилгаан хэрэгсэл шатах зэрэг ноцтой зөрчлүүд үүсэх бөгөөд гарсан төлбөрийг буруутай байгууллага ААНэгж, иргэн хариуцна.

10. Угсралтын ажлын явцад тус компанийн харьяа ашиглалт засварын төвөөр хяналт тавиулж холбогдох баримтыг бүрдүүлсэн байх.
11. Авто замын трасст орсон УБЦТС ТӨХК-ийн эзэмшлийн бус цахилгаан дамжуулах шугам, тоноглолыг шилжүүлэн зөөх тохиолдолд эзэмшигчээс зөвшөөрөл авах ба бусад инженерийн байгууламж хариуцсан байгууллагуудтай зөвшилцсөн байх.
12. Шилжүүлэн зөөсөн болон шинэчилсэн цахилгаан дамжуулах агаарын болон кабель шугам, тулгуур, дэд өртөө бусад тоноглолыг УБЦТС ТӨХК-ийн харьяа ашиглалт засварын төвд актаар хүлээлгэн өгөх.
13. Буусан тоног төхөөрөмжийг МОнгол улсын засгийн газрын 2020 оны 97-р тогтоолын 2.7.2-т заасны дагуу УБЦТС ТӨХК-ийн үндсэн хөрөнгөнд шилжүүлэн өгөх.
14. Зөөж шилжүүлэх цахилгаан дамжуулах шугамын угсралтын зураг төслийг ЦБД-ийн БД 43-101-03-д заасны дагуу зай хэмжээг баримтлан гүйцэтгэх.
15. Газар шорооны ажил эхлэхээс өмнө УБЦТС ТӨХК-ийн харьяа ашиглалт засварын төвд хандаж дахин тодруулга хийлгэх, барилга угсралтын ажлын үед хяналт тавиулж холбогдох баримтыг бүрдүүлсэн байх.
16. УБЦТС ТӨХК-ийн эзэмшлийн шугам дэд станцыг шилжүүлэн зөөх ажлыг харьяа түгээх төвөөр гүйцэтгүүлэх.
17. Шинээр барих цахилгаан дамжуулах кабель шугам нь:
    a) Шинээр татах 10кВ-ын кабель шугам нь MNS 6819:2015 стандартын шаардлагыг хангасан байх.
    b) Шинээр татах 10кВ-ын кабель шугамын хөндлөн огтлолыг хэрэглээ ачаалалтай уялдуулан зураг төслийн шатанд тооцоогор сонгох, ашиглагч УБЦТС ТӨХК-тай зөвшилцөх.
    c) Шинээр татах 10кВ-ын хүчдэлийн төвшинд ашиглах, орчны температур -15хэм байхад угсралт хийх боломжтой байх.
18. Шинээр баригдах цахилгаан дамжуулах агаарын шугам нь:
    a) Цахилгаан дамжуулах агаарын шугамын үндсэн хийц болох анкер болон завсрын тулгуур нь төмөр болон төмөр бетон байх.
    b) Дамжуулагч нь бүрээстэй байх ба хөндлөн огтлолыг ачаалалтай уялдуулан, тооцоогоор сонгох, мөн утасны механик ачаалалд тохирсон үндсэн хийцүүд, хөндийрүүлэгч элементүүдийг тооцоогоор сонгох.
    c) Цахилгаан дамжуулах агаарын шугамын үндсэн хийцүүд, дамжуулагч утас, хөндийрүүлэгч элементүүд, утас угсралтын тоног төхөөрөмжүүд нь Монгол улсын стандартын шаардлага хангасан байх, тухайн газрын байгаль цаг уур, газарзүйн онцлогийг харгалзан зураг төслөөр сонгох.

<u>5.8.3. Цахилгаан гэрэлтүүлгийн шугам сүлжээ:</u>

Туулын хурдны замын нийт 32км-т 6 эгнээ замын гэрэлтүүлгийг төлөвлөхдөө Үндсэн замын 2км тутамж 63кВА бүхий нийт 16ком иж бүрдмэл дэд өртөө барьж, гадна гэрэлтүүлгийн удирдлагийн самбараас цагийн болон фото релений удирдлага бүхий 2-4 гаргалга 0,4кВ-ын кабель шугамаар тэжээхээр төлөвлөв. Мөн уг дэд станцаас цаашид авто замтай холбоотой камер гэрэлт дохио зэрэгт зориулсан цахилгаан хэрэглээ авах бололцоог хангах нөөц 10-20кВт тэжээлийн эх үүсгэвэрийг тооцсон.

Гэрэлтүүлэгчийн шийдлүүд:

1. Шонгийн өндөр - 10м
2. Гэрэлтүүлэгчийн төрөл, чадал – LED-150W
3. Үндсэн замын голын бариерын дунд хос толгой бүхий гэрэлтүүлэгчтэй
4. Салбар зам болон 6 эгнээ замын захын эгнээний гэрэлтүүлэгт дан толгойтой гэрэлтүүлэгч байна
5. Гэрэлтүүлийн кабель нь барерийн бетон хашлагын нүхэнд сүвлэгдэнэ
6. Нэг тэжээлийн эх үүсгүүрээс 1км ээс ихгүй алслагдахаас хүчдэлийн уналтыг тооцсон

Хүснэгт 5. Дэд станц, гэрэлтүүлгийн жагсаалт

Үзүүлэлтүүд	1-р хэсэг	2-р хэсэг	3-р хэсэг
Дэд станцын тоо	3	7	6
Гэрэлтүүлэгчийн тоо	903	1730	1698
Нийт чадал	136кВт	260кВт	254кВт

5.9. Ажиллах хүч, тоног төхөөрөмжийн шаардлага

Энэ зүйлд заасан ажиллах хүч болон тоног төхөөрөмжийн шаардлагыг Гүйцэтгэгч хангасан байна.

Хүснэгт 6. Ажиллах хүчний шаардлага

№	Нэр	Тоо	Ажлын туршлага /Жилээр/
1	Төслийн менежер	1	15
2	Ерөнхий инженер	1	15
3	Чанарын менежер	1	10
4	ХАБЭА-ны менежер	3	10
5	Үйлдвэрлэлийн менежер	4	10
6	Ерөнхий нягтлан	1	10
7	Ерөнхий Төсөвчин	1	10
8	Барилгын инженер	4	10
9	Геотехникийн инженер	1	10
10	Цахилгааны инженер	3	10

11	Шугам сүлжээний инженер	3	10
12	Гүүрийн инженер	5	10
13	Авто замын инженер	5	10
14	Геодизийн инженер	8	5
15	Хяналтын инженер	10	5
16	Төсөвчин	2	5
17	Аюулгүй ажиллагааны мэргэжилтэн	10	5
18	Нягтлан	3	5
19	Хуульч	1	10

Хүснэгт 7. Тоног төхөөрөмж, машин механизмын шаардлага

№	Нэр	Тоо	Хүчин чадал
1	Экскаватор	8	1.6 м3
2	Грейдэр	6	175 морьны хүчтэй
3	Өөрөө буулгагч	50	20 тон
4	Далангийн индүү	6	14-16 тон
5	Асфальтны индүү	6	11-12 тон
6	Доргиурт индүү	6	13-16 тон
7	Ковш	6	3 м3
8	Асфальт дэвсэгч	2	2.5-12 м хүртэл сунах боломжтой
9	Эмульс цацагч	2	6,000 литр
10	Усны машин	4	15,000 литр
11	Помп	2	20 м
12	Бетон зуурагч миксер	10	8.0 м3
13	Кран	4	25 тон

6. СТАНДАРТ, ДҮРЭМ, ЖУРАМ, НОРМ, НОРМАТИВ

Ажлын зураг төсөл, барилгын ажил нь Захиалагч зөвшөөрсний дагуу болон холбогдох хууль, баримт бичиг, дүрэм, журам, стандартад нийцсэн байна.

Зураг төслийн техникийн шаардлага, стандарт, техникийн үзүүлэлтэд аливаа зөрчилдөөн үүсвэл Зураг төслийн техникийн шаардлага давуу хүчинтэй. Гүйцэтгэгч нь Монгол улсад мөрдөгддөггүй, хүчин төгөлдөр бус дүрэм, журам, стандарт ашиглах тохиолдолд Захиалагчаас татгалзах зүйлгүй тухай Мэдэгдлийг урьдчилан авах үүрэг хүлээнэ. Ийнхүү ашиглах дүрэм, журам, стандартыг орчуулж, батлуулах ажлыг Гүйцэтгэгч хариуцна.

Үйлчлэх дүрэм, журам, стандарт болон баримт бичгүүдэд дараах багтах ба эдгээр баримт бичгийн аливаа нэмэлт, өөрчлөлтийг хамруулан ойлгоно.

Хүснэгт 6. Стандарт, дүрэм, журам, норм норматив жагсаалт

Стандартын нэр	Тогтоолын дугаар
Авто зам гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ БД81-104-02	БД81-104-02
Авто зам төсөллөх ЗЗБНбД 22-004-2016	ЗТХС-ийн 2016 оны 187 дугаар тушаалаар
Авто замын гүүр хоолой төсөллөх БНбД32-02-12	БНбД32-02-12
Хот тосгоны барилгажилтын норм ба дүрэм БНбД 30.01.04	БНбД 30.01.04
Шон суурьтай замын тэмдэг. Замын гэрэлтдэг тэмдэг MNS EN 12966:2016	MNS EN 12966:2016
Радар ашиглан газрын хөрсөнд судалгаа хийх арга MNS ASTM D 6432:2016	MNS ASTM D 6432:2016
Авто замын төмөр хашлага. Техникийн шаардлага	MNS 5614 : 2016
Авто замын төлбөр хураах цэг. Ерөнхий шаардлага	
“Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт,чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм”	MNS 4596:2013
Хурд сааруулагч. Техникийн ерөнхий шаардлага, хэрэглэх дүрэм	MNS 5968: 2009
Ус зайлуулах болон ариутгах татуургын төмөрбетон хоолой, техникийн шаардлага	MNS ASTM C76 M : 2004
Төмөр бетонон гүүрийн гадаргууд ус тусгаарлах системийг хэрэглэх арга	MNS ASTM D4071 : 2006
Авто замын барилгын ажлын төсвийн жишиг норм	ЗЗБНбД 83-25-2023
Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм	БНбд30-01-04 /шинэчлэгдсэнээр/
Төмөр зам ба авто замын нүхэн байгууламж	БНбД 32-07-10
Усны барилга байгууламжийн инженер хайгуул судалгааны ажлын жишиг норм	БД81-105-11
Гадна дулаан хангамж	БНбд41-02-05
Цахилгаан байгууламжийн дүрэм	БД43-101-03
Ус хангамж гадна сүлжээний ба байгууламж	БНбд40-02-06

(дээрх жагсаалтад дурдсан баримт бичгийн нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулга нэгэн адил хамаарна.)

Ажлын зураг, Техникийн нөхцөл, Мэдээлэл нь Ажил гүйцэтгэх үүрэг, зорилго болон хэлбэртэй холбоотой Захиалагчийн ерөнхий ойлголт, зорилгыг илэрхийлнэ. Гүйцэтгэгч нь зураг төсөл боловсруулахдаа Захиалагчийн өгсөн мэдээлэлд үндэслэх хэдий ч үүгээр хязаарлагдахгүй байх ба зураг төслийн бүрэн гүйцэд байдалд хариуцлага хүлээнэ.

ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ 1-Д ЗААСАН БАРИМТ БИЧИГТЭЙ ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН ТАЛУУДЫН ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД:

ЗАХИАЛАГЧ “.....”-ИЙГ ТӨЛӨӨЛЖ: ДАРГА	ГҮЙЦЭТГЭГЧ “.....” ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ХАВСРАЛТ №2

ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨР, АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

/..... болон “.....” ХХК-ийн хооронд 2025 оны __ дугаар сарын __-ны өдөр байгуулав./

ГАРЧИГ

1. ГЭРЭЭНИЙ ҮНЭ 3
2. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ 4
3. ГЭРЭЭНИЙ ҮНИЙН ТОХИРУУЛГА 4
4. ЯВЦ ДУНДЫН ТӨЛБӨР 4
5. АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ - ДЭЛГЭРЭНГҮЙ 5

1. ГЭРЭЭНИЙ ҮНЭ

1.1. Энэхүү Гэрээний нийт үнийг Захиалагчийн 2025 оны 01 дүгээр сард боловсруулж, магадлуулсан Туулын хурдны замын техник эдийн засгийн үндэслэл (цаашид “ТЭЗҮ” гэх)-ийг эх сурвалж болгон нийт үнэд үндэслэн /LUMP SUM/ тогтоосныг нэгтгэн харуулбал:

Хүснэгт 1.1 Гэрээний нийт үнэ

№	Ажлын нэр	Бүгд өртөг /төгрөг/
1	Барилга угсралтын ажлын дүн	
2	Археологи, палеонтологи, түүх угсаатны хайгуул судалгаа, авран хамгаалах ажил	
3	Магадлашгүй ажлын зардал 2%	
	Бүгд өртөг	

*Магадлашгүй ажлын мөнгөн дүнг технологийн хувьд зайлшгүй шаардлагатай ТЭЗҮ, Гэрээнд тусгагдаагүй нэмэлт ажлыг гүйцэтгүүлэх зорилгоор Монгол Улсын хууль, дүрэмд нийцүүлэн Ажлын төлбөрт шилжүүлэн тооцож болно.

**Гүйцэтгэгчийн гэрээт ажлын дүнд удирдлагын зардал, гүйцэтгэгчийн ашиг, ХАБЭА-н үйл ажиллагааны зардал, норм нормативын сангийн зардал, хайгуул судалгаа, бүхий л даатгал, нэмэгдсэн өртгийн албан татвар зэрэг гүйцэтгэгчтэй холбоотой бүхий л зардлыг шингээн тооцсон.

1.2. Захиалагч нь эрх бүхий этгээдийн магадалсан нарийвчилсан зураг төсөл, хэмжилтээр тодорхойлсон Ажлын нэр, төрөл, тоо хэмжээг баримтлан Гэрээнд заасан тухайн Ажил (ажилбар)-ын “Төлбөрт эзлэх хувь”-ийг өөрчлөхгүйгээр гүйцэтгэсэн Ажлын нэр, төрөл, тоо хэмжээг дүйцүүлэн Явц дундын төлбөрийг тооцож төлнө.

1.3. Магадалшгүй ажлын нөөц хөрөнгийг дор дурдсан зориулалтаар зарцуулна. Үүнд:

a) Магадлагдсан зураг төсөл болон гүйцэтгэлийн зургийн тоо хэмжээ нь Гэрээнд заасан Ажлын тоо хэмжээнээс хэтэрсэн, ТЭЗҮ болон Гэрээнд тусгагдаагүй технологийн хувьд зайлшгүй шаардлагатай гэж үзсэн ажил;

b) Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас гарсан нэмэлт ажил болон үйл ажиллагааны зардлууд;

c) ТЭЗҮ, зураг төсөл магадлагдсаны дараа илрүүлсэн төсвийн тооцооны алдааг залруулах;

d) Барилгын материал хийц хэсгийг зураг төсөл зохиогчийн зөвшөөрөлтэйгээр өөрчилснөөс үүдэн гарах аливаа зардлууд;

e) Ажлын баримт бичгийн төслийн шийдлийн өөрчлөлтийн зөрүү;

f) Захиалагчийн шаардлага, хүсэлтийн дагуу аливаа шалтгаанаар гүйцэтгэсэн бусад ажил болон үйлчилгээ.

2. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

2.1. Гүйцэтгэгч Ажлыг магадлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэснийг Захиалагч хянан баталгаажуулна.

2.2. Гүйцэтгэгч төслийг бүхэлд нь энэхүү гэрээний хавсралт 5-т заасан хугацаанд багтаан ашиглалтад оруулах зорилгоор Захиалагчийн нэрийн өмнөөс төслийн зураг төсөл, худалдан авалт, барилга угсралтын санхүүжилтийг өөрийн эх үүсвэрээр урьдчилан санхүүжүүлж ажиллана. Ийнхүү урьдчилан санхүүжүүлсэн мөнгөн дүнг явц дундын төлбөрийн гэрчилгээгээр баталгаажуулна.

2.3. Захиалагч энэ зүйлийн 2.2-д заасан Гүйцэтгэгчийн өөрийн эх үүсвэрээр урьдчилан санхүүжүүлсэн төлбөрийг гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 4 жилийн хугацаанд төсөвт хуваан суулгаж аливаа хүү, шимтгэл, нэмэгдэлгүйгээр хуваан төлөх нөхцөлийг Гүйцэтгэгч зөвшөөрөв.

3. ГЭРЭЭНИЙ ҮНИЙН ТОХИРУУЛГА

3.1. Талууд Гэрээний үнэд шатахуун болон Барааны (цемент, арматураас бусад бараа) зах зээлийн үнийн өөрчлөлтөөс үүдэлтэй үнийн тохируулга, өөрчлөлт оруулахгүй байхаар харилцан тохиролцож, Гүйцэтгэгч шатахууны үнийн хэлбэлзлийн эрсдлийг дангаар хариуцахыг хүлээн зөвшөөрөв.

3.2. Ажил (ажилбар)-ын “Төлбөрт эзлэх хувь” нь Явц дундын төлбөрийн хэмжээг тодорхойлоход ашиглах хэрэглүүр бөгөөд энэ нь тухайн Ажлын нийт үнийн дүнд нөлөөлөхгүй.

4. ЯВЦ ДУНДЫН ТӨЛБӨР

4.1. Гүйцэтгэгч нь Явц дундын төлбөрийн хүсэлтийг Гэрээний нөхцөлд заасны дагуу боловсруулж, Захиалагчид хүргэх үүрэгтэй.

4.2. Гүйцэтгэсэн ажлын хувийг гаргахдаа ажилбар бүрийн Төлбөрт эзлэх хувийг нийт ажилд харьцуулан тодорхойлно. Ингэж тодорхойлсон ажлын гүйцэтгэлийн хувийг Гүйцэтгэгчийн гэрээт Ажлын нийт үнэд жинлэж Явц дундын төлбөрийн хүсэлтийг хүргүүлнэ.

4.3. Гүйцэтгэгч нь төлбөрийн баталгаажуулалтад шаардлагатай гүйцэтгэлийн зураг, холбогдох баримт бичгийг боловсруулахдаа ажлын бодит гүйцэтгэлийг нотлох, баталгаажуулж буй ажилд хамаарах барилга угсралтын болон санхүүгийн баримт бичиг, мэдээллийг Захиалагчид гаргаж өгөх үүрэгтэй.

5. АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ - ДЭЛГЭРЭНГҮЙ

5.1. Энэхүү гэрээний үнэ нь нийт үнэд үндэслэн /LUMP SUM/ нөхцөлөөр зөвшөөрсөн үнэ байх бөгөөд ажлын тоо хэмжээний задаргааг Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлыг баталгаажуулахад ашиглана.

5.2. Ажлын тоо хэмжээний хүснэгтэд дурдагдаагүй боловч гэрээнд заасан ажлын зорилгод хүрэхийн тулд зайлшгүй хийгдэх ажил, Гэрээгээр хийж гүйцэтгэхээр тохиролцсон ажил, түүний салшгүй хэсэг нь Гэрээний нийт төлбөрт багтсан байна.

5.3. Эрх бүхий этгээдийн магадалсан, нарийвчилсан зураг төслийн тоо хэмжээг талууд баримталж ажиллах бөгөөд бүх ажлын зураг төсөл магадлагдсаны дараа доорх тоо хэмжээ, төлбөрт эзлэх хувийн хүснэгтийг шинэчилж батална.

5.4. Захиалагч хүлээн зөвшөөрч, эрх бүхий этгээдийн магадалсан нарийвчилсан зураг төсөл, хэмжилтээр тодорхойлсон Ажлын нэр, төрөл, тоо хэмжээний дагуу Гүйцэтгэгч Ажлыг гүйцэтгэнэ.

5.5. Төлбөрт эзлэх хувийг 1,000,000.00 нэгжээр тэмдэглэв.

Хүснэгт 5.1 Ажлын тоо хэмжээ

№	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Төлбөрт эзлэх хувь
1				
1.1				
1.2				
2				
2.1				
2.2				

ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ №2-Д ЗААСАН БАРИМТ БИЧИГТЭЙ ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН ТАЛУУДЫН ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДҮҮД:

ЗАХИАЛАГЧ	ГҮЙЦЭТГЭГЧ
“.....”-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:	“.....” ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ДАРГА	ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ХАВСРАЛТ №3

БАЙГАЛЬ ОРЧИН, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ БОЛОН НИЙГМИЙН УДИРДЛАГА

/“.....” болон “.....” ХХК-ийн хооронд 2025 оны __ дугаар сарын __-ны өдөр байгуулав./

БАЙГАЛЬ ОРЧИН, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ БОЛОН НИЙГМИЙН УДИРДЛАГА

1. УДИРТГАЛ

1.1. Гүйцэтгэгч нь дараахь баримт бичгүүдийг үндэслэн “Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон нийгмийн удирдлагын төлөвлөгөө” (цаашид “БОХАБЭАНУ-ын төлөвлөгөө” гэх) боловсруулж, Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангаж ажиллана. Үүнд:

a) Захиалагчийн байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон нийгмийн удирдлагын талаарх баримтлах бодлого, журам (Хавсралт 3-ын 2-т заасан);
b) Захиалагчийн байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон нийгмийн удирдлагын төлөвлөгөөн тавигдах ерөнхий шаардлага (“Хавсралт 3-ын 3”-т заасан);
c) Туулын хурдны замын төсөлд хийсэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан.

1.2. БОХАБЭАНУ-ын төлөвлөгөөнд орон нутгийн байгаль орчин, нийгэмд үзүүлж болох боломжит сөрөг нөлөөллийг зохицуулах, бууруулах, аюулгүй байдлыг хангах, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үүрэг, хариуцлагыг тусгах бөгөөд энэхүү төлөвлөгөөгөөр эерэг өөрчлөлтийг бий болгох зорилготой.

1.3. Захиалагч нь байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон нийгмийн удирдлагын талаар баримтлах бодлого, журам, тавигдах шаардлагад өөрчлөлт оруулж болно. Гүйцэтгэгч нь аливаа өөрчлөлтийг нэн даруй хэрэгжүүлж, өөрөөр зөвлөөгүй бол өөрийн төлөвлөгөө, журмаа шинэчлэх замаар дагаж мөрдөнө.

2. ЗАХИАЛАГЧИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ БОЛОН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ТАЛААРХ БАРИМТЛАХ БОДЛОГО, ЖУРАМ

Захиалагчийн байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон нийгмийн удирдлагын талаарх баримтлах бодлого, журамд үндэслэн Гүйцэтгэгч нь эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой хууль тогтоомж стандарт, хэм хэмжээг хэрэгжүүлнэ.

Энэхүү бодлого, дүрэм, журмыг “Ажил эхлүүлэх тухай мэдэгдэл” ирүүлснээс хойш энэхүү Хавсралт 3-д тусгайлан заасны дагуу 30 хоногийн дотор Захиалагч Гүйцэтгэгчид гаргаж өгнө.

3. БАЙГАЛЬ ОРЧИН, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ БОЛОН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Гүйцэтгэгч нь байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон нийгмийн удирдлагын талаарх баримтлах бодлого, журамтай холбоотой дараахь шаардлагуудыг дагаж мөрдөнө. Үүнд:

3.1. БАЙГАЛЬ ОРЧИН

a) Гүйцэтгэгч нь байгаль орчныг хамгаалах (ажлын талбайн гадна болон дотор), элэгдэл, бохирдлоос урьдчилан сэргийлэх, байгаль орчинд халтай үйл ажиллагаанаас шалтгаалан хүрээлэн буй орчин, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд хохирол үүсэхээс сэргийлэх шаардлагатай арга хэмжээг авна.
b) Гүйцэтгэгч нь Захиалагчийн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар магадлуулсан жил тутмын Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дагаж мөрдөх ба төлөвлөгөөнд тусгагдсан байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлж байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
c) Гүйцэтгэгч нь Захиалагчийн байгаль орчны талаарх үйл ажиллагааны журам, шийдвэрийг дагаж мөрдөнө.
d) Гүйцэтгэгч нь хог хаягдалтай холбоотой хууль тогтоомж, шаардлагуудыг мөрдлөг болгон байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг боломжит түвшинд хүртэл бууруулах үүрэг хүлээнэ.
e) Гүйцэтгэгч нь ан амьтан, ургамал, агаарын чанарыг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх бөгөөд холбогдох хууль, журамд заасан шаардлагуудыг дагаж мөрдөнө.
f) Гүйцэтгэгч түр кемпийн газар, төслийн түр зам ашиглах зөвшөөрлүүдийг эрх бүхий байгууллагаас гаргуулан авах үүрэгтэй. Мөн түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрхийн хүрээнд түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиглах үүрэгтэй. Гүйцэтгэгч нь холбогдох хууль, журмын дагуу төлбөрийг төлж ашиглалт дуусаны дараа нөхөн сэргээлтийг хийн хүлээлгэн өгөх үүргийг хүлээнэ.
g) Гүйцэтгэгч нь химийн бодисын хаягдал, материалын алдагдал хүрээлэн буй орчин, ургамал, ан амьтад, хөрс, гадаргын болон газрын доорх усанд үзүүлсэн сөрөг нөлөөлөл, бохирдол зэрэг байгаль орчны зөрчил, осол аваарын талаар мэдээллийг Захиалагчид тухай бүр тогтмол мэдэгдэж байна. Гүйцэтгэгч нь сар бүрийн тайлангийн нэг хэсэг болгож байгал орчны тайланг Захиалагчид хүргүүлнэ.
h) Гүйцэтгэгч төслийн үйл ажиллагаанаас шалтгаалах элэгдэл, хорогдол, асгаралт, хаягдлын хэмжээ, ус зарцуулалтыг Техникийн шаардлага болон холбогдох хууль тогтоомжид заагдсан хэмжээнээс хэтрэхгүй байлгах үүрэгтэй.

3.2. АЖЛЫН ТАЛБАЙН МЕНЕЖМЕНТ

a) Гүйцэтгэгчийн ажлын талбай гэдэгт ажлын шаардлагаар ашиглаж буй байнгын болон түр талбайг хамруулан ойлгох ба зөвшөөрсөн газруудад тэмдэг, тэмдэглэгээ байршуулна. Гүйцэтгэгч нь өөрийн тоног төхөөрөмж, ажиллах хүчийг ажлын талбайд байршуулах болон ажил гүйцэтгэхэд шаардлагатай арга хэмжээг авна.
b) Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгч нь ажлын талбайг аливаа саадаас ангид байлгаж, Гүйцэтгэгч нь барилгын ажлын улирал бүрийн төгсгөлд ажлын талбайгаас хаягдал материалыг устгаж зайлуулах арга хэмжээ авна.
c) Гүйцэтгэгч нь барилгын ажлын техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгаж, стандарт шаардлагыг удирдамж болгон ТТАМ орд болон түр замыг нөхөн сэргээх ба ажилд үл хамаарах тээврийн хэрэгсэл зорчихгүй байлгах, хамгаалах арга хэмжээг авна.
d) Гүйцэтгэгч нь ажлын талбайд зөөвөрлөн авчирсан химийн болон аюултай материалыг зайлуулах, устгах ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу гүйцэтгэж, ажлын талбайг цэвэрлэж, аюулгүй байдлыг хангана.

3.3. ЭРҮҮЛ АХУЙ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ МЕНЕЖМЕНТ

a) Гүйцэтгэгч нь хууль тогтоомжид заасан Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлагуудыг дагаж мөрдөх бөгөөд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарахаас урьдчилан сэргийлж, ажиллах хүчний аюулгүй байдлыг бүрэн хангана.
b) Гүйцэтгэгч нь ажлын талбайд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжид заасан тоогоор хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны болон эрүүл ахуйн ажилтан ажиллуулна.
c) Гүйцэтгэгч нь эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны осол, осолд дөхсөн тохиолдлуудыг тайлагнах тогтолцоотой байх бөгөөд уг тайланг сар тутмын явцын тайланд тусгасан байна.

3.4. НИЙГМИЙН МЕНЕЖМЕНТ

a) Гүйцэтгэгч нь нийгмийн өв уламжлалыг хадгалах, хамгаалах, түүхийн болон соёлын үнэт зүйлсийг хамгаалах, орон нутгийн оршин суугчид, малчид, засгийн газрын болон төрийн бусад байгууллагуудад сонирхогчийн түвшинд мэдээлэл гаргаж өгөх, оролцох, аливаа хүсэлт, шаардлага, гомдолд хариу өгөх зэргээр хамтын ажиллагааг явуулна.
b) Гүйцэтгэгч нь орон нутгийн уламжлалыг хүндэтгэж, эдийн болон эдийн бус соёлын эд зүйлсийг хүндэтгэнэ.
c) Гүйцэтгэгч нь нийт ажиллах хүчний 20-иос доошгүй хувийг мэргэжлийн шаардлага хангасан орон нутгийн иргэдийг ажлын байраар хангана.

d) Гүйцэтгэгч нь Захиалагчтай орон нутгийн эдийн засгийг дэмжихэд хамтран ажиллах бөгөөд орон нутгаас эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан бараа, ажил, үйлчилгээ худалдан авахыг хичээнэ.
e) Гүйцэтгэгч нь гомдол барагдуулах төлөвлөгөөг хэрэгжүүлэх бөгөөд орон нутгийн иргэдээс ирсэн аливаа гомдлыг цаг тухайд нь (хамгийн ихдээ 30 өдөр, шаардлагатай бол илүү хурдан хугацаанд) хариу өгч, барагдуулах бөгөөд орон нутгийн иргэд, ажилчид, туслан гүйцэтгэгчдээс ирсэн аливаа гомдолтой холбоотой шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлнэ. Мөн түүнчлэн, гүйцэтгэгч нь орон нутгийн иргэд, туслан гүйцэтгэгч, ажилчдаас ирсэн гомдлыг сар бүр тайлан болгон бэлтгэж, тэдгээр гомдлыг хэрхэн барагдуулах боломжтой эсэх талаар Захиалагчтай зөвлөлдөнө. Гүйцэтгэгчийн хариуцлагагүй үйл ажиллагаанаас болж Захиалагч болон гомдол гаргагчид мөнгөн болон материаллаг хохирол үүссэн бол бүх хохирол, зардлыг Гүйцэтгэгч барагдуулна.

3.5. БАЙГАЛЬ ОРЧИН, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ БОЛОН НИЙГМИЙН УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТАВИГДАХ БУСАД ШААРДЛАГА

a) Захиалагч нь Гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд гэнэтийн болон хугацаат үзлэг хийнэ. Гүйцэтгэгч нь ажлын байрны үзлэгээр илэрсэн зөрчил, үл нийцлийг арилгах үүрэгтэй.
b) Захиалагч нь БОХАБЭАНУ-ын төлөвлөгөөг биелүүлээгүй, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, тогтоомжийг зөрчсөн, тайланг хоцроосон зэрэг тохиолдол бүрт 5.000.000 - 10.000.000 төгрөгийн торгуулийг Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авна.
c) Төслийн зам, барилгын ажилд ашигласан ТТАМ орд, кемпийн газар, түр зам зэрэг Гүйцэтгэгчийн зүгээс нөхөн сэргээх шаардлагатай газруудыг холбогдох албан тушаалтанд албан ёсоор хүлээлгэн өгөх хүртэл нөхөн сэргээлтийн зардлыг Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс барьцаа хэлбэрээр Захиалагчийн дансанд саатуулна.

Гарын үсэг арын хуудсанд

ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ №3-Д ЗААСАН БАРИМТ БИЧИГТЭЙ ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН ТАЛУУДЫН ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДҮҮД:

ЗАХИАЛАГЧ	ГҮЙЦЭТГЭГЧ
“.....”-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:	“.....” ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ДАРГА	ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ХАВСРАЛТ №4

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ШААРДАГДАХ ЗӨВШӨӨРӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ҮҮРГИЙН МАТРИЦ

/“.....” болон “.....” ХХК-ийн хооронд 2025 оны ..... дугаар сарын .....-ны өдөр байгуулав./

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ШААРДАГДАХ ЗӨВШӨӨРӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ҮҮРГИЙН МАТРИЦ

№	Ажилбар	Захиалагч	Гүйцэтгэгч	Хугацаа
1	**Зохион байгуулалтын арга хэмжээнүүд**			
1.1	Төлбөрийн баталгаа гаргах	Х		Гэрээ байгуулснаас хойш 30 хоногийн дотор
1.2	БОННҮ, БОМТ боловсруулах, магадлуулах	Х		Тухай бүр
1.3	Монгол Улсын хилээр оруулж ирэхтэй холбоотой ажиллах хүч, тоног төхөөрөмж, машин механизм, бараа материалын аливаа зөвшөөрөл, шаардлагатай арга хэмжээг зохион байгуулах	Х	Х	Тухай бүр
1.4	Авто замтай огтлолцсон зам болон бусад дэд бүтцийн байгууламжийн техникийн нөхцөл, шийдлийг холбогдох талуудтай тохирох	Д	Х	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногийн дотор
2	**Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, захиргааны байгууллагаас авах зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл**			
2.1	Авто зам, замын байгууламжийн үйл ажиллагаатай холбоотой тусгай зөвшөөрөл авах	Д	Х	Тухай бүр /Гүйцэтгэгч, эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн нэр дээр байх/
2.2	Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл авах	Д	Х	
2.3	Авто зам, замын байгууламжийн барилгын ажил үргэлжлүүлэх зөвшөөрөл авах	Д	Х	
2.4	Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгоход бүрдүүлэх бичиг, баримт	Х	Х	
2.5	Газар эзэмшүүлэх зөвшөөрөл	Х		
2.6	Авто замын зурвас газрыг батлуулах	Х	Х	
2.7	Авто замын ажилд ашиглах хэмжих багаж хэрэгслийн гэрчилгээжүүлэлт		Х	Тухай бүр /Гүйцэтгэгч, эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн нэр дээр байх/
2.8	Авто замын ажилд хэрэглэх өөрөө явагч машин механизмын гэрчилгээжүүлэлт		Х	Тухай бүр /Гүйцэтгэгч, эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн нэр дээр байх/
2.9	Бараа, материалын чанарын болон тохирлын гэрчилгээ		Х	Тухай бүр /Гүйцэтгэгч, эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн нэр дээр байх/
2.10	Газар чөлөөлөлт	Х	Т	
3	**Орон нутгийн байгууллагаас**			

Захиалагч тэмдэг Гүйцэтгэгч тэмдэг

№	Ажилбар	Захиалагч	Гүйцэтгэгч	Хугацаа
3.1	Кемпийн зөвшөөрөл		Х	Тухай бүр
3.2	Кемпийн газрын зөвшөөрөл	Х	Т	Тухай бүр
3.3	Түр замын зөвшөөрөл		ХТ	Тухай бүр
3.4	Хог хаягдлын түр цэгийн зөвшөөрөл		ХТ	Тухай бүр
3.5	ТТАМ ашиглалтын зөвшөөрөл	Х	Т	Тухай бүр
3.6	Ус ашиглалтын зөвшөөрөл	Х	Т	Тухай бүр
3.7	Хийх ажлын нарийвчилсан төлөвлөгөөний хяналт, баталгаажилт	Х	Х	Тухай бүр
4	**Ашиглалтад оруулах**	Х	Х	
4.1	Ашиглалтад оруулахад шаардлагатай эрх бүхий төрийн байгууллагын шийдвэрүүд /Улсын комиссын шаардлага хангасан байдлаар/	Х	Х	Тухай бүр
4.2	Улсын комисст хүлээлгэх өгөх хүсэлт гаргах	Х	Х	Тухай бүр
4.3	Авто зам, замын байгууламжийг ашиглалтад авахад бүрдүүлэх, архивт хүлээлгэн өгөх бичиг, баримтыг хангуулах	Х	Х	Тухай бүр
4.4	ЗТХС-ын 2018 оны 49-р тушаалаар баталсан "Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам"-д заасан шаардлагыг бүрэн хангах	Д	Х	Тухай бүр
4.5	Барилга, ашиглалт, засвар үйлчилгээний стандарт боловсруулж төрийн эрх бүхий байгууллагаар батлуулах	Д	Х	Тухай бүр
5	**Авто зам, замын байгууламжийн гэрчилгээжүүлэлт**	Х	Д	

Х-Хариуцна
Т-Төлбөр төлнө

Д-Дэмжинэ

Гэрээнд заасан ажилд зөвхөн энэхүү матрицыг мөрдөнө. Матрицад дурдсан арга хэмжээ, зөвшөөрлүүд нь эцсийнх биш бөгөөд Гэрээг хэрэгжүүлэх хугацаанд дахин шинэчлэх боломжтой.

Гарын үсэг арын хуудсанд

Захиалагч тэмдэг Гүйцэтгэгч тэмдэг

ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ 4-Т ЗААСАН БАРИМТ БИЧИГТЭЙ ТАНИЛЦАЖ,
ЗӨВШӨӨРСӨН ТАЛУУДЫН ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД:

ЗАХИАЛАГЧ	ГҮЙЦЭТГЭГЧ
“.....”-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:	“.....” ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ДАРГА	ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Захиалагч тэмдэг

Гүйцэтгэгч тэмдэг

ХАВСРАЛТ №5

АЖЛЫН ХУВААРЬ

/“.....” болон “.....” ХХК-ийн хооронд 2025 оны __ дугаар сарын __-ны өдөр байгуулав./

№	Барилгын ажил	Гүйцэтгэх хугацаа		
		Сар	эхлэх	дуусах
	Туулын хурдны зам	**60.0**	**2025.04.20**	**2030.04.20**
1	**Төслийн зураг төсөл, барилга угсралт, хүлээлгэн өгөх ажил**	**24.0**	**2025.04.20**	**2027.04.20**
1.1	**Зураг төсөл боловсруулах ажил**	**11.3**	**2025.04.20**	**2026.04.01**
1.1.1	**Урьдчилсан зураг төсөл төлөвлөлт**	**2.3**	**2025.04.20**	**2025.06.30**
1.1.2	**Нарийвчилсан зураг төсөл боловсруулалт**	**11.0**	**2025.05.01**	**2026.04.01**
1.2	**Замын барилга угсралтын ажил**	**18.3**	**2025.04.20**	**2026.10.30**
1.2.1	**Нүүлгэн шилжүүлэлт /ажиллах хүчин, машин механизм, кемп/**	**1.0**	**2025.04.20**	**2025.05.20**
1.2.2	**Доод бүтцийн газар шорооны ажил**	**13.3**	**2025.05.20**	**2026.08.30**
1.2.3	**Суваг шуудуун ажил**	**13.3**	**2025.05.20**	**2026.08.30**
1.2.4	**Төмөр бетон гүүрийн ажил**	**16.0**	**2025.07.01**	**2026.10.30**
1.2.5	**Хоолойн ажил**	**16.0**	**2025.07.01**	**2026.10.30**
1.2.6	**Туннелийн ажил**	**16.0**	**2025.07.01**	**2026.10.30**
1.2.7	**Хучилтын ажил**	**14.0**	**2026.09.01**	**2026.10.30**
1.2.8	**Замын тэмдэг, тэмдэглэгээ, тоноглолын ажил**	**5.0**	**2026.10.01**	**2027.03.01**
1.3	**Мэдээлэл, холбоо**	**9.0**	**2025.06.01**	**2027.02.28**
1.3.1	**Холбооны сувагчлал, кабель шилжүүлэх шинээр барих, камержуулалт, тоног төхөөрөмж, программ хангамж**	**9.0**	**2025.06.01**	**2027.02.28**
1.4	**ЦДАШ, дэд станц**	**9.0**	**2025.06.01**	**2027.02.28**
1.4.1	**Авто замын гэрэлтүүлэг, авто замын трасст орсон ЦШС-г хамгаалах, шилжүүлэх, дэд станц шилжүүлэх, шинээр барих**	**9.0**	**2025.06.01**	**2027.02.28**
1.5	**Хүлээлгэн өгөх**	**1.7**	**2027.03.01**	**2027.04.20**
2	**Бусад**	**59.2**	**2025.05.15**	**2030.04.20**
2.1	**Газар чөлөөлөлт**	**4.0**	**2025.05.15**	**2025.09.15**
2.2	**Зүгшрүүлэх, тохируулах**	**12.0**	**2027.04.20**	**2028.04.20**
2.3	**Чанарын доголдол арилгах**	**36.0**	**2027.04.20**	**2030.04.20**

**ГН*-ийн 8 дугаар зүйлд заасны дагуу ажил эхлэх, саатах, түр зогсох хугацаанд өөрчлөлт орсон, эсхүл ТЭЗҮ /Захиалагч/, зураг төслийн нэмэлт өөрчлөлт /Гүйцэтгэгч/-ийн улмаас Гэрээний хавсралт 2-т заасан ажлын хамрах хүрээнд нэмэлт, өөрчлөлт орсон бол энэхүү хуваарьт өөрчлөлт оруулах үндэслэл болно.

**Зураг төслийг хэсэгчилсэн байдлаар батлуулж, магадлуулж ажиллана.

***Нүүлгэн шилжүүлэлт гэж Гүйцэтгэгчийн ажиллах хүчин, машин механизм, тоног төхөөрөмжийг төслийн талбайд шилжүүлэх ажиллаар ойлгоно.

Гарын үсэг арын хуудсанд

ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ 5-Д ЗААСАН БАРИМТ БИЧИГТЭЙ ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН ТАЛУУДЫН ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД:

ЗАХИАЛАГЧ	ГҮЙЦЭТГЭГЧ
“.....”-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:	“.....” ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ДАРГА	ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ХАВСРАЛТ №6

ДОТООДЫН НӨӨЦ АШИГЛАХ ШААРДЛАГА

/“.....” болон “.....” ХХК-ийн хооронд 2025 оны __ дугаар сарын __-ны өдөр байгуулав./

“Туулын хурдны зам” төслийн зураг төсөл, худалдан авалт, барилга угсралтын ажил гүйцэтгэх Гүйцэтгэгч нь дотоодын аж ахуйн нэгж, бараа материал, ажил, үйлчилгээ, үйлдвэрлэл, ажиллах хүчийг дэмжиж ажиллана.

Гүйцэтгэгч нь уг төсөлд ажиллах хүний нөөц, машин механизм, худалдан авах бараа материалын доор заасан хувь хэмжээнээс багагүй хувийг тухайн орон нутгийн зах зээлээс заавал авч ажиллана. Үүнд:

Хүснэгт 1. Орон нутгаас авах хувь, хэмжээ

Д/д	Нэр	Хувь, хэмжээ
1	Ажиллах хүч	20-иос доошгүй хувь
2	Үндсэн бараа, материал	20-иос доошгүй хувь
3	Машин, механизм	60-аас доошгүй хувь

1. ТӨСЛИЙН АЖИЛЛАХ ХҮЧ

Гүйцэтгэгч нь Захиалагчийн шаардлагад нийцсэн, төсөл хэрэгжүүлэх туршлага бүхий мэргэжлийн багийг бүрдүүлнэ. Үүнд төслийн менежер, төслийн удирдлага, хяналтын мэргэжилтнүүд, нарийн мэргэжлийн инженерүүд болон холбогдох захиргааны ажилтнууд байна.

Уг төсөлд ажиллах нийт ажилтны 20-оос багагүй хувьд орон нутгийн иргэдийг авч ажиллуулна.

2. БАРАА, МАТЕРИАЛ

Гүйцэтгэгч нь чанар, стандарт, Захиалагчийн шаардлагад нийцсэн бараа, материалыг ашиглана. Төсөлд ашиглах нийт бараа, материалын 20-оос багагүй хувийн чанар, стандартын шаардлага хангасан бараа, материалыг дотоодын үйлдвэрээс худалдан авч төсөлд хэрэглэнэ.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоол “Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалт”-д дурдсан дараах үндсэн бараа, материалыг дотоодын зах зээлээс Гүйцэтгэгч нь худалдан авна.

Хүснэгт №2 Үндсэн бараа, материалын жагсаалт

№	Үндсэн бараа, материал
1	Цемент
2	Хайрга, дайрга, элс
3	Арматур
4	Асфальт бетон

3. МАШИН МЕХАНИЗМ

Гүйцэтгэгч нь авто зам, замын байгууламжийн ажилд шаардагдах машин механизмын хүрэлцээ, бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааг бүрэн хангуулж ажиллана.

Ингэхдээ авто зам, замын байгууламжид ашиглах нийт машин механизмын 60-аас багагүй хувийг дотоодын зах зээлээс худалдан авч, түрээсэлж ажиллана.

ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ 6-Д ЗААСАН БАРИМТ БИЧИГТЭЙ ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН ТАЛУУДЫН ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД:

ЗАХИАЛАГЧ	ГҮЙЦЭТГЭГЧ
“.....”-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:	“.....” ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ДАРГА	ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ